

АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН 2021

Штээгдүүдийн амхэтгэл

Улаанбаатар хот
2022 он



АГУУЛГА

"Авлигын Эсрэг Үндэсний Чуулган-2021"

<i>Үндэсний чуулганы үг</i>	5
Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа	5
Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар	9
Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх	13
Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ	16
Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч Андрей Михнев	24
Азийн хөгжлийн банкны дэд суурин төлөөлөгч Деклан Магий	27
 <i>Үндсэн илтгэл</i>	 29
Авлигатай тэмцэх бодлого, үйл ажиллагаа, үр дүн <i>Авлигатай тэмцэх газрын дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал</i>	30
Авлигатай тэмцэх улс төрийн хүсэл зориг, эрх зүйн орчин, хамтын ажиллагаа <i>Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо</i>	40
Цар тахлын дараа сайн засаглалыг бэхжүүлэхэд анхаарах асуудал <i>Бруүкингс институтийн зөвлөх, доктор, профессор Даниел Кауфманн</i>	45
Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал, олон нийтийн хяналт, оролцоо <i>Улсын Их Хурлын гишүүн, Авлигын эсрэг Парламентын бүлгэмийн гишүүн Ц.Мөнхцэцэг</i>	51
 <i>Салбар хэлэлцүүлэг 1.</i> <i>Авлигатай тэмцэх эрх зүйн орчин, хуулийн байгууллагуудын хамтын ажиллагаа</i>	 55
Авлигын эсрэг НҮБ-ын конвенци ба дотоодын хууль тогтоомж <i>Авлигатай тэмцэх газрын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Р.Баярмагнай</i>	58
Авлигын хэргийг хянан шалгах үйл ажиллагаанд тавих прокурорын хяналт, тулгамдсан асуудал <i>Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат</i> ..	63
Авлигын хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал <i>Улсын дээд шүүхийн шүүгч, Эрүүгийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр</i>	68

Авлигын гэмт хэрэг: Эрүүгийн эрх зүйн хууль тогтоомжийн тодотгол авлигын эсрэг эрх зүйн шинэтгэлийн явц

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг .. 83

Авлигын гэмт хэрэгтэй тэмцэхтэй холбоотой хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд анхаарах асуудал

Монголын хуульчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүн, хуульч Л.Галбаатар 91

Авлига ба хүний эрх

Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, хууль зүйн ухааны доктор Д.Сүнжид 95

Салбар хэлэлцүүлэг 2:

Авлигатай тэмцэхэд хэвлэл мэдээллийн болон иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоо..... 103

Авлигатай тэмцэх нь:Иргэдийн мэдэх эрх ба мэдээллийн ил тод байдал
“Глоб интернэшнл төв” ТББ-ын Хуульч Б.Пүрэвсүрэн..... 106

Авлигын эсрэг иргэдийн хяналт, оролцоо
Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн дарга Г.Ганбат 109

Авлигатай тэмцэхэд хэвлэл мэдээллийн салбарын оролцоо, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй
Монголын хэвлэлийн мэдээллийн зөвлөлийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа112

Шүгэл үлээгчийг хамгаалах, мэдээлэх тогтолцоог дэмжихүй
Авлигатай тэмцэх газрын УССГХ-ийн дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн.....117

Авлигаас ангид боловсролын салбар: төсөв, ил тод байдал, иргэний нийгмийн оролцоо
“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг..... 124

Авлигатай эсрэг залуусын оролцоо, санаачилга
“Цогц хөгжлийн үндэсний төв” ТББ-ын Тэргүүн М.Энхбадрал..... 131

Салбар хэлэлцүүлэг 3:

Төрийн албаны шударга, ил тод байдлыг бэхжүүлэх нь 134

Төрийн албан дахь авлигын эрсдэл: судалгааны үр дүн
Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албаны дарга, ахлах комиссар Ц.Шинэбаяр 138

Төрийн албаны томилгоо, ил тод байдал: Төрийн албаны зөрчлөөс сэргийлэх нь <i>Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг</i>	147
Авлига-залилангийн эсрэг төрийн аудитын бодлого чиглэл <i>Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат</i>	153
Төрийн үйлчилгээг цахимжуулах, авлига, хүнд суртлыг бууруулах нь: Нийслэлийн шийдэл, сорилт, үр дүн <i>Нийслэлийн инновац, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Р.Дагва</i>	157
Цахим шилжилт ба авлига <i>Хариуцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ</i>	160
Төсвийн ил тод байдал: Төсөв, нийтийн өмчийн хөрөнгийг захиран зарцуулахад иргэний нийгмийн байгууллагаас тавих хяналт <i>“Нээлттэй нийгэм форум” ТББ-ын засаглалын менежер Д.Оюунбадам</i>	164
Олон улсын хандив, тусламжийн зарцуулалтыг сайжруулах хэрэгцээ, шаардлага <i>Дэлхийн банкны Улсын салбарын ахлах зөвлөх Д.Бадамчимэг</i>	172
<i>Салбар хэлэлцүүлэг 4:</i> <i>Хувийн хэвшил ба шударга өрсөлдөөн</i>	177
Төрийн худалдан авах ажиллагааны ил тод, шударга байдлыг нэмэгдүүлэх нь <i>Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Ц.Батзул</i>	180
Авлигаас ангид шударга өрсөлдөөнийг дэмжих нь <i>Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Б.Бат-Эрдэнэ</i>	183
Хувийн хэвшлийн шударга байдал <i>Монголын бизнесийн зөвлөлийн Удирдах зөвлөлийн дарга Ц.Түмэнцогт</i>	188
Бизнесийн орчныг сайжруулах, өрсөлдөөний шударга байдлыг хангах нь <i>МҮХАҮТ-ын ерөнхийлөгч О.Амартүвшин</i>	192
Төрийн өмчит хуулийн этгээдийн засаглал: Ил тод, хариуцлага, шударга байдлыг бэхжүүлэх нь <i>Транспарэнси Интернэшнл байгууллагын Хараат бус зөвлөх, судлаач Д.Тэгибаяр</i>	197
АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ	201

“АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН-2021”

Нээлтийн үе

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮН КОМИССАР З.ДАШДАВАА



*Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга,
Эрхэмсэг хатагтай, ноёд, зочид
төлөөлөгчид, эрхэм хүндэт нөхөд
Та бүхнийхээ энэ өглөөний амар
амгаланг айлтган мэндчилье.*

Авлигын эсрэг үндэсний чуулганд хүрэлцэн ирсэн Эрхэм хүндэт Элчин сайд, дипломат төлөөлөгч, олон улсын байгууллагын суурин төлөөлөгч Та бүхэнд талархал илэрхийлье. Мөн цахим сүлжээгээр чуулганд оролцож байгаа бүх иргэн, хүмүүст энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Аливаа улс орны хөгжлийг сааруулагч олон хүчин зүйлийн нэгд “авлига” зүй ёсоор тооцогдсоор байгаа бөгөөд Монгол Улсын хувьд ч мөн адил авлига хэмээх үзэгдэл ядуурал, байгаль орчны бохирдол, халдварт өвчний нэгэн адил тодорхой хэмжээнд нийгэмд бугшсан, улс орны хөгжил дэвшлийг хойш чангааж байгаатай иргэн бүр санал нийлж байгаа. Авлигатай тэмцэх нь ардчилал, шударга ёс, сайн засаглал, хууль дээдлэх ёс, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хөгжлийн төлөө хийж байгаа ажил юм.

Авлига бол албан тушаалаа урвуулан ашиглах, үндэслэлгүй хөрөнгөжих төдий асуудал биш. Авлига нь засаглалыг сулруулж, зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээг бий болгодог бөгөөд хүн худалдаалах, зэвсгийн наймаа, хууль бусаар хил давуулах зэрэг олон арван гэмт хэргийг дэмжигч болж байдаг. Авлигын гэмт хэргийн дам хохирогч нь энэхүү нийгэмд амьдарч байгаа хүмүүс юм. Авлига, хахууль, татвар, санхүүгийн гэмт хэргээс хөгжиж байгаа орнууд

жилдээ 1.26 тэрбум ам.долларын хохирол хүлээдэг. Европын холбооны Дотоод хэргийн комиссарын мэдээлснээр Европын холбооны гишүүн улсууд жил бүр 132 тэрбум ам.долларыг авлигын гэмт хэргийн улмаас алддаг. Энэ мөнгийг иргэдийн боловсрол, эрүүл мэнд, бүтээн байгуулалтад зарцуулсан бол олон орны хөгжил, цэцэглэлтэд том хувь нэмэр болох байсан нь гарцаагүй.

Иймд дэлхийн улс орнууд авлигын эсрэг тэмцэлд дуу хоолойгоо нэгтгэн идэвхтэй оролцох боллоо. Мөн энэхүү хорт үзэгдэлтэй нэг улс дангаар тэмцэхээс илүүтэйгээр хамтын хүчээр тэмцэх нь үр дүнтэй болохыг хүлээн зөвшөөрч 2003 онд НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас Авлигын эсрэг конвенцийг тунхагласан. Энэхүү конвенцид дэлхийн 190 гаруй улс орон нэгдэн орсон бөгөөд Монгол Улсын Их Хурал 2005 онд конвенцийг соёрхон баталсан нь авлигатай тэмцэх шинэ арга хэрэгсэл, олон улсын стандартыг нэвтрүүлэх ажлын эхлэл болж чадсан.

Үүний зэрэгцээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей жил бүрийн 12 дугаар сарын 9-ний өдрийг Олон улсын авлигын эсрэг өдөр болгон тэмдэглэж байхаар дэлхий нийтэд зарлан тунхагласан бөгөөд энэ өдөр гишүүн орон бүр Авлигын эсрэг конвенциор хүлээсэн үүргээ сурталчлах, авлигын нийгэм, эдийн засагт учруулах хор хөнөөлийг тайлбарлан таниулах, авлигын эсрэг үйлсэд дуу хоолойгоо нэгтгэх, хүсэл зоригоо илэрхийлэх зэрэг олон талт арга хэмжээг зохион байгуулсаар ирлээ.

Энэ жилийн хувьд Олон улсын авлигын эсрэг өдрийг дэлхий нийтээр “Таны эрх-Таны оролцоо; Авлигад үгүй гэж хэлье” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж байгаа бөгөөд энэхүү уриагаар дамжуулан авлигатай тэмцэх үйлсэд улс орны иргэн бүрийн оролцоог чухалчлан үзсэн тул Та бид өнөөдөр мөн энэ уриан дор чуулж байна.

Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлж, манай улс дотоодын хууль тогтоомжоо Конвенцид нийцүүлэх, авлигатай тэмцэх бие даасан байгууллагыг байгуулах, ил тод, нээлттэй байдлыг хангах, хүнд сурталтай төрийн үйлчилгээнээс татгалзах, иргэний нийгмийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бий болгоход чиглэсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байгаа нь тодорхой үр дүнгээ өгч байна.

Авлигын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагааны чанар сайжирч, нийт шалгасан хэргийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Тухайлбал, 2007-2016 онд жилд дунджаар 200 орчим хэрэг шалгаж байсан бол сүүлийн 3 жилд дунджаар 1300 орчим хэрэг шалгаж байгаа нь даруй 6.5 дахин өссөн

үзүүлэлт юм. Шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн хэргийн тоо болон хохирол нөхөн төлүүлэлтийн байдалд ч мөн эрс өөрчлөлт гарч байна. Тухайлбал, 2019 онд 11.3 тэрбум, 2020 онд 35.6 тэрбум, 2021 онд 96.2 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлээд байна. Үүнд тус байгууллагын алба хаагчдын хичээл зүтгэлээс гадна ард иргэдийн оролцоо, дэмжлэг, хуулийн байгууллагуудын хамтын ажиллагаа нэн чухал байсныг тэмдэглэхэд таатай байна.

Авлига оршин тогтнох шалтгаан, нөхцөлийг арилгах, хууль эрх зүйн орчныг сайжруулах, төрийн үйлчилгээг цахимжуулах, төрийн албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх, хариуцлагыг чангатгахад Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайд анхаарлаа хандуулж, Авлигын индексийг бууруулах ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байгаа нь улс төрийн томоохон хүсэл зоригийн илэрхийлэл болсон төдийгүй авлигатай тэмцэх хамтын ажиллагааг сайжруулахад чухал хөшүүрэг болж байгаа бөгөөд өчигдөрхөн болж өндөрлөсөн эрх баригч намын Их хурлаас авлигатай хийх тэмцлийг улам эрчимжүүлж, авлига, албан тушаалын хэргийн ялын бодлогыг чангатгах зарчмаа тунхагласан нь авлигатай тэмцэх төрийн бодлогын үндэс суурь нь болно гэдгийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Гэвч авлигатай тэмцэх ажлыг улам эрчимжүүлэх шаардлагатайг олон улсын болон дотоодын судалгааны дүн харуулсаар байна. Дэлхийн улс орнуудын авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөж байгааг харьцуулан үнэлгээ гаргадаг Транспарэнси Интернэшнл” төрийн бус байгууллагын Авлигын индексийн судалгааны дүнгээр Монгол Улс 35 оноогоор 111 дүгээр байрт жагссан. Монгол Улсын оноо 2019 оныхоос өөрчлөгдөөгүй хэвээр боловч дарааллын хувьд 5 байраар ухарч эрэмбэлэгдсэн. Энэ дүнг сайжруулахад иргэн, төрийн байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшил болон бусад байгууллагуудын идэвхтэй оролцоо, дэмжлэг, хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай болохыг онцлон дурдахыг хүсэж байна. Хууль эрх зүйн орчин, хууль сахиулах оновчтой тогтолцоо бүрдсэн ч авлигын асуудлыг бүрэн цэгцлэхэд хүндрэлтэй. Учир нь авлигатай тэмцэх, авлигын нарийн төвөгтэй гэмт хэргүүдийг илрүүлэх, олны анхаарлын төвд авчрахад иргэн, хэвлэл мэдээлэл тэр дундаа эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үүрэг оролцоо их юм.

Бид цар тахлын нөхцөл байдалд эдийн засгийн хувьд хүндрэлтэй цаг үеийг туулж байгаа хэдий ч бизнесийн болон өрсөлдөөний шударга орчинг бүрдүүлэх, хөрөнгө оруулагчдын болон олон нийтийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд авлигатай хийх тэмцлийг шинэ шатанд гаргах хэрэгтэй байгааг онцлон тэмдэглэе.

Өнөөдрийн чуулган, салбар хэлэлцүүлэг дээр тавигдах илтгэлийн үзэл баримтлал, оролцогчдын санал зөвлөмж, дүгнэлтүүд авлигатай тэмцэх эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх, олон талт хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэх, хяналт, оролцоог нэмэгдүүлэхэд ашиг тусаа өгнө гэдэгт эргэлзэхгүй байна.

Бид бүхний урилгыг хүлээн авч энд хүрэлцэн ирсэн та бүхэнд дахин талархал илэрхийлээд, энэхүү хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож, санал бодлоо илэрхийлэхийг хүсье.

Чуулганы үйл ажиллагаанд амжилт хүсье.

Таны эрх, Таны оролцоо, Авлигад үгүй гэж хэлье.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР

*Авлигын эсрэг үндэсний чуулганд
оролцогч Та бүхэнд энэ өдрийн
мэндчилгээг өргөн дэвшүүлье.*

Өнөөдөр их сайхан өдөр байна. Авлигатай тэмцэх төрийн бодлого, үндэсний хэмжээний авлигатай тэмцэх тогтолцооны талаар ярилцаж, алдаа оноогоо шүүн хэлэлцээд цаашдын зорилтуудаа тодорхойлох эрхэм зорилго өвөртөлж хүрэлцэн ирсэн Та бүхэнд гүн талархал илэрхийлье.

Монгол Улсын Их Хурал нь авлигатай тэмцэх үндэсний тогтолцоонд чухал байр суурь эзэлдэг институт юм. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлан гаргаад хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэгтэй институт. Ард түмнээ төлөөлж байгаа Улсын Их Хурлын гишүүд авлигатай тэмцэх үйл ажиллагааны эрх зүйн үндэс болсон хуулиудыг шинээр батлах, боловсронгуй болгох, авлигатай тэмцэх чиглэлээр төрийн гадаад, дотоод бодлогын үндсийг тодорхойлох үүрэгтэй ажлуудыг хэрэгжүүлдэг.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дараа бид Улсын Их Хурлын гишүүний тангаргийн үгэнд Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар зориуд тусгаж оруулсан. Улсын Их Хурлын 8 дахь удаагийн сонгуулиар эмхлэн байгуулагдсан шинэ парламентын гишүүд маань тангаргаа сахиж авлигатай тэмцэх үйл ажиллагаанд манлайлан оролцох хүсэл зориг эрмэлзэл дүүрэн байгаа. Тиймээс Улсын Их Хурлын гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатарын санаачилгаар Авлигын эсрэг бүлэг Улсын Их Хуралд байгуулагдан ажиллаж байна. Авлигын эсрэг бүлгийн гишүүд маань авлигын эсрэг эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хуулийн биелэлтэд хяналт тавих, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа. Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төсөл боловсруулж байна. Ер нь нэлээд өргөн хүрээнд авлигын асуудлыг авч үзэх ёстой. Цалин хөлс хангамжаас авахуулаад нөгөө талдаа зөвшөөрлийн хууль, бизнесийн эрх зүйн орчин, цаашлаад шүүх гэх мэт салбар тус бүрийн

хуулиуд авлигаас ангид байх эрх зүйн орчин алга байна. Тиймээс хууль тогтоомжийн боловсруулалтад Авлигын эсрэг бүлэг тэр цонхоор харж хяналт тавих үүрэгтэй.

Улсын Их Хурлын намрын чуулган цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан 5 үндсэн зорилго дэвшүүлж



ажилласны нэг нь засаглалын чадавхыг бэхжүүлэх, сайн засаглал, эрүүл нийгмийг төлөвшүүлэхэд чиглэж байгаа юм. Засаглалын сул дорой байдал нь авлига, ядуурал, ажилгүйдлийн үндсэн шалтгаан болж байна. Энэ нь өөрөө популизмийг хөөрөгддөг, төрийн албыг данхайлгадаг, төрийн албаа дагаж томрох тусмаа авлига, хээл хахууль, хүнд суртал нэмэгддэг. Засаглалаа чадавхжуулаагүй цагт бид ямар ч сайн бодлого, зорилт дэвшүүлээд нэмэргүй. Засаглалыг сайжруулахын тулд төрийн албаны бүх шатанд авлигын үндсийг таслан зогсоох ёстой. Үүний тулд авлигатай тэмцэх ажлыг шинэ шатанд гаргаж, төрийн хүнд суртлыг халах зайлшгүй шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг хийх зорилго дэвшүүлээд байна. Энэ хүрээнд Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагын тухай хуулийн төслийг миний бие Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байх үеэсээ гурван жилийн турш боловсруулсан. Засгийн газрын санал аваад удахгүй хэлэлцэж эхэлнэ. Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагын тухай хууль бол авлигаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих хамгийн сайн сүлжээ, тогтолцоо болно гэж үзэж байгаа.

Мөн дэлхий нийтээр шүгэл үлээх гэж нэрлэдэг нийгэмд бугшсан буруу муу үйлдэл, ёс зүйн доголдол, албан тушаалын гэмт хэрэг, түүний дотор авлигыг илчлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, шударга иргэний эрх ашгийг хамгаалах зорилгоор Засгийн газраас боловсруулж өргөн мэдүүлсэн Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэж байна.

Шүгэл үлээгч буюу мэдээлэгчийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгосноор аливаа гэмт хэрэг, тэр дундаа хууль бус үйлдэл нь далд байдаг авлигын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгахад томоохон ахиц дэвшил гарна гэж бид үзэж байгаа. Хууль бус үйлдлийг илчилсэн, мэдээлсэн шүгэл

үлээгчийг яллах, хариуцлагад татах, дарамтлахыг хориглох, аливаа халдлагаас хамгаалах зохицуулалтууд тусгагдсан. Түүнчлэн мэдээлэгчийг урамшуулах, түүнд шаардагдах санхүүжилтийг бүрдүүлэх асуудал ч энэ хуульд тусгалаа олсон.

Улс төрийн намын болон сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн эрх зүйн тогтолцоо, бодит нөхцөл байдал нь авлигын шалтгаан, нөхцөл дотор ихээхэн жин дарж байгаа нь гадаад, дотоодын судалгааны үр дүнгээр нотлогддог. Иймээс улс төрийн намуудын төсөв санхүүжилт нийтэд ил тод байх зарчимд суурилсан Үндсэн хуулийн заалтыг үндэс болгон хуулийн төслийг Цэрэнжамцын Мөнхцэцэг нарын гишүүд боловсруулж, иргэд олон нийт, эрдэмтэн судлаачид, улс төрийн намуудын төлөөллийг оролцуулсан уулзалт хэлэлцүүлгийг өрнүүлж санал авч байна.

Төрийн эрх мэдлийг иргэдэд ээлтэй байдлаар хэрэгжүүлж, ард түмнийхээ засаглах эрхийг хангахад цахим шилжилт нэн чухал ач холбогдолтой гэж Улсын Их Хурал үзэж байгаа. Төрийн албан дахь авлига, хүнд суртлыг багасгах нэг үндсэн арга нь төрийн үйлчилгээг цахимжуулах явдал юм. Энэ чиглэлээр Зөвшөөрлийн тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай зэрэг хуулийн төсөл, шинэчилсэн найруулгыг энэ намрын чуулганаар хэлэлцэхээр төлөвлөж байна.

Хуулийн засаглалыг бэхжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг эрчимжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгт оноох ял, шийтгэлийг чангатгах, иргэний эрхийг зөрчих явдалтай тэмцэх явдлыг бодитоор хэрэгжүүлэхэд энэ удаагийн чуулганаар хэлэлцэж байгаа Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль чухал алхам болно. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр тусгагдсан Хянан шалгах түр хороо байгуулах зорилго энэ хууль батлагдсанаар бас хэрэгжих болно. Нийгэм, олон нийтийн анхаарал татсан авлига, албан тушаалын томоохон гэмт хэргүүдийг илчлэн шийдвэрлэхэд нийтийн эрх ашгийг хөндсөн тодорхой асуудлуудаар Хянан шалгах түр хорооны үйл ажиллагаа тус дөхөм үзүүлэх болно.

Эрхэм нөхөд өө!

Сайн засаглалыг бэхжүүлж, шударга ёсыг дархлаажуулах, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэж, иргэнээ дээдэлсэн, эдийн засаг нь өсөж, ард түмний амьдрал дэвжсэн шинэ нийгмийг цогцлоох бидний хүсэл эрмэлзэлд хамгийн их саад тотгор болж буй үзэгдэл бол авлига гэдгийг хүн бүхэн мэднэ. Тиймээс улс орны аюулгүй байдалд заналхийлж ардчилсан тогтолцоо, үнэт зүйлсийг доройтуулан хөгжлийг сааруулж төрд итгэх иргэдийн итгэлийг алдагдуулагч

энэ хорт үзэгдэлтэй бүх нийтээрээ тэмцэх итгэл үнэмшил, оролцоо дэмжлэг, хяналтыг нийгэмд бий болгох нь чухал байна.

Авлигын барьцааг ард түмэн ирээдүйгээрээ, улс орон хөгжил дэвшлийн боломжоороо төлдөг гэдгийг мартаж болохгүй.

Манай Улсад улс төрийн авлигын түвшин олигтой буурахгүй, авлигын нөхцөл байдлыг хүн амын тоонд харьцуулан үзэхэд дээгүүр байр эзэлсэн хэвээр байгааг судалгааны дүн харуулж байна. “Транспэрэнси интернэшнл” олон улсын байгууллагаас жил бүр гаргадаг авлигын төсөөллийн индекс ахиц дэвшил гарахгүй байна. Монгол Улсад авлигыг үл тэвчих үзэл бодол, үйл ажиллагаа нийт нийгмийг хамран өрнөж, үр дүнд нь авлига хумигдаж, эрүүл шударга нийгмийг цогцлоох замдаа орсон гэсэн дүгнэлт гарах тэр өдрийн төлөө бодит тэмцэл өрнүүлэх, улам эрчимжүүлэх цаг ирсэн байна.

Иймээс авлигатай хийх тэмцлийг бүх шатанд идэвхтэй өрнүүлж, төрийг авлигаас бүрэн ангид байлгах, бизнесийн болон өрсөлдөөний шударга орчин бүрдүүлэх, авлигачдад хуулийн дарангуйлал тогтоох, улмаар олон нийтийн төрд итгэх итгэлийг сэргээхийн төлөө чин шударгаар хамтран зүтгэхийг та бүхэндээ уриалъя.

Үндэсний чуулганаар эдгээр асуудлуудыг хэлэлцэж, авлигын эсрэг үйл ажиллагаагаа шүүн тунгааж, цаашдын зорилтоо тодорхойлон бодит үр дүн гаргах олон чухал шийдвэр дэвшүүлнэ гэдэгт итгэж байна.

Чуулганы үйл ажиллагаанд амжилт хүсье.

Таны эрх, Таны оролцоо, Авлигад үгүй гэж хэлье.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ УХНААГИЙН ХҮРЭЛСҮХИЙН ИЛГЭЭЛТ

*Эрхэм хүндэт төлөөлөгчид
Эрхэм төрийн албан хаагчид аа!*

Монгол төрийн бодлогын төвд ямагт монгол хүн, монгол айл өрх байж ирсэн билээ. Монгол хүн эрдэм боловсролтой, эрүүл чийрэг, ажил орлоготой, дэлхийн түвшинд өрсөлдөх чадвартай, эх орондоо айх аюулгүй, сэтгэл хангалуун аж төрөх бүх талын боломж нөхцөлийг Монгол төр бүрдүүлэх ёстой. Энэхүү нөхцөлийг бүрдүүлэх нэг үндэс нь төрийн байгууллагууд нь цомхон бүтэцтэй, чадварлаг мэргэшсэн, хариуцлагатай хүний нөөцтэй, хүнд сурталгүй, авлигагүй, тогтвортой бөгөөд ил тод бодлого, үйл ажиллагаатай, төр ба иргэний нийгэм, хувийн хэвшил нь нягт хамтын ажиллагаатай, ажлынхаа үр дүнг ард түмнээрээ дүгнүүлдэг хяналттай байх явдал юм.

Үүний тулд төр засаг, ард түмэн хамтдаа авлигатай эрс шийдэмгий тэмцэх, шийдвэр гаргах үйл ажиллагаанд хүний оролцоог багасгах зэрэг олон арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Энэ нь эцсийн дүндээ хүн биш хууль засагладаг, ардчилсан шударга төртэй байх асуудал бөгөөд ардчилсан шударга төртэй байх гол үндэс нь авлигаас ангид төрийн албыг төлөвшүүлэх явдал гэж үзэж байна.

“Транспэрэнси интернэшнл” олон улсын байгууллагаас зарласан 2019 оны авлигын индексээс харахад Монгол Улс 5 оноогоор 105 дугаарт эрэмбэлэгдэж байсан бол 2020 онд мөн 35 оноогоор дээрх жагсаалтын 5 байраар ухарч 111 дүгээрт эрэмбэлэгдсэн байгаа нь манай авлигатай тэмцэх үйл ажиллагаа дорвитой үр дүнд хүрэхгүй байгааг харуулж байна гэж үзэж байна. Түүнчлэн Монголд төрийн өмчит компаниудын олигархи бүлэглэлүүд нийлэн цөлмөдөг, үйл ажиллагаанд нь авлига их байгааг олон улсын байгууллага тодорхойлсон байна. Ийм учраас төрийн өмчит компаниудын хуулийг батлан гаргах шаардлагатай гэж үзэж байгаа юм.

Мөн улс төрийн намууд хамгийн их авлигажсан институт болж хувирсан тул зайлшгүй хууль эрх зүйн орчны өөрчлөлт хийж, санхүүжилт нь төрөөс гардаг цомхон бодлогын институт болгон өөрчлөх шаардлагатай байна.

Бид авлигын эсрэг тэмцлийг цаг алдалгүй эрчимжүүлж чадваас хууль хүн бүрт тэгш үйлчилдэггүй, нийгмийн баялгаас нэг хэсэг нь хулгайлдаг, ирээдүй хойч үеийнхээ олон боломжийг үгүйсгэх, улмаар энэ байдал даамжирвал цаашид эдийн засгийн тусгаар тогтнолоо алдахыг ч үгүйсгэх аргагүй байна.

Авлига нь Монгол хүнийг, Монгол төрийг, Монгол Улсыг сулруулах аюул занал мөн гэдгийг бид үргэлж санаж, түүнтэй эрс шийдэмгий, системтэй тэмцэх шаардлагатай. Авлигатай тэмцэх нь нэг өдрийн, нэг жилийн, эсхүл нэг Засгийн газрын хийдэг ажил биш. Хүний амьсгалах агаар мэт өдөр тутмын нэн хэрэгцээ шаардлага болж байнга тэмцэж байх үйл явц юм. Ийм үйл хэрэгт төр, төрийн байгууллага, төрийн албан хаагчид түүчээлэх хэрэгтэй гэж бодож байна. Монголын төрд зүтгэж буй хүн бүр авлигаас ангид, чигч шударгаар ажиллаж чадвал авлигатай тэмцэж байгаа ажлын бодит үр дүн болно.

Авлигыг бууруулах, таслан зогсоох нэг суурь нь хараат бус, бие даасан, шударга хууль, шүүхийн байгууллагатай байх явдал юм. Эрх мэдэлтэй, эд хөрөнгөтөйд нь зөөлөн ханддаг, эгэл ардад хатуу ханддаг шүүхийн тогтолцоог өөрчлөхийг иргэд хүсэж байна.

Шүүх, прокурор, хуулийн байгууллагын албан хаагчид бизнесийн явцуу эрх ашиг сонирхолд автдаггүй, улс эх орныхоо язгуур эрх ашгаас урвадаггүй, хэн нэгний дарамт шахалт, даалгавраар гэм зэмгүй нэгнийг хэлмэгдүүлдэггүй, авлигач гэмт этгээдийг ял завшуулдаггүй байх нь нэн чухал юм.

Саяхныг болтол улс орнууд авлигын эсрэг асуудлыг дотооддоо дангаараа шийдвэрлэхээр зорьж, тал бүрийн арга хэмжээ авч байлаа. Гэвч улс үндэстнүүдийн харилцаа, бизнес өргөжин тэлж байгаатай холбоотойгоор авлига хил дамнасан, дэлхий нийтийн шинж чанартай болсон байна. Тийм учраас Нэгдсэн Үндэсний Байгууллагаас Авлигын эсрэг Конвенцийг баталж, мөн авлигын эсрэг олон улсын өдрийг тэмдэглэж байхаар шийдвэрлэсэн нь авлига хэр ноцтой, хэр өргөн цар хүрээтэй, хүн төрөлхтний өмнө шийдэл хүлээсэн тулгамдаж байгаа асуудал болохыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, хамтран тэмцэх шаардлагатай байгаагийн нотолгоо юм. Нэг үгээр хэлбэл, авлигатай тэмцэх нь дэлхий нийтийн үйл хэрэг болоод байна.

Монгол Улсын хувьд 2005 онд Авлигын эсрэг Конвенцийн үзэл санааг хүлээн зөвшөөрч, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө үүрэг хүлээн тус Конвенцид нэгдэн, дэлхий нийтийн авлигатай тэмцэж байгаа тэмцэлд өөрийн хувь нэмрээ оруулж байгаа.

Түүнчлэн манай улс 2017 онд Авлигатай тэмцэх олон улсын стандартыг үндэсний стандарт болгож баталсан анхны улс болсон юм.

Төрийн тэргүүний хувьд авлигатай тэмцэх бүх нийтийн үйл хэрэгт нэгдэж, манлайлан оролцох нь зүй ёсны хэрэг бөгөөд Монгол төр, хууль ёсоо дээдлэн, төрийн албан хаагчид нь хуульд захирагддаг, хуулийн хэрэгжилтийг хангахын төлөө хоёргүй сэтгэлээр ажилладаг байж сая шударга журмыг сахиулах, иргэд хуулийг дээдэлдэг болох учиртай.

Ард түмний эв нэгдэл, нийгмийн тогтвортой байдал шударга ёс дээр тогтдог тул чуулганд оролцогч Та бүхэн ухаан бодлоо уралдуулж, идэвх зүтгэл гарган авлигатай тэмцэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Авлигын эсрэг үндэсний чуулганд өндөр амжилт хүсье.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ

Авлигын эсрэг үндэсний чуулганд оролцож байгаа эрхэм хүндэт төлөөлөгчид та бүхэнд энэ өглөөний мэндийг дэвшулье.

Монгол Улс авлигын индексээр 35 оноо авч дэлхийд өнөөдөр 111-т эрэмбэлэгдэж байгаа нь туйлын хангалтгүй үзүүлэлт юм. Тийм ч учраас бидний хувьд нэн яаралтай төрийн хүнд суртлыг багасгаж, авлигын индексийг шат дараалан бууруулж, алдаж байгаа оноон дээрээ дүгнэлт хийх зайлшгүй шаардлага байна гэж үзэж байна.

Монгол Улсын Засгийн газрын тэргүүний хувьд “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх эхний 10 жилийн дотор Монгол Улсын хөгжилд саад болж буй боомилгогч хүчин зүйлүүдийг багасгах, устгах зорилтыг дэвшүүлж байгаа.

Судалгаагаар Монгол Улсын хөгжилд хамгийн их саад болж байгаа 6 хүчин зүйл гарч ирсэн. Мэдээж далайд гарцгүй орны хувьд боомтынхоо хүчин чадлыг нэмэх, Монгол Улсын эрчим хүчний салбарыг шинэ түвшинд гаргах, Монгол Улсын аж үйлдвэржилтийн салбар буюу бүтээн байгуулалтын салбараа богино хугацаанд өөд нь татах зэрэг олон асуудлууд байна.

Харамсалтай нь судалгаагаар төр өөрөө, төрийн хүнд суртал, тэр дундаа төрийн анхан, дунд шатны байгууллага, тэр дундаа нийслэл Улаанбаатар хот, яамд нь өнөөдрийн Монгол Улсын хөгжлийг чөдөрлөж, хязгаарлаж, цаг алдуулж байгаа, тодорхойгүй болгож байгаа, ойлгомжгүй болгож байгаа хамгийн гол хүчин зүйл өөрөө болж байна гэсэн ийм дүгнэлтэд ажлын хэсэг болон судалгааны багийнхан хүрсэн.

Хэрвээ бид Монгол Улсын эдийн засгийг сэргээе гэвэл, хэрвээ бид эрчимжсэн хөгжил рүү очье гэвэл, бид эрүүл мэнд, боловсролын тогтолцоог

шинэ түвшинд гаргая гэвэл, бид хөрөнгө оруулалт хайхаас илүүтэйгээр бид өөрөө өөртөө шүүмжлэлтэй хандаж сурах хэрэгтэй.

Бид дасчихсан сэтгэлгээ, уламжлалт асуудлуудыг шийдвэрлэх нүдний шилээ өөрчлөх цаг болсон байна. Өнөөдөр Монгол Улсад мөнгөгүйгээр шийдэх, төрийн бүтээмжээ сайжруулах олон асуудлууд байгаа.

Би зүгээр нэгэн жишээг сүүлийн үед их дурдаж байгаа. Монгол Улс өвлийн улиралтай, дөрвөн улиралтай, бүтээн байгуулалтын ажлууд хавар эхэлдэг. Гэтэл аж ахуйн нэгжүүдэд юу тохиолддог вэ? Төсөв батлагдах гэсээр байтал 11 дүгээр сарын дунд үе хүрдэг. Үүний дараа орон нутгийн төсөв батлагддаг. Нэгдүгээр сард тендер зарлаж, шалгаруулах буюу маш хүнд процесс эхэлдэг. Энэ нь үргэлжилсээр цагаан сарын ард очиж, гуравдугаар сарын дундуур идэвхжиж, зургаадугаар сар, долдугаар сар хүртэл үргэлжилдэг.

Дараа нь шүүхийн процесс дээр очдог. Сангийн яам дуудна, шүүх дуудна, хууль хяналтын байгууллагууд дуудна. Ингээд гацаа эхэлдэг. Шүүхийн гурван шатны процессоор шийдвэр гаргуулахын тулд нэг аж ахуйн нэгж багадаа жил 6 сар орчим хугацааг зарцуулдаг. Харамсалтай нь сүүлийн үед аж ахуйн нэгжүүд дээр хувийн компаниуд очиж, хэрвээ бид нар маргаан үүсгэхгүй бол та нар бид нарт шан харамж өг гэдэг. Бүр авлигын бүхэл бүтэн тийм өмгөөллийн фирмүүд гарч ирсэн. Энэ хэнээс болж байна вэ?

Биднээс, бид яагаад энэ цаг хугацааг хамтдаа яриад өөрчилж болохгүй гэж. Энэ асуудлыг бид ярих хэрэгтэй. Эрх зүйн цогц шинэчлэл эндээс эхлэх учиртай. Шүүхийн процессыг яагаад бид энгийн ойлгомжтой болгож болохгүй гэж!

Өнөөдөр энд манай хууль хяналтын байгууллагын олон удирдлагууд, манай шүүх, прокурорынхон сууж байна. Бид нар асуудлыг зөвхөн манай байгууллагын гэдэг өнцгөөс харахад л энэ цогц биш болж байгаа юм. Бид асуудлыг бүхэлд нь харах хэрэгтэй. Төр бүтээмжээ хэрхэн сайжруулах хэрэгтэй вэ?, Монгол Улс цаашаа нэг алхахад бид яаж дэмжих вэ? гэдэг сэтгэл зүйгээр хандаж сурах цаг болсон. Тэгэхгүй бол шат шатандаа энэ миний орон зай, энэ миний албан тушаал, энэ миний эрх зүйн орчин, энэ гүйцэтгэх засаглалын орчин, энэ хууль тогтоох засаглалын орчин, энэ хууль хяналтын байгууллагын орчин гэдэг энэ агуулга маань өөрөө гацчихаад байна.

Мөн хууль батлахын өмнө хувийн хэвшил, олон нийттэй маш дэлгэрэнгүй ярьдаг тогтолцооны шинэчлэл рүү орох хэрэгтэй. Монгол Улсад хууль маш хурдан батлагдаж байна. Тийм учраас сонгодог парламентын засаглал руу цаг алдалгүй орох шаардлагатай. Хууль маш чанартай батлагддаг, тэр нь олон нийтэд, хувийн хэвшилд, иргэнд, хөрөнгө оруулагчдад ойлгомжтой байх ёстой.

Энд нугалаа үүсдэг, нугалааны ард авлига, хүнд суртал үүсдэг, ойлгомжгүй байдал бий болдоггүй байх ёстой. Аливаа тайлбар бүрийн цаана авлига бий болж байна. Тийм учраас бид авлигатай тэмцэх тэмцлээ зөвхөн авлигын хөрсөн дээр ургасан хогийн ургамлуудыг таслах биш, хогийн ургамал ургаж байгаа хөрсийг устгах тал руу харах нь туйлын чухал юм.

Энэ ч агуулгаар Монгол Улсын Засгийн газраас гүйцэтгэх засаглалын хувьд авлига, хүнд суртлыг багасгаж, төрийн бүтээмжийг сэргээх, цахим шилжилт хийх асуудлаар үндэсний хороо байгуулж, Ерөнхий сайдын хувьд биечлэн ахалж байгаа.

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд чамлахааргүй олон үр дүн, үзүүлэлтүүд гарсан. Энэ танхимд өнөөдөр олон улсын донор байгууллагуудын төлөөлөл, гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдууд хүрэлцэн иржээ. Та бүхэн маань Монгол Улсад тусалж, хамтран ажиллаарай, түншлэн ажиллаарай.

Бидэнд авлигын индексийг бууруулах, авлигатай тэмцэх, төрийн хүнд суртлыг арилгах, төр өөрөө гацаагч биш, хөгжлийг чөдөрлөгч биш, төр харин дэмжигч, сэдэлжүүлэгч байх чин эрмэлзэл байна. Тиймээс энэхүү чин эрмэлзлэлийг бодитой ажил хэрэг болгохын тулд дор дороо хичээж ажиллах нь туйлын чухал юм.

Цаашид хийх ажлууд дээр хэд, хэдэн саналаа хэлье. Жишээлбэл, цахим шилжилт. Цахим шилжилт нэг жилийн өмнөөс идэвхжсэн Өнөөдөр хүнд суртал үүсгэсэн төрийн 512 орчим үйлчилгээг e-Mongolia цонхонд нэгтгэж чадсан. Газрын зөвшөөрлөөс эхлээд ирэх 7 хоногт эрүүл мэндийн салбарт цаг авдаг системүүд үндсэндээ цахимжина. Нэг үгээр хэлбэл, төрийн үйлчилгээ авахад төрийн албан хаагчийн оролцоо байхгүй, оролцоо багасна. Энэ нь тухайн хүний авлига авах, нугалаа үүсгэх, өөрийн үзэмжээр хандах зэрэг асуудлыг таслан зогсооно.

Цахим шилжилтийн асуудал үргэлжилж, ашигт малтмалын салбар, хяналт шалгалтын тогтолцоо ч цахимжих ёстой. Төрийн худалдан авалтын процессыг цахимжуулна. Хэрвээ шалгуур хангасан бол заавал түүнийг ажлын хэсэг гарч үнэлдэг биш, шалгуур хангасан бол тэр байгууллага автоматаар үнэлэгддэг тогтолцооны шинэчлэл рүү цаг алдалгүй орох учиртай. Энэ ажилд хууль хяналтын байгууллага, шүүх, прокурор, хувийн хэвшил, худалдаа аж үйлдвэрийн танхим, мөн олон улсын байгууллагууд хамтарч ажиллах хэрэгтэй.

Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин сайжрах ёстой. Шүлүухан хэлэхэд, хөрөнгө оруулагчид Монголд ганцхан тохиолдолд л тогтвортой хөрөнгө оруулна. Энэ нь шүүх хэнээс ч хараат бус гэж итгэсэн тохиолдолд л тэд хөрөнгөө оруулна.

Яагаад Швейцар Улсад, яагаад Сингапур Улсад, яагаад Америкийн Нэгдсэн Улсад хөрөнгө оруулалт илүү тогтвортой байна вэ? Тэнд улс төрчдөөс үл хамаарсан шүүхийн тогтолцоо байгаа гэж итгэдэг учраас тэд хөрөнгөө оруулж байгаа. Тиймээс өнөөдөр хөрөнгө оруулалт хийхийг уриалахаас илүү манай шүүх хараат бус гэж нүүр бардам хэлж чаддаг байх ёстой. Манай хууль хяналтын байгууллага авлигач биш гэж хэлж чаддаг байх ёстой. Манай төр засаг танаас хууль бус шан харамж авахын тулд зориудаар хүнд суртал үүсгэдэггүй гэж хэлж чаддаг байх ёстой.

Энэ тохиолдолд бид Та Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх, том төслүүдийг хөдөлгөх, 10 жилийн, 20 жилийн тогтвортой гэрээ хийх саналыг тавихдаа итгэл дүүрэн, нүүр бардам байж чадна.

Хөгжлийг боомилгоч хүчин зүйл бидэнд өөрсдөд маань байна. Энэ бүх зүйл дээр хамтдаа эрх зүйн цогц шинэчлэл хийх асуудлыг идэвхжүүлэн эхлүүлье.

Цахим шилжилтийг Ерөнхий сайдын хувьд бүх талаар дэмжих болно. Өнөөдөр та бүхэн хуралдаад хамгийн хүндрэлтэй байгаа цахим шилжилтийг хэрхэн хийх вэ гэдэг саналаа гаргаад гүйцэтгэх засаглалд өгөөрэй.

Аль асуудал хамгийн хүндрэлтэй байна. Тэрийг бид цахимжуулья, аль асуудал хамгийн амаргүй байна, шийдэл гаргая, цахимжуулья.

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд e-Mongolia цонхонд нэгдсэн төрийн үйлчилгээ болон хандалттай холбоотой гарч буй хурдыг авч үзвэл, бид 2024 он гэхэд төрийн хүнд сурталтай байгаа үйлчилгээний 90-ээс доошгүй хувийг бүрэн цахимжуулах боломж байна гэдэг нь харагдаж байгаа.

Бид Эстони, Энэтхэг улсын Засгийн газар, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Монголд гарч байгаа цахим шилжилт бусад улстай харьцуулахад хурдтай байна гэж үзэж байгаа. Яагаад гэвэл, бидний хувьд хүн ам цөөхөн, хүн амын дийлэнх нь залуучууд, бүгдээрээ цахим ертөнцөд туйлын идэвхтэй. Бусад улсаас бид хэрэглээгээ илүү хурдан болгох боломжтой. Богино хугацаанд нийгмийн бугширсан соёлыг өөрчлөх боломжтой. Өөдрөг аливаа шинэ зүйлд дасан зохицоходоо туйлын амархан ард түмэн. Тийм учраас цахим шилжилтийг хийх ажлаа илүү идэвхжүүлье гэж хэлэхийг хүсэж байна.

Тендерийн хуультай холбоотой асуудлуудыг багцаар нь эргэн харж, үүнийг шүүхийн процесстой уялдуулж шийдвэрлэх нь илүү чухал гэж үзэж байна.

Мөн авлига, албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг татвартай уялдуулах нь илүү оновчтой. Хэн татвар төлж байна. Татварын бүртгэлийн системтэй хөрөнгө, орлогын мэдүүлгийг уялдуулдаг байх шинэчлэл рүү явбал энэ илүү ойлгомжтой болно гэж итгэж байна.

Авлигатай тэмцэхдээ төрийн бүтээмжид саад болж байгаа хүчин зүйлүүдийг ч бодох ёстой. Жишээ нь, өнөөдөр эрчим хүчний салбарт эрчим хүчний салбарын хүн ажиллаж чадахгүй. Барилга хот байгуулалтын салбарт барилга, хот байгуулалтын салбарын хүн ажиллаж чадахгүй. Зам тээврийн яаманд замын мэргэжлийн хүн ажиллаж чадахгүй болж байна. Яагаад гэхээр, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хянан үзэх явцад тухайн салбарт, хувийн хэвшилд ажиллаж байгаа хүнийг ашиг сонирхлын зөрчилтэй байж болзошгүй гэсэн дүгнэлт гардаг. Энэ нь төрийн бүтээмжид чөдөр саад болж байна. Тухайн салбарын хамгийн сайн мэргэжилтэн тухайн салбартаа ажиллаж болно. Гэхдээ тэр хүн авлигад өртөхгүй байхыг л тодотгож өгмөөр байна. Өнөөдөр Эрчим хүчний яаманд барилгын, Барилга, хот байгуулалтын яаманд эрчим хүчний, Зам, тээврийн хөгжлийн яаманд өөр салбарын хүмүүс ажиллаж байгаа нь дэлхийд ч түгээмэл асуудал юм.

Тиймээс бидний авлигатай хийх тэмцэл маань илүү хөрсөндөө буусан бодитой байх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Том зургаар харвал, бид төрийн бүтээмжийг гацаагч биш, сайжруулагч тал руу явмаар байна. Төрийн албан хаагчид өөртөө итгэлтэй, ажлаа сайн хийж чаддаг, авлига, ашиг сонирхлоос ангид байх нь туйлын чухал юм. Монгол Улсын төр 1000 гаруй тусгай зөвшөөрлийг олгож байгаагийн дийлэнх нь нийслэлээс олгогддог. Тусгай зөвшөөрөл бүрийн цаана гарын үсэг, гарын үсэг бүрийн цаана албан тушаалтнууд, тэдний цаана тодорхой хэмжээний эрх ашиг бий. Энэ бол нууц биш. Үүнийг таслан зогсоохын тулд тусгай зөвшөөрөл олоход төрийн байгууллагаас шаарддаг техникийн нөхцөлийг 50 хувиас доошгүй болгож багасган цахимжуулья.

Та бүхэн авлигын хөрсийг хэрхэн багасгах вэ гэдэгт анхаарлаа хандуулна уу. Мөн Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон бусад донор байгууллагуудаас уриалахад Монгол Улсад хамгийн их хүнд сурталтай ямар үйлчилгээ байна, үүнийг үүсгэж буй хүчин зүйлсийг судлан тодорхойлох олон улсын экспертүүдийг бидэнтэй хамтран ажиллахад дэмжлэг үзүүлнэ үү. Яагаад гэвэл, бид дэлхийн хамгийн сайн туршлагуудыг цаг алдалгүй авч, тусгаж ажиллах нь чухал байна.

Төрийн хяналт шалгалт, төлөвлөгөөт шалгалтыг багасгацгаая.

Татвар, нийгмийн даатгал, мэргэжлийн хяналт, цагдаагийн байгууллагын зэрэг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтуудын тоог багасгая. Өнөөдөр аль нэг улсын байцаагчийг хоолонд оруулахгүй бол тухайн ресторан ажиллаж чадахгүй нөхцөл байдалд байгаа нь үнэн. Ялгаатай ханддаг. Төрсөн өдрөө тэмдэглэж байгаа зарим нэг хууль сахиулагч аль нэг хувийн хэвшлийн

ресторанд үнэгүй хоол иддэг нөхцөл байгаа нь бодитой шүү дээ. Энэ бүхнийг бид авлига гэж харах ёстой. Энэ нь байдаг л юм шиг, байх ёстой юм шиг бодож болохгүй ээ. Өнөөдөр манай төрийн байгууллагын албан тушаалтнууд дунд сарынхаа цалингаас хэд дахин үнэтэй бэлэг, шан харамж авдаг тохиолдол бий, тэр нь байх ёстой зүйл гэж боддог нийгмийн соёл байгаад байна.

Үүнийг л бид хамтдаа сэтэлж гарах учиртай. Үүнийг сэтэлж гарахын тулд бид Шүгэл үлээгчийн хуулийг зайлшгүй богино хугацаанд батлах шаардлагатай болоод байна. Шүгэл үлээнэ гэдэг бол, авлигын талаар мэдээлэл өгнө гэдэг бол, авлигад өртөж болзошгүй албан тушаалтныг илчилнэ гэдэг бол, нийгэмд гавьяа байх сэтгэл зүй рүү орох хэрэгтэй. Энд матаач, хэн нэгний мууг үздэг хүн гэдэг агуулгаар ханддаг хандлагаа өөрчлөх хэрэгтэй. Авлигыг илчилж, шүгэл үлээснээр нийгэмдээ хувь нэмэр оруулсан, идэвхтэй эх оронч иргэн гэдэг хандлагыг бий болгох нь зүйтэй. Ингэж л авлигыг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйг бүрдүүлэх учиртай юм.

Төрийн өмчит үйлдвэрийн газруудын үр ашиг, засаглалыг сайжруулж олон нийтийн хяналтад оруулах тогтолцооны шинэчлэл рүү бидний хувьд цаг алдалгүй орох учиртай.

Улс төрийн намын санхүүжилтийн асуудал байна. Энэ талаарх хуулийн төслийг боловсруулах чиглэлээр ажиллаж байгаа Ц.Мөнхцэцэг гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо нар энд сууж байна. Үүнийг дахиад бид төрийн бүтээмж талаас нь харах хэрэгтэй. Асуудлыг цогцоор нь харахгүй, шийдэхгүй учраас зохисгүй бусад асуудлууд үүсэж байгаа юм. Жишээлбэл, цар тахалтай холбоотой асуудал бол зөвхөн эрүүл мэндийн салбарын асуудал биш. Энэ нь соёлын салбарын, нийгмийн салбарын, боловсролын салбарын, эдийн засгийн салбарын, олон улсын, дипломат ёсны асуудал. Бүх асуудлууд хоорондоо уялдахгүй бол үр дүн гарахгүй.

Яг үүнтэй адилхан авлигагүй нийгэм, бүтээмжтэй төр гэдэг бол өөрөө цогц ойлголт. Төрийн байгууллага албан тушаалтан бүхэн хамтдаа харах өнцгөө нэг болгохгүй бол үр дүнд хүрэхгүй. Дор дороо л ажиллана. Тэр зүйл нь нэг зүйлд төвлөрөхгүй. Нэг үгээр хэлбэл, хэн нэгэн нь цавуу зуураад, хэн нэгэн нь мод хөрөөдөөд, хэн нэгэн нь олс авчраад усан онгоц босгож чадахгүй гэсэн үг. Харин хамтдаа усан онгоцоо хийж, далайд хэрхэн хөвөхийг харж чадвал бид аяндаа тэр бүтээн байгуулалтыг босгоно. Тийм учраас авлигын эсрэг тэмцэл, авлигагүй нийгэм, хүнд сурталгүй төр, бүтээмжтэй төрийн тухай төсөөллөө ойлгуулах нь чухал юм.

Үүнд гүйцэтгэх засаглалын тэргүүний хувьд ч, эрх баригч намыг удирдаж байгаа намын даргын хувьд ч та бүхэнтэйгээ нягт хамтарч ажиллана. Мөн

бусад улс төрийн хүчнүүдтэй, иргэний нийгмийн байгууллагуудтай, хувийн хэвшлийнхэнтэйгээ ч нягт хамтарч ажиллана.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйг дэмжих хэрэгтэй. Сэтгүүлчид авлигатай холбоотой асуудлыг баримттай гаргаж тавих, хэвлэл мэдээллийнхнийг энэ чиглэлээр бэлтгэх, think.tank-уудтай хамтарч ажиллах, эрэн сурвалжлах дэлхийн том байгууллагуудтай хамтарч ажиллах, энэ түвшин рүү гарахад бид нар хэвлэл мэдээллийн байгууллагуудыг, сэтгүүлчдийг бэлтгэхэд анхаарах хэрэгтэй.

Сэтгүүл зүй хөгжих тусам, сэтгүүл зүй илүү дүгнэлттэй, анализтай болох тусам тэнд нийгэмд зөв ойлголт өгөх гүүр үүснэ. Зөв ойлголт өгөгдөх тусам нийгэм авлигыг үл тэвчих сэтгэл зүйтэй болно. Энэ асуудал үүсэх тусам төр өөрөө даган өөрчлөгдөх цогц хамааралтай гэж үзэж байгаа юм. Тийм учраас энэ асуудлыг бидний хувьд хийх нь зүйтэй.

Авлига, албан тушаалын гэмт хэргийн ялын бодлогыг чангатгах асуудлыг өнөөдөр Та бүхэн маань бас ярих байх. Миний хувьд үүн дээр санал нэг байдаг. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн хүн, ял авсан хүн 4, 5 жилийн дараа буцаад төрийн албаны нэг дарга болдог тогтолцоог нийгэм хүлээн зөвшөөрөх боломжгүй. Тэрбум төгрөгийн авлига авсан хүн 100 сая төгрөгийн торгууль төлөөд ялаас мултардаг эрх зүйн орчныг өөрчилж, олон улсын жишигт нийцүүлэх шаардлагатай. Нэг үгээр хэлбэл, ялын бодлого авлига дээр илүүтэй чанга байх учиртай.

Тэгэхгүй бол авлига авсан хүн амьдралаа маш хялбархнаар шийдэж болдог юм гэсэн ойлголтыг нийгэмд өгч байна. Өөрийн орлогоос, өөрийн цалингаас илүү тансаг хэрэглээтэй болчихсон төрийн албан тушаалтнуудыг хэрвээ хөрөнгөө нотолж чадахгүй бол хөрөнгийн асуудлыг хэрхэх талаарх эрх зүйн шинэчлэлийг ч бид хамтдаа хийх учиртай. 1,5 сая төгрөгийн цалинтай төрийн албан хаагч өнөөдөр ЛандКруйзер, Лексус-570 унаж, 2 давхар хауст амьдарч, хамгийн үнэтэй цаг зүүж, хамгийн үнэтэй брэндээр хувцаслаж, улирал бүхэн гадагшаа явж тансаглан казино тоглож байгааг 5 сая төгрөгийн цалинтай хувийн хэвшлийн байгууллагад чин сэтгэлээсээ ажиллаж байгаа шилдэг менежерүүд юу гэж ойлгох вэ?

Монголд бизнес хийснээс илүү төрийн дунд шатанд дарга хийсэн нь илүү юм байна гэсэн сэтгэхүй үүсвэл хаачих вэ?

Өнөөдөр Монгол Улсын ажиллах насны иргэдийн 4 хүн тутмын нэг нь төрөөс ямар нэг хэмжээгээр цалин авч байна. Харамсалтай нь цалин хангалттай биш.

Шинэ Үндсэн хуулийг 1992 онд батлан хэрэгжүүлж ирснээс хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд манай төрийн системд бүтэн тогтолцооны шинэчлэл хийгдээгүй явж байна. Зарим хууль нь Германаас шууд авчирч хуулбарласан хуулиуд, түүнийг дагасан тогтолцоо. Зарим нь Америкийн Нэгдсэн Улсаас шууд авчирч хуулбарласан хуулиуд, түүнийг дагасан тогтолцоо. Зарим нь хуучин Зөвлөлт Холбоот Улсын үеэс уламжлагдан ирсэн тогтолцоо, цаашдаа салах ёстой.

Өнөөдөр манайх шиг төрийн гурван институц нэг ордонд референтүүдтэйгээ нийлээд дээд, доод давхарт байж байдаг улс дэлхийд байхгүй. Хууль тогтоох засаглал, гүйцэтгэх засаглал, шүүх засаглал салах ёстой. Ялгаа заагтай. Бид хоорондоо уулзах уулзалт протоколоор олон нийтэд ил байх учиртай.

Энэ бүх зүйлүүдийг бид хамтдаа хийж, өнгөрсөн 30 жилд тэр бүр ярьж чадаагүй зүйлүүдээ ярьж хурлын тоог нэгээр нэмдэг биш, шийдлийн тоог нэжгээдээр нэмдэг болох хэрэгтэй.

Тийм ч учраас авлигын эсрэг энэхүү чуулган олон талаар шинэ зүйлийг авчрах, шинэ хандлагыг авчрах байх гэдэгт итгэлтэй байна.

Бид авлигагүй нийгмийг цогцлоож чадсан цагт хөгжлийн зорилтуудаа хэрэгжүүлж, төр тунгалагшин, эдийн засгийн цусны эргэлт нэмэгдэж, иргэдийн амьдралын чанар, хүний хөгжлийн үзүүлэлтүүд бодитоор сайжирна гэдэгт итгэлтэй байна.

Таны эрх, Таны оролцоо, Авлигад үгүй гэж хэлцгээе.

Иргэн, аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагч, гүйцэтгэх засаглал, хууль тогтоох засаглал, шүүх засаглал, хууль хяналтын байгууллагууд ард түмэнтэйгээ нэг байж тулгамдаад байгаа, хөгжлийг боомилгоч хүчин зүйлсийг хамтдаа нурааж, авлигагүй нийгмийг бүрдүүлэхийн төлөө хамтдаа зүтгэцгээе.

Авлигыг үл тэвчих цоо шинэ хандлага, цоо шинэ соёлыг хамтдаа бүрдүүлье гэж та бүхэнд уриалж байна.

Баярлалаа.

Чуулганы үйл ажиллагаанд амжилт хүсье.



ДЭЛХИЙН БАНКНЫ МОНГОЛ ДАХЬ СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧ АНДРЕЙ МИХНЕВ

*Эрхэм хүндэт Ерөнхийлөгч,
Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд,
Төрийн байгууллагуудын дарга,
удирдлага, хамтран зүтгэгчид,
Хувийн хэвшил, бусад олон улсын
байгууллагууд, иргэний нийгмийн
төлөөлөгчид, хүндэт зочид, хатагтай, ноёдоо!*

Дэлхий нийтийн өмнө тулгамдсан, ярвигтай бөгөөд олон талыг хамарсан асуудал болох авлига, түүнтэй тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч Монгол Улсын гол байгууллагуудын төлөөллийг нэг дор цуглуулсан энэхүү “Авлигын эсрэг үндэсний чуулган”-аар Та бүхэнд хандаж үг хэлэх болсон минь нэр төрийн хэрэг юм.

Дэлхийн банкнаас гаргасан “Дэлхий нийтийн үр ашигт ажиллагаа, ил тод байдлыг сайжруулах нь: Авлигын эсрэг тэмцэл” судалгаанд сорил бэрхшээл тулгарсан үед ч ахиц дэвшил гарах боломжтойг онцлон дурджээ. Энэхүү тайланд орсон олон тооны кейсүүдээс үзэхэд улс төрийн хүсэл зориг, манлайлал байсан цагт тодорхой асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн, оппортунист үйл ажиллагаанаас амжилтын түүх төрөн гарч байсныг харж болно. Ийм үйл ажиллагаа нь эхэндээ хязгаарлагдмал үр нөлөөг үзүүлдэг боловч цаашдын үйл ажиллагааны хөрс суурийг бүрдүүлдэг. Эдгээр амжилтын түүхүүд нь тухайн улсын нөхцөл байдалд тохирсон арга хэрэгсэл, эхлэлийн цэг, зөв арга барилтайгаар ажилласан цагт төрийн байгууллагын албан тушаалтнууд нь иргэний нийгэм болон бусад оролцогч талуудын хамтаар өөрчлөлтийг бий болгож, авлигатай тэмцэхэд дэвшил авчирч чадна гэдэг итгэл, найдварыг бидэнд өгч байна.

Монгол Улс нь сүүлийн арван жилийн хугацаанд засаглалын чиглэлээр мэдэгдэхүйц амжилт гаргасан нь хариуцлагын тогтолцоо, хяналт шалгалтын байгууллагуудыг бэхжүүлэх, иргэдэд түргэн шуурхай үйлчилгээг үзүүлэх зорилго бүхий нийтийн албаны ил тод, үр ашигт ажиллагааг сайжруулах

чиглэлээр цаашдын ахиц дэвшлийг авчрахад ихээхэн хувь нэмэр оруулахаар байна.

Авлигатай тэмцэх үйл ажиллагаа үргэлжилсээр байна, бид бүрэн амжилтад хүрэх цаг болоогүй байгаа боловч төсвийн ил тод байдал нэлээд сайжирч, иргэний нийгмийн байгууллагууд төрийн байгууллагуудаас хариуцлагаа дээшлүүлэхийг шаардах нь ихэссээр байна.

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн шийдлийн гүйцэтгэх үүрэг чухал. Тухайлбал, төрийн үйлчилгээг цахимжуулах, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн цахим системийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зэрэг ажлууд нь уг зорилгод хүрэхэд чухал нөлөөг үзүүлэх юм. Гэвч технологийн боломжийг бүрэн ашиглахын тулд Монгол Улс нь цахим төрийн үйлчилгээтэй холбоотой эрх зүйн орчныг сайжруулан, цахим системүүдийн хуваагдлыг багасгаж, нийтийн албаны үйл ажиллагаа, үйлчилгээг иргэдэд хүргэх интернэт орчны програм хангамжуудыг хөгжүүлэх шаардлагатай байна. Магтууштай нь эдгээр шинэтгэлийн асуудлуудыг төр хүлээн зөвшөөрч, зохих бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдэд тусгасан тул зорилтот үр дүнд хүрэхэд чиглэсэн үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Монгол Улс нь бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлж, институтын хүчин чадлаа бэхжүүлж, авлигатай тэмцэх замаар урагшилж байгаа энэ үед бидний хүрэх амжилт нь тухайн улсын эдгээр асуудлуудыг шийдвэрлэх эрмэлзэл бүхий эвслийг байгуулж, харилцан ойлголцлыг бий болгох чиглэлээр ажиллах чадавхаас ихээхэн шалтгаалдаг. Иймд Засгийн газрын зүгээс гүйцэтгэх, хууль сахиулах байгууллагууд болон иргэний нийгэм, хувийн хэвшил зэрэг бусад оролцогч талуудын дотроос манлайлагчдыг олж, тэдний оролцоог нь хангах арга хэмжээ авах шаардлагатай байдаг. Ийм эвсэл, харилцан уялдаа холбоо бүхий хүчин чармайлт нь мэдээлэл солилцох, бодлогын үйл ажиллагааг тодорхойлох, тэдгээрийн хэрэгжилтийг хянаж, дэмжлэг үзүүлэх хөрс суурийг бүрдүүлдэг. Эвслийн ач холбогдлыг таниулж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, технологиор дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэх, авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар тайлагнах нь хариуцлагаас зайлсхийх явдлыг зогсоох, иргэдийн зүгээс бүх нийтийн үүрэг хариуцлага болох авлигатай тэмцэхэд оролцох оролцоогоо ухамсарлах үзлийг бий болгоход чухал ач холбогдолтой.

Бид түүх, ёс заншил, улс төрийн соёл зэрэгт гүн суусан байж болзошгүй авлигын хувирамтгай шинж чанарыг дутуу үнэлж болохгүй. Иймд шинэтгэлийг хэрэгжүүлэгчдийн нөлөөллийн хүрээ нь тэдний улс төрд нөлөөлөх эрх мэдлийн

түвшнээр хязгаарлагддаг тул авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүн ихэвчлэн урт хугацааны дараа гардаг. Гэвч бид олон улсын индекс, зэрэглэл, иргэдийн төсөөлөлд зохих хугацааны дараа үр дүн гарах хүртэл асуудлыг хариуцан шийдвэрлэж, өөрчлөлтийг авчрахын төлөө хүчин зүтгэх нь чухал билээ.

Эцэст нь, Монгол Улс Дэлхийн банканд гишүүнээр элссэний 30 жилийн ой тохиож буй энэ үед хамтын ажиллагааныхаа талаар эргэцүүлэн бодож, цаашид хэрэгжүүлэх ажлынхаа талаар төлөвлөх боломж бидэнд олдож байна. Тус улс нь 2050 онд өндөр орлоготой улс болох зорилго тавьж байгаа тул Дэлхийн банк нь Монгол Улстай хүний хөгжлийн дээд түвшинд хүрэх, амьдралын чанарыг ахиулах, эдийн засгийг төрөлжүүлэх, сайн засаглалыг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх түншлэлийн бодлогоо үргэлжлүүлэхэд бэлэн байна.

Анхаарал тавьсан Та бүхэнд талархахын ялдамд Чуулганы үеэр өрнөх үр өгөөжтэй хэлэлцүүлэгт Та бүхэнтэй хамтран оролцоход таатай байхаа илэрхийлье.



АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ДЭД СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧ ДЕКЛАН МАГИЙ

*Эрхэм хүндэт Ерөнхий сайд
Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын
дарга Г.Занданшатар, Авлигатай
тэмцэх газрын дарга, тэргүүн
комиссар З.Дашидаваа, хатагтай,
ноёд, хүндэт зочид оо!*

Азийн хөгжлийн банкнийг төлөөлж, “Авлигын эсрэг үндэсний чуулган”-д үг хэлж байгаадаа таатай байна. Би Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар болон түүний хамт олонд энэхүү чухал арга хэмжээг санаачлан зохион байгуулж байгаад талархлаа илэрхийлье.

Бидний олонх авлигын хор хөнөөлийн талаар сайн ойлголттой билээ.

Авлига, хөрөнгө оруулалт, бизнес эрхлэлтийн зардлыг өсгөж, улмаар ажлын байр, ажил эрхлэлтэд сөргөөр нөлөөлдгийг бид мэднэ. Мөн авлига нь суурь үйлчилгээ авах зардлыг өсгөдөг нь орлогынхоо ихэнх хэсгийг зориулахад хүрдэг ядуу бүлгийнхэнд хамгийн хүндээр тусдаг.

Сүүлийн жилүүдэд Монгол Улс нь ихэнх улс орнуудын адилаар авлигатай тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ сорил, бэрхшээлтэй тулгарч байна.

Тус улс нь авлигын төсөөллийн индексийн сүүлийн үнэлгээгээр байр уруудсан. Азийн сангаас эрхлэн гаргадаг SPEAK судалгааны дүнгээр тус улсын авлигын төсөөллийн үнэлгээ өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

Эдгээр авлигын төсөөллийн талаарх сөрөг чиг хандлагатай зэрэгцээд өөдрөг хүлээлтэй байх бодит шалтгаан бидэнд бий. Өнөөдөр эдгээр болон үлдсэн сорил, бэрхшээлийг эргэцүүлэн бодох боломж бидэнд олдож байгаа тул энэхүү боломжийг ашиглаж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа түлхэц өгцгөөе.

Азийн хөгжлийн банк нь эдгээр өөдрөг хүчин чармайлтын нэгэн хэсэг болж байгаадаа таатай явдаг төдийгүй цаашид илүү их үр дүнд хүрэхийн тулд Монгол Улстай хамтран ажиллахад бэлэн байдаг юм.

Үүнтэй холбоотой зарим нэгэн жишээг Та бүхэнд танилцуулья:

Азийн хөгжлийн банк нь Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар болон Авлигатай тэмцэх газартай хамтран авлигын хэргийн хөдөлгөөнийг зохицуулах үүднээс авлигын эсрэг тогтолцоог жигдрүүлэх чиглэлээр ажиллаж байна. Тус банк нь бусад хөгжлийн түншүүдийн хамтаар уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай байдаг тус улсын хувьд нэн чухалд тооцогдох Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгад элсэн Монгол Улсын гишүүнчлэлийг дэмжсээр ирсэн төдийгүй, холбогдох зөвлөмжийг хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлдэг. Мөн Азийн хөгжлийн банк нь бусад хөгжлийн түншүүдийн хамтаар байнгын анхаарал, хүчин чармайлт шаардагддаг мөнгө угаах гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэгч улсуудын саарал жагсаалтаас Монгол Улсыг хасах үйл ажиллагаанд өргөн цар хүрээтэй туслалцааг үзүүлсээр ирсэн. Түүнчлэн Азийн хөгжлийн банк нь холбогдох байгууллагуудтай хамтран цахим шийдлийн тусламжтайгаар улсын бүртгэл, татвар, гааль, аудит болон бусад олон салбарууд дахь авлигын эрсдэлийг бууруулах төслүүдийг хэрэгжүүлж байна.

Бид сүүлийн үед хэрэгжиж байгаа авлигын эсрэг үйл ажиллагаа, гаргаж байгаа хүчин чармайлтаас урам зориг авах хэрэгтэй юм. Гэвч бодит үр дүнг үзэхийн тулд энэ нь тууштай, тогтмол хүчин чармайлт, хэрэгжилтийг биднээс шаардах бөгөөд үр дүн нь зөвхөн урт хугацааны дараа ажиглагдах болно. Мөн өнөөдрийн гаргаж байгаа хүчин чармайлт судалгааны индекс тусгалаа олоход цаг хугацаа шаардагдах тул авлигатай зогсолтгүй тэмцэж, үйл ажиллагааныхаа эрчийг нэмэгдүүлэхийн тулд цуцашгүй манлайллыг чиг шугамаа болгож, авлигын эсрэг үйл ажиллагааг олон нийтэд сайтар мэдээлэх нь чухал юм.

Анхаарал хандуулсан Та бүхэнд талархахын ялдамд өдрийг таатай өнгөрүүлэхийг Та бүхнээс хүсье.

“АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН-2021”

Үндсэн шатгал

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮН:

*Авлигатай тэмцэх газрын дэд дарга,
эрхэлсэн комиссар Г.Азжаргал*



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ УЛС ТӨРИЙН ХҮСЭЛ ЗОРИГ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ХАМТЫН АЖИЛЛАГАА

*Хууль зүй, дотоод хэргийн
дэд сайд Б.Солонгоо*



ЦАР ТАХЛЫН ДАРАА САЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

*Брүүкингс институтийн зөвлөх,
доктор, профессор Даниел Кауфманн*



УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТ, ОРОЛЦОО

*Улсын Их Хурлын гишүүн, Авлигын эсрэг
Парламентын бүлгэмийн гишүүн Ц.Мөнхцэцэг*





АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮН

*Авлигатай тэмцэх газрын
дэд дарга, эрхэлсэн комиссар
Г.Азжаргал*

Авлига нь дэлхийн улс орон бүрийн өмнө тулгарч буй, нийгэм, эдийн засаг, улс төрийн бүхий л хүрээ, түвшинг хамарч, ардчилсан тогтолцоо, үндэсний эдийн засаг, хууль дээдлэх ёсонд онцгой хохирол учруулдаг цогц үзэгдэл юм. Тиймээс төрийн зүгээс оновчтой, эрс шийдэмгий бодлого боловсруулж, үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага үүсдэг.

Авлига нь сонгуулийн үйл явцыг гажуудуулж, хууль дээдлэх ёсыг үнэгүйдүүлж, хахууль шаардах үндсэн нөхцөл болох хүнд суртлын намаг бий болгох замаар ардчилсан институцийн үндэс суурь руу халдаж байна. Авлигын улмаас гадаадын шууд хөрөнгө оруулалт татарч, жижиг бизнесүүдэд шаардлагатай “гарааны нөхцөл”-ийн өртөг нэмэгддэг тул эдийн засгийн хөгжил зогсонги байдалд ордог.

Энэ бүх нөхцөл байдлыг өөрчлөх, авлигаас ангид нийгэм, эдийн засаг, улс төрийн систем цогцлоохыг дэлхийн улс орон бүр зорьж байна. Авлига өөрөө цогц үзэгдэл учраас авлигатай тэмцэхэд иж бүрэн, олон талт бодлого, хандлага шаардлагатай. Авлигатай тэмцэх төрийн бодлого бол Авлигыг хянахын тулд хэн юуг хэрхэн хийж, ямар үр дүнд хүрэх вэ? гэдэг асуултад хариулах зорилготой дагаж мөрдөх замын зураглал юм.

Манай улсад авлигатай тэмцэх үйл ажиллагааг урьдчилан сэргийлэх ба хууль сахиулах гэсэн үндсэн 2 чиглэлээр явуулж байна. Энэ үйл ажиллагаанд баримтлах төрийн бодлого нь Монгол Улсын олон улсын гэрээ, хууль, бусад эрх зүйн актад тусч хэрэгжиж байна. Тухайлбал, Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, Авлигын эсрэг хууль, Эрүүгийн хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Авлигатай тэмцэх үндэсний

хөтөлбөр, Авлигатай тэмцэх газрын стратеги төлөвлөгөө (2020-2023) зэргийг дурдаж болно. Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлд “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасан нь төрийн үйл ажиллагаа, нийгмийг авлигаас ангид байлгах суурь зарчмыг тодорхойлсон явдал мөн. Авлигатай тэмцэх төрийн бодлого бол үндсэндээ энэхүү зарчмыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн төлөөх бодлого юм.

Улсын Их Хурлаас Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийг 2005 онд соёрхон баталсан нь тус конвенцид тусгагдсан авлигын эсрэг бодлогыг өөрийн улсын төрийн бодлогын хэмжээд тооцож, хэрэгжүүлэхийг сайн дурын үндсэн дээр хүлээн зөвшөөрсөн шийдвэр хэрэг юм. Дэлхий нийтийн асуудалтай нэгдсэн шийдэл, бодлогоор тэмцэхэд энэхүү конвенцийн утга учир оршдог. Конвенц нь авлигаас урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгт тооцох, хууль сахиулах, олон улсын хамтын ажиллагаа, хөрөнгө буцаах ажиллагаа, техникийн туслалцаа үзүүлэх ба мэдээлэл солилцох үйл ажиллагааны талаар гишүүн орнуудын хэрэгжүүлэх бодлогын суурь баримт бичиг юм. Конвенцийн үзэл санаа Монгол Улсын төрийн бодлого, үндэсний хууль тогтоомжид хэрхэн тусч байгаа талаар Та бүхэнд тусад нь танилцуулах болно.

Монгол Улсын авлигын эсрэг төрийн бодлого, чиглэлийг тодорхойлсон үндсэн баримт бичиг бол 1996 онд анх баталж, 2006 онд шинэчлэн баталсан Авлигын эсрэг хууль юм. Авлига гэдэгт юуг ойлгох, авлигаас урьдчилан сэргийлнэ гэж ямар үйл ажиллагааг хэлэх, соён гэгээрүүлэх гэдгийг хэрхэн ойлгох, эдгээр үйл ажиллагаа нь хэнд хамаатай байх, тэдгээр хүмүүсийн юу хийж болох, болохгүйн зааг ялгаа хаанаа байх, авлигатай тэмцэх чиглэлийн тусдаа байгууллага байх тухай гэх мэт чухал асуудлуудыг тогтоосон хууль хэрэгжиж эхлээд эдүгээ 15 жил өнгөрсөн байна. Хуульд 2008-2020 оны хооронд 16 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд цаашид ч бодлогын шинжтэй томоохон нэмэлт, өөрчлөлт оруулах, магадгүй шинэчлэн найруулах нийгмийн шаардлага, бодит шалтгаан бий. Ямар гэмт үйлдлийг авлигын гэмт хэрэг гэж тооцох, тэдгээрт ямар ял шийтгэл оногдуулах гэх мэт асуудлыг Монгол Улсын Эрүүгийн хуульд тодорхойлсон. 2002 оны Эрүүгийн хуульд 12 төрлийн үйлдлийг “Албан тушаалын гэмт хэрэг” гэж нэрлэж байсан бол 2015 оны Эрүүгийн хуульд 11 төрлийн үйлдлийг “Авлигын гэмт хэрэг” гэж нэрлэж заасан байдаг. Тус хуульд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд нийтийн албанд томилогдох эрхийг 2-8 жил хасаж 5400–400000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 6 сараас 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 12 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар

заасан. Авлигын хэргийн ялын бодлого ямар хэмжээнд хэрэгжиж байгааг дараа дэлгэрүүлэн авч үзнэ.

Аливаа ашиг сонирхол нь түүхийн аль ч үед, төрийн ямар ч дэглэмийн үед, нийгмийн хөгжлийн ямар ч үе шатанд байсан, байсаар ч байх болно. Гагцхүү төрийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол нь түүний хуулиар хүлээсэн албан үүрэг болон нийтийн ашиг сонирхлоос ямагт доор байх нь нийгмийн шударга ёс юм. Төрийн албан тушаалтны энэ “дутуу”-г нөхөж төрөөс ажиллаж хөдөлмөрлөх баталгаа, нөхцөлөөр хангадаг.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд энэ бодлогыг тодорхойлж өгсөн. Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050”-д ардчилал, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын нэг эрхэм зорилго гэж тодорхойлсон. Баримт бичгийн 5.6-д “Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна” гэж заасан. Энэ бол авлигатай тэмцэх урт хугацааны зорилго бөгөөд 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2021-2030 онд хэрэгжих нэгдүгээр үе шатанд Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлэхээр тодорхойлсон. 2031-2040 онд хэрэгжих хоёрдугаар үе шатанд Авлигатай бүх нийтээр тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэхээр заасан бол 2041-2050 онд хэрэгжих гуравдугаар үе шатанд Авлигагүй нийгмийг цогцлоохоор заасан. Үндсэндээ 2050 он гэхэд Монгол Улсад нийгмийн бүх түвшинд шударга ёс тогтсон, авлигагүй нийгмийг цогцлоон төлөвшүүлсэн байхыг бодлогын түвшинд тодорхойлсон. Үүнээс гадна, Монгол Улс алсын хараагаа “2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болно” гэж тодорхойлсон. Энд дурдагдаж буй “нийгмийн хөгжил”, “эдийн засгийн өсөлт”, “иргэдийн амьдралын чанар” гэдэг үзүүлэлтүүд бол бүгд авлигын түвшинтэй хамааралтай хүчин зүйлүүд.

Улсын Их Хурлаас 2016 онд баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр бол авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх зорилготой үндэсний хэмжээний 2 дахь хөтөлбөр юм. Энэхүү хөтөлбөрт төрийн болон хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээ, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдал, олон нийтийн хяналтыг сайжруулах, иргэдийг соён гэгээрүүлэх, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээр 11 зорилт дэвшүүлсэн. Эдгээр

зорилтуудын хүрээнд 6 жилийн хугацаанд хэрэгжүүлэх 83 үйл ажиллагаа, 216 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг 2017 онд Засгийн газар баталсан.

Авлигатай тэмцэх газрын 2020-2023 он хүртэлх үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд байгууллагын түвшний дунд хугацааны бодлогыг тусгаж хүрэх үр дүнгээ тодорхойлсон. Стратеги төлөвлөгөөнд байгууллагын Алсын харааг “Шударга ёсны төлөө иргэдийн итгэл хүлээсэн байгууллага байна” гэж, эрхэм зорилгоо “Авлигатай тэмцэж, шударга ёсыг тогтоон хөгжил дэвшилд хүргэнэ” гэж томъёолсон бөгөөд байгууллагын стратегийн 5 зорилгыг дэвшүүлсэн.

Авлигатай тэмцэх бодлогын талаар Та бүхэнд товч байдлаар танилцууллаа.

Эдгээр бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг нэгд, авлигаас урьдчилан сэргийлэх, хоёрт хууль сахиулах үйл ажиллагаа гэсэн 2 үндсэн чиглэлээр танилцуулья.

Төрийн болон хувийн хэвшил дэх авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийн оролцоог дэмжих зарчим, бодлого дээрх хууль, бусад баримт бичгүүдэд тусч тодорхой түвшинд хэрэгжиж байна. Төрийн байгууллагад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн баримт бичиг, захиргааны арга хэмжээг тогтмол үнэлж дүгнэх ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газар 2007 оноос хойш давхардсан тоогоор 1,279 төрийн байгууллагад ажиллаж, 597 тушаал, дүрэм, журмыг хянаснаас холбогдох хууль тогтоомжид нийцээгүй гэсэн үндэслэлээр 122-ыг нь хүчингүй болгуулсан байна. Мөн төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж 169 зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилттэй давхардсан тоогоор 369 удаа танилцсан байна. Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийг татан оролцуулах нь авлигаас урьдчилан сэргийлэх бодлогын салшгүй хэсэг юм. Соён гэгээрүүлэх ажлын үр дүнд төрийн албанд шударга ёсны соёл тогтож, хүн бүрд тэгш, шударгаар ханддаг, үйл ажиллагаа нь дээд зэргийн үр ашигтай болсон байх ёстой. Авлигатай тэмцэх газраас иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг сургалт зохион байгуулах, сурталчилгааны материал боловсруулж түгээх, аян зохион байгуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах зэрэг олон төрөл, хэлбэрээр зохион байгуулж байна. Соён гэгээрүүлэх ажлын үр дүн нийгмийн ерөнхий соёл, хандлагаар шууд бусаар илэрч, үр шимээ өгдөг. Нөгөө талаас, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх ажил нь бүх шатны төрийн байгууллагын албан тушаалтнууд, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн шууд оролцоо, иргэдийн өөрсдийн ухамсар, хандлагаас ихээхэн шалтгаалдаг.

Төрийн албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх

нь төрийн албан дахь авлигаас сэргийлэх чухал чиглэл юм. Төрийн албанд томилогдох, сонгогдох этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргах, түүнийг хүлээн авч, хянах ажиллагаа тусгайлан хууль, дүрэм, журмаар зохицуулагддаг. 2012 оноос хойш Авлигатай тэмцэх газарт 101,538 мэдүүлэг хүлээн авч, хянан шийдвэрлэснээс 409 мэдүүлгийг зөрчилтэй гэж дүгнэсэн байна. Албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, холбогдох эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хийх зүйл олон байна. Урьдчилсан мэдүүлэг гаргаж хянуулалгүйгээр төрийн албанд томилох, эсхүл, томилсны дараа мэдүүлэг хянуулахаар ирүүлдэг зөрчил арилахгүй байна. Мэдүүлгийн хяналт шалгалтыг цахимжуулах, хиймэл оюуныг ашиглах талаар судалж, тодорхой ажлыг эхлүүлээд байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг Авлигатай тэмцэх газар жил бүр нэгтгэн гаргаж, Улсын Их Хуралд танилцуулдаг. 2023 онд дуусах энэ Хөтөлбөрийн биелэлт 2020 оны байдлаар 69 хувьтай байна. Авлигаас урьдчилан сэргийлэх бодлогын нэг чухал чиглэл бол авлигын шалтгаан нөхцөл, авлигын ерөнхий нөхцөл байдлыг судлах, судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийх явдал юм. Олон улсын болон дотоодын төрийн болон төрийн бус байгууллагууд авлигын нөхцөл байдлын талаарх төрөл бүрийн судалгааг өөр өөрийн мэдээлэл, арга зүйд үндэслэн зохион байгуулдаг. Эдгээрээс дэлхийн олон улсад Транспэрэнси интернэшнл байгууллагын Авлигын төсөөллийн индексийг хүлээн зөвшөөрөх хандлагатай байна. Авлигын төсөөллийн индекс нь нэгдмэл аргачлал бүхий бие даасан судалгаа биш бөгөөд АНУ, ХБНГУ, Их Британи, Швейцар, Гонконгод байрлан үйл ажиллагаа явуулдаг 13 байгууллагын судалгаа, үнэлгээний авлига болон түүнд холбогдох хэсгийн үзүүлэлтийг сонгон авч тодорхой аргачлалаар тооцдог индекс юм. 2020 оны хувьд манай улс уг индексээр 35 оноотой, 180 улс орноос 111 дүгээр байрт орсон. Монгол Улсын Засгийн газраас Авлигын индексийг сайжруулж, байрыг 100-аас дотогш оруулах зорилготой Ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа билээ.

Монгол Улсын авлигатай тэмцэх бодлого, авлигын нөхцөл байдалд иргэд болон олон улсын байгууллагуудаас сөрөг үнэлгээ өгөхөд дараах үзүүлэлтүүд голчлон нөлөөлж байна. Үүнд:

- ✦ Төрийн удирдах албан тушаалтнууд хариуцлага хүлээдэг эсэх
- ✦ Төрийн эрх мэдлийг хувийн ашиг сонирхолд ашигладаг эсэх
- ✦ Иргэний нийгэм төрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг авах боломжтой эсэх
- ✦ Бизнес эрхлэгчид авлигад өртдөг эсэх
- ✦ Төсвийн хөрөнгийг шамшигдуулж, зориулалтын бусаар зарцуулдаг эсэх

- ✦ Иргэд авлигатай нүүр тулгардаг эсэх
- ✦ Төрийн албан хаагч авлигын гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээдэг эсэх, ийнхүү хариуцлага хүлээлгэх хараат бус шүүх байдаг эсэх
- ✦ Хариуцлага, хяналтгүй зарцуулах боломжтой тусгай сан байдаг эсэх
- ✦ Гэрээ байгуулах, давуу байдал бий болгох зорилгоор хахууль өгөх заншил байдаг эсэх зэрэг.

Товчоор хэлбэл, авлигын эсрэг төрийн бодлого эдгээр үзүүлэлтүүдийг бууруулах зорилтыг хангах, шийдвэрлэхэд анхаарах ёстой.

Авлигатай тэмцэх газраас Шударга байдлын үнэлгээ, Хүүхдийн шударга байдлын судалгаа, Улс төр, хууль, хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын төсөөллийн судалгаа зэрэг судалгааг жил бүр хийдэг. Мөн төрийн байгууллагуудад авлигын эрсдэлийн үнэлгээ хийж байна. Төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээний 2021 оны дүн 72.9 гарсан байна. Энэ нь өмнөх үнэлгээний дүнгээс 1.2 пунктээр буурсан үзүүлэлт юм.

Иргэд төрийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй танилцах, түүнд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх, мөн холбогдох байгууллагад хандаж авлигын талаар мэдээлэх, ялангуяа нэрээ нууцлан мэдээлэх боломжоор хангах нь авлигаас урьдчилан сэргийлэх бодлогын чухал зорилт юм. Энэ хүрээнд албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хураангуй хэлбэрээр Авлигатай тэмцэх газрын цахим мэдээллийн сүлжээнд жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан байршуулж байна. Өргөдөл, гомдол, мэдээллийг биечлэн болон цахимаар, шуудангаар хүлээн авахын зэрэгцээ төлбөргүй шууд дугаар ажиллуулж байна. 2020 онд зөвхөн 110 тусгай дугаараар 317 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авсны 45.7 хувьд нь иргэд нэрээ нууцалсан бол 54.3 хувьд нь нэр, хаягаа ил тодоор бүртгүүлсэн байна. Бид иргэдэд аль болох нээлттэй байж, хувь хүний болон мэдээллийн нууц, мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангахыг эрмэлзэж байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй төрийн байгууллагын албан тушаалтнууд энэ үүргээ хангалтгүй биелүүлж байгаа нь бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Нөгөө талаас тогтолцооны шинжтэй хүчин зүйлс ч нөлөөлж байна. Авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд санхүүгийн болон эрх мэдэл, чиг үүргийн төвлөрлийг багасгах, нийгмийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор гарч байна. Мөн хэвлэл мэдээллийн болон уул уурхайн салбарын ил тод байдал, улс төрийн намын санхүүжилт, шүгэл үлээгч буюу мэдээлэгчийн эрх зүйн байдлын тухай зэрэг хууль тогтоомжууд авлигаас урьдчилан сэргийлэхэд чухал түлхэц болно. Мөн:

- ✦ авлигын эсрэг хуулийн биелэлт, үйл ажиллагааны талаар
- ✦ гэмт хэргийн ялын бодлого,
- ✦ хохирол нөхөн төлүүлэх үйл ажиллагаа,
- ✦ хүний нөөцийн бодлого,
- ✦ хууль зүйн техникийн шинжтэй зарим асуудал,
- ✦ авлигатай тэмцэх бодлого боловсруулах үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг хөндөх болно.

Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцид тусгагдсан хууль сахиулах үйл ажиллагааны олон суурь асуудал манай улсын холбогдох хууль тогтоомж хийгээд тэдгээрийг хэрэгжүүлэх практик үйл ажиллагаанд мөрдөгдөхгүй байна. Тухайлбал, “хөөн хэлэлцэх хугацааг уртаар тогтоох буюу хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх”, “гэмт хэрэгт тухайн гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан шийтгэл ногдуулах”, “гэмт хэрэгт шийтгэгдсэн этгээдийг хугацаанаас нь өмнө суллах буюу тэнсэн суллах боломжийг авч үзэхдээ тухайн гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан үзэх” зэрэг асуудлуудыг дурдаж болно. Тухайлбал, 2017-2019 онд анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн албан тушаалын гэмт хэргийн 119 шийдвэрт дүн шинжилгээ хийж үзэхэд 5 саяас 10 сая төгрөгийн хахуулийн хэрэг болон 150 саяас 600 сая хүртэлх төгрөгийн хахуулийн хэрэгт оногдуулсан хорих ялын дундаж нь бараг ижил буюу 3.6 жил, торгох ялын дундаж хэмжээ 6.1 сая төгрөг байна. Авсан хахуулийг улсын орлого болгодог хэдий ч оногдуулж буй шийтгэлийн байдал ийм л байна. Хорих ял шийтгэгдсэн ялтан хугацаанаас өмнө суллагдсан хувь ч харьцангуй өндөр буюу тухайн жилд авлигын хэрэгт хорих ял эдэлсэн нийт хүний 60-80 хувьтай тэнцэж байгааг судлаачид тогтоосон байна.

Гэтэл дэлхийн зарим улсад, тухайлбал, БНХАУ, Өмнөд Африк, Индонез, Вьетнам зэрэг улсад хахууль авах, өгөх гэмт хэрэгт дээд тал нь бүх насаар нь хорих ял оногдуулж байгаа бол Авлигын төсөөллийн индексээр манай улстай ойролцоо ихэнх улсууд энэ төрлийн гэмт хэрэгт дунджаар 15 жилийн хорих ял оногдуулж байна. Малайз, Өмнөд Африк, Вьетнам зэрэг улсууд хахуулийн хэмжээг 5 дахин, ОХУ, Казахстан улсуудад 40-60 дахин нэмэгдүүлэн торгох ял оногдуулж байгаагаас гадна ихэнх улсууд торгох ялын хэмжээг хахуулийн болон хохирлын хэмжээтэй ямар нэгэн байдлаар уялдуулан тогтоож байна. Энэ нь “... гэмт хэрэгт тухайн гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан шийтгэл ногдуулна” гэсэн Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн заалттай уялдаж байгаа юм.


Авлигатай тэмцэх үйл ажиллагааг үр дүнд хүргэх, иргэдийн итгэл найдварыг сэргээх, нийгэмд шударга ёсыг тогтоохын тулд бид олон улсын хамтын

нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх ёстой. Ялын бодлого хэт чанга, эсхүл, хэт сул байхын аль аль нь авлигатай тэмцэхэд сайнаар нөлөөлдөггүйг олон улсын туршлага харуулж байна. Авлигын гэмт хэргийн эрүүгийн ялын бодлого нь тухайн улсын авлигын түвшин ба голлох авлигын төрөл, хэлбэр, ардчиллын түвшин, засаглалын хэлбэр, нийгэм-эдийн засгийн хөгжил, хүн амын тоо, газар нутгийн хэмжээ зэрэг олон хүчин зүйлийн уулзварт оршдог эмзэг, нарийн төвөгтэй асуудал юм.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нь авлигатай тэмцэх олон улсын төдийгүй үндэсний гол стратеги юм. Хохирлыг нөхөн төлүүлэх нь төрийн үйл ажиллагааны шударга байдал, ардчиллын үнэт зүйлс, иргэдийн хүртэх ёстой байсан боломжид учирсан хор уршгийг бүрэн эдгээж, нөхөж чадахгүй ч нийгэмд шударга ёсыг тогтоох нэгэн чухал хүчин зүйл билээ. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд Авлигатай тэмцэх газар онцгой анхаарч, 2019 онд 11.3 тэрбум, 2020 онд 35.6 тэрбум, 2021 оны эхний 11 сарын байдлаар 96.2 тэрбум төгрөгийн хохирлыг бодитоор барагдуулж, улсын санд хуримтлуулаад байна.

Авлигын хэргийг мөрдөн шалгах, хохирлыг нөхөн төлүүлэх, хулгайлагдсан хөрөнгийг буцаах ажиллагаанд дотоодын төдийгүй гадаад улсын хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах шаардлага өнөө цагт тулгамдсан асуудал болж байна. Учир нь, авлига үндэсний хэмжээнээс хальж, зөвхөн биет төдийгүй биет бус, цахим төлбөр тооцооны хэрэгслийг ашиглах боллоо. Үүнд олон улсын банк, санхүүгийн байгууллага, төрийн болон хувийн хэвшил оролцох нь улам бүр нэмэгдэж байна.

Манай улс иргэн, эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх, гэмт этгээд шилжүүлэх, ялтан шилжүүлэх тухай 4 төрлийн 36 гэрээг 20 орчим улс оронтой байгуулсан. Энэ төрлийн гэрээ хэлэлцээрийг цаашид өргөжүүлэх, гүнзгийрүүлэх шаардлагатай байна. Бид энэ хугацаанд харилцан туслалцааны гэрээ байгуулаагүй гэдгээр шалтаглан хойш суусангүй. Хэд хэдэн улстай Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн хүрээнд үр дүнтэй хамтран ажиллаж,



ялангуяа, хөрөнгө буцаах, мэдээлэл солилцох чиглэлээр чамлахааргүй амжилт гаргаад байгааг энд хэлэхийг хүсэж байна.

Авлигын эсрэг хууль сахиулах бодлогод хамаарах нэгэн тулгамдсан асуудал бол авлигатай тэмцэх хүний нөөцийн бодлогын асуудал.

Авлигатай тэмцэх газар сүүлийн 5 жилд дунджаар 1,090 хэрэг шалгасан нь өмнөх 10 жилийн дунджаас даруй 5 дахин нэмэгдсэн тоо юм.

Энэ өсөлт мөрдөгч, прокурор, шүүгчдийн ажлын ачааллыг ч мөн төдий хэмжээгээр нэмэгдүүлсэн. Бид мөрдөгч, прокурор, шүүгчдийн хэрэг мөрдөн шалгах, дүн шинжилгээ хийх, зөв, оновчтой шийдвэрлэх ур чадварыг сайжруулж, олон улсын эрх зүй, санхүүгийн харилцааны талаарх мэдлэгийг дээшлүүлж, шинэ нөхцөл байдалд дасан зохицох чадамжийг хөгжүүлэх нь авлигыг үр дүнтэй хянах хүний нөөцийн хүчин зүйл гэж үзэн, онцгойлон дэмжиж ажиллаж байна.

Авлигатай тэмцэх хүний нөөц, олон улсын харилцаа, хамтын ажиллагаа, технологид хийх хөрөнгө оруулалт нь авлигад алдаж буй хөрөнгийн хэмжээтэй харьцуулшгүй бага боловч авлигатай хийх тэмцлийн зүй ёсны үндэс суурь болно.

Авлигын эсрэг аливаа бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь эрх зүйн харилцаанд хэрэглэх үг, ойлголтын утга агуулгыг хэрхэн ойлгохыг тогтоох, тодорхойлохтой салшгүй холбоотойг энд цөөн жишээгээр дурдъя.

Авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэг, албан тушаал, албан тушаалтан, бэлэг, хандив, эрх нөлөө, хамаарал бүхий этгээд гэх мэт гол гол ойлголтуудыг хэрхэн тодорхойлох нь бодлого, түүний хэрэгжилтэд шууд нөлөөлдгийг болж өнгөрсөн олон үйл явдал харуулж байна. Одоог хүртэл “авлигын гэмт хэрэг” ба “авлигын зөрчил”, “ашиг сонирхлын зөрчил”-ийн хоорондын, “бэлэг”, “хандив” ба “хахууль”-ийн хоорондын зааг ялгааг нэг мөр тодорхой болгож чадаагүй байна. “Төрийн алба”, “төрийн албан тушаалтан” ба “нийтийн алба”, “нийтийн албан тушаалтан” гэдэг ойлголтууд ч нэг мөр шийдэгдээгүй, өнөө хэр аль алиныг нь зэрэгцүүлэн хэрэглэж байна. Цаашилбал, авлигатай тэмцэх хүрээнд маш өргөн хэрэглэдэг “шударга ёс” гэдэг үгийг ч маш олон янзаар ойлгож, тайлбарлаж байна.

Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад “шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг танхимын саналыг үндэслэн гаргах” бүрэн эрхийг Улсын дээд шүүхэд олгосон нь энэ асуудлыг шийдэх нэг гарц гэж үзэж байна.

Авлигатай тэмцэх төрийн бодлого бол олон талаас нь ул үндэстэй бодож,

боловсруулах, энэ улсын иргэн бүр чармайн зүтгэж хэрэгжүүлж байж зорьсон үр дүндээ хүрэх өргөн цар хүрээтэй, нарийн төвөгтэй, цогц стратеги юм.

Бодлого боловсруулах үйл явцад бодлогыг хэрэгжүүлэгч болон хэрэглэгчийн оролцоог хангах, ил тод байдлыг сайжруулах нь бодлого өөрөө үр ашигтай байх, үндэсний ашиг сонирхол, үнэт зүйлд нийцсэн байх нөхцөлийг бүрдүүлнэ.

Энэ бүхэнд холбогдох олон агуулга, сэдвийг нэг илтгэлийн хүрээнд илэрхийлэх боломжгүй учраас зөвхөн гол гол асуудлыг л товчлон танилцууллаа.

Дүгнэн хэлбэл, авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх олон улсын хамтын нийгэмлэгийн бодлого зорилтод суурилсан, өөрийн орны нийгэм-эдийн засаг, улс төрийн нөхцөл байдлыг харгалзсан төрийн бодлого үндэсний хууль тогтоомж, бусад баримт бичигт туссан байна. Гэхдээ авлигын эсрэг хууль сахиулах үйл ажиллагаатай холбоотой зарим асуудал орхигдсон байгааг засаж залруулах ажил бидний өмнө байна. Бодлого байх нэг хэрэг. Бодлогыг нэг мөр хэрэгжүүлж, хуулийг дээдлэн сахихгүй бол бодлого байхгүйтэй адил болж, хүн бүр дураараа дургидгийг хэн бүхэн мэднэ. Бодлогыг хэрэгжүүлэхгүй байх, дур дураараа аашлах нь ардчилал биш. Харин тодорхой бодлогыг хэрэгжүүлэх арга, зарчимд л ардчилал оршдог.

Бид бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга зам, зарчмаа Үндсэн хуульдаа тодорхойлчихсон. Монгол Улсын Үндсэн хууль дахь “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн энэхүү заалтыг бүрэн утгаар нь хэрэгжүүлж чадвал бид нийгэм, эдийн засаг, улс төрийн тулгамдсан олон асуудлыг шийдэж чадна.

*Монгол Улс авлигаас ангижирч, шударга ёс,
хөгжил дэвшилд хүрэх болтугай.*

*Та бүхний ажил, амьдралд амжилт, эрүүл энх, сайн сайхныг хүсье.
Баярлалаа.*



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ УЛС ТӨРИЙН ХҮСЭЛ ЗОРИГ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ХАМТЫН АЖИЛЛАГАА

*Хууль зүй, дотоод хэргийн
дэд сайд Б.Солонгоо*

Эрхэм хүндэт чуулганд оролцогчид, зочид та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Монгол Улс шинэ Үндсэн хуулиа баталж, ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш 30 жилийн хугацаанд олон сорилтыг даван туулсаар ирлээ.

Ардчилал бидэнд эрх, эрх чөлөө, олон ургалч үзэл, чөлөөт хэвлэл, ардчилсан сонгууль, олон намын тогтолцоо бүхий парламентын засаглал, зах зээлийн эдийн засаг гээд олон чухал үнэт зүйлсийг өгсөн нь түүхэн үнэн.

Гэвч төрийн албан хаагчдын дунд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах, авлига, ашиг сонирхлын зөрчилд холбогдох, шударга бусаар давуу байдал олж авах зэрэг хууль бус үйлдэл байсаар байна.

Авлига, албан тушаалын гэмт хэрэг нийгэм, эдийн засгийн хөгжил, улс төрийн шинэчлэлд шууд чөдөр тушаа болдог. Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үйл ажиллагаа нь хууль өөрчлөх, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэхээр хязгаарлагдахгүй.

Өөрөөр хэлбэл, авлигатай тэмцэх эрх зүйн орчин тодорхой түвшинд бүрдсэн хэдий ч Авлигын төсөөллийн индексийн үзүүлэлт сүүлийн жилүүдэд тогтмол ухарч байгаа нь бидний авлигатай тэмцэх ажлын үр нөлөөг дүгнэж үзэх шаардлагатай болохыг харуулж байна.

“Транспаренси Интернэшнл” олон улсын төрийн бус байгууллагаас жил болгон боловсруулан гаргадаг Авлигын төсөөллийн индексийн дүнгээр Монгол Улс 2020 онд 35 оноо авч 180 улс орноос 111 дүгээр байрт эрэмбэлэгдсэн байна. Энэ нь өмнөх оныхтой ижил оноотой боловч 5 байраар ухарсан үзүүлэлт болж байна. Монгол Улсын индексийг тооцоход нийт 9 эх сурвалжийг ашигласан байна¹. Үүнээс АНУ-ын “Пи Ар Эс” группээс гаргадаг

1 <https://www.transparency.org/en/cpi/2020/results>

Эрсдэлийн үнэлгээ 6 оноогоор, Швейцарын “Ай Эм Ди” байгууллагын өрсөлдөх чадварын эмхэтгэлийн үзэл бодлын судалгаа 4 оноогоор, Ардчиллын олон талт байдлын үнэлгээ 3 оноогоор тус тус өссөн бол Дэлхийн эрх зүйн төслийн Хууль дээдлэх ёсны индекс 3 оноогоор, “Глобал инсайт” байгууллагын Улс орнуудын эрсдэлийн түвшин 12 оноогоор тус тус буурчээ. Харин Дэлхийн эдийн засгийн форумын үзэл бодлын судалгаа, “Бертелсман сан” Шилжилтийн индекс, Дэлхийн банкны Улс орны бодлого, институцийн үнэлгээ, Эдийн засгийн мэдээллийн нэгжийн Улс орнуудын эрсдэлийн үнэлгээний оноо өмнөх оныхоос өөрчлөгдөөгүй байна².

Төрийн байгууллагуудын ойлголтын зөрүү, ажлын арга барилын ялгаа, байгууллагын явцуу эрх ашгаа эн тэргүүнд тавьдаг зэрэг нь авлигатай тэмцэх ажлыг хойш татаж байгаа нь нууц биш юм. Аливаа гэмт хэрэгтэй тэмцэх ажилд үр дүнтэй чухал хандлага, арга хэлбэрийн нэг нь “олон талт хамтын ажиллагаа”³, түүнийг бэхжүүлэх явдал юм.

Иймээс Монгол Улсын Ерөнхий Сайдын 2021 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 120 дугаар захирамжаар Авлигын төсөөллийн индексийг бууруулах зорилго бүхий Ажлын хэсгийг байгуулсан.

Ажлын хэсгээс эрчимжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөг Монгол Улсын Ерөнхий сайдаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд төлөвлөгөөнд Хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, Төрийн үйлчилгээний хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлж, цахим үйлчилгээний чанарыг сайжруулах, Урьдчилан сэргийлэх, олон нийтийг мэдээллээр хангах, Төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, авлигын хэргийг хянан шийдвэрлэх чадавхыг бэхжүүлэх, төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх 4 чиглэлийн хүрээнд нийт 50 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр Нийтийн мэдээллийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг боловсруулан, Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байна.

Түүнчлэн Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан бөгөөд энэ хуулийн төслийн зорилго нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээх нөхцөлийг бүрдүүлэх, шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах, урамшуулах, түүний эрх зүйн байдлыг дордуулсан шинжтэй аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх үр дүнтэй арга байж чадна гэж бид үзэж байгаа юм.

2 <https://iaac.mn/post/91180>

3 Авлигын эсрэг НҮБ-ын Конвенци. Удиртгал хэсэг

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулж байгаа Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр авлига, албан тушаалын гэмт хэргийн шинжийг тодруулах, оногдуулах эрүүгийн хариуцлагыг чангатгах чиглэл барьж байна.

Монгол Улсын Засгийн газраас Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Улсын Их хуралд өргөн барьсан. Эдгээр хуулиар төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, санхүүжилтийг ил тод болгоход анхаарч, ашгийн төлөө бус байгууллагаар халхавчлан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, татвар төлөхөөс зайлсхийх хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн яам нь Сангийн яамтай, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хамтран Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг батлан, хуулийн төслийг эцэслэн боловсруулахаар ажиллаж байна.

Дээр дурдсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлаар батлуулснаар төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал сайжрах бөгөөд төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, хяналт тавих боломж өргөжиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгохоос гадна зохион байгуулалтын олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, төрийн үйлчилгээний хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлж, цахим үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр Иргэд, олон нийттэй харилцах төвийн “1111” тусгай дугаарт 2021 оны 07 дугаар сарын 22-ноос 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийг хүртэл төрийн байгууллагын хүнд суртал, авлигын шинжтэй нийт 2242 дуудлага, мэдээлэл хүлээн авсан бөгөөд авлигын гэмт хэргийн шинжтэй 21 гомдол хүлээн авч, АТГ-т албан шугамаар шилжүүлж, хүнд сурталтай холбоотой 1252 дуудлага, мэдээлэл бүртгэгдсэнийг шийдвэрлэх чиглэлээр холбогдох ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал, Газрын алба, түүний албан тушаалтан, үйл ажиллагаатай холбоотой авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд сурталтай холбоотой гомдол, мэдээлэл ихээр ирснийг анхаараалдаа авч, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ, кадастрын зураг, гэрээг цахимаар үнэгүй авах нөхцөлийг бүрдүүлж, 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 20206 иргэн, хуулийн этгээд газрын гэрчилгээ, кадастрын зургаа хэвлэн авч, иргэд 465,1 сая төгрөг хэмнэсэн байна.

“e-Mongolia” системээр иргэдэд цахимаар үзүүлэх үйлчилгээг өргөжүүлж, 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 56 байгууллагын 564 үйлчилгээг цахимжуулж, 1,908,131 хэрэглэгчтэй болж, 5,827,924 удаагийн үйлчилгээ авсан байна. “e-Mongolia” системд өнөөдрийн байдлаар Булган, Хөвсгөл, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгууд холбогдсон бөгөөд бусад аймгуудыг холбохоор судалгаа, зохион байгуулалтын ажлууд хийгдэж байна.

Гаалийн цахим үйлчилгээний системийг 2021 оны 10 дугаар сараас ашиглалтад оруулсан. Уг систем нэвтэрснээр гаалийн байгууллагаас үзүүлж буй гаалийн бүрдүүлэлт, төлбөр тооцоо, лавлагаа, тодорхойлолт, гадаад худалдааны барааны статистик мэдээлэл, барааны ангилал, тарифын мэдээлэл болон тусгай зөвшөөрөл зэрэг нийт 30 гаруй үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгжүүд цахимаар авах боломжтой болсон.

Татварын албанаас Цахим татварын системийг ашиглан татвар төлөгчөөр бүртгүүлэх, татварын тайлан гаргах, лавлагаа тодорхойлолт авах, Төрийн үйлчилгээний нэгдсэн систем e-Mongolia, цахим төлбөрийн баримт систем, Гэрэгэ киоск, интернэт банкаар татвар төлөх үйл ажиллагааг бүрэн цахимжуулсан.

Төрийн албаны тухайн албан тушаалын шалгалтын системийг 100 хувь цахимжсан ерөнхий шалгалтын үндсэн платформ дээр түшиглэн шинэчилсэн системээр 2021 оны IV улирлаас эхлэн орон даяар захиалгын дагуу зохион байгуулсан. Шинэ системээр сул орон тооны зар, албан тушаалын тодорхойлолт, бүртгүүлсэн иргэд, шалгалтын дүн, баталгаажуулах гэх мэт шалгалтын процесс бүрэн цахимжиж, иргэдэд ил тод, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүллээ.

Цаашид засаглалын бүхий л салбарт авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг онцгойлон анхаарч, ажлаа эрчимжүүлэхийн зэрэгцээ дээр дурдсан Улсын Их Хуралд өргөн барьсан хуулийн төслүүдээ батлуулах, Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төсөл, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Улсын Их хуралд өргөн мэдүүлнэ.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалыг сайжруулах, төрийг төлөөлөх этгээдийг ил тод, хариуцлагатай, мэргэшсэн, хяналттай, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.

Төрийн байгууллагын чиг үүрэг, ажлын байр, албан тушаалын давхцал болон өөрийн үзэмжээр буюу субъектив байдлаар шийдвэр гаргах боломж бүрдүүлсэн хууль, эрх зүй, салбар, албан тушаалын судалгааг хийж, санал дүгнэлт гаргана.

Төрийн болон орон нутгийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах явдалтай тэмцэх, төрд учруулсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээ авч, үр дүнг тооцно.

Төрийн бүх шатны албан тушаалд нэр дэвшигч этгээд нь цахим хэлбэрээр ажилд орох, дэвшин томилогдох хүсэлтээ гаргаж, тухайн ажлын байрны шаардлагыг хангаагүй тохиолдолд мэдүүлэх боломжгүй болгох, мөн хүсэлтийг томилох төрийн байгууллага, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газарт давхар хүргүүлэх тогтолцоог бэхжүүлнэ.

Авлига, албан тушаалын гэмт хэргийн улмаас гадаад улсад байршсан эд хөрөнгийг хураах, битүүмжлэх, Монгол Улсад буцаан авчрах талаар хууль эрх зүйн орчныг сайжруулах зэрэг ажлуудыг эхлүүлээд байна.

Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тууштай, үр дүнтэйгээр тэмцэх цаг нь болсон гэдгийг энэхүү үндэсний чуулган дээр онцлон тэмдэглээд үүгээр би илтгэлээ өндөрлөе.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

ЦАР ТАХЛЫН ДАРАА САЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

*Бруүкингс институтийн
зөвлөх, доктор, профессор
Даниел Кауфманн*



Бид авлигын эсрэг системт, баримтад тулгуурласан засаглалын арга замаар тэмцэх хэрэгтэй. Хэдийгээр авлигын хор уршиг төсөөлж баршгүй их боловч энэ нь засаглалын тулгуур зарчим алдагдсаны үр дагавар байдаг. Иймд засаглалын тулгуур зарчимтай холбоотой үүссэн эдийн засаг, улс төр, институтын шинжтэй гол асуудлуудыг олж тогтоож, ил тод байдлыг сайтар хангаж өгөх нь дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэхэд нэн чухал хувь нэмрийг оруулдаг. Энэ нь өнөөдрийн чуулганы гол үзэл санаатай уялдаж байгаа юм.

Цар тахлын дараа бид цоо шинэ орчинтой нүүр тулах болно. Улс төрийн манлайлал байсан цагт олон талт шинэтгэлийг явуулж чадна гэдэгт итгэлтэй байж болно. 1996 оноос эхэлсэн Дэлхийн банкнаас 30 гаруй улс дахь 40 гаруй мэдээллийн санг жил бүр нэгтгэн гаргадаг “Дэлхий дахины засаглалын индекс” судалгаанд 200 гаруй улс хамрагдаж байна. Энэхүү судалгаагаар улс орнуудын засаглал, авлигын эсрэг үйл ажиллагааг зургаан үзүүлэлтийн хүрээнд үнэлж байна.

Эдгээр нэр бүхий зургаан үзүүлэлтийн эхний хоёрт дуу хоолой ба хариуцлага, улс төрийн тогтвортой байдал, хүчирхийлэл, терроризмээс ангид байдлыг тусгаж оруулдаг. Дараагийн бүлэг үзүүлэлтэд засгийн газрын үйл ажиллагааны үр ашигтай байдал болон бодлогын зохицуулалтын чанарыг авч үздэг. Сүүлийн бүлэг хэмжигдэхүүнд мөн хоёр үзүүлэлтийг багтаадаг. Тухайлбал, нийгэм дэх хууль дээдлэх ёс, авлигын эсрэг үйл ажиллагаа зэрэг болно.

Засаглал болоод авлига гэх хоёр ухагдахуун нь харилцан ялгаатай ойлголтууд аж. Засаглал гэх ойлголтын хамрах цар хүрээ нь илүү өргөн байдаг бол авлигын нийгэмд үзүүлэх хор уршиг түүнээс дутахгүй их юм. Иймд авлигыг бууруулж байгаа улсад засаглалын оновчтой хэлбэр ноёлж байгааг харуулж байдаг. Эдгээр үзүүлэлтээр бид улс орнуудыг дүгнэж, байр эзлүүлж байна.



Дуу хоолой ба хариуцлага

Монгол Улсад маш их давуу тал, боломж бололцоо байдаг. Тус улсын 10 жилийн турш засаглал, авлигын эсрэг явуулж ирсэн үйл ажиллагааг нь дүгнэн харахад ололт амжилт, сорил бэрхшээлийн дундуур тодорхой замыг туулж өнгөрүүлсэн нь мэдэгддэг. Тухайлбал, хэвлэл мэдээллийн эрх чөлөө, иргэний нийгмийн үйл ажиллагааны эрх чөлөө, хараат бус байдал гэх мэт үзүүлэлтээрээ Монгол Улс дэлхийн шилдэг улсуудын тоонд орж байна. Дээрх үзүүлэлтээр Шинэ Зеланд, Австрали Улсууд дээгүүрт ордог. Мөн эдгээр улсууд нь дуу хоолой ба хариуцлагын үзүүлэлтээр дэлхийд тэргүүлэх байрт ордог.



Улс төрийн тогтвортой байдал, хүчирхийлэл, терроризмээс ангид байдал

Монгол Улсад эдгээр үзүүлэлтүүд сайнаар үнэлэгдэх давуу тал бий. Мөн хоёр дахь бүлэг хэмжигдэхүүн болох улс төрийн тогтвортой байдал, хүчирхийлэл, терроризмээс ангид байх үзүүлэлтээр Монгол Улс сайн үнэлгээтэй явдаг. Сүүлийн бүлэг үзүүлэлт болох хууль дээдлэх ёс, авлигын эсрэг үйл ажиллагаагаар Монгол Улс нь Төв Азийн бүс нутгийн улсуудтай харьцуулахад сайн үнэлгээтэй байгаа боловч дэлхийн жишигтэй харьцуулахад доогуур оноо авсан байна. Мөн засгийн газрын үр ашигтай байдлаар дэлхийн 210 орноос 180 дугаарт жагсжээ. Мөн Монгол Улс нь хууль дээдлэх ёс, авлигын эсрэг үйл ажиллагааны үзүүлэлтээр нэлээд доогуур үнэлэгдсэн. Тус улс нь Азийн бүс нутгийн зарим улсуудтай харьцуулахад давуу тал их байгаа боловч нөөц бололцоогоо хангалттай түвшинд ашиглаж чадаагүй байна.

“Дэлхий дахины засаглалын индекс”-ийн дүнд харьцуулалт хийхийн тулд өөр өөр улсуудад ямар бэрхшээл учирдгийг Та бүхэнд товч дурдъя. Авлигад нэлээд автсан Венесуэль Улсын засаглал дампуурсан гэж үзэж болно. Тус улс нь индексийн бүх үзүүлэлтээр 0 гэсэн үнэлгээг авч байна.

Мөн Өмнөд Америкийн Колумб Улс нь Венесуэль Улсын адилаар Испани Улсын колони байсан түүхтэй. Тус улс нь өмнө дурдсан улсуудтай түүх, нөхцөл байдлын хувьд адил бөгөөд индексийн үзүүлэлтээрээ ойролцоо үнэлгээ авчээ. Гэтэл Уругвай Улс нь засаглалын индексээр АНУ-аас дээгүүр үнэлэгдсэн. Эндээс бид зүй зохистой засаглалтай байхын тулд баян улс байх шаардлагагүй гэсэн дүгнэлтэд хүрч болохоор байна. Уругвай Улс нь үүний тод жишээ юм. Монгол Улстай хөрш БНХАУ-ыг авч үзвэл засаглалын чиглэлийн үзүүлэлтээр сайжирч байгаа боловч авлигын түвшинээр сайжраагүй аж. Мөн ОХУ авлигын үзүүлэлтээр төдийлөн сайн дүгнэгдэхгүй байна.



Хууль дээдлэх ёс

Монгол Улсыг авч үзвэл дуу хоолой ба хариуцлага, улс төрийн тогтвортой байдал, хүчирхийлэл, терроризмээс ангид байх зэрэг үзүүлэлтээр сайн үнэлгээтэй боловч авлигын эсрэг үйл ажиллагааны үзүүлэлт нь сайжрахгүй байна. Тэгэхээр авлигын хор уршгийн талаар хэдэн үг хэлэхийг хүсэж байна. Сайн засаглал нь эдийн засгийн өсөлт, иргэдийн эрүүл мэнд, макро эдийн засгийн тогтвортой байдал, хөрөнгө оруулалт, эдийн засгийн төрөлжүүлэлт, улсын өрсөлдөх чадвар зэрэгт сайнаар нөлөөлдөг чухал хүчин зүйлд тооцогддог. Тухайн улс нь авлигын түвшинг бууруулахад нэг хүнд ногдох орлогыг гурав дахин нэмэгдүүлж болдгийг харж болно. Мэдээж үүнийг нэг шөнийн дотор хийх боломжгүй. Тухайлбал, Чили Улс нь багагүй хугацааг зарцуулсны эцэст нэг хүнд ногдох орлогоо нэмэгдүүлсэн. Цар тахлын үед ч засаглалын асуудлаас шалтгаалж нэг хүнд ногдох орлогын түвшин улс бүрээр харилцан адилгүй байна.



Авлигын эсрэг үйл ажиллагаа

Монгол Улсын хувьд засаглалыг сайжруулах, авлигыг бууруулах чиглэлээр тууштай байр сууриа илэрхийлдэг. Тус улс нь өрсөлдөх чадвараар 210 улсаас 102 дугаар байрт орж байна. Дараагийн нэг чухал асуудал нь санхүүгийн өртөг зардлын үзүүлэлт байдаг. Улс орнууд дэлхийн санхүүгийн зах зээлээс өндөр хүү бүхий зээл босгодог. Гэвч авлигын улмаас буцаан төлөгдөх зээлийн хүүгийн хэмжээ огцом нэмэгддэг. Иймд бид судалгааныхаа загварт энэ нөхцөл байдлыг заавал харгалзан үздэг. Авлигын хор уршиг нь зээл, хөрөнгө оруулалт гэх мэт салбаруудад өртөг зардлыг нэмэгдүүлдэг гэдгийг анхаарах хэрэгтэй. Чили, Европын холбооны улсууд энэ өртөг зардлыг сайтар ойлгон ухамсарладаг тул авлигад тавих хяналтыг улам чангатгадаг. Үүний эсрэгээр авлигад тавих

хяналтыг сулруулснаар макро эдийн засагт сөргөөр нөлөөлж, төсвийн алдагдал улам нэмэгддэг.

Манай судалгааны бас нэг чухал сэдэв нь эдийн засгийг төрөлжүүлэхийн ач холбогдлыг авч үздэг. Зарим улс орнуудын эдийн засаг газрын тос, ашигт малтмалаас маш их хамааралтай байдаг. Малайз Улс нь эдийн засгаа төрөлжүүлэх оролдлогыг маш сайн хэрэгжүүлж байна. Тус улсын эдийн засгийн төрөлжүүлэх арга хэмжээ тодорхой үе шаттай хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн. Гэвч Монгол Улс нь нүүрс, зэсийн экспортоос хамаарал бүхий эдийн засагтай байсаар байна. Эдийн засгийг төрөлжүүлэхгүй бол авлигын өртөг зардал буурдаггүй зүй тогтол бий. Одоогоор Монгол Улс нь эдийн засгийн төрөлжилтийн үзүүлэлтүүдээр дундаж түвшинд явдаг. Цаашид зэрэглэлээ ахиулахын тулд хэрхэн ажиллаж болохыг судалгаанаас дэлгэрүүлэн харж болно.



Малайз Улсын эдийн засгийн төрөлжилт. 2019 оны байдлаар

Монгол Улсын эдийн засгийн төрөлжилт. 2019 оны байдлаар



Мөн мэдээллийн ил тод байдал, хэвлэл мэдээллийн эрх чөлөө авлигыг хазаарлахад ямар чухлыг харж болно. Монгол Улсын хувьд энд багагүй сорилт тулгарч байгаа юм.

Эцэст нь энэ хуралдаанаар хэлэлцүүлж болох зарим саналыг дэвшүүлье. Нэн тэргүүнд засаглалын хувьд гол сорилт бүхий асуудлыг үндэсний стратегид тусгах шаардлагатай. Энэ асуудлаар тус бүрд нь хууль гаргаж болох боловч үндэсний стратегид цогцоор нь авч үзсэнээр үр дүнд хүрэх магадлал өндөр байдаг. Мөн эдийн засгийн засаглалдаа анхаарах шаардлагатай. Үүнд анхаарвал зохих гурван тулгуур багана байдаг. Нэгдүгээрт, эдийн засгийн засаглалаа сайжруулах хэрэгтэй. Авлига макро эдийн засагт эрсдэлийг бий болгодог. Иймд төсөв, мөнгөний бодлогын зүй зохист харьцаанд анхаарах хэрэгтэй. Хоёрдугаарт, эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлж, уул уурхай гэх мэт нэг салбараас хэт их хамаарах байдлыг бууруулах ёстой. Гуравдугаарт, институтийн засаглалд анхаарах шаардлагатай. Энэ чиглэлээр төрийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг шинэчлэх ажлыг улсууд эхлүүлж байна. Тусгай баялгийн сангуудын захиран зарцуулалт, ажиллах журмыг илүү төгөлдөржүүлэх шаардлагатай. Төрийн албадыг улс төрөөс ангид байлгах нь их чухал юм. Мөн ил тод байдлын зарчмыг эн тэргүүн хангах нь зүйтэй юм. Үүнтэй холбоотой үйл ажиллагаа явуулдаг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын талаар та бүхэн мэдэж байгаа. Түүнчлэн эцсийн өмчлөгчийг ил болгох асуудалд онцгой анхаарах шаардлагатай. Түүнчлэн хөрөнгө оруулалтын бодлого, улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг хангах хэрэгтэй.

Эцэст нь илтгэлээ эхэлсэн асуудал руу буцаж очихыг хүсэж байна. Бид түүхийн өвөрмөц үед амьдарч байна. Монгол Улс авлигын эсрэг байр сууриа тууштай хадгалахад улс төрийн хүсэл, манлайлал маш чухал үүрэгтэй юм. Үүнд иргэний нийгмийн тогтолцоо чухал хувь нэмрийг оруулна. Монгол Улсад төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа хэрхэн сайжирч байгааг судалгаанд дурдагдсан тоон үзүүлэлтээс хараад миний сэтгэл ихээр хөдөлж байна. Энэ үйл ажиллагааг та бүхэн тууштай хэрэгжүүлбэл сайн үр дүнд гарцаагүй хүрнэ гэдэг нь эргэлзээгүй. Үүнээс нийт нийгмээрээ хожно. Ирээдүй хойч үе маань эрүүл, итгэлтэй орчинд аж төрөх юм. Ийнхүү би танилцуулгаа өндөрлөө.

УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТ, ОРОЛЦОО

*Улсын Их Хурлын гишүүн,
Авлигын эсрэг Парламентын
бүлгэмийн гишүүн Ц.Мөнхцэцэг*



Энд хүрэлцэн ирсэн зочид та бүхэндээ УИХ-ын Авлигын эсрэг бүлгийн нэрийн өмнөөс мэндчилж байна.

Улсын Их Хурлын Авлигын эсрэг бүлэг төрийн өмчит компани, тэр дундаа уул уурхайн компаниудын орлого, зарлага, санхүүжилтийн ил тод байдлыг хангах, засаглалыг сайжруулах, түүнд тавих олон нийтийн оролцоо, хяналтыг сайжруулах асуудал, мөн авлигын илрүүлэлтэд гол нөлөө үзүүлэх Шүгэл үлээгчийн тухай хууль болон улс төрийн авлигатай холбоотой улс төрийн нам, сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг сайжруулах асуудлаар голлон ажиллаж байна. Энэ удаагийн миний илтгэлд улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал, санхүүжилтэд олон нийт хэрхэн хяналт тавих тухай болон улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар товч танилцуулга бэлтгэсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгч удахгүй Улс төрийн намын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барих гэж байна. Энэ төслийн гол шинэчлэл бол 2019 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орсны дагуу улс төрийн намын хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байх явдал юм. Мөн намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, үндэсний хэмжээнд бодлогын үйл ажиллагаа явуулдаг байх ёстой.

Энэ дашрамд Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахад 10 гаруй жил хамтран ажиллаж ирсэн иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллага, эрдэмтэн судлаачиддаа баярлалаа.

Монгол Улсын өнгөрсөн 30 жилийн үйл явцыг дүгнэн харахад улс төрийн шинэчлэл хамгийн бага хийгдсэн, эрх зүйн зохицуулалт нь хоцрогдсон салбар бол улс төрийн намын санхүүжилт, улс төрийн намын тогтолцооны асуудал байгаа. Тийм учраас улс төрийн намын асуудлыг Үндсэн хуулийн хүрээнд

шинэчлэх, ялангуяа хамгийн их шүүмжлэлд өртдөг улс төрийн санхүүжилт, улс төрийн намууд бизнесийн бүлгээс хараат байх асуудлыг цэгцлэх үүднээс хуулийн төсөл боловсруулж байна.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд олон улсын байгууллага, эрдэмтдээс өгсөн олон санал тусгагдсан. Тухайлбал, өнөөдрийн хууль, эрх зүйн орчин намд олгож буй төсвийн санхүүжилт, түүний хариуцлага тооцох механизм сул, намын санхүүжилт ил тод биш, тайланг олон нийтэд ил тод болгодоггүй, намд олгож буй төсвийн санхүүжилтийн зарцуулалт нь тодорхой бус, улс төрийн өрсөлдөөний тэгш бус байдлыг дэмжсэн байдаг зэрэг шүүмжлэлүүд ирсэн. Энэ шүүмжийг хүлээн авч шинэ хуулийн төсөлд тусган боловсруулж байна. Тухайлбал, Улс төрийн намын тухай хуулийн төсөлд улс төрийн нам гэдгийг шинээр тодорхойлж, улс төрийн нам нь Үндсэн хуульд байгууллага, ардчилсан тогтолцооны зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг гэсэн томъёолол оруулсан. Нам бол ард түмний улс төрийн хүсэл зориг олон нийтийн үзэл бодлыг илэрхийлэх төр ард түмний хооронд байнгын идэвхтэй харилцаа холбоо үүсгэх, иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, жендерийн тэгш оролцоог хангах, хариуцлагатай иргэнийг бэлтгэх, Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтөд оролцох, сонгуульд нэр дэвшүүлэн шударгаар өрсөлдөх зэрэг үүргүүдийг улс төрийн намд хүлээлгэсэн.

Улс төрийн намын тухай хуулийн төсөл дэх гол шинэчлэл бол улс төрийн орчин дахь авлигаас сэргийлэх үүднээс улс төрийн намын санхүүжилтийн зохицуулалтыг чангатгаж улс төрийн намуудад хориглох зүйл, хүлээх үүргийг тодорхой оруулж өгсөн. Тухайлбал улс төрийн намын хандив авах үйл ажиллагаа, намын дотоод сонгууль, намын сонгуулийн болон бусад дотоод ажилд оролцсон гишүүдэд урамшуулал өгдөг зэргээр намын төсвийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлдэг үйл ажиллагаануудыг хориглож байгаа. Намын санхүүжилтийн гол асуудал нь намын санхүүгийн тайлан ил тод байх, намд төсвөөс олгож байгаа зохицуулалтад хяналт тавих, зориулалтыг зааж өгөх зэргээр олон улсын намын санхүүжилтийн гол стандартуудыг нэвтрүүлж байна.

Мөн дараагийн нэг шинэ нэмэлт өөрчлөлт бол улс төрийн намуудын гарааны тэгш өрсөлдөөнийг дэмжих үүднээс УИХ-д суудал аваагүй ч гэсэн сонгогчдын тодорхой хувийн дэмжлэг авсан намуудад төсвөөс хэсэгчилсэн санхүүжилт олгохоор зааж өгсөн явдал. Намууд төсвөөс олгож буй санхүүжилтийг гишүүд, дэмжигчдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дэмжих, нийгмийн бүлгүүдийн төлөөллийг хангах, намын дэргэдэх бодлогын судалгаанд зарцуулахаар хуулийн төсөлд зааж өгсөн.

Улс төрийн намууд энэ хуулийн дагуу томоохон хандивлагч, хөрөнгө

мөнгөтэй цөөн хүмүүсийн нөлөөллөөс гарах ёстой. Үүний тулд намд олгох хандивын дээд хэмжээ, хандивын зарцуулалтыг хатуу зохицуулж өгч байгаа. Тухайлбал, Монгол Улсын иргэн жилд нэг удаа аль нэг улс төрийн намд хандив өгч болно. Гэхдээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй буюу таван сая төгрөг дотор багтааж хандив өгөхөөр хуульчилж байна. Нам хандив өгсөн хүмүүсийг нэг бүрчлэн ил болгоно. Зарцуулалтаа тайлагнана. Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд оролцсон иргэн тухайн тендерийн үйл ажиллагаанд оролцсоноос хойш дөрвөн жилийн хугацаанд намд хандив өгөхийг хориглож байгаа. Энэ нь төрөөс зарлагдаж байгаа тендер худалдан авалтад оролцохын тулд оролцсоны дараа улс төрийн намд шан харамж болгож хандив өгөх эсхүл авлигын шинжтэй үйлдэл хийхийг хориглож улс төрийн нам дахь далд санхүүжилт, хөрөнгө мөнгөний нөлөөг багасгах үр дүн гарна.

Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу намууд үндэсний хэмжээний бодлого явуулах ёстой. Тиймээс энэ хуулийн төсөлд намуудыг цаг зуурын шинжтэй, популист, нэг хүний нөлөөн дэх нам биш, урт хугацааны бодлого дэвшүүлж сонгуульд өрсөлддөг, намын мөрийн хөтөлбөр сонгуулийн мөрийн хөтөлбөр нь харилцан уялдсан, Монгол Улсын хөгжлийн бодлого үнэт зүйл нь Үндсэн хуульд нийцсэн бодлогын нам байхаар зохицуулалтууд орж байна. Бодлогын нам байна гэдэг нь намаас гарч буй шийдвэрүүд шинжлэх ухааны үндэстэй, бодлого судалгаанд үндэслэсэн байна. Үүний тулд ХБНГУ-ын жишгээр намуудын дэргэд бодлогын судалгааны хүрээлэн байгуулагдах ба бодлогын судалгааны хүрээлэн нь тухайн намын бодлогын үйл ажиллагаа хариуцах, төсвийн санхүүжилтийн тодорхой хувийг авч түүгээрээ иргэдийн улс төрийн бодлогын үйл ажиллагааг нэмэгдүүлэх ажил хийнэ.

Намын санхүүжилттэй холбоотой олон улсын жишгийг нэвтрүүлж буй дараагийн нэг зохицуулалт нь намын тайлан гаргах процесс. Намууд үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа жилд хоёр удаа Сонгуулийн төв байгууллага руу хүргүүлж олон нийтэд ил тод мэдээлнэ. Ингэснээр иргэд, олон нийт улс төрийн намын санхүүжилтэд хяналт тавих боломжтой болох юм. Намын тайланд оруулах мэдээлэл, тайлангийн заалт бүрийг төсөлд нарийвчлан оруулж байна. Намууд тухайн тайлант хугацаанд дурдах бүх санхүүгийн орлого, зарлагын зарцуулалтыг аудит хийлгэж Сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ. Үүний дараа Сонгуулийн төв байгууллага тухайн намуудын санхүүгийн тайланд дахин аудит хийнэ.

Санхүүжилттэй холбоотой намд хүлээлгэсэн үүргийг зөрчсөн, тухайлбал, тайлангаа буруу мэдээлсэн, хуулиар хориглосон ямар нэг эх үүсвэрээс

санхүүжилт авах, намын дотоод сонгууль намаас дэвших үйл явцад нэг дэвшигчдээс болон хувь хүнээс хуульд заагаагүй хэмжээний мөнгөн хандив авах, нэр дэвшигчээс дэнчин шаардах зэрэг санхүүгийн хууль бус үйлдэл гаргасан тохиолдолд төсвийг хязгаарлах буюу зогсоох арга хэмжээ авна. Тухайлбал, тухайн улс төрийн нам санхүүжилтийн тайланг удаа дараа буюу хоёр ба түүнээс дээш удаа хугацаандаа өгөөгүй, тухайн улс төрийн нам санхүүжилтийн тайланг удаа дараа буюу хоёр ба түүнээс дээш удаа хугацаандаа дэвшигчдээс болон хувь хүнээс хуульд заагаагүй хэмжээний мөнгөн хандив авах, нэр дэвшигчээс дэнчин шаардах зэрэг санхүүгийн хууль зөрчилтэй, санаатай, илт худал мэдүүлсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт орж байгаа.

Тайланг хүлээж авах, аудитын байгууллага хянах энэ бүхнийг дарааллыг нарийвчлан зохицуулж өгсөн. Улс төрийн намууд жил бүрийн тайлангаа олон нийтэд нээлттэй ил тод байршуулна. Мөн төсвөөс авсан санхүүгийн дэмжлэгийн дагуу зориулалт, үйл ажиллагааны тайланг тусад нь гаргаж өгөхөөр заасан. Намын тайлан цахимд ил тод болсноор иргэд болон иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавих ач холбогдолтой. Тухайлбал, намын хандив гэх зэрэг санхүүжилттэй холбоотой тодорхой асуудлыг илрүүлэх, ашиг сонирхлын зөрчилтэй этгээдээс хандив авсан эсэхийг ил тод харах боломж бүрдэж байна.

Энэ бүхний үндсэн дээр улс төрийн намын тогтолцоо, санхүүжилтэд өөрчлөлт оруулж чадах юм бол Монгол Улсын авлигын индексийг бууруулах, улс төр дэх хөрөнгө, мөнгөний нөлөөг багасгах, улс төрийн үйл явц дахь ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чухал алхам болно. Ингээд иргэний нийгмийн болон хууль, хүчний байгууллагууд, Авлигатай тэмцэх газар Улс төрийн намын тухай хуулийн төсөлд санал өгч хамтран ажиллахыг урьж байна.

Авлигын эсрэг хүн бүр дуу хоолойгоо өргөө.

Баярлалаа.

◆ “АВЛИГЫН ЭСРЭГ
ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН-2021”

Талбар хэлэлцүүлгээ 1

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН,
ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
ХАМТЫН АЖИЛЛАГАА**



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ХУУЛИЙН


АВЛИГЫН ЭСРЭГ НУБ-ЫН КОНВЕНЦИ БА ДОТООДЫН ХУУЛЬ ТОГТООМЖ

*Авлигатай тэмцэх газрын хэлтсийн
дарга, эрхэлсэн комиссар Р.Баярмагнай*



АВЛИГЫН ХЭРГИЙГ ХЯНАН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

*Улсын ерөнхий прокурорын орлогч,
төрийн хууль цаазын шадар зөвлөх
М.Чинбат*



АВЛИГЫН ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

*Улсын дээд шүүхийн шүүгч, Эрүүгийн
танхимын тэргүүн Ч.Хосбаяр*



БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГ: ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТОДОТГОЛ АВЛИГЫН ЭСРЭГ ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН ЯВЦ

*Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн
бодлогын газрын дарга П.Сайнзориг*

АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АНХААРАХ АСУУДАЛ

*Монголын хуульчдын холбооны удирдах
зөвлөлийн гишүүн, хуульч Л.Галбаатар*

АВЛИГА БА ХҮНИЙ ЭРХ

*Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн,
хууль зүйн ухааны доктор Д.Сүнжид*



АВЛИГЫН ЭСРЭГ НҮБ-ЫН КОНВЕНЦ БА ДОТООДЫН ХУУЛЬ ТОГТООМЖ

*Авлигатай тэмцэх газрын
хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар
Р.Баярмагнай*

Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан зохион байгуулж байгаа “Авлигын эсрэг форум-2021” арга хэмжээнд хүрэлцэн ирсэн эрхэм хатагтай, ноёд, төрийн болон төрийн бус байгууллага, судлаачид, иргэд, аж ахуйн нэгж, дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын төлөөлөл болон хэвлэл мэдээллийн төлөөллүүд та бүгдэд энэ өдрийн мэнд дэвшүүлье.

Өнөөдрийн арга хэмжээнд манай байгууллагын зүгээс хариуцсан чиг үүрэг тус бүрийн хүрээнд хийж хэрэгжүүлж байгаа ажлуудыг тодорхой танилцуулсан учраас та бүгдэд ойлгомжтой, тодорхой байлгах үүднээс дараах 3 сэдвийн хүрээнд товч танилцуулахаар бэлтгэлээ.

1. Гадаад хамтын ажиллагаа /international cooperation/
2. Хөрөнгө буцаах /asset recovery/
3. Хохирол нөхөн төлүүлэх /compensation of damage/

1. Гадаад хамтын ажиллагаа чиглэлээр /international cooperation/

Авлигатай тэмцэх газар нь хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд гадаад улсын хууль сахиулах байгууллага, авлигатай тэмцэх байгууллага болон авлига, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллага, сүлжээтэй хамтран ажиллаж байна.

Эдгээр байгууллагад хүсэлт гаргаснаар иргэн, хуулийн этгээдтэй холбоотой мэдээлэл гаргуулан авч болохоос гадна Монгол улсын иргэн, хуулийн этгээдийн тухайн улсад хөдлөх, үл хөдлөх хөрөнгөтэй, банканд данстай талаар мэдээлэл ирүүлдэг.

Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцид Монгол Улс 2005 онд нэгдэн орж, Улсын Их Хурал 2005.10.27-ны өдөр соёрхон баталсан. Тус конвенцид дэлхийн 189 нэгдсэн орсон байдаг бөгөөд авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой

иргэн, хуулийн этгээдийн талаарх мэдээ, мэдээллийг шаардлагатай тохиолдолд гаргуулан авах үүд хаалга нээлттэй болсон.

Конвенцид авлига, мөнгө угаах гэмт хэрэг, түүнээс олсон хууль бус хөрөнгө, орлогын байршил, шилжилт хөдөлгөөн, тэдгээрийг хувиргах, нуун далдлах зэрэг хэрэгт ач холбогдол бүхий мэдээллийг Конвенцийг үндэслэн гадаад орны эрх бүхий байгууллагатай харилцан мэдээлэл солилцож, цаашлаад хууль бус хөрөнгө, орлогыг битүүмжлэх, царцаах, хураан авах, буцаан авчрах ажиллагааг хийж гүйцэтгэх эрх зүйн орчныг тусгасан байдаг.

Манай улс 20 улстай эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Авлигатай тэмцэх газраас сүүлийн 5 жилд Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн хүрээнд болон эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний дагуу БНХАУ-ын ЗЗОБ Хонгконг, Швейцар, Панам, Австри, Англи, АНУ, ОХУ, Франц, Латви зэрэг улс орнуудын холбогдох байгууллагууд руу MLA /mutual legal assistance/ буюу Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт илгээж, мэдээлэл солилцож, мөрдөн шалгах ажиллагаанд нотлох баримтын хэмжээнд ашиглаж байна.

Оффшор бүс болох БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Хонгконг муж, Сингапур, Сейшель, Гибралтар, Бермуд, Британийн Виржинийн арлууд, Кипр зэрэг улсуудын санхүүгийн тагнуулын алба, Авлигатай тэмцэх байгууллагуудад хандан шаардлагатай иргэд, аж ахуйн нэгжийн мэдээллийг нотлох баримтын хэмжээнд гаргуулан авахаар хүсэлтийг илгээж, мэдээлэл солилцон хамтран ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газар нь Харилцан ойлголцлын санамж бичгийг БНХАУ, БНСУ, ИБУИНВУ, Тайланд, Австри, Азербайжан, Казахстан улсуудтай байгуулан хамтран ажиллаж байна.

Олон улсын сүлжээний талаар:

Хууль сахиулах байгууллага хоорондын хамтын ажиллагаанаас гадна бид олон улсын сүлжээг ашиглан хууль бус хөрөнгө, орлогын байршил, шилжилт хөдөлгөөн зэрэг сэжигтэй гүйлгээний мэдээллийг шуурхай тогтоож чаддаг болсон. Өнгөрсөн хугацаанд /2017 оноос хойш/ бид олон улсын сүлжээгээр 625 этгээдэд холбогдох 85 хүсэлт хүргүүлж, 478 этгээдэд холбогдох 73 хүсэлтийн хариуг авч чадсан.

Манай байгууллага олон улсын сүлжээтэй хамтран ажилласнаар:

- ★ Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээтэй улс орнууд, Олон Улсын байгууллагуудтай харилцах, мэдээлэл солилцох ажиллагаа сайжирсан;
- ★ Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцид нэгдсэн аль ч улстай харилцах, мэдээлэл солилцох боломжтой болсон;

- ✦ Ингэснээр оффшор бүс дэх мэдээлэл, гадаад шилжүүлэг гүйлгээг хянах боломж бүрдсэн;
- ✦ Оффшор бүсэд угаагдаж орж ирсэн хөрөнгийг хураах, улсын орлогод төвлөрүүлэх ажил шат дараатайгаар явагдаж байна;
- ✦ Гадаад хамтын ажиллагаа сайжирснаар гэмт хэргийг бүрэн гүйцэд тогтоон шийдвэрлэж байна;
- ✦ Хэргийг богино хугацаанд шийдвэрлэхэд ахиц гарсан.

Гадаад хамтын ажиллагаа сайжирснаар оффшор бүс дэх мэдээлэл, гадаад шилжүүлэг гүйлгээг харж, хянах бүрэн боломжтой болсон. Нуугдмал хөрөнгийг тогтоох, илрүүлэх, хөрөнгө царцаах, хураах, хулгайлагдсан хөрөнгийг эх орондоо буцаан авах чиглэлээр 2019-2021 онд олны анхаарал татсан онцлог, өндөр дүнтэй хэргүүдийг шийдвэрлэсэн.

Авлигатай тэмцэх газраас гадаад улсын эрх бүхий байгууллагад 2015 оноос хойш эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай 36 хүсэлт явуулсан бөгөөд 14 улсаас хүсэлтэд заасан хариуг ирүүлсэн байна. Үүнд: ОХУ, АНУ, Австрали, Канад, Швейцар, Панам, Австри, Британийн Виржиний Арлууд, Украин, Латви, Франц зэрэг орнуудаас хариуг авч, эрүүгийн хэрэгт хавсарган нотлох баримтаар ашиглаж байна.

Нэг оронтой гэрээ байгуулахаас илүүтэйгээр тухайн бүс нутгийг хамарсан гэрээнд нэгдэн орох нь мэдээллийн сүлжээ томорч, илүү дэлгэрэнгүй мэдээллийг олон эх сурвалжаас шуурхай гаргуулан авах боломж бүрддэг. Тухайлбал, Европын холбооны конвенцод нэгдэн орвол тухайн конвенцод нэгдэн орсон Европын холбооны бүх гишүүн оронтой мэдээлэл харилцан солилцох боломж бүрддэг.

Мөн бичиг цаасаар харилцахаас илүүтэйгээр хоёр талт нүүр тулсан уулзалт хийх нь мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг болж, ахиц гаргахад чухал нөлөө үзүүлдэг.

Дэлхий даяар “Ковид-19” цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж бүхий л салбар уналтад орсон хэдий ч цар тахлын үед хэд хэдэн хэрэгт шаардлагатай мэдээллийг оффшор бүсээс гаргуулан авах ажлыг богино хугацаанд үр дүнтэй зохион байгуулж чадсан.

Хэргийн жишээ:

Төрийн өмчит үйлдвэрийн газрын удирдах албан тушаалд ажиллаж байсан эрх бүхий албан тушаалтнууд нь оффшор бүсэд үүсгэн байгуулсан “Х” компаниараа дамжуулж, эрх мэдэл албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, төрийн өмчит компаниас зохион явуулсан тендер, шууд худалдан авалтын ажилд мэдээлэлд ойр байдлаа давуу байдал болгон ашиглаж оффшор компаниараа их хэмжээний мөнгө угаасан хэргийг илрүүлэн шалгасан.

Тус гэмт хэрэгт олон улсын сүлжээ ашигласан талаар: Олон улсын сүлжээг ашиглан 4 улс руу 5 хүсэлт явуулан ажилласан.

Уг гэмт хэрэгт Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх талаар Британийн Виржиний арал, Латви, БНХАУ-ын ЗЗОБ Хонгконг улсууд руу эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хүсэлт явуулж Британийн Виржиний арал болон Латви улсаас хариу авч, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу ашигласан.

2. Хөрөнгө буцаах чиглэлээр /asset recovery/

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42 дугаар бүлэгт заасан Гадаад улсын нутаг дэвсгэрт тодорхой ажиллагаа явуулах шаардлагатай бол уг асуудлыг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай болон олон улсын бусад гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ.

Хөрөнгө буцаах ажиллагааг Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн 5 дугаар бүлгийн 51-59 дүгээр зүйлд тусгасан бөгөөд авлигын гэмт хэргийн улмаас гадаад улсад хөдлөх, үл хөдлөх хөрөнгө болгон хувиргасан хөрөнгийг эх орондоо эргүүлэн авах, хууль ёсны эзэмшигчд нь хүлээлгэн өгөх үйл ажиллагааг энэхүү Конвенцийн тулгуур зарчмаар тодорхойлсон бөгөөд дээрх үйл ажиллагаанд оролцогч улсууд бие биетэйгээ хамгийн өргөн хүрээнд хамтран ажиллаж, туслалцаа үзүүлнэ гэж заасан.

Хөрөнгө буцаах үйл ажиллагааг товчоор тайлбарлавал: Гэмт хэргийн замаар олсон хөрөнгө, орлогоо нуун далдлах, гэмт хэргийн ул мөрөө арилгах зорилгоор гадаад улсын банк санхүү болон бусад салбаруудын үйл ажиллагаагаар дамжуулан шилжүүлж, хувиргаж мөнгөө угаан хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө болгон байршуулсныг олж илрүүлэн хохирогч талд буцаан авч ирэх үйл ажиллагааг хэлнэ.

Хөрөнгө буцаан авч ирсэн хэргийн талаар:

Авлигатай тэмцэх газрын зүгээс төрийн өмчит үйлдвэрийн газрын нэр бүхий албан тушаалтнууд болох Д, Г нар нь урьдчилан үгсэн тохиролцож албан тушаалын байдлаа урвуулан ашиглах байдлаар оффшор бүсэд үүсгэн байгуулсан аж ахуйн нэгжээрээ төрийн өмчит үйлдвэрийн газарт бараа, материал нийлүүлэх ажлыг тогтмол авах байдлаар хууль бус аргаар ашиг олж, Монгол Улсад их хэмжээний хохирол учруулсан хэрэгт санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа дотоодод болон гадаад улс орнуудтай хамтран явуулж Г нь хууль бус хөрөнгөө угаах зорилгоор ИБУИНВУ-ын Лондон хотын төвд 1,100,000 фунт стерлинг буюу өнөөдрийн ханшаар 4,3 тэрбум төгрөгийн үнэлгээтэй орон сууц худалдан авч мөнгөө угаасан болохыг тогтоон, уг хөрөнгийг эх орондоо

буцаан авах зорилгоор гадаад хамтын ажиллагааг зохион байгуулж 2021.09.16-ны өдөр 4300000000 тэрбум төгрөгийн хохиролд дүйцүүлэн Лондон хотын “А” бүсэд байрлах үл хөдлөх хөрөнгийг төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгүүлж, хулгайлагдсан хөрөнгийг эх орондоо авчрах ажлыг богино хугацаад үр дүнтэй зохион байгуулсан сайн туршлага бидэнд байна.

Мөн дээрх хэргийн хүрээнд үйлдвэрийн инженер Д-ээс улсад учруулсан хохиролд 2020 онд 700000000 сая төгрөг, 388,000 ам.доллар буюу тухайн үеийн ханшаар 1 тэрбум 344 орчим сая төгрөгийг тус тус Төрийн сангийн дансанд төвлөрүүлж, хууль бус хөрөнгөө угааж Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт худалдан авсан байсан 269000000 сая төгрөгийн үнэлгээтэй орон сууцыг илрүүлэн, төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгүүлж шилжүүлсэн бөгөөд Д-ээс нийт 2 тэрбум 700 орчим сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн.

ГУРАВ: Хохирол нөхөн төлүүлэх /compensation of damage/

Эрүүгийн хуулийн 6 дугаар бүлгийн 6.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Шүүх хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн хүний хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан хохирол нөхөн төлөх хугацааг тэнссэн хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болно” гэж, Эрүүгийн хуулийн 7 дугаар бүлгийн 7.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг хураан авч хадгалах, устгах, гэмт хэргийн хохирол нөхөн төлөхөд зарцуулна” гэж тус тус заасан.

Сүүлийн 5 жилд хохирол нөхөн төлүүлсэн талаар:

Авлигатай тэмцэх газраас 2017 онд 3.4 тэрбум, 2018 онд 17.5 тэрбум, 2019 онд 11.3 тэрбум, 2020 онд 35.6 тэрбум, 2021 оны эхний 11 сарын байдлаар 96.2 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж ажилласан.

Хохирол нөхөн төлүүлсэн байдлыг ангилж авч үзвэл:

2021 оны эхний 11 сарын байдлаар Сангийн яамны Төрийн сангийн дансанд 8.1 тэрбум, Монгол улсын хөгжлийн банканд 2.4 тэрбум, Монгол банканд 62 тэрбум, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд 110 сая, Төрийн байгууллагын дансанд 8.1 тэрбум, Улсын орлогод оруулсан хөрөнгө, барилга байгууламж, газар 7.3 тэрбум, бусад 4.5 тэрбум төгрөг буюу нийт 96.2 тэрбум төгрөгийн хохирол нөхөн төлүүлэн ажиллаж байна.

Анхаарлаа хандуулсанд баярлалаа.



АВЛИГЫН ХЭРГИЙГ ХЯНАН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

*Улсын ерөнхий прокурорын орлогч,
төрийн хууль цаазын шадар зөвлөх
М.Чинбат*

Авлигын эсрэг үндэсний чуулганд оролцож байгаа хүндэт зочид, төлөөлөгчид Та бүхний энэ өдрийн амар амгаланг эрэн мэндчилье.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 онд баталсан Авлигын эсрэг конвенцийг Монгол Улсын Их Хурал 2005 онд соёрхон баталснаас хойш 16 жилийн хугацаа өнгөрч байна.

Манай улс Авлигын эсрэг хуулийг баталж, 2016 онд “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг, 2017 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан гаргаж, авлигатай тэмцэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Олон улсын “Транспаренси Интернэшнл” байгууллагаас “Авлигын төсөөллийн индекс”-ийг танилцуулсан дүнгээс үзэхэд, Монгол Улс 2020 онд авлигын индексээр 35 оноо авч 111 дүгээр байрт жагсаж, өмнөх оноосоо зургаан байраар ухарсан нь анхаарах асуудлын нэг болоод байна.

Нийгмийн харилцааны хувьсал, өөрчлөлттэй холбоотойгоор эрүүгийн хууль тогтоомжийг дэлхий нийтийн чиг хандлага, зарчимд нийцүүлж боловсронгуй болгох, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд бодит байдлыг тогтоохын тулд асуудлыг тал бүрээс нягтлан шалгаж, шуурхай шийдвэрлэх, хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, шударгаар шүүлгэх эрхийг хангах зохицуулалтыг шинэчлэн баталсан *Эрүүгийн* хууль тогтоомжууд хэрэгжээд багагүй хугацаа өнгөрч байна.

Прокурорын байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцон, хүний эрх, эрх чөлөө, төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх,

зөрчигдсөн эрхийг сэргээхэд хяналтаа чиглүүлэн ажиллаж байна.

Өнгөрсөн хугацаанд авлигын гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлтийн байдал, хэрэг шалгах ажиллагаа удааширсан шалтгаан, нөхцөлийг судалж, гарч буй хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг тухай бүр нь тодорхойлж ирсэн байна.

Прокуророос 2019 онд авлигын 1042 гэмт хэрэгт хяналт тавьж, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан 228 хэргийн 38.1 хувийг, 2020 онд 1110 хэрэгт хяналт тавьж, мөрдөн байцаалтын 337 хэргийн 52.2 хувийг, харин 2021 оны эхний 11 дүгээр сарын байдлаар 1064 хэрэгт хяналт тавьж, мөрдөн байцаалтын 340 хэргийн 47.0 хувийг шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлжээ.

Олон үйлдэл, холбогдогч, хохирогчтой, ээдрээ төвөгтэй, зохион байгуулалттай үйлдсэн гэмт хэргийг хуульд заасан үндэслэл журмын дагуу тал бүрээс шуурхай, бүрэн шалгуулах, хууль зүйн үндэслэлтэй шийдвэр гаргуулах үүднээс зэрэгцэж хяналт тавих прокуроруудыг томилон ажиллуулж, тэднийг дагнан мэргэшүүлэхэд анхаарч ажиллалаа.

Мөрдөн шалгах хэд хэдэн байгууллагын харьяалан шалгах хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хамтарсан ажлын хэсэг байгуулан шалгуулж байгаа нь хэргийг шуурхай шийдвэрлэхэд бодит үр дүнгээ өгч байна.



Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд эрх зүйн болон санхүү, эдийн засгийн өндөр түвшний мэдлэг, ур чадвар, туршлагаас гадна хэрэг шалгах ажиллагаа өргөн цар хүрээг хамарсан, цаг хугацаа, хөрөнгө, хүч их шаардсан, зарим хэргийн холбогдогч төрийн өндөр албан тушаал эрхэлдэг зэргээс

шалтгаалан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учирч байна.

Гэмт хэрэг үйлдэх арга нарийсаж, илүү зохион байгуулалттай болж байгаатай холбоотойгоор мөрдөгч, прокурорууд мэдүүлэгт тулгуурлан хэрэг шийдвэрлэхээс аль болох татгалзаж, банк санхүү, нягтлан бодох бүртгэлийн баримт, мөнгөний урсгалыг хөөж шалгах, мөрдөгчийн магадлагааг түгээмэл хэрэглэх байдлаар өөрсдийн үйл ажиллагааны хандлага, нотлох баримт цуглуулах арга барилыг өөрчлөх шаардлагатай байна.

Авлигын гэмт хэргийн улмаас хууль бусаар олсон эд хөрөнгө, бэлэн ба бэлэн бус мөнгө, ялангуяа банк, томоохон аж ахуйн нэгж, орд газрын хувь эзэмших эрх олж авах, түүнийгээ бусдын нэр дээр шилжүүлэх, эсхүл бусдаар дамжуулан хөрөнгө, хувьцаагаа зарж, олсон ашгаа гадаад улс, оффшор дансанд байршуулах, өөрийн гэр бүл, хамаатан садан, найз нөхдийн нэр дээр үл хөдлөх эд хөрөнгө, хувьцаа, лиценз худалдан авах зэргээр авлигын хэлбэр дүрсийг хувиргах ажиллагаа ихэвчлэн зохион байгуулалттай явагддаг.

Авлигын гэмт хэрэг глобал шинжтэй, улс дамжсан хэлбэртэй болж байх тул гэмт хэргийг илрүүлэх, хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг буцаан авах, нотлох ажиллагааг гүйцэтгэхийн тулд гадаад улсуудын байгууллагатай хамтран ажиллаж байна.

Гадаад улсын нутаг дэвсгэрт мэдүүлэг авах, үзлэг, нэгжлэг, туршилт хийх, эд хөрөнгө хураан авах шаардлагатай бол энэхүү ажиллагааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу хийдэг.

Прокурорын байгууллагаас гадаад улс орнуудад эрх зүйн туслалцааны хүсэлтийг хүргүүлж байгаа боловч тэр бүр хугацаандаа хариу ирдэггүй нь авлигын хэргийг шалгах ажиллагаа удаашрах нөхцөл болж байна.

Мөрдөх байгууллагууд Улсын ерөнхий прокурорын газраар дамжуулан 2019 онд 29, 2020 онд 34, 2021 оны эхний 11 дүгээр сард 16, нийт 79 хүсэлт, даалгаврыг гадаад улсад илгээсэн ч дийлэнх хүсэлтийн хариу хүлээгдэж байна.

Иймд гадаад орны хууль хяналтын байгууллагатай мэдээлэл шуурхай солилцон, хамтарч ажиллах эрх зүйн орчныг сайжруулах нь нэн түрүүнд шийдвэрлэх ёстой асуудлын нэг гэж харж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2000 оны Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Конвенцийг Монгол Улсын Их Хурлаас 2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр соёрхон баталсан.

Уг конвенцид “...оролцогч улсууд олон улсад мөрдөн байцаалт, шүүхийн ажиллагаа, эсхүл хамтарсан мөрдөн байцаалт явуулж болно. ...мөрдөн байцаалт явагдах улсын бүрэн эрхт байдлыг бүрэн дүүрэн хүндэтгэх нөхцөлөөр хангана” гэж заасан.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хэм хэмжээ болон дээрх Конвенцид нийцүүлж, мөрдөн шалгах ажиллагаа явуулах боломжийг эрэлхийлэх нь зүйтэй байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг

төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх талаар заасан.

Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх нь чухлаар тавигдаж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, албан тушаалтан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын төлөвлөлт, явц, үр дүнгийн нууцлалыг хангаж ажиллана, шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хүн, хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй, шүүх гаргах гэж байгаа шийдвэр, яллагдагчийн гэм буруутай эсэх асуудлаар байр суурь, саналаа урьдчилан илэрхийлэх, шүүх, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, шинжээч, мэргэжилтэн хуулийн хүчин төгөлдөр шийдвэр гарах хүртэл яллагдагчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж олон нийтэд мэдээлэхийг хориглоно” гэж, Мэдээллийн ил тод байдлын тухай хуульд, ...хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай бол мэдээллийг бусдад задруулахыг хориглоно гэж тус тус хуульчилсан.

Гэвч авлигын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэх талаар шүүхийн шийдвэр гараагүй байхад Мөрдөх байгууллагад шалгагдаж байгаа хэрэг, хүн, хуулийн этгээд, мөрдөн шалгах ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээ ашиглан, бодит байдалд нийцээгүй мэдээлэл гаргасаар байна. Монгол Улсын Үндсэн хуульд, гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд халдаан хэрэглэхийг хориглоно гэж заасан.

Хэдийгээр хэрэг үйлдсэн этгээдийн гэр бүлийн гишүүний эрхийг мөрдөн шалгах ажиллагааны явцад хязгаарлаагүй боловч олон нийтэд мэдээлэгдсэн мэдээллийн улмаас тухайн гэр бүлийн гишүүд эрх, эрх чөлөөгөө эдэлж чадахгүй, нийгэм, хамт олны зүгээс шүүмжлэлд өртөж, энэ нь ял зэмлэлийг давхар халдаан хэрэглэсэнтэй ижил хэмжээний үр дагаврыг бий болгодог.

Иймд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлалыг ханган, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхийн тулд дээр дурдсан хууль бус ажиллагааг таслан зогсоож, хууль зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх нь зүй ёсны хэрэг юм.

Авлигын гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь нэн чухал боловч авлигатай тэмцэх үйл ажиллагаа гагцхүү хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдах ёстой.

Энэ төрлийн гэмт хэргийг шалгаж шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийн зөрчил гаргахгүй байх нь хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд

иргэдийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх, цаашлаад авлигын хэргийг илрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоог сайжруулахад чухал ач холбогдолтой.

Шүүхээс авлигын гэмт хэрэгт оногдуулж байгаа ял шийтгэлийн төрөл, хэмжээ нь үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, учруулсан хохирол, хор уршигтай харьцуулахад хэт хөнгөн байгаа талаар олон нийтийн зүгээс шүүмжлэлтэй хандаж байна.

Эрүүгийн хуульд заасан, авлигын 11 төрлийн гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн төрөл, хэмжээг авч үзэхэд, 40 сая хүртэлх төгрөгөөр торгох, 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрх хязгаарлах, эсхүл 6 сараас 12 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар хуульчилсан бөгөөд хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 3-12 жил байна.

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар, авлигын бүх төрлийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжтой байна.

Учруулсан хохирол, хор уршгийг арилгасан байх шаардлагыг авлигын хэрэг үйлдсэн этгээд хангасан гэж үзэж, хэргийг хялбаршуулж шийдвэрлэж байгааг ч дахин авч үзэх шаардлагатай байна.

Энэ төрлийн гэмт хэрэг ихээр үйлдэгдэж буй улс орон хөгжилгүй, ард иргэд нь ядуу байдаг талаар судлаачид онцолжээ. Өөрөөр хэлбэл, авлигын гэмт хэрэг улс орны хөгжилд саад болж, эдийн засаг, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн үр ашгийг бууруулах хүчин зүйл болж, улс үндэстний аюулгүй байдалд заналхийлж байдгаараа бусад төрлийн гэмт хэргээс нийгмийн хор аюулын хувьд хэд дахин илүү юм.

Тиймээс авлигын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн төрөл хэмжээг гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, учруулсан хохирол, хор уршгийг харгалзан, бусад төрлийн хэргээс ялгамжтай, оновчтой байдлаар тогтоох, хэргийн хөөн хэлэлцэх хугацааг уртасгах, түүнчлэн энэ гэмт хэрэгт хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах нөхцөлийг тусгайлан авч үзэх байдлаар хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхээс хамтран ажиллах этгээдээр тогтоох үндэслэлийг хуульчилсан бөгөөд авлигын гэмт хэрэгт хамтран ажиллах этгээдийг тогтоох хууль зүйн зохицуулалт бүрхэг байна.

Иймд авлигын гэмт хэргийн мэдээлэгч, хэрэг илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн этгээдийн эрхийг хэрхэн хамгаалах талаар хууль эрх зүйн орчинг сайжруулснаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал хөшүүрэг болно.

Анхаарал тавьсанд талархаж, чуулганы үйл ажиллагаанд амжилт хүсье.



АВЛИГЫН ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

*Улсын дээд шүүхийн шүүгч,
Эрүүгийн танхимын тэргүүн
Ч.Хосбаяр*

Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс 2021 оны 10 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд хяналтын шатны шүүхээр хянан хэлэлцэгдсэн албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэсэн байдлын талаар судалгаа хийхэд Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан 55 гэмт хэрэг хүлээн авснаас прокурорт буцаасан 6, хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон 1 хэрэг гарчээ.

Хэргийг эцэслэн шийдвэрлээгүй, эсхүл хэрэгсэхгүй болгосон тохиолдлуудад дүн шинжилгээ хийхэд нотлох ажиллагаатай холбоотойгоор хэргийн бүрдэл хангагдаагүй үндэслэлээр дахин мөрдүүлэхээр прокурорт буцаасан, хөөн хэлэлцэх хугацаатай холбоотойгоор хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн дээрх хоёр нөхцөл байдал хэдий олон биш боловч ийм үр дүнд хүргэсэн шалтгаанаараа илүү анхаарал татахаар байна.

Шүүхийн тогтоолуудын үндэслэлтэй танилцахад авлига, албан тушаалын зарим гэмт хэргийг нотлох ажиллагааны онцлогийг шүүх үл хүлээн зөвшөөрч оролцогчийн эрхийг хууль бусаар хязгаарласан байна гэж үзэж зарим баримтат мэдээллүүдийг нотлох баримтаас хасаж тооцсоноос нотолгооны хүрэлцэхүйц байдал алдагдаж улмаар нэмэлт нотолгоо цуглуулах шаардлагатай гэсэн үндэслэлээр хэрэг прокурорт буцсан, дараачийн тохиолдолд шүүгдэгчийн гэм буруу тогтоогдсон боловч хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой хуулиудын зөрчилт байдал бий болсноос түүнийг зөв тооцож эс чадан төөрөгдөн хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн гэж шүүх дүгнэж хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдлууд байгаа нь цаг алдалгүй засах, залруулах шаардлагатай асуудлууд мөн гэж Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим үзсэн.

Дээрх агуулга бүхий анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэрүүд

хяналтын журмаар хянагдаж анх эхэлсэн үеэс буюу 2018 оны II улирлаас шүүхийн практикт үндэслэсэн хуулийн зөв хэрэглээг тогтоосон тогтоолууд гаргах¹ болон сургалтын хэлбэрээр зөвтгөх арга хэмжээнүүдийг авснаар эхний тохиолдол буюу нотлох ажиллагааны онцлогоос хамааралтай хэрэг буцах нь эрс багассан боловч хөөн хэлэлцэх хугацааг буруу тооцох явдал шүүхүүдийн дунд байсаар, цаашдаа нэмэгдэх хандлагатай, энэ талаар шүүхүүд саналын зөрүүтэй хэвээр байна.

Асуудал нэг.

Хэргийн талаар заавал нотлох байдлууд болон нотлох үүрэг² хэнд ногдож байгаа талаар хууль сахиулах, прокурорын байгууллагууд болон шүүхүүдийн хооронд үүссэн үл ойлголцол нь ихэвчлэн албан тушаалын эсрэг болох үндэслэлгүй хөрөнгөжих, түүнтэй голдуу хамт үйлдэгддэг эдийн засгийн эсрэг болох мөнгө угаах, татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргүүдийг шүүхээр шийдвэрлэх явцад бий болжээ.

Дээрх гэмт хэргүүдийг мөрдөн шалгаж нотлох, хариуцлага хүлээлгэхэд баримтлах тусгай зарчим нь нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйн төлөө бус харин түүний илэрсэн үр дагаварт хариуцлага хүлээлгэх байдлаар нийгэмд асар их хор уршиг учруулдаг атлаа хэргийг илчлэх гэрч, хохирогчгүйгээс гадна нууц далд аргаар үйлдэгддэгийн³ улмаас нотлоход бэрхшээлтэй зарим төрлийн гэмт хэрэгтэй хийх тэмцлийг бодитой, үр дүнтэй болгох зорилгоор хуульчдын бүтээсэн эрүүгийн эрх зүйн өвөрмөц механизм юм. Олон улсын эрүүгийн практикт тун цөөн тооны гэмт хэргийг, эсхүл түүний зөвхөн зарим шинжийг нотлоход хязгаартай хэрэглэгддэг чанд хатуу эрх зүйн арга хэрэгсэлд тооцогдоно.

Авлигын гэмт хэргийн тухайд албан тушаалтны албаны эрх мэдлээ урвуулсан тухайн үйлдэл, эс үйлдэхүйг шалгаж тогтоохгүйгээр зөвхөн үр дүнд нь бий болсон орлогыг хууль бус болохыг *vice versa*⁴ нотолсноор энэ хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх шалгуур хангагдсанд тооцдог нотолгооны хялбаршуулсан стандартыг үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийг мөрдөн шалгахад хэрэглэнэ. Энэ процедур нь эрх зүйн философи, эрүүгийн болон эрүүгийн процессын эрх зүйн суурь зарчмууд, түүнд суурилсан нотлох ажиллагааны онолд харшилддаггүй, логик-учир зүйн онолоор бүрэн тайлбарлагдахын зэрэгцээ оролцогчдын эрхийн зарим хамгаалалтыг хүчлэн

1 УДШ-ийн 2018 оны 05 дугаар 30-ны өдрийн 249 дүгээр тогтоол

2 Burden of Proof

3 USAID. The Asia Foundation. Хууль зүйн үндэсний хүрээлэн. Авлига, албан тушаалын гэмт хэрэг. Хуульчдад зориулсан гарын авлага. УБ., 2014

4 Эсрэг талаас нь нотлох буюу энэ тохиолдолд “хууль ёсны болох нь нотлогдохгүй байх”-ыг хэлж байна. Зохиогч

тусгаснаар шүүгдэгчийн процессын эрхэд эрсдэл учруулахгүйгээр албан тушаалын гэмт хэргийг нотлох, хариуцлага хүлээлгэх боломжийг нэмэгдүүлдэг үр дүнтэй арга хэрэгсэл гэдэг дээр улсууд санал нэгдээд байна.

Анхан болон давж заалдах шатны шүүхийн хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэснээс бусад шийдвэрүүдийн хувьд “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” тодорхой гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа Эрүүгийн болон Эрүүгийн процессын 2002, 2015 оны хуулиудад тусгагдсан гэмт хэргийн бүх шинжийг нотлох, хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоохын тулд хуульд заасан бүх арга хэмжээг авах, шүүгдэгчээс гэм буруугүй болохыг өөрөөр нь нотлуулахаар шаардахгүй байх, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар албадахыг хориглох, шүүгдэгчид сонсгосон ялыг нотлох үүргийг прокурор хүлээх зарчмуудад нийцээгүй талаар онцлон зааж хэргийн талаар нотолбол зохих асуудлууд бүрэн шалгагдаж тогтоогоогүй болохыг тэмдэглэн шүүгдэгчийн процессын эрхүүд зөрчигдсөн болохыг дурдаж, хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдлууд цөөн боловч байна. Зарим хэргийг шүүх эцэслэн шийдвэрлэж шүүгдэгчид ял оногдуулсан боловч хэргийн зүйлчлэлийг өөрчилснөөр яг “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэгт ял шийтгүүлсэн тохиолдол маш цөөн гарчээ.

Эндээс харахад “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэргийн мөн чанар, шинж нь гэмт хэргийн сонгодог тодорхойлолтоос ялгаатай, түүнийг нотлох ажиллагааг эрүүгийн процессын нийтлэг зарчмаас өөр хандлагад тулгуурлан явуулдагас мөрдөн шалгах ажиллагааг хийж гүйцэтгэдэг болон түүнд хяналт тавьдаг, улмаар хянан хэргийг шийдвэрлэдэг байгууллагуудын хооронд (шүүх хооронд мөн хамаарна) ажлын арга зүй, хэрэглэж буй хууль зүйн техникийн зөрүү үүссэн, тухайн гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүний болон нотлох ажиллагааны стандартын талаар нэгдмэл ойлголт тогтоогүй, ажилтан албан хаагчдын эрх зүйн хэвшмэл сэтгэлгээ нь энэ төрлийн хэргийн шүүн таслах ажиллагаанд ахиц гарахгүй байгаа шалтгаан байж болзошгүй талаар хэлж болохоор байна. Хууль сахиулагч, өмгөөлөгч, прокурор, шүүгч нарын дунд үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэрэг, түүнийг илрүүлэх, шалгах, тогтоох, хянан шийдвэрлэх талаар нэг мөр нэгдмэл ойлголт бий болохгүйгээр түүнийг бусад төсөөтэй гэмт хэрэг, зөрчлөөс ялгаж оновчтой зөв зүйлчлэх, шүүгдэгчийн процессын эрхийн баталгааг бий болгох, гэм бурууг бодитой тогтоох, шударга шийтгэлийг оногдуулах, бусад оролцогчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хохироохгүй ажиллах нөхцөл орчин бүрдэхгүй нь ойлгомжтой.

Төрийн албан тушаалтныг гэмт хэрэг үйлдсэнийг нь шалгаж тогтоогоогүй атлаа эд хөрөнгийг нь хууль бусад тооцож хүсвэл гэм буруугүйгээ өөрөө

нотлохыг шаардах байдлаар эрүүгийн процессыг хэт хялбарчлан явуулах нь оролцогчийн эрхийг дээдэлсэн орчин үеийн эрүүгийн процессын эрх зүйн суурь зарчмуудад нийцэх, зөвтгөх үндэслэл, шалтгаан бий эсэх талаар ярилцах шаардлага зайлшгүй урган гарч байна. Энэ онцгой горим нь эрүүгийн процессын тулгын гурван чулуу гэх гэм буруугүйд тооцох болон өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, мөрдөн шалгах аливаа ажиллагаа хууль ёсны байх зарчмуудыг үгүйсгэдэг гэх нийтлэг шүүмжлэл хэр бодитой вэ? Дээрх зарчмуудыг хэрхэн яаж хөнддөг, үүнд ямар хариу тайлбар гаргасан байдгийг энэ гэмт хэргийг эрүүгийн хууль тогтоомждоо суулгасан улсуудын туршлага, шүүхийн практикт тулгуурлан авч үзье.

Анх энэ гэмт хэргийг эрүүжүүлэн хуульчилсан Аргентин Улсын Дээд шүүх үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийг шалгах журамтай холбоотой гомдлоор *Alsogaray*⁵-д холбогдох хэргийг хянан хэлэлцээд гаргасан тогтоолд “энэ нь гэм буруугүйн зарчимд харшлахгүй” гэж дурдаад цааш нь “...энэ хэрэгт холбогдсон этгээдээс өөрийн хөрөнгийг хууль ёсны болохыг батлахыг шаардаж буй нь яллагч гэм бурууг баримтаар нотлох үүргээ биелүүлэхээс татгалзаж буй хэрэг бус бөгөөд албан тушаалтан өөрийн орлоготой хэрхэвч дүйцэхгүй хэмжээний орлого олсон болохыг хангалттай баримтаар прокурор нотолсны эцэст шүүгдэгчид яллах дүгнэлтэд эргэлзээ төрүүлэх баримт байгаа бол гаргаж өгөх боломж олгож буй гэж ойлгож болно. Хэрвээ шүүгдэгч энэ эрхээ эдэлж тайлбар, баримт гаргаваас түүнийг хангалттай баримтаар сөргөж няцааснаар яллагч энэ гэмт хэргийг хөдөлбөргүй нотлох үүргээ ч биелүүлж шүүгдэгч ч түүнд эргэлзээ төрүүлэх эрхээ эдэлсэн гэж үзэхээс өөр яах билээ...” гэсэн тайлбарыг хийсэн байна.

Эндээс үзвэл Аргентины дээд шүүх энэ хэргийн мөн чанарыг авч үзэхдээ хоёр асуудал дээр төвлөрч тайлбар хийсэн байна. Нэгд, үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн цаг хугацааны ба үйлдлийн хүрээг тогтоохдоо албан тушаалтан уг эд хөрөнгийг олохын тулд өмнө үйлдсэн гэмт хэргийг гадна орхиж гэмт хэрэг гарсан цагийг ердөө хөрөнгө, хуримтлал ил болсон үеийг тооцож мөн уг хөрөнгийг албан тушаалтан эзэмшилдээ авахыг гэмт үйлдэл гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл, албан тушаалтны өмчлөлд хууль бус эд хөрөнгө бүртгэгдсэнээр гэмт хэрэг гарсан гэж үзэж буй тул гэмт хэрэг гарахаас өмнөх үйлдэл, эс үйлдэхүйд шүүгдэгчийг буруутгаж яллахгүй, түүнийг нотлох шаардлагагүй гэсэн байр суурь харагдаж байна.

Энэ хэрэгт прокурорын зүгээс нотолбол зохих байдал нь албан тушаалтанд хууль ёсны орлогоос илүү үнэтэй хөрөнгө бий болсон ба албан тушаалтны

5 Maria J. Alsogaray, Cámara Nacional de Casación Penal (National Chamber of Criminal Appeals), June 9, 2005.

хөрөнгийн эх үүсвэрийн талаар гаргасан тайлбар няцаагдсан байх гэсэн нөхцөл байдлууд болно.

Одоо үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийг шалгаж тогтоох журам нь шүүгдэгчийн өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй зөрчилддөг эсэх талаар мөн л шүүхийн практикт тулгуурлан судлан үзье. Энэ асуудалд дараах шүүхийн шийдвэрийг хариу өгсөн гэж үздэг. Английн дээд шүүх⁶ *O'Hallaran and Francis v. the United Kingdom*⁷ хэргийг хянан шийдвэрлэх явцдаа дараах тайлбарыг хийсэн нь өөрийгөө илчлэхгүй байх (өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх) эрх нь туйлын хөндөшгүй биш гэсэн агуулгатай аж. Энэ хэрэг нь замын цагдаагийн ажилтан тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодсон байж болзошгүй этгээдээс драггераар шалгуулахыг шаардсаныг “өөрийнхөө гэм бурууг нотлох баримт гаргаж өгөхийг албадсан” гэж гомдол гаргаснаас шүүхэд очсон маргаан юм.⁸ Английн дээд шүүх дээр ялагдсан нэхэмжлэгч шийдвэрийг эс зөвшөөрч Хүний эрхийн Европын шүүхэд хандсан боловч эндээс Английн шүүхийн шийдвэрийг зөвтгөсөн шийдвэр гарчээ. Страсбург дахь Хүний эрхийн Европын шүүх тогтоолдоо “Тээврийн хэрэгсэл эзэмшиж, эсхүл жолоодож буй этгээд нь эрх бүхий байгууллагаас явуулж буй ийм сорилтод шалгуулж байх үүрэгтэй бөгөөд энд өөрийн эсрэг нотлох баримт гаргахгүй байх эрх зөрчигдсөн гэж үзэхгүй. Энэ нь автомашин эзэмших, жолоодох эрхийг төрөөс олгодогт бус харин тээврийн хэрэгсэл нь галт зэвсгийн адил орчиндоо аюул учруулах боломжтой зүйлсийн ангилалд багтдаг, мөн тийм шинж чанарын улмаас тэдгээрийг эзэмшигчдийн эрх зүйн байдлыг бусдаас ялгаатай тогтоосонтой холбоотой”⁹. гэжээ. Өөрөөр хэлбэл, тээврийн хэрэгсэл жолоодоогүй эсвэл эзэмшдэггүй хэн нэгнийг албадан согтуурал шалгахыг хориглох атал халдашгүй, чөлөөтэй байх болон өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх нь жолооч нарын хувьд хязгаартай хэрэгжиж шалгуулах нь үүрэг болон үлдэнэ гэж үзсэн.

“Хязгаарлагддаггүй /туйлын/ эрх гэж байхгүйгээс гадна тухайн этгээдийн эрх зүйн байдлаас хамаарч тодорхой эрхийг ялгаатай хүрээнд эдлэхээр тогтоож болно” гэсэн тэгш эрхийг эрхэмлэгчдийн хувьд эгдүүцэл төрүүлэхээр энэхүү шүүхийн дүгнэлт эхлээд англи-саксоны эрх зүйн бүлгийн улсуудад дараа нь дэлхий нийтэд нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн.

6 Яг үнэндээ Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс нь 2009 онд парламентаас тусдаа дээд шүүхтэй болсон, өмнө Хуульч Лорд буюу Хяналтын Лордуудаас(Лордын танхимын гишүүн, Дээд шүүхийн шүүгч) бүрдсэн танхим дээд шүүхийн үүрэг гүйцэтгэж байсан

7 *O'Hallaran and Francis v. the United Kingdom*, Application nos. 15809/02 and 25624/02 (2007).

8 Энд нэг зүйл тэмдэглэж хэлэхэд зөвхөн Англи-Америкийн эрх зүйн тогтолцоот улсууд төдийгүй баруун Европын улс орнуудын хууль зүйн практикт гэмт хэргийн ул мөр, гарын хээ, цус, эд эрхтэнээс авсан сорьцод хийсэн шинжилгээний үр дүн нотлох баримт болно гэдэг шалтгаанаар тэдгээрийг мэдүүлэгтэй адилтган үзэх явдал түгээмэл юм.

9 Дээрх хэргийн материал, хуудас 57

1958 оны 6 дугаар сарын 25-ны өдөр баталж, 1960 оны 6 дугаар сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсон Алагчлахгүй байх (ажил, хөдөлмөр эрхлэлт) тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенцын 1 дүгээр зүйлийн 2-т “Тодорхой ажлын онцлогтой холбоотой тавигдах шаардлагад үндэслэсэн ялгаварлах, эсхүл давуу байдал олгох үйлдлийг “алагчлах” хэмээх ойлголтод хамааруулахгүй” гэж зааснаас үзэхэд тодорхой ажил, албан тушаал, мэргэжлийн онцлогтой холбоотойгоор хуулиар зарим хязгаарлалт, нэмэлт шаардлага, шалгуур тогтоох, хариуцлагыг өндөржүүлэх нь хууль бус гэж үзэхээргүй байна.

Дээрх байдлаар төрийн албан хаагч нарын хувьд төрөөс хүлээлгэсэн итгэл, эрх мэдлийг урвуулан ашиглах эрсдэл байгаа учир тэдгээрийн эрх зүйн байдлыг энгийн иргэдээс өөрөөр тогтоох нь алагчлалд хамаарахгүй. Өөрийн эд хөрөнгөнд гарсан өөрчлөлтийн талаар мэдээлэх үүргийг хуулиар хүлээлгэж буй нь тэдгээрийг бусад иргэдээс өөр статустай авч үзэж буйн нэг илрэл мөн. Үүнтэй холбоотойгоор өөрийгөө илчлэхгүй байх эрх нь төрийн албан хаагчийн хувьд хязгаартай хэрэгжиж болох бөгөөд түүнээс өөрийн эд хөрөнгийг эх сурвалжийг тайлбарлахыг шаардах нь энэ эрхийг хөндсөн гэж үзэхгүй, эд хөрөнгөө нууцлах эрх албан тушаалтанд байхгүй болж таарч байна.

Одоо үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийг шалгах аргачлал нь аливаа эрүүгийн мөрдлөг “хууль ёсны байх”¹⁰ шаардлагад нийцдэг эсэх талаар дээр өгүүлсэн *Alsogaray*-ын тогтоолд юу гэж заасныг үзье.

Alsogaray-ын хэргийг Аргентины дээд шүүх хянан шийдвэрлэсэн тогтоолд “...албан тушаалтны өмнө ямар гэмт хэрэг үйлдэж энэ баялгийг өөртөө бий болгосон нь үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэрэгт яллахад ач холбогдолгүй, учир нь гэмт хэрэг үйлдсэн цаг хугацааг эд хөрөнгө бий болсон үеэр таслан тооцож яг энэ үйл явдлыг гэмт хэрэг гэж үзнэ. Албан тушаалтны өмнөх үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэргийн хүрээний гадна орхиж харин ямар нэг эх сурвалжийн тайлбаргүй эд хөрөнгөтэй болохыг гэмт хэрэгт тооцож эрүүлжүүлэн хариуцлага хүлээлгэж буй учир зөвхөн ийм хөрөнгө бий болсныг гэмт хэрэг гэж хуульдаа тусгаснаар мөн энэ үйл баримтыг нотолсноор тухайн хэрэгт хууль ёсны зарчим хангагдсан гэж үзнэ. Албан тушаалтныг албаны байдлаар урвуулсных нь төлөө бус түүнд тайлбаргүй эд хөрөнгө бий болсны төлөө шийтгэж байгаа болохоор өмнөх гэмт хэргийг нотолж тогтоогдсон эсэх, энэ нь эрүүгийн хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдэхүй мөн эсэх нь сүүлийн хэрэгт хамааралгүй” гэж тайлбарласан байна.

10 Д. Баярсайхан. Гадаад орнуудын эрүүгийн процесс. Анхны хэвлэл. УБ., 2015. 27 дахь тал

Асуудал хоёр.

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад албан тушаалын гэмт хэргийн хамгийн хүндрүүлсэн бүрэлдэхүүнд тоолох хөөн хэлэлцэх хугацааг 5 жилээр тогтоосон нь Авлигын эсрэг конвенцын агуулгад нийцэхгүй байна. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 29 дүгээр зүйлд улс орнууд өөрийн үндэсний эрх зүйн тогтолцооныхоо онцлогийг харгалзахын зэрэгцээ авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг харьцангуй урт, гэмт этгээд хариуцлагаас зайлсхийсэн бол хөөн хэлэлцэх хугацааг тоолохыг зогсоож байхаар хууль тогтоомждоо тусгахыг үүрэг болгосон. Энэхүү конвенцын 30 дугаар зүйлийн 3-т конвенцод нэгдсэн орнууд өөрийн авлигын нөхцөл байдалд дүгнэлт хийн тэмцэхэд шаардлагатай хэмжээнд Конвенцоор тогтоосон шаардлагуудыг чангатгаж хуульчилж болох санаа тусгагдсан байгаа юм.

НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар (UNODC) болон Бүс нутаг дамнасан гэмт хэрэг, шударга ёсны судалгааны институтээс (UNICRI) эрхлэн гаргасан Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцыг хэрэгжүүлэх мэргэжил, арга зүйн гарын авлага, Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцын техникийн удирдамжид заасан тайлбаруудыг Гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцын 31(3)(с) зүйлд зааснаар Авлигын эсрэг конвенцыг тайлбарлах эх сурвалж болж чадах бичиг баримтууд юм.

Конвенцыг хэрэгжүүлэх мэргэжил, арга зүйн гарын авлагын 2012 онд хууль тогтоох байгууллагуудад зориулан сайжруулсан хоёр дахь хэвлэлээр гаргасан хувилбар боть номын 370-373 дугаар удирдамжуудад авлигын гэмт хэргийн удаан хугацаанд илэрдэг, олон улсын хамтын ажиллагаанд их цаг зарцуулдаг онцлогуудыг харгалзан авлигын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх тусгай хугацаа тогтоох боломжтойг зөвлөсөн байна. Ямар ч тохиолдолд авлигын гэмт хэргийн хүнд хэлбэрийг үйлдсэн этгээд хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн үндэслэлээр ял завшихгүй байхыг үндсэн шалгуур болгож хугацааг тогтоох ёстой гэжээ. Манай улсын хувьд татварын гэмт хэргүүдэд тусгай хугацаа тогтоосон туршлагад үндэслэн Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэг буюу авлигын гэмт хэргийн хамгийн хүнд хэлбэрүүдийн хувьд энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагааны онцлогоос хамаараад сунжрах шинж чанартайг харгалзан хөөн хэлэлцэх хугацааг тусгайлан тогтоох боломж байгаа юм.

Хөөн хэлэлцэх хугацаа богино хуульчлагдсан нь хэргийг энэ үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон тохиолдлыг нэмэгдүүлж байгаагаас гадна хуулиудын зөрчилдөөний орчинд шүүх хөөн хэлэлцэх хугацааг алдаж тоолох тохиолдол цөөн боловч гарсан нь байдлыг улам дордуулах эрсдэл дагуулж байна.

Хөөн хэлэлцэх хугацаанд багтааж авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлэх нэг арга зам түүнийг зөв тоолж сурах явдал мөн.

Яллагдагчаар татсанаар хөөн хэлэлцэх хугацаа зогсох зохицуулалтаас гадна энэ хугацааг эхлэн тоолох цаг хугацааны заагийг зөв сонгох нь ач холбогдолтой. Хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн философийг олон талаас нь тайлбарлаж болдог боловч үндсэн зорилго нь гэмт хэрэгт холбогдсон этгээдэд гэм бурууг нь тогтоохоор төрийн албадлага хэрэглэх хугацааг хязгаарлаж өгч байгаа явдал. Өөрөөр хэлбэл, гэмт этгээдийн гэм бурууг нотлох үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг хугацаагаар хязгаарлаж тэдгээрт зориулан бий болгосон нөхцөл байдал, шалгуур юм. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь ердийн боломжит хугацаанд хэргээ шийдвэрлүүлэх эрхтэй, хэт сунжирч түүнд хүнлэг бус хандах, дарамт шахалтын үр нөлөөг энэ хугацаа өөртөө агуулах учиргүй. Хэргийг хэт сунжруулж шалгахгүй байх үзэл баримтлалын үүднээс мөрдөн шалгах байгууллагын гэмт хэргийг тогтоож шалгах үйл ажиллагаа эхэлснээр цаг тоологдож эхлэх бөгөөд хуулиар тогтоосон боломжит хугацаа өнгөрснөөр энэ үйл ажиллагааг зогсооно. Ердийн гэмт хэргийн хувьд гэмт хэргийн хор уршиг шууд бий болж хохирогч энэ талаар гомдол гаргах, хэргийн газар ил болсонтой зэрэгцэн мөрдөн шалгах ажиллагаа эхэлдэг. Өөрөөр хэлбэл тус гэмт хэрэг гарсан цаг хугацаа, мөрдөн шалгах байгууллагын үйл ажиллагаа эхлэх хугацаатай бараг давхацдагаас хөөн хэлэлцэх хугацаа тоолох зарчимд зөрүү гардаггүй. Хэргийг илрүүлэх талаар ямар нэгэн ажиллагаа явагдаагүй байхад уг ажиллагаанд өгдөг хугацаа тоологдох нь эрх зүйн хувьд нон сенс байж болно.

Манай улсын хувьд 2002 оны Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлд “Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дор дурдсан хугацаа өнгөрвөл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй” хэмээн заасныг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг яллагдагчаар татах хүртэл тоолохоор ойлгон хэрэглэж байсныг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчилж, Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийн гарчиг болон зарим төрлийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаанд нэмэлт, өөрчлөлт оруулснаас хойш гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болох хүртэл тоолох хууль хэрэглээний практик тогтсон юм.

Харин 2015 оны 12 дугаар сарын 03-ны багтагдсан Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд “Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй... Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно” гэж хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмын талаар өмнөх хуулиудаас зарчмын өөр агуулгатай заалтыг хуульчилсан юм. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хариуцлагын

зорилгыг хангахын тулд мөрдөх байгууллага болон прокурорын зүгээс гэмт хэрэг үйлдсэн хүнийг шуурхай илрүүлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу тасралтгүй явуулах шаардлагатай бөгөөд хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааны дотор гэмт хэрэг үйлдсэн хүнийг олж тогтоож чадаагүй бол эрүүгийн хэрэг үүсгэж, хэн нэгнийг яллагдагчаар татаж болохгүй, эсхүл нэгэнт яллагдагчаар татсаны дараа дээрх нөхцөл байдал тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх талаар Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой заасан.

Гэвч УИХ-аас хууль тогтоох бүрэн эрхийнхээ хүрээнд, дээрх зохицуулалт нь эрүүгийн хэргийг мөрдөн шалгах болон шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хөөн хэлэлцэх цаг хугацааны хязгаарлалтгүйгээр явагдаж, гэмт хэрэгт холбогдсон хүний аль болох боломжит богино хугацаанд хэргээ шийдвэрлүүлэх эрх нь зөрчигдөж болзошгүй гэж үзэн Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолохоор хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар өмнөх 2002 оны Эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох уламжлалт зохицуулалт агуулгын хувьд хэвээр үлдсэн.

Тухайлбал, гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс хойш хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрч, хэрэг бүртгэлтийн шатанд гэмт хэрэг үйлдсэн хүнийг олж тогтоож чадаагүй бол эрүүгийн хэрэг үүсгэж, хэн нэгнийг яллагдагчаар татаж болохгүй, нөгөө талаас нэгэнт яллагдагчаар татсаны дараа буюу гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болтол хөөн хэлэлцэх хугацаа өнгөрвөл тухайн хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхээр хуульчилсан болно.

Иймд дээрх зохицуулалттай уялдан мөрдөх байгууллага болон прокурорын зүгээс гэмт хэрэг үйлдсэн хүнийг шуурхай илрүүлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу тасралтгүй явуулах, улмаар анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүх хэргийг хөөн хэлэлцэх хугацааны дотор эцэслэн шийдвэрлэх нь хэргийг шуурхай шийдвэрлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх талаасаа ач холбогдолтой боловч нөгөө талаас ийнхүү хуульд заасан хугацаанд хэргийг шийдвэрлэж чадаагүй бол тухайн хэргийг хэргийг хэрэгсэхгүй болгох үр дагавар үүсдэг нь ял шийтгэл гарцаагүй байх зарчимд нийцэхгүйгээс гадна шүүхийн практикт дараах сөрөг үр дагаврыг дагуулж байсан тул түүнийг дахин зайлшгүй өөрчлөх шаардлага үүссэн.

Тухайлбал, хууль тогтоогч Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10

дугаар зүйлийн 2 дахь хэсэгт гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолохоор өөрчлөлт оруулсан нь агуулгын хувьд мөн зүйлийн 1 дэх хэсгийн “Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй” гэсэн заалттай харилцан зөрчилтэй болсноос гадна яллагдагчаар татсанаас хойш шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл хөөн хэлэлцэх хугацаа өнгөрвөл хэргийг хэрэгсэхгүй болгож, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх эсэх асуудлыг шүүх хэрхэн шийдвэрлэхийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлд хуульчлаагүй орхигдуулсан нь шинэчлэн найруулсан 2015 оны Эрүүгийн хуулийн үзэл баримтлалд нийцээгүйгээс гадна хуулийг хэрэглэхэд ойлгомжгүй, хүндрэлтэй байдлыг бий болгосон.

Дээр дурдсан нөхцөл байдлууд нь Эрүү болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хийдэл зөрчлийг арилгах, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолох журмыг тодорхой болгох, хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах хүртэл тоолох журмыг сэргээн хуульчлахаас гадна Эрүү болон Зөрчлийн тухай хуульд хөөн хэлэлцэх хугацааны талаар ижил зарчим баримтлах, Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэргийн төрөл, тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээг харгалзан энгийн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацааг ялгамжтай тогтоох, зарим төрлийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлэх бодит шаардлага бий болсны нотолгоо юм.

Иймд хууль тогтоогч Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно” гэсэн заалтыг сэргээн хуульчилсан.

Түүнээс гадна өмнөх 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болсон зорилгыг /эрүүгийн хэргийг шуурхай хянан шийдвэрлэх/ хангахын тулд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэнээс хойш Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тухайн хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хугацаа өнгөрсөн бол мөрдөн байцаалтын хугацааг сунгаж болохгүй. Энэ хуулийн 31.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн, эсхүл хэргийг прокурорт шилжүүлсэн бол мөрдөн байцаалтын хугацааг зогсооно. Түдгэлзүүлсэн хэргийг сэргээсэн, эсхүл хэрэгт нэмэлт ажиллагаа хийлгэхээр

прокуророос мөрдөгчид хэргийг буцааснаас эхлэн мөрдөн байцаалтын хугацааг үргэлжлүүлэн тоолно.” гэсэн заалт оруулсан нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах цаг хугацааны нэг шалгуур болгосноос гадна мөрдөн шалгах ажиллагаанд цаг хугацааны хязгаарлалт тогтоож, хэргийг тасралтгүй мөрдөн шалгаж, аль болох хурдан хугацаанд яллагдагчийн гэм буруутай эсэхийг хянан шийдвэрлэж, хүний зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх зорилгыг хангахад чиглэсэн юм.

Өөрөөр хэлбэл, хэзээ эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсанаас үл хамааран мөрдөн шалгах ажиллагаа нь гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш хөөн хэлэлцэх хугацааг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хугацааны дотор мөрдөн шалгах ажиллагаа явагдаж дууссан байх ёстой. Энэ хугацааг хэтрүүлж явуулсан мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг хүчингүйд тооцох үр дагавартай тул эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хөөн хэлэлцэх хугацааг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх абсолют хугацаанаас хэтэрч болохгүй.

Ийнхүү Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 болон 2 дахь хэсгийн харилцан зөрчилтэй байдал, мөн дээр дурдсан Эрүү болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд үүссэн хийдэл арилсан боловч уг хуулийг буцаан хэрэглэх эсэх талаар шүүхийн практикт хууль зүйн маргаан дагуулсан.

Түүнээс гадна Монгол Улсын Их Хурал 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай уялдуулан тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталсан нь онолын болон хууль хэрэглээний томоохон маргаантай асуудлыг бий болгосон юм.

Тухайлбал, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1, 2 дугаар зүйлээр 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр мөрдөн байцаалтын шатанд прокурорын тогтоолоор, мөн хугацаанд шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан гэмт хэргийг сэргээн шалгахгаар, түүнчлэн 3 дугаар зүйлээр дээрх хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам өөрчлөгдсөнтэй холбогдуулан мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд шалгагдаж байгаа гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлд заасан хууль буцаан хэрэглэх зохицуулалт үйлчлэхгүй байхаар заасан.

Энэ хуулийн 3 дахь зүйлийн зохицуулалтаас харахад хууль тогтоогч хөөн хэлэлцэх хугацаа тоолох журмыг зохицуулсан хэм хэмжээ нь процессын шинж

чанарыг агуулсан тул хууль буцаан хэрэглэх зарчим хамаарахгүй гэж үзсэн нь тодорхой бөгөөд энэ талаараа Үндсэн хуулийн цэцэд тайлбар хүргүүлсэн байна.

2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн үндэслэлээр нэр бүхий иргэд Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргасны дагуу Үндсэн хуулийн Цэцийн гишүүний 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 69 дугаартай тогтоолоор маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэж, улмаар Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 12 дугаар дүгнэлтээр уг хуулийг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлэхээр шийдвэрлэсэн. Үндсэн хуулийн цэц Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болгож шийдвэрлэхдээ УИХ-аас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд оруулсан өөрчлөлтийг хөндөөгүй болохыг дурдах нь зүйтэй.

Улмаар Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн Чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэж, энэ талаарх Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталсан бол Үндсэн хуулийн Цэцийн 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн их суудлын хуралдаанаар УИХ-ын 2020 оны нэгдүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай дөрвөн зүйл бүхий хуулийг бүхэлд нь хүчингүй болгож шийдвэрлэсэн болно.

Дүгнэлт нэг.

Албан тушаалтан албаны байдлаа урвуулан хууль бусаар эд хөрөнгө хуримтлуулахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, ийм замаар бий болсон эд хөрөнгийн гарал үүслийг хууль бус болохыг нэхэн тогтоох эрх зүйн орчин, хүн хүч, арга зүй, санхүүгийн боломж хүрэлцээгүйгээс авлигын замаар хөрөнгөжих гэмт хэрэгтэй тэмцэхэд хууль сахиулах, хэрэглэх байгууллагууд хүчин мөхөсдөх цагт хэрэглэдэг, авлигын гэмт хэргийг нь нотлохгүйгээр хэрэг гарсан цаг хугацааг уг хууль бус хөрөнгө бий болсон үеэр тооцож ялладаг, яллахдаа цагаатгах баримтыг өөрөөр нь гаргуулж улмаар яллагдагч няцааж чадаагүй бол үндэслэлийг эс харгалзан ял шийтгэл хүлээлгэх байдлаар гэмт хэргийн шинжийг хялбарчлан тогтоож нотлох ажиллагааг товчлон журамласан эрүүгийн эрх зүйн хатуу арга механизм¹¹ гэж үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэрэг, түүнийг нотлох ажиллагааны агуулга, мөн чанарыг товч тодорхойлж болно.

11 Strict liability doctrine англ.

Үндэслэлгүй хөрөнгөжихийг эрүүжүүлэх, шалган тогтоох арга зам нь эрүүгийн процессын суурь зарчмуудад харш, хүний эрх, тухайлбал шүүгдэгчийн процессын эрхүүдийг ноцтой зөрчдөг, гэм буруугүйн зарчим, өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг хөсөрдүүлдэг гэх шүүмжлэл байнга гардаг боловч энэ гэмт хэргийг эрүүжүүлсэн улсуудын эрдэмтэн, судлаачдын бүтээсэн үндэслэлгүй хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцохыг зөвтгөсөн номлол сургаал, тэдгээрийн шүүхээс хэрэг шийдвэрлэх замаар гаргасан тайлбаруудыг буруутган няцаах бодитой үндэслэл бас байдаггүй. Үндэслэлгүй хөрөнгөжихийг эрүүжүүлэх, түүнийг чанд хатуу зарчмаар мөрдөн шалгаж тогтоох нь хүний үндсэн эрх, эрх чөлөөг ноцтой хөнддөг аюул эрсдэл байгаа нь бас бодит үнэн боловч энэ зохицуулалтыг хэрэгжүүлсэн улсуудын туршлагаас үзэхэд мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагааны журамд оролцогч нарын болон институтүүдын эрх зүйн хамгаалалт, процессын эрхийг баталгаажуулан суулгаж өгвөөс авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал хөшүүрэг болж чаддаг нь нотлогдсон.

Улс орнууд үндэслэлгүй хөрөнгөжих явдалтай эрүүгийн эрх зүйн механизмыг ашиглан тэмцэх эсэх талаар шийдвэр гаргахдаа эрх зүйн онолын үндэслэлээс илүүтэйгээр нийгэмд бий болох бодит үр дүн, улс орны хөгжил дэвшилд тусах өөрчлөлтийг харгалзан үзэж байна. Хууль, эрх зүйн орчинд өөрчлөлт хийх нь ихэнх тохиолдолд хоёр талт үр дагавар авч ирдэг тул үр ашигт байдлыг тогтоохдоо хооронд нь харьцуулан үзэх шаардлага гардаг нь ойлгомжтой. Үндэслэлгүй хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцож шалган тогтоох процедурыг *prima facie* хандлагад тулгуурлах нь өөрийн давуу болоод дутагдалтай талтай байж болох тул зохицуулалтын үр нөлөөг өөрийн улсын нөхцөл байдалтай холбон судалж үр дагаврыг төсөөлөх оролдлогыг улсууд хийж байна. Үндсэндээ уг эрх зүйн хэрэгслийг нэвтрүүлснээр оролцогч нарын эрхийн хязгаарлалтаас бий болох сөрөг нөлөө буюу хүний эрхийн асуудал, нөгөө талд нийтийн эрх ашиг сонирхолд бий болох давуу тал буюу авлигатай хийх тэмцэлд гарах үр дүн хоёрыг дэнслэх нь чухал. Тухайн улс орны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, авлигын гэмт хэргийн түвшин, тэмцэх эрх зүйн арга хэрэгслийн иж бүрэн байдал, орчноос хамааран авлигын гэмт хэргээс нийтийн ашиг сонирхолд учирч буй хохирол, хор уршгийн хэмжээг цэгнэн үзсэний эцэст улс орон бүр өөр, өөрийн арга замаар энэ асуудлыг шийдвэрлэж байгаа туршлага харагдаж байна.

Европын хүний эрхийн шүүх нотлох ажиллагааны зарим хэсгийг прокуророос шүүгдэгчид шилжүүлэх байдлаар “няцаалтаар нотлох” буюу *praesumptio iuris tantum*¹² аргыг зарим төрлийн гэмт хэргийн нотолгоонд хэрэглэх нь шүүгдэгчийн процессын эрхэд илтэд хохирол учруулахгүйн тулд хязгаарлалтын зарим арга хэмжээ авсан тохиолдолд шүүн таслах ажиллагааны зорилтыг хангахад сайн үр нөлөөтэй болохыг нэгэнтээ хүлээн зөвшөөрсөн болно.¹³ Уг шийдвэртээ Европын хүний эрхийн шүүх нийгмийн ашиг сонирхол шаардаж буй бол шүүгдэгчийн өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг ч онцгой нөхцөл байдалд хязгаарлаж хэргийн талаар тайлбар гаргах үүргийг оногдуулах боломжтой гэжээ. Шүүх энэ шийдлийг гаргахдаа эрүүгийн процессын цаад үндсэн зорилгыг онцлон үзэж нийтийн аюулгүй байдал, амар амгалан, хүн төрөлхтний нийтлэг эрх ашиг, сонирхлыг аливаа эрүүгийн процессын хууль энэ тэргүүнд хамгаалах ёстой гэсэн үзэл баримтлалыг чухалчилсан гэжээ. Европын хүний эрхийн шүүх болон Европын хэд хэдэн улсын үндэсний шүүхүүд гэм буруугүй байх, өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх зэрэг шүүгдэгчийн процессын эрхүүдийг “үндэслэлтэй ба харьцаатай байх” шаардлагыг баримтлан тодорхой хэмжээгээр хязгаарлах боломжтой, энэ нь нийгмийн үнэт зүйлсэд хохирол учруулахгүй болохыг тэмдэглэсэн.

Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцод нэгдэж үндэслэлгүй хөрөнгөжихийг гэмт хэрэгт тооцон эрүүжүүлснээр Монгол Улсын хувьд албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн арга хэрэгсэл нэмэгдэн илүү таатай орчин бүрдэж улмаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд ахиц дэвшил гарах учиртай байсан боловч хүссэн үр дүн бий болоогүй шалтгаан нь энэ гэмт хэргийн шинж, мөн чанар, мөрдөн шалгах ажиллагааны стандартын талаар хууль, шүүхийн байгууллагууд, ажилтан, албан хаагчдын дунд нийтлэг ойлголт, нэгдмэл байр суурь бүрдэн тогтох явдал удаашралтай байгаатай холбоотой байж болохоор байна. Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийг шалган тогтоох аргачлалын талаар гарын авлага, зөвлөмж гараагүй, шүүхийн практик цөөн, сургалт явагддаггүй, судалгаа хийгдэхгүй байгаа нь дээр дурдсан нэгдсэн ойлголт, стандарт бий болж төлөвшихгүй байгаа нэг шалтгаан болно.

Дүгнэлт хоёр.

Хөөн хэлэлцэх хугацаа богино хуульчлагдсан нь хэргийг энэ үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон тохиолдлыг нэмэгдүүлж байгаагаас гадна хуулиудын

12 Няцаалтаар нотлогдох буюу *prima facie* буюу анхны дүгнэлтийг няцаах, үүнд прокурор ялах дүгнэлтээ нотлохгүй ба яллагдагчийн няцаалтаар эсвэл үл няцааснаар хэрэг нотлогдоно гэж үзнэ. *Prima facie* зарчмын өөрөөр ингэж нэрлэнэ. Энд *prima facie* нь ялах ажиллагаанд хамааралтай бол *praesumptio iuris tantum* нь сөрөг няцаах ажиллагаанд хэрэгжинэ. Зохиогч

13 Salabiaku v. France (1998), Application no. 10519/83, Section 28

зөрчилдөөний орчинд шүүх хөөн хэлэлцэх хугацааг алдаж тоолох тохиолдол цөөн боловч гарсан нь байдлыг улам дордуулах эрсдэл дагуулж байна.

Хөөн хэлэлцэх хугацаанд багтааж авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлэх нэг арга зам түүнийг зөв тоолж сурах явдал мөн.

Шүүх ийнхүү хэргийг хянан шийдвэрлэхдээ гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмыг тогтоосон зохицуулалт нь хэдийгээр материаллаг хуульд тусгагдсан боловч зохицуулж байгаа харилцааны мөн чанар, агуулгын хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинжийг илэрхийлдэг тул тухайн харилцааг зохицуулж байсан өмнөх Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолох” заалтыг буцаан хэрэглэхгүйгээр, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан “Гэмт хэргийн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно” гэсэн заалтыг шүүх баримталж хэргийг шийдвэрлэсэн нь хууль зөрчөөгүй хэмээн тайлбарлаж, хууль хэрэглээний практик тогтоожээ.

Тухайлбал, материаллаг болон процессын хуулийн хэм хэмжээ өөр, өөр харилцааг зохицуулдаг, хоорондоо ялгаатай болох нь ойлгомжтой, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ойлголт хэдий ч зарим тохиолдолд тэдгээр хэм хэмжээний зохицуулалтын хил хязгаар давхцаж, холимог шинжийг илэрхийлдэг, эсхүл харилцан зөрчилдсөн байдлаар хуульд тусгагдаж болохыг эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн онолоор хүлээн зөвшөөрдөг учир тухайн хэм хэмжээний агуулга мөн чанарыг харгалзан хэрэглэдэг талаар шүүхийн шийдвэрүүдэд дурдсан байна.





АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГ: ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТОДОТГОЛ АВЛИГЫН ЭСРЭГ ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН ЯВЦ

*Хууль зүй, дотоод хэргийн яамны
Хууль зүйн бодлогын газрын дарга
П.Сайнзориг*

Эрүүгийн хууль тогтоомжийг тодотгож ярихын өмнө Монгол Улсын Засгийн газраас авлигатай тэмцэх, төрийн үйл ажиллагааны хүнд суртлыг халах чиглэлд ямар хууль эрх зүйн шинэчлэл хийж байгаа талаараа цухас дурдах нь зүйтэй байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдал, цахим гарын үсгийн тухай:

Монгол Улсын Засгийн газар цахим шилжилтийг уялдаатай, төрийн бүтээмжийг нэмэгдүүлсэн, хүний эрх, эрх чөлөөг мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, эдийн засаг, бизнесийг дэмжсэн байдлаар хийхэд чиглэсэн багц хуулийн төслүүдийг УИХ-д өргөн барьж хэлэлцүүлж байна.

Үүний нэг нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль бөгөөд бид үүнийг Нийтийн мэдээллийн тухай хууль хэмээн өргөжүүлж байна. Учир нь төрийн байгууллагуудаас гадна төрийн зарим чиг үүргийг шилжүүлж авсан мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит компаниуд энэ хуулийн үйлчлэлд хамаарна. Хуультай төрийн бус байгууллагууд мөн хамаарна. Түүнчлэн анхаарал татаж байгаа нэг асуудал бол улс төрийн намууд энэ хуулийн үйлчлэлд хамаарч байгаа юм.

Өөрөөр хэлбэл 56 төрлийн багц мэдээлэл, хаалттай болон хязгаарлалтайгаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх зарчмыг энэ хуулийн төсөлд тусгаж өгсөн. Хаалттай мэдээлэлд төрийн нууц, хүний гар хурууны хээ, биометрийн өгөгдөл, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу авагдсан арга хэмжээнүүд орно. Хязгаарлалттай мэдээлэлд 3 төрлийн мэдээлэл орж байгаа. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалттай холбоотой мэдээлэл. Энэ мэдээлэл одоо ч хязгаарлалттай, үүнийг тодруулж л өгч байгаа. Дараагийнх нь төрийн хяналт шалгалтыг шийдвэрлэх явцад цуглуулсан мэдээлэл. Тухайн байгууллагын нэр

хүнд бизнесийн нэр хүндтэй холбоотой байдаг тул шийдвэрлэх хүртэл дурын этгээдэд нээлттэйгээр цацаад байж болохгүй. Гурав дахь нь соёлын хосгүй үнэт зүйлийн байршил үүнд хамаарч байгаа болно.

Нээлттэй мэдээлэлд жагсаалт үүсгэх асуудалд шүүмжлэлтэй ханддаг. Үүнийг бид илүү их тодруулж анхаарч байгаа юм. Тухайлбал, эцсийн өмчлөгч, эзэмшигчийн мэдээлэл бүгд нээлттэй болно. Монгол Улсад төрийн болон төрийн бус байгууллагаас (төрийн зарим чиг үүргийг шилжүүлж авсан Хуульчдын холбоо г.м) олгож байгаа бүх тусгай зөвшөөрөл нээлттэй, ил тод болно. Энэ нь өөрөө эргээд авлига, ашиг сонирхлоос гадна бизнесийг дэмжиж буй үйл ажиллагаа юм. Түүнчлэн төрийн зардлаар сурдаг мэдээллийг нээлттэй болгоно. Төрийн өмчит компанийн удирдлага, бүрэлдэхүүн, цалин хөлс, урамшууллын мэдээлэл бүгд ил тод болно. Гэхдээ энэ бол нэг удаагийн шинэчлэл биш цаашид засаглалыг сайжруулах шинэчлэл үргэлжилнэ.

Нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоож, цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим харилцаанд шилжиж, нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байхаар зохицуулах нь иргэн, хуулийн этгээд төрийн үйлчилгээг цаг хугацааны хувьд хэмнэлттэй, мөн хүндрэл, зардал багатайгаар шуурхай авах, түүнчлэн төрийн байгууллагууд хоорондоо цахимаар мэдээлэл солилцож төсвийн бичиг хэрэг, шуудангийн гэх мэт зардлыг эрс бууруулах олон талын ач холбогдолтой юм.

2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр нээлтээ хийсэн төрийн үйлчилгээний нэгдсэн систем болох “e-Mongolia”-д төрийн 57 байгууллагын 563 үйлчилгээ холбогдсон байгаа бөгөөд тус системээр дамжуулан төрийн үйлчилгээ авсан иргэн, хуулийн этгээд 1.050.436, тэдгээрт үзүүлсэн төрийн үйлчилгээний тоо 5.699.205-г хүрээд байна. Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл батлагдсанаар дээрх тоо улам өсөх юм.

Цахим шилжилтийг хийхдээ хүний хувийн мэдээлэл халдашгүй, чөлөөтэй байхыг эрхийг ханган баталгаажуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог шинэ шатанд гаргах асуудлыг анхаарч байна.

Түүнчлэн дээрх багц хуулийн төслийг баталж, хэрэгжүүлсэн тохиолдолд цахим шилжилтийг дэмжиж Монгол Улсын 16 ба түүнээс дээш насны 2 сая 300 мянга орчим иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээг үнэ төлбөргүй олгох боломж бүрдэж, хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага хоорондоо тоон гарын үсэг хэрэглэн мэдээлэл дамжуулах, солилцох нөхцөлийг сайжруулж, цахим хэлбэрээр хийх гэрээ, хэлцлийн тоог нэмэгдүүлэх зэргээр цаасан суурьтай хэрэглээг багасгах, эдийн засгийн бизнесийн харилцааг түргэвчлэх ач холбогдолтой байх болно.

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай:

Засгийн газраас Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлээд байна.

Уг хуулийн төсөл нь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, шударга өрсөлдөөнийг дэмжих талаар нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн этгээдийг дэмжих, хамгаалах, урамшуулах, шүгэл үлээгчдийг хууль зүйн хариуцлагад татах, дарамтлахаас хамгаалах, аливаа өш хонзон, гэмт хэргийг хохирогч болохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилготой юм.

Холбооны эрх зүйн байдлын тухай:

Засгийн газраас Төрийн зарим чиг үүргийг нээлттэй, ил тод байх, ашиг сонирхлын зөрчилгүй байх зарчмыг баримтлан сонгон шалгаруулалтын үндсэн дээр мэргэжлийн холбоогоор гүйцэтгүүлж болох эрх зүйн орчинг бүрдүүлэхээр Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлээд байна.

Энэ хуулийн төсөлд ямар холбоог мэргэжлийн холбоо гэх вэ гэдэг асуудлыг тодорхой болгож байгаа. Ингэснээр төрд байгаа зарим чиг үүргийг мэргэжлийн холбоо руу шилжүүлэх асуудал тунхаглалын шинжтэй биш бодитойгоор хэрэгжүүлэх алхмуудыг илүү өргөн хүрээнд шийдвэрлэх боломжтой болох юм.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай:

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн засаглал, ил тод байдал, сахилга батыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх, хувийн хэвшил хийж болох бизнесийн салбар болон талбарт төр бизнес эрхэлж өрсөлдөхгүй байх чиглэлд эрх зүйн орчныг тодотгон боловсронгуй болгоно.

Төр, хувийн хэвшилтэй өрсөлдөж үйл ажиллагаа эрхлэхгүй, зөвхөн стратегийн ач холбогдол бүхий салбарт, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чухал ач холбогдолтой томоохон төслийг хэрэгжүүлэх зорилгоор, мөн төрөөс үнэ тарифын зохицуулалт хийдэг, хувийн салбарын хүчрэхгүй, нийтийн ашиг сонирхлын үүднээс зайлшгүй эрхлэх үйл ажиллагааны чиглэлд компани байгуулдаг байх, бизнесийн үйл ажиллагааны удирдлагад хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх байдлыг хязгаарлаж, бизнесийн шийдвэрийг “улс төрийн нөлөөлөл”-өөс ангид гаргадаг байх, төрийн өмчит хуулийн этгээд хувийн хэвшилтэй тэгш, нөхцөл, ижил дүрмээр үйл ажиллагаа эрхэлдэг байх, төрийн бизнесийн үйл ажиллагааг бодитой үнэлдэг, эргээд урамшуулал, хариуцлага асуудлыг тооцдог байх чиглэлд Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулаад байна.

Авлигын индексийн график болон Монгол Улс дахь авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн мэдээлэл:

Азийн хөгжлийн банкнаас хийсэн Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлангаас авсан болно. (Авлигын индексийн график болон Монгол Улс дахь авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн мэдээлэл)

Авлигатай тэмцэх эрх зүйн орчин зохих түвшинд бүрдсэн хэдий ч Авлигын индексийн үзүүлэлт 2016 оноос тогтмол, огцом буурч байгаа нь авлигатай тэмцэх тогтолцооны үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай болохыг харуулж байна.

Авлигын индекс улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал, төрийн өмчит компанийн засаглал, зөвшөөрөл, бүртгэлтэй холбоотой асуудал зэрэг олон хүчин зүйлээс хамаарч буурахгүй байна.

Эрүүгийн хуулийн Хоринхоёрдугаар бүлэгт 11 төрлийн авлига, албан тушаалын гэмт хэргийг хуульчилсан бөгөөд статистикийг эдгээр төрлөөр авч үзэхэд 22.1 дүгээр зүйлд заасан Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг, 22.4, 22.5 дугаар зүйлд заасан Хахууль авах, өгөх гэмт хэрэг нийт авлигын хэргийн ихэнх хувийг эзэлж байна.

Тоон мэдээллээс харахад авлигын гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, илрүүлэх, шалгаж байгаа хэрэг болон шүүхэд шилжүүлж байгаа хэргийн тоо, шүүхээр шийдвэрлэж байгаа хэрэг бүгд өсөж байна. Авлигатай тэмцэх газар байгуулагдаад 10 жилийн хугацаанд 1700 орчим хэрэгт хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж прокурорт шилжүүлж, шүүх рүү шилжүүлсэн гэсэн тоо мэдээлэл байна. Гэтэл өнөөдөр сүүлийн 5 жилийн хугацаанд 5400 орчим гомдол мэдээллийг шалгаж байна гэдэг нь эргээд Эрүүгийн хуулийн үр нөлөө ямар байна гэдгийг тоон статистик илэрхийлж байна.

Бид 2017 оноос хэрэгжиж байгаа Эрүүгийн хуулийг хэрэгжих орон зай, цаг хугацааны боломжийг өгөх хэрэгтэй. Хууль зүй, дотоод хэргийн яам концепцийн огцом шилжилт өөрчлөлт хийхээс татгалзаж байгаа. Гэхдээ зайлшгүй шаардлагатай тодотгол, өөрчлөлтүүдийг тухай бүрд нь хийнэ гэсэн бодлого, байр суурьтай байна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл:

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулж байгаа Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан Эрүүгийн хуулийн Хоринхоёрдугаар бүлэгт заасан 11 төрлийн гэмт хэрэгт дүн шинжилгээ хийж, дараах зохицуулалтыг хөндөхөөр ажиллаж байна.

Хоринхоёрдугаар бүлэгт заасан Авлига, албан тушаалын зарим төрлийн гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатгах, гэмт хэргийн шинжийг тодорхой болгон

хуульчлах, үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын хэмжээг ялгамжтай тогтоох шаардлага байна.

Тухайлбал, Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүний ял хариуцлага адил хэмжээтэй оногдуулахаар заасан давхардал, зөрчлийг арилгаж ялгамжтай байхаар өөрчлөх, торгох ялын санкцыг хасах, зарим төрлийн гэмт хэргийн шинжийг тодорхой болгох, хариуцлагын асуудал зэргийг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим тоон статистикаас харахад хэрэгжээд эхэлсэн гэж үзэж болохоор байна. Оногдуулж байгаа ял хариуцлага нь олон нийтийн шүүмжлээд байгаа шиг бага байна уу гэдэг асуудал бол дараагийн нэг яригдах сэдэв юм.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулж байгаа хуулийн төсөлд торгох ялыг зарим гэмт хэргээс хасаж байгаа болно. Түүнчлэн Эрүүгийн хуулийн ерөнхий ангид нэмэгдэл ял буюу эрх хасах ялын дээд хэмжээ 8 жил байхаар заасан. Үүнийг бид Эрүүгийн хуулийн Хоринхоёрдугаар бүлэгт бүх насаар нь байх эсэхийг судалж байна. Ийм жишигтэй улс орнуудын туршлагыг судалж байна. Тухайлбал, Казахстан.

Нөгөөтэйгүүр, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн хүнийг буцаагаад төрийн өмчит компанид ажилд авдаг, нийтийн эрх зүйн этгээдэд ажилладаг, шат шатны улс төрийн сонгуульд оролцуулдаг зэрэг байдалд нөгөө институцүүд манлайлал үзүүлэх шаардлагатай. Ингэж байж хууль эрх зүйн орчин цогцоороо ажиллана уу гэхээс биш бүх асуудлыг Эрүүгийн хуульд хаалт хийж хуульчилна гэсэн зарчмаар явбал Эрүүгийн хуулийн үндсэн зарчмууд алдагдахад хүрээд байна. Үүнийг 2 талтай асуудал гэдгийг анхаарах нь зүйтэй.

Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн субъектийг зөвхөн нийтийн албан тушаалтан гэж заасан. Иймд нийтийн албан тушаалтнаар хязгаарлахгүйгээр субъектийг нь өргөжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Хөрөнгийн эх үүсвэрээ нотолж чадахгүй, шударгаар татвар төлөөгүй асуудалд ял хариуцлага оногдуулах ёстой гэсэн зарчим барьж байгаа.

Дараагийн нэг боловсронгуй болгох зохицуулалт бол Дураараа аашлах гэмт хэргийн шинжийг тодорхой болгож, энэхүү Авлига, албан тушаалын гэмт хэргийн бүрэлдэхүүнд байх эсэх, субъектийг өргөжүүлэх асуудлыг судалж байна.

Хөөн хэлэлцэх хугацааны асуудал. Хорих ялыг нэмэгдүүлэх асуудалтай холбогдуулан хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлэх, нөгөөтэйгүүр хөөн

хэлэлцэх хугацааг тоолох асуудал байна. Зарим төрлийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох асуудлыг өөрөөр шийдвэрлэх шаардлагатай байгаа. Тухайлбал, оргох гэмт хэрэг. Эдгээрийг бид ажлын хэсгийн хүрээнд ярилцаж, судалж байна.

Эрүүгийн хуулийг боловсронгуй болгох бусад асуудал:

- ★ Торгох ялын доод хэмжээг өндөрсгөх. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргүүдэд торгуулийн ялын доод хэмжээг “дөрвөн зуун тавин нэгж” гэж тогтоосон байх бөгөөд энэ нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Торгох ялын хэмжээ нь нэг зуун нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.” гэсэн торгуулийн ялын доод хэмжээтэй зөрчилдсөнийг;
- ★ Бага болон үлэмж хэмжээний хооронд учраад байгаа хохирлын хэмжээ тодорхойгүй, орхигдуулсныг тодорхой болгох (300 нэгжээс 10.000 нэгжтэй тэнцэх хүртэл);
- ★ Өршөөл, уучлал үзүүлэхгүй байх гэмт хэрэг: Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Ерөнхийлөгчийн уучлал үзүүлэхгүй байх гэмт хэрэгт хүүхдийн эсрэг, хүрээлэн байгаа орчны эсрэг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар ашиглах, авлига, мөнгө угаах гэмт хэргийг нэмсэн.

Түүнчлэн Улсын Их Хурлаас 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр баталсан Өршөөлийн хуульд ч энэ концепцийг өргөн барьсан байгаа.

Мөн хуулийн төсөлд Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах, албадан гаргуулахтай холбоотой зохицуулалтыг ойлгомжтой тодорхой болгох үүднээс өөрчлөн найруулж тусгаад байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл:

- ★ Мэдүүлэг авах, шийдвэр танилцуулах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулахаар гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээчийг дуудан ирүүлэх болон албадан ирүүлэх эрхийг мөрдөгчид олгох;
- ★ Яллагдагчид хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг авах эсэхийг мөрдөн байцаалтын шатанд мөрдөгчийн саналыг үндэслэх прокурор, шүүхийн шатанд прокурорын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэдэг байх;
- ★ Мөрдөн шалгах ажиллагаанд дүрс харж ярих боломжтой холбоо мэдээллийн хэрэгсэл ашиглах;

- ★ Эрх бүхий байгууллагын цахим мэдээллийн сангаас цахим гарын үсгээр баталгаажуулж авсан лавлагаа, тодорхойлолтыг нотлох баримтад тооцох;
- ★ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширсан, тухайлбал мөрдөн байцаалтын хугацаа үндэслэлгүйгээр сунгасан, мөрдөн байцаалтыг үндэслэлгүйгээр түдгэлзүүлсэн асуудлууд ихээр гардаг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчийн эрхийг хангах үүднээс энэ талаарх гомдлыг дээд шатны прокурор, улмаар шүүхэд гаргах зохицуулалтыг тусгах.

Авлигын эсрэг дагнасан шүүхийн загвар

1. *Ердийн шүүхэд авлигын хэрэг, маргааныг дагнан шийдвэрлэх мэргэшсэн шүүгчийг бэлтгэх тогтолцоо* (SOLO JUDGE MODEL)-Ямар нэгэн тусгай шүүх байгуулахгүй. Харин эрүүгийн шүүхэд авлигын гэмт хэргийг шийдвэрлэх мэргэшсэн шүүгчийг ажиллуулах бөгөөд шүүхийн шийдвэрийг давж заалдах, хяналтын журмаар шийдвэрлэх механизм нь ердийн шүүхтэй адил. Бангладеш, Кени зэрэг улсад энэхүү загварыг хэрэглэж байна.

2. *Авлигын хэргийн анхан шатны дагнасан шүүхийн тогтолцоо* (FIRST INSTANCE COURT)-Авлигын хэргийг тухайлан байгуулсан Авлигын дагнасан шүүх анхан шатны журмаар шийдвэрлэх бөгөөд шийдвэрийг Улсын дээд шүүх хянана. Авлигын дагнасан шүүхийн эрх зүйн байдал нь ердийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийнхтэй адил. Хорват, Словак, Пакистан, Непал, Камерун, Бурунди, Сенегал зэрэг улсуудад энэхүү загварыг хэрэглэж байна.

3. *Холимог тогтолцоо* (HYBRID COURT)-Авлигын эсрэг дагнасан шүүх нь зарим төрлийн авлигын хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэхийн зэрэгцээ авлигын хэргийг шийдвэрлэсэн анхан шатны ердийн шүүхийн шийдвэрийг давж заалдах журмаар хянана. Авлигын хэрэгт холбогдон шалгагдаж байгаа этгээд нь өндөр албан тушаалтан байх, хохирол буюу авлигын хэмжээ өндөр байх гэсэн хоёр шалгуураар Авлигын эсрэг дагнасан шүүх шийдвэрлэх бөгөөд эдгээр шалгуураас бусад авлигын хэргийг ердийн шүүх анхан шатны журмаар шийдвэрлэж, уг шүүхийн шийдвэрийг Авлигын эсрэг шүүх хянана. Филиппин, Ботсвана зэрэг улсуудад энэ загварыг хэрэглэж байна.

4. *Авлигын эсрэг анхан болон давж заалдах шатны дагнасан шүүхийн тогтолцоо* (COMPREHENSIVE PARALLEL COURT)-Авлигын эсрэг дагнасан шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны дагнасан шүүх хянана. Болгар, Индонез, Малайз, Афганистан, Мадагаскар зэрэг улсуудад энэ загварыг хэрэглэж байна.

Авлигын дагнасан шүүхийн тогтолцооны хамгийн сайн загвар гэж байхгүй бөгөөд тухайн улс өөрийн улсын онцлогт тохируулан хамгийн үр нөлөөтэй хэлбэрээр тодорхойлох боломжтой юм.

Монгол Улсын тухайд шүүгчийг дагнан мэргэшүүлэх, үүнтэй холбогдуулан прокурор, мөрдөгч дагнан мэргэшүүлэх хувилбарыг үр нөлөөтэй гэж үзэж байна.

Түүнчлэн авлигын хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх үүднээс давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэдэг байх, давж заалдах эрхийг Улсын дээд шүүхэд хангах бодлогыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас баримтлан хуулийн төсөлд тусгаад байна.

Эрх зүйн шинэчлэл бүр хүний эрхийн төлөө, авлига, ашиг сонирхлыг бууруулахын төлөө, төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгахын төлөө зорьж ажиллаж байна. Аль болох хувийн хэвшилдээ боломж олгосон, тэдгээрийн үйл ажиллагааг хориглосон, хязгаарласан гэхээс илүүтэй эрхжүүлсэн байх зарчмыг хуулийн төслүүдийг бичихдээ баримталж ажиллаж байна. Харин төрийн хувьд эсрэгээ эрхжсэн бус үүрэг хүлээсэн байдлаар, тодорхой хэмжээний хязгаарлалтын дор үйл ажиллагаагаа явуулдаг энэ чиглэл рүү бид хууль бичилтийн техникээ ч хандуулж байна.



АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АНХААРАХ АСУУДАЛ

*Монголын хуульчдын холбооны
удирдах зөвлөлийн гишүүн, хуульч
Л.Галбаатар*


Та бүхэнд өдрийн мэнд хүргэе!

Миний хувьд энэхүү илтгэлээр дараах хоёр агуулгыг танилцуулна. Нэгдүгээрт, авлигын гэмт хэргийг мөрдөн шалгаж, түүнд хяналт тавьж байгаа, шийдвэрлэж байгаа хүмүүсийн мэдлэг, ур чадварын тухай, хоёрдугаарт эдгээр хүмүүс хөндлөнгийн нөлөөллөөс ангид байх асуудлын талаар хөндөж ярих юм.

Эдгээр асуудлыг 2020 онд Азийн хөгжлийн банкны захиалгаар Азийн сангийн судалгааны багаас хийж, 2021 онд танилцуулсан “Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан”-ийн үр дүн буюу авлигын гэмт хэрэг дээр ажилладаг мөрдөгч, прокурор, шүүгчдээс өөрсдөөс нь авсан үнэлгээнд үндэслэж ярих юм.

Авлигын хэрэг мөрдөн шалгах, хяналт тавих, хянан шийдвэрлэх ур чадварын өөрийн үнэлгээгээр дараах үр дүн гарсан байна. Үүнд:

*Авлигын хэрэг мөрдөн шалгах, хяналт тавих, хянан шийдвэрлэх ур чадвар
(Өөрийн үнэлгээ)*




Ерөнхийдөө таны ур чадвар ямар вэ гэсэн асуулт асуухад харилцан адилгүй үр дүн үзүүлсэн байх ба “сайн” гэх үнэлгээг шүүгчдийн 74 хувь, прокуроруудын

60 хувь, мөрдөгчдийн 44 хувь өгч, ур чадвараа үнэлсэн байна. Үүнээс үзэхэд энэ гурван субъект харилцан өөр өөр байдлаар үнэлсэн гэдэг нь харагдаж байна. Харин энэ гурван субъектээр хэргээ шийдүүлж байгаа, шалгуулж байгаа хүний хувьд тэдгээрийн ур чадвар нь харилцан адилгүй байх нь нэлээд ноцтой асуудал гэж үзнэ. 74 хувиар сайн байна гэж шүүгч өөрийгөө хамгийн өндрөөр үнэллээ ч гэсэн энэ бол хангалтгүй үр дүн гэсэн үг. Хүний эрхийн талаасаа авлигын гэмт хэргийн асуудлыг шийдвэрлэхэд 90-ээс дээш хувийн ур чадвартай байх ёстой. Гэтэл эдгээр албан хаагчдын хувьд өөрсдөө өөрсдийн ур чадвараа ингэж үнэлж байна.

Тэгвэл, ур чадварыг сайжруулах асуудлын гарц, шийдэл нь сургалт зохион байгуулах явдал байдаг. Сургалтын үр дүн нь ямар байна вэ гэдгээр өөрийн үнэлгээний асуумжийг авсан бөгөөд дараах байдалтай үнэлэгдсэн.

*Мэдлэг, ур чадвар нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтын үр дүн
(Өөрийн үнэлгээ)*




Мэдлэг ур чадвар нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтын үр дүнгийн талаарх өөрийн үнэлгээнээс харахад, “үр дүн сайтай” гэж үзэж байгаа нь шүүгчийн хувьд 50 хувь, прокурорын 30 хувь, мөрдөгчийн 33 хувь байна. Энэ нь үндсэндээ сургалт үр дүнгүй бөгөөд тал хувь нь хэрэггүй, хэрэг болох зүйлс орохгүй байна гэсэн үг болж таарч байна. Иймд ур чадвар сайжруулахаар зохион байгуулж буй арга хэмжээний нэг арга сургалт нь бүрэн шийдэл болж чадахгүй байгааг илэрхийлж байна. Гэхдээ энэ нь сургалтын үйл ажиллагааг явуулахгүй гэсэн үг биш бөгөөд сургалтын чанар, үр дүнг сайжруулах шаардлагатай гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, кейс анализ, дүн шинжилгээ дээр тулгуурласан сургалтыг мөрдөгч, прокурор, шүүгч нарт тогтмол явуулах шаардлагатай байна. Жилдээ 1 юм уу, эсхүл 2 жилд 1 удаа сургасан болоод өнгөрөх биш сургалтыг тогтмол явуулах, дээр нь сургалтын агуулга, сэдэв нь уян хатан өөрчлөгдөж байх шаардлагатай байна. Энэ хүрээнд сургалтын гарын авлага, материалын агуулга, сэдэв бүрээр хамтран боловсруулах асуудал чухал байна. Сургалт зохион байгуулж буй байгууллагын хувьд шүүгчдийн сургалтыг Шүүхийн

ерөнхий зөвлөл гэх мэтээр байгууллагууд тус тусдаа зохион байгуулж байна. Иймд нэгдсэн байдлаар сургалтыг зохион байгуулах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, энгийн иргэнд байгууллагууд тус тусдаа үйл ажиллагаа явуулж байгаа гэдэг нь сонин биш, тухайн асуудлаар энэ 3 субъект нэг ойлголттой, нэг хэмжээний мэдлэг ур чадвартай байх ёстой гэсэн шаардлагад нийцсэн байдлаар сургалтыг зохион байгуулах шаардлага байгаа юм. Энэ дээр Монголын хуульчдын холбооны үргэлжилсэн сургалтын механизмыг ашиглах боломжтой. Учир нь эдгээр 3 субъектийн шүүгч, прокурорын хувьд Монголын Хуульчдын холбооны заавал гишүүнчлэлтэй байдаг, мөрдөгчдийн хувьд мөн хуульчдын холбооны гишүүнчлэлтэй байх нь бий. Мөн сургалтын хувьд ерөнхийдөө залхаах маягаар хийгддэг гэдэг шүүмжлэл байдаг. Тийм учраас сургалтыг богино буюу 1 удаадаа 3-4 цагаас хэтрүүлэхгүй, сэдэвчилсэн байдлаар хийх, сургалтыг шинэлэг арга зүйгээр зохион байгуулах нь зүйтэй гэсэн санал байна.

Илтгэлийн дараагийн хэсгээр шүүгч, прокурор, мөрдөгчийн болон тэдгээртэй холбоотой ажиллаж буй хуульчдын хөндлөнгийн нөлөөллөөс ангид байх асуудлыг авч үзнэ. Мөн дээр хэлсэнчлэн “Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан”-д үндэслэсэн мэдээлэл байгаа юм.

Зүй бус нөлөөлөл, дарамт шахалт авлигын хэргийг шалгаж, шийдвэрлэхэд их, маш их сөрөг нөлөөтэй гэж дараах байдлаар дүн гарсан.

Зүй бус нөлөөлөл, дарамт шахалт авлигын хэргийг шалгаж, шийдвэрлэхэд их, маш их сөрөг нөлөөтэй (Өөрийн үнэлгээ)



Шүүгч, прокурор, мөрдөгчийн хувьд хөндлөнгийн зүй бус нөлөө, дарамт шахалт маш их байна гэж нийтлэг байдлаар хариулсан. Энэ гурваас гадна Монголын Хуульчдын холбоо, Азийн сан хамтарч 2018 онд хийсэн “Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга байдлын судалгаа” судалгаанд хуульчдын 77 хувь нь ийм нөлөөлөл маш их байгаа гэж дүгнэсэн байгаа юм. Үүнээс үзэхэд дээрх субъектүүд зүй бус нөлөө байгаа гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа ба энэхүү нөлөөлөл нь өөрөө асуудлыг шийдвэрлэхэд,

гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлөх нь тодорхой байна.

Иймд энэхүү нөлөөллөөс яаж ангид байх вэ гэдэг асуудлыг бид зайлшгүй ярих шаардлагатай байна. Хуульчдын хувьд нөлөөллөөс ангид байх механизм нь хуульчийн мэргэжлийн дүрэм байдаг. Энэхүү дүрэмд хуульч хэрхэн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, хуульчид хоорондын харилцаа, хуульчдын нийтийн өмнө хүлээх үүрэг, нууцлал, эрх хэмжээ, хараат бус байдал болон хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдсон бусад харилцааг зохицуулдаг. Хуульчийн мэргэжлийн дүрмийг үр дүнтэй мөрдүүлэх нэг механизм нь мэргэжлийн дүрмийг зөрчсөн хуульчид хариуцлага хүлээлгэх юм. Харамсалтай нь 2021 оны 01 дүгээр сарын 15-нд Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлахдаа Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн эсэхийг гомдлын дагуу хянан шийдвэрлэх, хуульчид хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг бүхэлд нь хүчингүй болгосон. Шүүгч, прокурор, мөрдөгчийн ёс зүйн асуудлыг тус тусынхаа байгууллагаар шийдвэрлүүлнэ гэдэг байдлаар тайлбарлаж хүчингүй болгосон боловч үлдсэн 3000 орчим бусад хуульчийн мэргэжлийн дүрмийн хэрэгжилтийг хангуулах байдал хэрхэх эсэх нь тодорхойгүй болж орхигдсон. Иймд энэ асуудлыг шийдвэрлэх ёстой.

Шүүгчийн хувьд нөлөөллийн мэдүүлэг гаргах үүрэгтэй хэдий ч нөлөөллийн мэдүүлэг гаргах ёстой тухайн тохиолдолд тийнхүү мэдүүлээгүй асуудал нь өөрөө ямар нэгэн хариуцлага, үр дагавар байдаггүй, мэдүүлэг гаргах нь сайн дурын буюу сонголтын шинжтэй байдаг. Үүний цаана мэдүүлэх ёстой байхад нөлөөлөлтэй эвлэрсэн, байх ёстой зүйл гэж үзсэн тохиолдлууд ч бас байдаг. Мөрдөгч, прокурорын хувьд бол шүүгчтэй адилхан нөлөөллийн мэдүүлэг гаргах аргаар зүй бус нөлөөллийн асуудлыг шийдвэрлүүлэх нь чухал юм.

Дээрхээс үндэслэн мөрдөн шалгах, түүнд хяналт тавих, шийдвэрлэх ажиллагаанд учирч буй аливаа саад, хөндлөнгөөс нөлөөлөх оролдлогын талаар мөрдөгч, прокурор, шүүгч мэдээлэх, түүнийг хүлээн авах, хянан үзэх тогтолцоо, механизмыг бий болгох, хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн эсэхийг гомдлын дагуу хянан шийдвэрлэх, хуульчид хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг сэргээн батлах нь зүйтэй гэж дүгнэхээр байна.



АВЛИГА БА ХҮНИЙ ЭРХ

*Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, хууль зүйн ухааны доктор
Д.Сүнжид*

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хүний эрхийн чиглэлээр баталсан 100 гаруй гэрээ, конвенц байдгаас Монгол Улс нэгдэн орсон 50 орчим гэрээ Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц багтаж байгаа юм. Үүний зэрэгцээ үндэсний хэмжээнд авлигатай холбоотой хууль тогтоомж, хөтөлбөрийг холбогдох байгууллагууд баталсан байна. Үүнд:

- ★ Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцыг соёрхон батлах тухай хууль (2005.10.27)
- ★ Авлигын эсрэг хууль (2006.07.06)
- ★ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2012.01.19)
- ★ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017.05.18)
- ★ Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр (УИХ-ын 51 дүгээр тогтоол 2016.11.03)-ийг тус тус баталсан байна.

Дэлхийн шударга ёс төсөл (World Justice Project)-ийн хүрээнд Хууль дээдлэх ёсны индексийг гаргадаг. Энэхүү индексийг гаргахад эрх зүйчид, хуульчид, шүүгчид зэрэг мэргэжлийн хүмүүсийг түлхүү оролцуулж, Хууль дээдлэх ёсны төвшинг 8 багц шалгуураар маш нарийвчлалтайгаар гаргадгаараа онцлог юм. Энэхүү индекс нь 2014 онд гарч эхэлсэн бөгөөд Монгол Улсын талаар 2012 оноос тусгасан байна. Монгол Улсын хувьд дэлхий нийттэй харьцуулахад хууль дээдлэх ёсны үзүүлэлтэд дорвитой ахиц дэвшил гараагүй байна. 2021 оны үзүүлэлтээр 139 орноос Эрүүгийн шүүхийн шударга байдлын үзүүлэлтээр 57 дугаарт, Хэв журам аюулгүй байдлын үзүүлэлтээр 58 дугаарт, Үндсэн эрхийг хангах үзүүлэлтээр 63 дугаарт, Иргэний шүүхийн шударга байдлын үзүүлэлтээр 63 дугаарт, Засгийн газрын эрхийг хуулийн дагуу хязгаарлах байдлаар 66 дугаарт, Журам, зохицуулалтын хэрэгжилтийн үзүүлэлтээр 70 дугаарт, Нээлттэй засаглалын үзүүлэлтээр 72 дугаарт, Авлигыг устгах


үзүүлэлтээр 81 дүгээрт жагсаж байна. Энэ жагсаалтаас үзэхэд авлигыг устгах үзүүлэлт Монгол Улсын хувьд хамгийн хангалтгүй үнэлгээ авсан байх бөгөөд задаргааг нь харвал цагдаагийн байгууллага 0.64, шүүх 0.53 хэмээн дунджаас дээгүүр оноо авсан бол гүйцэтгэх эрх мэдэл 0.41, хууль тогтоох эрх мэдлийн түвшинд 0.16 хэмээн дунджаас доогуур үнэлгээ авсан ажээ.

“Транспэрэнси Интернэшнл” олон улсын байгууллагаас “Дэлхий нийтийн авлигын хэмжүүр”-ийг жил бүр тооцоолон гаргадаг. 2020 оны Авлигын төсөөллийн индексийн дүнгээс харахад Авлига нь Ковид-19-ын эсрэг арга хэмжээг үр дүнгүй болгож, дэлхий даяарх цар тахлын эсрэг тэмцэл удааширч байна хэмээн үзжээ. Өөрөөр хэлбэл, Авлига болон Ковид-19 халдварт өвчин улс орнуудын ардчилалд ухралтыг авчирч байна хэмээн дүгнэж байна. 2021 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр Берлин хотод “Транспэрэнси Интернэшнл” байгууллагаас 2020 оны “Авлигын төсөөллийн индекс”-ийг зарлахдаа “авлига нь эрүүл мэндийн салбарын хүртээмжтэй үр дүнтэй байдлыг дордуулж, улс орнуудын ардчилсан байдалд том нөлөө үзүүлж байна” гэж мэдэгдсэн байна. Ийнхүү “Транспэрэнси Интернэшнл” байгууллагын ТУЗ-ийн дарга хатагтай Дэла Фэрррира Рубио: “Ковид-19 цар тахал бол зөвхөн эрүүл мэнд, эдийн




CORRUPTION PERCEPTIONS INDEX 2021

The perceived levels of public sector corruption in 180 countries/territories around the world.



SCORE COUNTRY/TERRITORY

81	Denmark	67	Chile	53	Cyprus	42	Burkina Faso	36	Moldova	30	Laos	23	Iraq
80	Ireland	67	United States of America	53	Rwanda	42	Bulgaria	36	Panama	30	Paraguay	23	Zimbabwe
79	New Zealand	65	Barbados	53	Saudi Arabia	41	Timor-Leste	36	Peru	30	Togo	23	Eritrea
78	Norway	65	Bahamas	52	Oman	41	Belarus	35	Albania	29	Kenya	21	Congo
75	Singapore	63	Qatar	52	Slovakia	41	Tinidad and Tobago	35	Bosnia and Herzegovina	29	Angola	21	Guinea-Bissau
75	Sweden	62	Korea, South	49	Armenia	40	India	35	Malawi	29	Malawi	20	Liberia
74	Switzerland	60	Portugal	49	Greece	40	India	35	Malawi	29	Mali	20	Comoros
74	Netherlands	61	Lithuania	49	Jordan	40	Madives	35	Mongolia	29	Russia	20	Haiti
71	Luxembourg	61	Spain	49	Namibia	40	Colombia	34	El Salvador	28	Myanmar	20	Sudan
68	Germany	60	Israel	48	Malaysia	39	Colombia	34	Sierra Leone	28	Myanmar	20	Nicaragua
59	United Kingdom	59	Latvia	47	Croatia	39	Guyana	34	Egypt	28	Myanmar	20	Haiti
59	Hong Kong	59	Saint Vincent and the Grenadines	46	Montenegro	39	Morocco	33	Nepal	28	Pakistan	19	Burundi
59	Canada	58	Cabo Verde	45	China	45	China	33	Philippines	27	Uzbekistan	19	Democratic Republic of the Congo
54	Iceland	58	Costa Rica	45	Romania	39	Suriname	33	Zambia	27	Uzbekistan	19	Turkmenistan
54	Ireland	57	Slovenia	45	Sao Tome and Principe	39	Suriname	33	Zambia	27	Uzbekistan	19	Equatorial Guinea
54	Estonia	57	Slovenia	45	Vanuatu	45	Vanuatu	38	Argentina	31	Niger	17	Libya
54	Austria	56	Italy	45	Poland	45	Poland	38	Brazil	31	Gabon	16	Alghanistan
54	Australia	56	Saint Lucia	44	Jamaica	44	Jamaica	38	Brazil	31	Gabon	16	Korea, North
53	Belgium	56	Botswana	44	South Africa	44	Tunisia	38	Lesotho	31	Niger	16	Yemen
53	Japan	55	Botswana	44	Tunisia	44	Tunisia	38	Lesotho	31	Niger	16	Venezuela
53	Uruguay	55	Dominica	43	Ghana	43	Ghana	38	Senegal	31	Papua New Guinea	16	Somalia
53	France	55	Fiji	43	Hungary	43	Hungary	38	Senegal	31	Papua New Guinea	16	Syria
50	Seychelles	55	Georgia	43	Kuwait	43	Kuwait	37	Gambia	30	Bolivia	14	South Sudan
50	United Arab Emirates	54	Czechia	43	Senegal	43	Senegal	37	Kazakhstan	30	Bolivia	14	Central African Republic
50	Bhutan	54	Malta	43	Solomon Islands	43	Solomon Islands	37	Kazakhstan	30	Bolivia	14	Cambodia
49	Taiwan	53	Mauritius	42	Bahrain	42	Bahrain	36	Cote d'Ivoire	30	Dominican Republic	14	Honduras
		42	Grenada	42	Benin	42	Benin	36	Ecuador	30	Dominican Republic	14	Honduras



#cpi2021
www.transparency.org/cpi

This work from Transparency International (2021) is licensed under CC BY-ND 4.0

засгийн хямрал биш бас авлигын хямрал бөгөөд бид ялагдаж байна. Өнгөрсөн жил улс орнуудад урд өмнө байгаагүй хэцүү сорилт боллоо. Авлига өндөртэй улс орнууд энэхүү сорилтод бүдэрч байна. Мөн Авлигын төсөөллийн индексийн оноо өндөр байх тул улс орнууд авлигатай тэмцэхэд бусдадаа туслах үүргээ гүйцэтгэхийг уриалж байна” гэж мэдэгджээ.

2020 оны Авлигын төсөөллийн индексийн дүнгээр Монгол Улс нийт 180 орноос 35 оноотойгоор 111 дүгээрт жагссан байна.

Дэлхийн авлигын барометрийн мэдээлснээр Монголчуудын 61 хувь нь төр засгаас авлигатай хийж буй тэмцлийг маш муугаар үнэлж байна. Санал асуулгад оролцогчдын 46 хувь нь УИХ-ын гишүүдийн ихэнх нь буюу бүгд авлигын хэрэгт холбогдсон гэж үздэг. Зөвхөн 14% нь эрх баригчдыг авлигатай тэмцэх үр дүнтэй арга хэрэгсэл гэж үзэж байна (бүс нутгийн дундаж нь 22%) боловч монголчуудын 69% нь авлигын талаар мэдээлэх үүрэгтэй гэж үзжээ. 49% нь авлига өгөхөөс татгалзах нь авлигатай тэмцэх хамгийн сайн арга гэж иргэд үздэг (бүс нутгийн хувьд 21%).

Азийн сан болон Сант-Марал сангийн хамтран хийсэн 2018 оны “Авлигын талаарх мэдлэг, ойлголтын хүрээнд” хийсэн судалгааг авч үзвэл:

- ★ Авлига нь ажилгүйдлийн дараах үед манай улсын хувьд хоёрдогч үндсэн асуудалд тооцогддог.
- ★ Хариулт өгсөн нийт хүмүүсийн 90.1% нь авлига нь Монгол Улсад маш нийтлэг ойлголт болсон бөгөөд өссөөр байгаа хэмээжээ.
- ★ 70.7 % нь авлигатай хэрхэн тэмцэхээ мэддэггүй.
- ★ Оролцогчдын дийлэнх нь буюу 59% нь АТГ-ын авлигатай тэмцэх үйл ажиллагааг муу, эсхүл маш муу гэж үнэлж байна.
- ★ Энэ нь АТГ-ын үйл ажиллагаанд өгсөн хамгийн муу үнэлгээ бөгөөд санал асуулгад оролцогчдын 75 хувь нь АТГ-т итгэлгүй байгаа бол 74 хувь нь тус байгууллагыг шударга бус хууль сахиулах байгууллага гэж үзэхгүй байна.

Засгийн газраас өгсөн мэдээллийн дагуу авлигад өртөж буй байгууллагуудыг дурдвал эхний 5-г:

1. Шүүх байгууллага,
2. Газрын алба,
3. Эрүүл мэндийн салбар,
4. Яамд болон агентлагууд,
5. Боловсролын салбар оржээ.

Монголын нийгэм, эдийн засаг, улс төрийн байдлын талаарх 2019 оны судалгаагаар тулгамдсан асуудлыг 1) Ажилгүйдэл 11.6, 2) Улсын Их Хурал

ба Засгийн газар, улс төрийн намын хямрал 11.1, 3) Авлига 9.5 гээд цааш үргэлжлүүлэн бусад асуудлыг нэрлэжээ.

2018 онд Азийн сангаас Бизнес эрхлэгчдийн орчин дахь авлигын нөхцөл байдлын судалгаанд 2015-2018 оны хооронд судалгаанд оролцогчдын бараг тэн хагас нь төрийн албаны авлига тэдгээрийн бизнест “маш ихээр” буюу “тодорхой хэмжээнд” нөлөөлсөн гэж мэдэгдсэн байна. Мөн тус судалгаанд оролцогчид Татварын алба, Мэргэжлийн хяналт болон Гаалийн байгууллагыг бизнес эрхлэхэд хамгийн их саад бэрхшээл учруулж буй төрийн байгууллагаар онцлон, дээрх гурван байгууллагыг авлигад хамгийн ихээр өртсөн байгууллагаар нэрлэсэн байна.

Олон улсын болон үндэсний судалгааны жагсаалт, дүгнэлтээс үзэхэд Монгол Улсад авлигын нөхцөл байдал ноцтой байна.

Авлигын үр дагавар нь хүний эрхийн зөрчил мөн. Авлига нэмэгдэх тусам иргэдэд төрөөс үзүүлэх хүний эрхийн хамгаалал багасаж, иргэдийн амьдралд тусах хүндрэл, бэрхшээл тулгардаг. НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албаны мэдээлснээр авлигын улмаас жилд 1.26 триллион ам.долларыг хөгжиж буй орнууд алддаг байна.

1. Авлигын улмаас эдийн засаг, нийгэм, соёлын эрх тодруулбал, амьдралын чанар, хоол хүнс, орон байр, эрүүл мэнд, боловсролын эрх авлигын улмаас түгээмэл зөрчигддөг. Учир нь Иргэний эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын хоёрдугаар хэсгийн 2-т зааснаар Пактад оролцогч улс бүр дангаараа болон олон улсын тусламж, хамтын ажиллагаагаар, тухайлбал, эдийн засаг, техникийн салбарт, энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг бүрэн хэрэгжүүлэхийг дэвшилттэйгээр хангахын тулд хууль тогтоомжийн арга хэмжээг оролцуулан, зохистой арга хэмжээг байгаа бүх боломжийнхоо хэрээр авах үүрэгтэй байдаг. Иймийн тулд улс орнууд өөрийн нөөц, боломж, арга, хэрэгслийг ашиглан эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлэхдээ байнгын ахицдэвшилд тэмүүлж, хөгжих эрхийг хангах учиртай болдог. Тиймээс авлигын улмаас эрхийн хэрэгжилтийг хангах тогтолцоо, хэрэгсэл, механизм, нөөцийн хуваарилалт дутагдахад хүрдэг байна. Хэрэв хязгаарлагдмал нөөцтэй үед бол эхний ээлжинд илүү эмзэг бүлэгтээ зориулсан дэмжих арга хэмжээ авах, тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрхийн амьжиргааны түвшин доогуур, бусад эрсдэлтэй нөхцөлд байгаа хэсгийг тухайлан дэмжих арга хэмжээ авах учиртай байдаг.

2. Иргэний болон улс төрийн эрхийг хэрэгжүүлэхэд, тодруулбал шударга шүүхээр шүүлгэх эрх, хуулийн албадлагыг хангах, шоронгийн тогтолцоо, чөлөөтэй шууд ардчилсан бүх нийтийн сонгуулийг зохион байгуулахад мөн

тодорхой нөөц шаардлагатай. Тиймээс энэ бүлэг эрхийн тухайд нийтийн төсөв, санхүүгийн эх үүсвэрийг хууль бус зориулалтаар зарцуулах, зарчмыг зөрчиж хуваарилах зэрэг асуудал авлигын үр дагавар болж үүсэж болзошгүй байдаг. Жишээлбэл, сонгуулийн санал худалдаж авбал, энэ нь авлигын замаар улс, иргэний эрх зөрчих тохиолдол болно.

3. Авлигын үр дүнд шууд зөрчигддөг эрх бол тэгш эрх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх болдог. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, олон улсын пакт, Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно хэмээн заасан. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг авлига гэнэ. Авлигын тодорхойлолтоос үзэхэд тухайлсан нөхцөл байдалд адил хүлээн зөвшөөрүүлэх, үндсэн эрхийг адил тэгш эдлэх боломжийг үгүйсгэдэг үр дагавар үүсгэх зорилгоор авлигын үйлдлийн улмаас заримд нь давуу тал олгох, заримын эрхийг хасах, заримынх нь эрхийг ялгамжтай тодорхойлдог гэжээ. Авлигаас үүдэн нийгэмд шударга, зүй бус үйлдэл, ялгаварлан гадуурхалт бий болдог бөгөөд төрийн албан тушаалтан эрх мэдлээ ашиглан, авлига авах, нөгөө талаар өөрийн ажил, хүсэл, зорилгоо хууль бус хялбар аргаар бүтээх гэж авлига өгч буй этгээдүүдийн хоорондын үйлдэл иргэний хуулиар олгогдсон наад захын үндсэн эрхийг шууд ба шууд бусаар зөрчиж байдаг. Тухайлбал хүүхэд, залуус ерөнхий болон их, дээд сургуульд элсэн орох хангалттай оноо, мэдлэгтэй байсан ч эрх мэдэл, мөнгөтэй хэн нэгэн албан тушаалтны хүүхэд хахууль өгч өмнө нь ордог. Энэ нь тухайн хүүхдийн хуулиар олгогдсон тэгш эрх, сурч боловсрох эрх нь зөрчигдөхөд хүргэж байгаа юм. Нөгөө талаас, хахууль өгч сургууль төгссөн хүүхдийн мэдлэг, ур чадвар дутмаг муу боловсон хүчин болж гарснаар уг хүний ажлын байр баталгаагүй, хамт олондоо нэр хүндгүй болох нөхцөлийг бүрдүүлдэг. Авлигын үр дүн бол хууль дээдлэх ёсны зарчимд нийцэхгүйгээр тэгш эрх, ялгаварлан гадуурхалтын зарчмыг шууд зөрчдөг учир хүний эрхийн зөрчил болдог. Авлига нь нийгмийн шударга ёс, хууль тогтоомжийг тойрон гарч, албан тушаалтнаар хууль бус үйлдлийг хийлгэх зорилгод шууд үйлчилдэг учраас алхам тутамдаа хүний эрхийн зөрчлийг дагуулдаг. Ийм учир авлигын улмаас нийгмийн эмзэг бүлгийнхэн, шилжин суурьшигчид, нийгмийн цөөнх зэрэг эрх мэдлийн цөөнх хэсэг хамгийн их нэрвэгддэг байна.

4. Авлигын улмаас шударга шүүхээр шүүлгэх эрх, хохирлыг нөхөн төлүүлэх эрх зөрчигддөг.

Хууль хяналтын байгууллагын албан хаагчид авлигад өртсөнөөр иргэдийн халдашгүй байх, хууль, шүүхийн өмнө эрх, тэгш байх, шударга шүүхээр шүүлгэх, хохирлоо нөхөн төлүүлэх эрхийн баталгаа алдагдаж, хуулийн хамгаалалтгүй болох, аливаа асуудлыг зөвхөн хөрөнгө мөнгө, танил талаараа зохицуулахад хүргэдэг. Энэ нь иргэдийн хууль хяналтын байгууллагад итгэх итгэлийг сулруулж, эрхээ хамгаалуулах боломжийг хааж байдаг. Түүнчлэн хил, гаалийн ажилтнууд хахууль авч хил гарах зөвшөөрлийг хууль бусаар гаргаж өгөх нь хүний наймаа, охид эмэгтэйчүүдийн биеийг хүчээр үнэлүүлэх зэрэг гэмт хэрэг гарах эрсдэлийг бий болгох магадлалтай. Эдгээр хэлбэрийн авлига болон хүний эрхийн зөрчлийн хоорондох холбоог олж харахад хэцүү ч нийгэмд бүхэлд нь ноцтой хор хөнөөл учруулдаг байна.

5. Аж ахуй эрхлэх, шударгаар хөдөлмөрлөж, орлого олох эрхэд авлига шууд нөлөөтэй. Бизнес шударга өрсөлдөөн байхгүй бол импортоор чанаргүй бараа бүтээгдэхүүн, эмнэлгийн болон бусад хоцрогдсон тоног төхөөрөмж орж ирэх нь ихсэж иргэд, нийтэд хохирол учруулахад хүргэдэг. Үүнээс иргэдийн эрүүл, аюулгүй хоол хүнсээр хангагдах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрх зөрчигддөг байна. Хүний нэг эрх зөрчигдсөнөөр бусад эрхүүд бас зөрчигдөх нөхцөл үүсдэг. Үндэсний хэмжээний судалгааны дүнгээс үзэхэд улсын төсвийг бүрдүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэдэг гааль, татварын байгууллага, мэргэжлийн хяналт хамгийн их авлигад өртөмтгий салбар байгаа нь түгшээсэн мэдээлэл бөгөөд энэ салбарт авлига төрийн бүх үйлчилгээний чанар, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтэд шууд нөлөөлнө. Үүний улмаас иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох эрх зөрчигдөхөд хүрч, нийгмийн халамж, үйлчилгээ шаардлагатай байдаг иргэдэд шууд сөргөөр нөлөөлөх магадлалтай.

Авлигаас үүдэх хор хохирлыг зөвхөн мөнгөн дүнгээр илэрхийлэх хангалтгүй, иргэдийн итгэлийг алдах сөрөг үр дагавартай. Төрд итгэх иргэдийн итгэлийг алдах урт хугацааны үргэлжилсэн сөрөг үр дагавар үүсгэх бөгөөд эрх зүйн ухамсар, хуулийг дагаж мөрдөх хандлагад хүртэл нөлөөлнө. Авлигын үнэлгээ бүрийн ард алдагдсан боломж, нэг юм уу бүлэг иргэдийн эрх, нийтийн ашиг сонирхол, түүнчлэн үндэсний аюулгүй байдалд ч сөргөөр нөлөөлдөг.

Авлигын эсрэг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар “Транспэрэнси интернэшнл” байгууллага дэлхийн улс орнуудад авлигыг бууруулах болон дахин тохиолдож болох хямралын хариу арга хэмжээний хүрээнд дараах санал хүргүүлж байна. Үүнд:

- ✦ Хөрөнгө, санхүүжилт нэн шаардлагатай хүмүүст хүрч байгааг бататгахын тулд Хяналтын байгууллагуудаа бэхжүүлэх.

- ✦ Авлигатай тэмцэх болон аудит ба бусад хяналтын байгууллагууд үүргээ биелүүлэхэд нь хангалттай санхүүжилт, хүний нөөцтэй мөн эрх зүйн хувьд хараат бус байх.
- ✦ Хууль бус үйлдэлтэй тэмцэх, ашиг сонирхлын зөрчлийг олж тогтоох болон шударга хямд үнэ тогтоох үүднээс худалдан авалтын гэрээ байгуулахад Нээлттэй, ил тод байдлыг хангах.
- ✦ Төр, засагт хариуцлага хүлээлгэх бололцоог хангахын тулд ардчилал болон иргэний нийгмийн орон зайг хамгаалах
- ✦ Олон нийтэд хүртээмжтэй, цаг тухайд нь мэдээллийг хүргэх үүднээс Холбогдолтой мэдээллийг нийтэлж мэдээлэл авах боломжоор хангах

Авлигын эсрэг олон улсын гэрээ, хэлэлцээр, олон хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд дараах арга хэмжээ авах шаардлагатай. Үүнд тухайлбал:

- ✦ авлига хүний эрхэд нөлөөлж байгаа байдлын талаар нарийвчилсан судалгаа, дүн шинжилгээ хийх;
- ✦ мэдээллийн ил тод байдлыг шаардаж хангуулах (Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хууль зэрэг);
- ✦ улс төрийн нам, бодлогын дээд түвшний буюу УИХ, Засгийн газар, шүүх эрх мэдлийн хүрээний авлигын хүчин зүйл, шалтгааныг тодорхойлж, тэмцэх;
- ✦ хууль тогтоомжид холбогдох өөрчлөлт оруулах, тухайлбал, Эрүүгийн хуульд нийтийн албан тушаалтан авлигын гэмт хэргийн улмаас мөрдөн шалгах ажиллагааны явцад бусад гэмт хэрэгтэй адил ял наймаалцах боломжийг хаах;
- ✦ авлигатай тэмцэх талаарх төрийн албан хаагчдад хяналт тавьж, хэрэгжилтийн нөхцөл байдлаас шалтгаалан хариуцлага гарцаагүй хүлээлгэх, (газар олголт, тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрх өгөх, Улаанбаатарт нийслэлд барилга барих зөвшөөрөл өгөх асуудал илт хууль зөрчсөн үйлдэл, нийтэд харагддаг үйлдэл боловч үүний улмаас хариуцлага хүлээсэн албан хаагч байдаг эсэх);
- ✦ төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, байгууллага дотооддоо ёс зүйн дүрэм, журмын хэрэгжилтийн хяналтыг сайжруулах;
- ✦ хамгийн их авлигад өртөмтгий салбарыг цахимжуулах (хүнтэй аль болох шууд харилцахгүй байх);

- ✦ хэвлэл мэдээллийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж зэрэг олон талт иргэдийн оролцоог хангах замаар аливаа авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх, хамгаалах түншлэх.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхийг хангахад, хууль дээдлэх ёс, шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэхэд авлигыг таслан зогсоох нь чухал суурь асуудал юм.


Эх сурвалж:

<https://worldjusticeproject.org/sites/default/files/documents/WJP-INDEX-21.pdf>

<https://www.unodc.org/e4j/en/anti-corruption/module-7/key-issues/impact-of-corruption-on-specific-human-rights.html>

“2020 оны Авлигын индексийг Transparency International танилцуулж байна.”

<https://legaldata.mn/b/556>



◆ “АВЛИГЫН ЭСРЭГ
ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН-2021”

Талбар хэлэлцүүлэг 2

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХЭД ХЭВЛЭЛ
МЭДЭЭЛЛИЙН БОЛОН ИРГЭНИЙ
НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ,
ОРОЛЦОО**



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХЭД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ, ОРОЛЦОО

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ НЬ: ИРГЭДИЙН
МЭДЭХ ЭРХ БА МЭДЭЭЛЛИЙН ИЛ
ТОД БАЙДАЛ**

*“Глоб интернэшнл төв” ТББ-ын Хуульч
Б.Пүрэвсүрэн*



**АВЛИГЫН ЭСРЭГ ИРГЭДИЙН
ХЯНАЛТ, ОРОЛЦОО**

*Авлигатай тэмцэх газрын дэргэдэх
Олон нийтийн зөвлөлийн дарга
Г.Ганбат*



**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХЭД ХЭВЛЭЛ
МЭДЭЭЛЛИЙН САЛБАРЫН
ОРОЛЦОО, СЭТГҮҮЛЧИЙН
МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙ**

*Монголын хэвлэл мэдээллийн зөвлөлийн
Гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа*



БОЛОН ИРГЭНИЙ НИЙГМИЙН

ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙГ ХАМГААЛАХ, МЭДЭЭЛЭХ ТОГТОЛЦООГ ДЭМЖИХҮЙ

Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн

АВЛИГААС АНГИД БОЛОВСРОЛЫН САЛБАР: ТӨСӨВ, ИЛ ТОД БАЙДАЛ, ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦОО

*“Бүх нийт боловсролын төлөө!”
Иргэний нийгмийн үндэсний эвслийн
ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг*

АВЛИГАТАЙ ЭСРЭГ ЗАЛУУСЫН ОРОЛЦОО, САНААЧИЛГА

*“Цогц хөгжлийн үндэсний төв” ТББ-ын
Тэргүүн М.Энхбадрал*



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ НЬ: ИРГЭДИЙН МЭДЭХ ЭРХ БА МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

*“Глоб интернэшнл төв” ТББ-ын
Хуульч Б.Пүрэвсүрэн*

Авлигатай тэмцэхэд мэдээллийн эрх чөлөө ямар ач холбогдолтой талаар ярихын тулд эхлээд оршил хэрэгтэй. Өдөр тутамдаа бид маш олон төрлийн мэдээллүүдэд дүн шинжилгээ хийн, шийдвэр гаргадаг. Тухайлбал, өнөөдөр цаг агаарын байдал ямар байгаа талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийж, бороотой, эсхүл цастай өдрөөс шалтгаалан тухайн цаг агаарт таарсан хувцсыг өөртөө тохируулан өмсөж чадна.

Ийм учраас 1948 оны “НҮБ-ын Ерөнхий Ассамблей”-ийн анхдугаар чуулганаар мэдээллийн эрх чөлөөний асар их ач холбогдлыг үнэлэн, энэхүү эрх нь ардчилсан нийгмийн тулгын 3 чулуу мэт үнэ цэнэтэй болохыг дэлхий нийтэд зарлан тунхагласан байдаг.

Бид бүхэн мэдээллийн эрх чөлөөг ашигласнаар энэ анхдагч эрхээс одоо яагаад авлигатай тэмцэх гэж байгаа вэ гэсэн асуулт урган гарна. Авлигатай тэмцэхэд мэдээллийн эрх чөлөөг маш сайн хангах нь чухал ач холбогдолтой бөгөөд энэ нь нэн түрүүнд нээлттэй байх ёстой юм. Аливаа асуудалд мэдээллийн эрх чөлөө хаалттай, ил тод биш байвал бидний дээр дурдсан анхдагч эрхийг хэрэглэхэд нэн хүндрэлтэй байдаг. Барилга байгууламж барихад өртөг шингэнэ, хувцас хоол гээд иргэдийн өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэд өртөг шингэнэ. Үүнийг “уран зохиолын” хэлээр энгийн байдлаар тайлбарлавал зохиолч Жорж Оруэллийн 1948 онд бичсэн “1984” гэсэн нэртэй романд дурдсанаар том ахын засаглал, мэдээллийг хянадаг тогтолцоо юм.

Эрх мэдэл, эд хөрөнгийг тогтмол хянахын тулд мэдээллийн ил тод байдал чухал гэдгийг харуулсан эхний үзүүр юм. Мөсөн уулын орой гэсэн үг. Яагаад бид мэдээллийг ашиглах вэ гэхээр нийтийн хөрөнгийг захиран зарцуулах, төрийн нэрийн өмнөөс шийдвэр гаргахдаа алдаа дутагдал гаргах магадлалтай байдаг. Үүнийг хянах механизм нь мэдээллийн эрх чөлөө болон хувирч байна.

Бид бүхэн авлигатай тэмцэхийн тулд олон төрлийн хөтөлбөрөөс авхуулаад

олон том зүйлийг ярьдаг. Манай улс 180 гаруй орноос авлигын индексээр 111 дүгээр байрт жагсаж байна. Гэтэл бид өнөөдөр мэдээллийн эрх чөлөөг урагшлуулах, нэмэгдүүлэх талаар үр дүнтэй оролдлого хийхгүй байна. Зүгээр хуулийн төсөл санаачилсныгаа мэдээллийн эрх чөлөөг урагшлуулж байна гэж эндүүрч байна. Мэдээллийн эрх чөлөөний индексийн хамгийн сүүлийн үеийн тоо баримтаар 134 орноос Монгол Улс 63 дугаар байранд жагсаж байна.

Дээрх 2 индексийн хувьд хоорондоо харилцан хамааралтай бөгөөд мэдээллийн эрх чөлөө тухайн улс оронд сайн хангагдах юм бол авлигын индекс уялдаж буурах учиртай юм. Авлигын үзүүлэлт хамгийн бага буюу авлигатай сайн тэмцэж байгаа улс орны индексийг харахад хэвлэлийн эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөөний индекс нь мөн адил урагшилж, тэргүүн байранд жагсаж байдаг.

Манай Улсын мэдээллийн эрх чөлөөний тогтолцоонд үүсээд байгаа хамгийн том хорт хавдар нь “нууцын тогтолцоо” болж байна. Үндсэн хуулийн арван зургадугаар зүйл, арван долдугаар зүйлд “төр түүний байгууллагаас хууль бусаар тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй...” гэж заасан. Энэ хэсгийг энгийнээр тайлбарлавал “зоосны 2 тал лугаа” юм. Мэдээж аливаа улс оронд үндэсний аюулгүй байдлыг чухалчлах нь зөв. Хуулийн хүрээнд тогтоох нууцын асуудал дэлхийн аль ч улс оронд байдаг. Үүнийг бол хүлээн зөвшөөрч байна. Үндсэн хууль, олон улсын гэрээ конвенцод ч хүлээн зөвшөөрдөг.

Харин бусад бүх мэдээлэл нээлттэй ил тод байх ёстой боловч манай улс энэ тогтолцооны эсрэг явж байна. Тухайлбал, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14.2 дугаар зүйлд зааснаар зөвхөн тухайн байгууллагын даргын шийдвэрээр ил тод байх ёстой мэдээллийг “субъектив” байдлаар хандаж хэн нэгэн албан тушаалтан, даргын шийдвэрээр нууцалдаг тогтолцоо байсаар байна. Байгууллагаас нууцад хамааруулсан ямар ч мэдээллийг иргэн олж авах боломжгүй байдаг. Хүний эрхийн Үндэсний комисст хандаад, Захиргааны хэргийн шүүхэд хандаад ч олж авч чадахгүй нөхцөл байдал байсаар байна. Тиймээс бид хоорондоо уялдаа холбоо бүхий нууц, нээлттэй мэдээллийн ялгаа заагийг сайтар ойлгох шаардлага бий болоод байна.

Мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн төсөлтэй уялдуулан зарчмын шинжтэй хэдэн зүйл хэлэх хүсэлтэй байна. Олон нийт энэ хуулийн төсөлд анхаарлаа хандуулах ёстой юм.

Тухайлбал, тус хуулиар нээлттэй, хаалттай, хязгаарлалттай гэдэг зүйлийг зохицуулахаар тусгасан. Харамсалтай нь нээлттэй мэдээллийг нэрлэн зааж байгаа нь өөрөө давуу тал мэт ойлгогдож байна. Хуулиар хориглосон буюу хязгаарлалттай, хаалттай мэдээллээс бусад мэдээлэл бүгд нээлттэй байх

учиртай. Ялангуяа технологийн дэвшил хөгжсөн энэ цаг үед бид ямар төрлийн мэдээлэл нээлттэй байхыг хуулийн хүрээнд урьдчилан таамаглаад, түүнийгээ нэг бүрчлэн тогтоож, зааж чадахгүй.

Мэдээллийн эзний зөвшөөрлөөр мэдээлэл хүсэгч нь зорилгоо бичнэ гэсэн байгаа. Тэр зорилгыг өөрөөр ашиглахад хуулийн хариуцлага хүлээхээр байна. Жишээ нь сэтгүүлзүйн арга хэлбэр дээр би энэ мэдээллээр мэдээ, сурвалжилга бичнэ гэж байгаад нийтлэл, эсвэл хөрөг гаргачихвал зорилго өөрчлөгдөнө. Ингээд тухайн этгээд зорилго өөрчилсөн учраас Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээхээр байна. Энэ мэт ойлгомжгүй, уялдаа холбоогүй олон асуудал байна.

Үүнээс гадна бид иргэдийн мэдээлэл авах эрхийг анзаарахгүй өнгөрөөхөөр зарчмын асуудал байна. Тухайлбал, мэдээллийн эзний мэдээллийг төрийн байгууллага буюу мэдээлэл хариуцагч байгууллага нийтэлсэн тохиолдолд шүүхэд хандахаар байна.

Монгол Улсын хувьд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу хувь хүн, хуулийн этгээд төрийн байгууллагаас мэдээлэл авч чадсангүй гэж Захиргааны хэргийн шүүхэд хандсан тохиолдол одоог хүртэл байхгүй байна.

Миний хувийн нууцтай холбоотой хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх, намайг урьдчилан харах боломжтой мэдээллийг нийтэлсний төлөө би шүүхэд гомдол, нэхэмжлэн гаргаж залруулья гэхэд үнэ цэнэ хаана орших юм бэ. Нэгэнт задарч олон нийтэд ил болсон тухайн мэдээллийг бүгд мэддэг болсны дараа шүүхээр эрхээ хамгаалуулаад яах юм бэ гэх мэтийн олон асуудал урган гарч ирнэ.

Хуулийн төслийг нэг харахад, ахиад нэг харахад, үе үе харахад маш олон алдаа харагдаж байна. Энэ хуулийн зарим заалт амьдрал дээр хэрэгжих боломжгүй олон учир дутагдал байна. Үүнийг хувь судлаачийнхаа болон хуульч, өмгөөлөгчийн зүгээс хэлэхэд ийм байна.

Иймд та бүхнээс энэ асуудалд анхаарлаа хандуулан, төслийн шатанд илүү сайн боловсронгуй болгоход оролцоосой хэмээн хүсэж байна. Дараагийн нэг асуудал нь өнөөдөр албаны нууцын хүрээ, хязгаар, хэмжээ байхгүй, юуг албаны нууцад тогтоож болохгүй вэ гэдэг асуудлыг хуульд заагаагүй. Төрийн нууцын хүрээ, байгууллагын нууцын хүрээ, хувь хүний нууцын хүрээ байдаг тус тусын хуульдаа бий. Өнөөдрийн байдлаар нэг байгууллага багадаа 10 гаран, дээд тал нь 100 гаруй албаны нууцтай байна. Нийт “албаны нууц” хэдэн мянгаар тоологдохоор байна. Үүнээс үүдэн авлига, ашиг сонирхол, булхай, луйвар үүсэх эрсдэл бий болоод байна.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.



АВЛИГЫН ЭСРЭГ ИРГЭДИЙН ХЯНАЛТ, ОРОЛЦОО

*Авлигатай тэмцэх газрын дэргэдэх
Олон нийтийн зөвлөлийн дарга
Г.Ганбат*

Та бүхэнд энэ өдрийн мэнд дэвшүүлж, Авлигын эсрэг үндэсний чуулганд олон нийтийг төлөөлж үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх боломж олгосонд талархал илэрхийлье.

Авлигын эсрэг ажиллагааны олон нийтийн дэмжлэг

Авлигыг өргөн утгаар нь авч үзвэл олон нийтийн эсрэг гэмт хэрэг юм. Авлигын гэмт хэргийн эцсийн хохирогч нь олон нийт буюу ард түмэн байдаг. Тиймээс гагцхүү ард түмний итгэл, дэмжлэг хүлээж, оролцоог хангаж байж авлигатай тэмцэх үйл ажиллагаа үр дүнд хүрнэ.

Олон нийтийн итгэл гэдэг нь төр, түүний эрх бүхий байгууллагууд иргэд, олон нийтийн мэдээлэл авах эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлж, үйл ажиллагаа, мэдээлэл нь нээлттэй, ил тод, үнэн бодит, шуурхай, хүртээмжтэй байж, тэд хуульд захирагдан хариуцлагатай, шударга ажилласнаар иргэдийн дэмжлэг хүлээх явдал бол оролцоог хангана гэдэг нь нийгмийн олон талт бүлгүүдтэй төр тэгш харьцах, түншлэх, авлигын эсрэг хамтран тэмцэх тухай асуудал юм.

Авлигатай тэмцэнэ гэдэг авлигачидтай тэмцэнэ гэсэн үг. Тэдний бүтээсэн тогтолцоотой тэмцэнэ гэсэн үг. Олон улсын болон улс орны түвшинд тогтолцоожсон энэ гамшигт үзэгдэлтэй зөвхөн төрийн хууль, эрх зүй, институтийн макро тогтолцоо бүрдүүлэх замаар тэмцээд зогсохгүй дунд болон микро түвшинд иргэд, олон нийт, хувийн хэвшил, иргэний нийгэм, хэвлэл, мэдээллийн хэрэгслийн шууд оролцоог хангасан, хүчтэй дэмжлэгт тулгуурласан, тэдний итгэлийг хүлээсэн үндэсний шударга ёсны тогтолцоог бий болгон тэмцэх шаардлагатай байна.

Монгол Улсад үндэсний шударга ёсны тогтолцоо бүрэлдэн тогтоогүй, бэхжиж амжаагүй байна. Бидэнд авлигын эсрэг хууль, хөтөлбөр, стратеги байвч

хэрэгжилт сул, авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага, тогтолцоо байвч хамгаалалтгүй шахам, авлигыг жигших олон нийт байвч оролцоо, дэмжлэг нь ор нэр төдий байна.

Авлигатай тэмцэх үндэсний шударга ёсны тогтолцооны манлайд улс төрийн хүсэл зориг, манлайлал байх ёстой. УИХ, Засгийн газар хуульчилсан хулгай буюу албан ёсны авлига, ашиг сонирхлын зөрчлийг таслан зогсоож, авлигын өршөөл, хөөн хэлэлцэх хугацаа, хялбаршуулсан журам, ялгавартай ялын бодлогоор авлигачдаа өөгшүүлэхээ больсон цагт авлига бодитой буурна, иргэдийн төрд итгэх итгэл сэргэнэ. Авлигын индексийг 111 дүгээр байраас 60-руу буулгалаа гээд тоо өөрчлөгдөхөөс чанар өөрчлөгдөхгүй. Хүлээлт, бодит үр дүн хоёр зөрвөл бас л нийгмийн итгэл алдарч, тогтворгүй байдалд хүргэж болзошгүй. Төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, хэрэгжүүлэх, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн үзэл бодол, хяналт, санаачилга, оролцоог хангаж, дэмжлэгийг хүлээсэн цагт авлигатай тэмцэх бодлого жинхэнэ амжилттай хэрэгжинэ.

Авлигатай тэмцэх үндэсний шударга ёсны тогтолцоонд шүүх, хууль, хяналтын байгууллагуудын хууль дээдлэх, шударга ажиллах явдал амин чухал юм. Хууль, хяналтын байгууллагуудын шинэчлэлийн хүрээнд “хүчний” гэх менежментийн эмзэг хандлагыг бууруулж, иргэнлэг байдлыг нь нэмэгдүүлэх шаардлагатай байна. Хараат бус, бие даасан гэх хамгаалалтын дор нуугдсан шүүх засаглал, хүчний гэх тодотголдоо хэт автсан хууль, хяналтын байгууллагуудын үйл ажиллагаа, мэдээлэл, хамтын ажиллагааны харьцангуй хаалттай байдал нь ужгирсаар иргэд, олон нийт, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй сөргөлдөөнт байдалд хүргэж, тэдний итгэл, дэмжлэгийг алдахад хүргэж байна. Сэтгэлгээ, арга барил, хандлагаа эрс өөрчилж, олон нийтийн төлөөлөл, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийг нийгэмтэй харьцах, итгэл олох, дэмжлэг авах найдвартай гүүр, зөөлөн дэд бүтэц хэмээн үзэж, иргэнлэг цоо шинэ менежмент эхлүүлэх цаг нь болжээ.

Авлигатай тэмцэх үндэсний шударга ёсны тогтолцооны харуулд авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, мөрдөн шалгах дагнасан чиг үүрэг бүхий Авлигатай тэмцэх газар зогсож байна. Гэхдээ авлигын хэргээр дагнасан шүүх, прокурор ажиллуулж байж авлигатай тэмцэх тогтолцоо бүрэн бүрдэж, улам бэхжинэ, үр дүнтэй ажиллаж эхэлнэ. Цаашид онцгой эрх мэдэлтэй энэ байгууллагын үйл ажиллагаа, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг эрс шинэчилж, олон нийтийн хараат бус хяналт, хамтын ажиллагааны арга хэлбэрийг сайжруулах шаардлага нэн тулгамдсан байна. Ялангуяа Олон нийтийн зөвлөлийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх хууль, эрх зүй, зохион байгуулалтын шинэчлэл хүлээгдэж байна. Эс бөгөөс “Тос дотроосоо

өтөх” эрсдэл үүсэж болзошгүй юм.

Авлигатай тэмцэх үндэсний шударга ёсны тогтолцоонд иргэдийн оролцоо, олон нийтийн хяналт, хувийн хэвшлийн түншлэл, иргэний нийгэм, хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хамтын ажиллагаа ус агаар мэт хэрэгтэй байна. Чухам үүнийг хийж, дэмжиж, хамтын ажиллагааг хөгжүүлж авлигатай хийх тэмцэл бодит үр дүнд хүрч, төр, шүүх, хууль, хяналтын байгууллагуудын нэр хүнд сэргэж, иргэдийн итгэл, дэмжлэгийг хүлээнэ. Нөгөөтэйгүүр оролцогч талуудын авлигыг үл тэвчих соёл, эрх зүйн ухамсар, ёс зүй, шударга байдал, нийгмийн хариуцлага чухал үүрэгтэй.

Авлигатай тэмцэх үндэсний шударга ёсны тогтолцоонд хууль, эрх зүйг шинэчлэх, алдаа завхралыг засах, шударга ёсыг сэргээн тогтоох бодлого хүлээгдэж байна. Хууль хүний эрхийн асуудлыг ямагт хөндөж байдаг. 800 гаруй хуулийг өөрчлөхөөр яригдаж байна. Нэг нам парламентын үнэмлэхүй олонхыг бүрдүүлж байгаа энэ цаг үед хүний суурь эрхийг хөнддөг дараах хуулиудын шинэчилсэн найруулга, нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэхэд онцгой сонор сэрэмжтэй байж, идэвхтэй оролцохыг иргэд, олон нийтээс хүсэж байна.

Тухайлбал, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хууль, Улс төрийн намын санхүүжилтийн тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Нийтийн мэдээллийн тухай хууль, Төрийн болон албаны, хувь хүний нууцын тухай хуулиуд, Өргөдөл, гомдлын тухай хууль, Захиргааны тухай хууль, Цахим засаглалын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Жагсаал цуглааны тухай хууль гэх мэт олон хуулиудын нэмэлт, өөрчлөлтийн тухай ярьж байгаа гэдгийг та бүхэн мэдэж байгаа байх.

Дээрх хуулиудын нэмэлт, өөрчлөлт, шинэчлэлд иргэд, олон нийт оролцоогоо хангаж чадахгүй бол манай улсын авлигын нөхцөл байдал улам дордоно, иргэний эрх, эрх чөлөө хумигдаж болзошгүй гэдгийг та бүхэнд сануулж хэлэхийг хүсэж байна.

“...Ардчилал бол ард түмний засаглал. Ардчилал бол хувь хүн биш, хууль засагладаг нийгэм. Ардчилал бол эрх чөлөө, үүрэг хариуцлагын нийлбэр. Ардчилал бол иргэн бүрийн идэвхтэй оролцоо юм...”

Энэ бол Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн уржигдархан хэлсэн үг. Ийнхүү хэлж чадаж байна, гагцхүү хийх хэрэгтэй.

Гэтэл энэ үзэл санааг төр, засагтаа хүргэх л гэж иргэн би энэ бяцхан мэдээллийг дахин дахин нуршсан билээ.

Авлигыг ард түмэн л зогсоож чадна. Иймд авлигын эсрэг тэмцлийг хамтдаа хийхийг Та бүхэнд уриалж байна!

Анхаарал тавьсанд баярлалаа!



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХЭД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН САЛБАРЫН ОРОЛЦОО, СЭТГҮҮЛЧИЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙ

*Монголын хэвлэл мэдээллийн
зөвлөлийн Гүйцэтгэх захирал
Г.Гүнжидмаа*

Аль ч улс орны хувьд авлигатай тэмцэхэд үндэсний хууль тогтоомж чухал нөлөөтэй. Гэвч үүнээс ч илүү чухал үр нөлөөтэй нь эрэн сурвалжлах сэтгэл зүй юм гэдгийг 2015 онд Норвеги улсад болсон Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн олон улсын хуралд онцолсон байдаг. Тодруулбал, тус олон улсын сүлжээ байгууллагаас Аргентин, Бразил, Чили, Хятад, Чех, Франц, Гана, Унгар, Индонез зэрэг улс төрийн болон нийгмийн хөгжлийн түвшин харилцан адилгүй улс орнуудад хийсэн судалгаагаар авлигатай тэмцэхэд үндэсний хууль тогтоомжоос нь илүү эрэн сурвалжлах сэтгүүл зүй чухал нөлөөтэй байсан гэдгийг харуулжээ.

Монгол Улс 2020 онд хэвлэлийн эрх чөлөөний индексээрээ “улбар шар” буюу мэдэгдэхүйц асуудалтай орнуудын тоонд багтаж дэлхийн 180 орноос 28.97 оноотойгоор 68 дугаарт эрэмбэлэгдсэн бол Авлигын төсөөллийн индексээр 111 дүгээрт жагсаж байна. Ардчилал, хүний эрх, чөлөөт шударга байдлыг илтгэдэг эдгээр индексүүд нь хоорондоо харилцан уялдаатай. Учир нь хэвлэлийн эрх чөлөөний орчин сайжирч индексийг 25-г хүргэхэд манай улс сэтгэл хангалуун буюу “шар” түвшин рүү орно. Монгол Улс авлигатай бүх шатанд тэмцэхээ илэрхийлж буй энэ цаг үед хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, дэмжих замаар шударга, чөлөөт эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлж авлигыг төсөөллийн индексийг бууруулах боломжтой юм.

Гэвч хэвлэлийн эрх чөлөөний индекст сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсэд үг хэлэх үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж болзошгүй хуулийн зохисгүй хязгаарлалтууд олноор гарч байгаа, нууцын хуулийн малгайн дор мэдээллийн ил тод нээлттэй байдал хангалтгүй хэвээр, улмаар шүүмжлэлт сэтгүүл зүйг цагдан хяналтаар боомилох оролдлогууд нийтлэг зэргийг дурдаж болно.

Эдгээр нь мэргэжлийн сэтгүүл зүйн үйл ажиллагаанд саад учруулж улмаар сэтгүүлчид нийтийн эрх ашгийн төлөө шүүмжлэл өрнүүлэхээс татгалзаж “эс үйлдэл”-рүү хөтлөх бодит эрсдэл үүссэн. Сэтгүүлчид “тархиндаа хайч үүсгэх” буюу шүүмжлэл, дарамт дагуулах мэдээллээс татгалзаж, нийтийн эрх ашгийн төлөө дуугарахдаа өөртөө цензур тавьж эхлэх цагт бид авлига, хээл хахуультай тэмцэж, ардчилал хүний эрхийг хамгаалах талаар яриад ч үр дүнд хүрэхгүй.

Чөлөөт, шударга сэтгүүл зүй дараах үүргийг нийгмийн өмнө хүлээдэг.

- ✦ Бүх төрлийн мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах (Right to know)
- ✦ Санал бодлоо солилцох үйл явцыг аливаа хориг саадгүйгээр явуулах (Free expression)
- ✦ Хараат бус анхааралтай ажиглалтаар нийгмийн бүх түвшинд ил тод байдлыг бий болгох (Watchdog)

Эдгээрээс сүүлийн буюу “хоточ банхар”-ын үүрэг роль нийгэмд шударга ёс, ил тод байдлыг хангахад ихээхэн нөлөөтэй. Иймээс авлигатай тэмцэхэд хэвлэл мэдээллийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд дараах хүчин зүйлүүдийг анхаарч, сайжруулах шаардлагатай байна. Үүнд:

1) Эрх зүй болон ёс зүйн хүрээнд хараат бус эрэн сурвалжилсан бүтээлийг хөхиүлэн дэмжих, түгээн сурталчлах

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэхэд эрх зүйн таатай орчин бүрдүүлэх тэр дундаа нууц эх сурвалжаа хамгаалах, мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулах, сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагааг нь эрүүгийн хууль болон бусад дүрэм журмаар цагдан хянах, шүүж шийтгэхээс татгалзах нь чухал байна. МҮОНРТВ-д ажилладаг сэтгүүлчдээс бусад нь нууц эх сурвалжаа хамгаалах эрх зүйн орчин бүрдээгүй байгаа юм. Бусад хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчид хууль бус асуудлыг эрэн сурвалжлах, мөрдөн мөшгих, нийтэлж нэвтрүүлэх, сурталчлан хамгаалахад эрх зүйн таатай орчин дутагдсаар байгаа. Тиймээс сэтгүүлчийн аюулгүй байдал, нууц эх сурвалжаа хамгаалах эрхийг нь хангах эрх зүйн зохицуулалтыг олон улсын хэм хэмжээ, сайн туршлагад нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх нь эрэн сурвалжлах сэтгүүлчдэд томоохон дэмжлэг болох юм.

2) Редакцын хараат бус байдлыг хангах: Санхүүгийн бусад эх үүсвэрийг хөгжүүлэх, хөдөлмөрийн гэрээгээр хангах тогтолцоог бий болгох:

Редакцын хараат бус байдлыг баталгаажуулахад сэтгүүлчийн эрх зүйн байдал болоод аюулгүй байдлын асуудал зайлшгүй хөндөгдөнө. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт сэтгүүлчийн аюулгүй байдлыг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх тухай тусгасан хэдий ч дорвитой ахиц дэвшил гараагүй

байна. 2019 онд ХМЗ-өөс ГИТ-тэй хамтран хэрэгжүүлсэн судалгаагаар төрийн албан тушаалтан “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн дагуу мэдээлэл өгөхөөс татгалзаж байсан тохиолдол 10 сэтгүүлч тутмын долоод нь тохиолдсон бөгөө ийнхүү татгалзах гол шалтгаан нь нууцын тухай хууль байсан.

Түүнчлэн 300 сэтгүүлч хамрагдсан уг судалгаанд оролцогчдын гуравны хоёр (67 хувь) нь бичсэн нийтлэл, олон нийтэд түгээсэн мэдээллээсээ болоод ямар нэгэн дарамт, сүрдүүлэгт өртөж байжээ. Хамгийн түгээмэл заналхийлэлд утсаар дарамтлах, эрхлэгч эсхүл редакцын бусад гишүүдийг айлгаж сүрдүүлэх, олны өмнө доромжлох, утсаар тагнаж чагнах зэрэг тохиолдлууд нэг сэтгүүлчид дунджаар 3-4 удаа тохиолдсон байв.

Эрэн сурвалжлах сэтгэл зүйн бүтээл гаргахад нь эр зоригийн бөгөөд цаг хугацаа, хөрөнгө шаардсан багийн ажил байдаг. Иймд эрэн сурвалжилгад редакцын эзэд, удирдлагын дэмжлэг, хамтын ажиллагаа ихээхэн тустай тул гурвалсан гэрээ байгуулах, аюулгүй байдлаа хангуулах нь сэтгүүлчийн хувьд ихээхэн чухал болдог.

3) Нууц эх сурвалж, шүгэлдэгчтэй ажиллах арга зүйг хэрэгжүүлэх: Итгэлцэл бий болгох, Хамгаалах, Чухал мэдээлэлд ашиглах:

Сэтгүүл зүйн бүтээлийн амин сүнс нь эх сурвалж юм. Эх сурвалж үгүй бол сэтгүүл зүйн бүтээл төрөхгүй. Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүл зүйн сүлжээ байгууллагаас боловсруулсан арга зүйд тулгуурлан сэтгүүлчдийг нууц эх сурвалж, шүгэлдэгчтэй хэрхэн хамтарч ажиллах чадавхыг сайжруулах, ур чадвар бий болгох нь чухал байна. Нууц эх сурвалжийг шүгэлдэгчтэй андуурах, хольж хутгах, шүгэлдэгчийн тухай суурь ойлголтыг буруу, зөрүү ойлгон хэрэглэж буй зарим хандлагыг өөрчилж нэгдсэн нэр томъёоны ойлголттой болох хэлэлцүүлэг, дугуй ширээний ярилцлага гэх мэт олон талт оролцоо бүхий үйл явдлыг дэмжих нь үр өгөөжтэй.

4) Авлигын сэдвээр эрэн сурвалжлах сэтгүүлчдийн сургалт, чадавхжуулах бусад арга хэмжээг дэмжих:

2000 оноос дэлхий нийтээр түгэн дэлгэрч буй эрэн сурвалжлах шинэ арга зүй, технологи, түүнтэй холбоотой мэдээллийг монголын сэтгүүлчдэд хүртээмжтэй байдлаар хүргэх, эрэн сурвалжилсан бүтээл дээр ажиллахад нь арга зүйн зөвлөгөө өгөх мэргэжлийн байгууллагууд, сургагч багш нарын санаачилгыг дэмжиж хамтран ажиллах шаардлага байна. Мөн нийгэмд сайн өөрчлөлт авчирсан, тогтолцооны шинжтэй буруу гажуудлыг засаж залруулахад

нөлөө үзүүлэхүйц бүтээл хийж буй сэтгүүлчдийг тэтгэлэгт хамруулах, холбогдох салбарын байгууллагуудын зүгээс мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, тухайн мэдээлэлтэй холбоотой баримт, өгөгдлөөр хангах зэргээр хамтран ажиллаж болох юм.

Нийтийн эрх ашгийн төлөө мэдээлэл олж авах, сэтгүүлч аюулгүй байдлаа хангах тал дээр эрх зүйн орчин дутмаг хэдий ч сэтгүүлчид эрэн сурвалжилсан бүтээлүүдээрээ шударга бус байдал, авлигын эсрэг тэмцэлд хувь нэмрээ оруулсаар байна. Жишээ нь: 2020 оны эхээр өрөг.мн сайт “Баримт: Эрдэнэт үйлдвэрийн мөнгө ёолдоггүй ба дураараа дургигчид” гэсэн цуврал эрэн сурвалжилсан бүтээлийг олны хүртээл болгосон. Үүний дараа нэвтрүүлэгт эрх ашиг нь хөндөгдсөн компани редакцаас 1 тэрбум төгрөг нэхэмжлэн шүүхэд бизнесийн нэр хүндээ сэргээлгэхээр өргөдөл гаргасан. Гэвч өнөөдрийг хүртэл уг хэрэг шийдэгдээгүй байна. Мөн тус компаниас Хэвлэл мэдээллийн зөвлөлд хандан тус редакцыг нэр төрд халдаж худал мэдээлэл тараан Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмаа зөрчсөн хэмээн гомдол гаргасан. Ёс зүйн хороо уг хэргийг хэлэлцээд редакцыг нийтийн эрх ашгийн өмнөөс сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа явуулсан хэмээн дүгнээд ёс зүйн зарчим зөрчөөгүй хэмээн шийдвэрлэсэн.

Эндээс харахад эрэн сурвалжлах сэтгүүл зүйн бүтээл хийж буй сэтгүүлчдийг цаг хугацаа, хүн хүч, хөрөнгө мөнгөнөөс илүүтэй сэтгэл зүйн болон торгууль, ял шийтгэлийн дарамтууд хүлээж байдаг. Хуулийн заалтуудаар далайлган хууль хүчний байгууллагад сэтгүүлчийн эсрэг гомдол гаргагчдын дийлэнх олонх нь авлигад өртөх эрсдэлтэй бүлэг болох өндөр дээд албан тушаалтнууд, төрийн байгууллагууд, бизнесийн томоохон компаниуд байдаг нь судалгаагаар тогтоогдсон.

Хэвлэл мэдээллийн зөвлөлд өнгөрсөн зургаан жилийн хугацаанд 400 гаруй өргөдөл, гомдлыг иргэн болон аж ахуйн нэгж байгууллагаас хүлээж авсан бөгөөд үүний талаас илүү хувь нь жирийн иргэд, иргэний нийгмийн идэвхтнүүд харин цөөн хувь нь улс төрд нөлөө бүхий этгээдүүд байна.

Цаашид авлигын эсрэг тэмцэлд хүчин чармайлт гаргаж буй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн мэргэжлийн байгууллагуудыг хэрхэн дэмжих вэ?

Нэгдүгээрт: Нээлттэй эх сурвалж буюу дата өгөгдлийг нээлттэй болгох ёстой.

Нээлттэй эх сурвалжуудыг цахим орчинд ил тод байршуулах, түүнд анализ дүн шинжилгээ хийх боломжтой болгох нь нийтийн асуудлыг олон нийтийн анхааралд аваачих, иргэдийн оролцоотой хяналтыг бий болгоход ихээхэн тустай. Энэ чиглэлээр ажиллаж буй залуучуудын санал санаачилга өргөжиж буйг дэмжих нь зүйтэй.

Хоёрдугаарт: Эрх зүйн таатай орчинг бүрдүүлэхэд төр засгийн зүгээс бодлогоор анхаарах нь зүйтэй. Харин эрх зүйн орчныг таатай болгох нэрийн дор улам бүр эрх чөлөөг нь хумиад байж болохгүй. Одоогоор 40 гаруй хууль, тогтоомжоор хэвлэлийн эрх чөлөө болон сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг хязгаарласан байна хэмээн судлаачид тэмдэглэж байна. Иймээс хэвлэлийн эрх чөлөөг хязгаарласан аливаа заалтыг бусад хууль тогтоомжуудад оруулахгүй байх, улмаар 1998 онд батлагдсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хэрэгжилтийн судалгаагаар цогцоор хийж, алдаа дутагдал хийдлийг илрүүлэх нь чухал.

Гуравдугаарт: Зөөлөн зохицуулалтын хэм хэмжээ болох хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг улс төрийн соёлын болоод бодлогын түвшинд хүлээн зөвшөөрч дэмжих шаардлагатай байна. Ингэж гэмээнэ хэвлэлийн эрх чөлөөгөөр тэргүүлж буй улс орнуудын нэгэн ижил чөлөөт, шударга хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид бүх төрлийн цагдан хяналтаас ангид, айдас, аюулгүйгээр мэргэжлийн ажлаа нэр төртэй бөгөөд үр дүнтэй хэрэгжүүлнэ. Улмаар хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын тогтолцоо нь чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн баталгаа болдог билээ.



ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙГ ХАМГААЛАХ, МЭДЭЭЛЭХ ТОГТОЛЦООГ ДЭМЖИХҮЙ

*Авлигатай тэмцэх газрын
Урьдчилан сэргийлэх,
соён гэгээрүүлэх хэлтсийн дарга,
эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн*



Авлигыг үүсгэдэг олон шалтгаан байдаг. Эдгээр шалтгааныг судлан, ямар үйл тэдгээрийг нөхцөлдүүлж байгааг тогтоон, тэдгээр шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чухал хэсэг юм. Мэдээлэх, шүгэл үлээх нь авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны салшгүй хэсэг бөгөөд аливаа зүй бус үйлдлийг мэдээлэхийг дэмждэггүй, эсхүл хамгаалдаггүй орчин нөхцөлд авлигын эрсдэл, санхүүгийн бусад гэмт хэргийн гаралт нэмэгддэг гэж үздэг. Иргэд төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг хянаж, зөв, бурууг ялган, алдаа дутагдлыг засаж залруулах, хууль зөрчсөн үйлдлийг мэдээлэх, хэрэг, зөрчил гарахаас сэргийлэхэд чухал үүрэгтэй оролцогчийн хувьд нийтийн ашиг сонирхлын төлөө мэдээлэх үүргээ ч мөн биелүүлэх ёстой.

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны талаар иргэд үзэл бодол, санал хүсэлтээ чөлөөтэй илэрхийлж, ялангуяа хууль тогтоомж, дүрэм, журмыг зөрчиж байвал холбогдох байгууллага, албан тушаалтанд хандах, мэдээлэх эрх нь хууль тогтоомжийн хүрээнд нээлттэй байна. Гэтэл аль нэг байгууллага, албан тушаалтанд мэдээлэл өгснөөр эргээд өөрт нь дарамт шахалт ирэхээс эмээн болгоомжилж зүй бус асуудлын талаар мэдээлэхгүй тохиолдол ажиглагддаг. Хууль бус үйлдлийг холбогдох байгууллагад нь мэдээлэхгүй байгаагаас тэдгээрийг засаж залруулах, дахин давтан гаргуулахгүй байхаас сэргийлэх, буруутай албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх арга хэмжээ хэрэгжихгүй байна. “Транспарэнси Интернэшнл” байгууллагаас гаргадаг Авлигын төсөөллийн индексийн судалгааны дүнд тухайн улс орон шүгэл үлээх тогтолцоог нэвтрүүлсэн буюу Мэдээлэгчийг хамгаалах эрх зүйн орчинг

бүрдүүлсэн эсэх асуудал зохих нөлөө үзүүлдэг. “Транспэрэнси интернэшнл” байгууллагаас Ази, номхон далайн бүс нутгийн 20 гаруй мянган хүмүүсийн дунд авлигын талаар судалгаа зохион байгуулж “авлигын эсрэг иргэд тэмцэх хамгийн үр дүнтэй алхам юу вэ?” гэж асуухад тэдний хамгийн олон нь буюу 22 хувь нь “мэдээлэх”, мөн 21 хувь нь “хахууль өгөхгүй байх” гэж хариулсан байна. Улмаар уг судалгаагаар яагаад “мэдээлэх” буюу шүгэл үлээх алхмыг хийгээгүй шалтгааныг тодруулахад хамгийн олон буюу судалгаанд оролцсон иргэдийн 36 хувь нь (монгол улсаас судалгаанд оролцсон иргэдийн мөн хамгийн олон буюу 22 хувь нь) “үр дагавраас айдаг”¹ гэж хариулсан байдаг. Хахууль авснаа төрийн албан хаагч илчлэхгүй. Үйлчилгээ авахдаа давуу байдал олж авсан иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл мөн энэ байдлаа хүлээхгүй. Олон улсын байгууллагуудын судалгааны дүнгээр нийт үйлдэгдсэн авлигын тохиолдлын 10 хүрэхгүй хувь нь мэдээлэгддэг гэсэн тооцоо гарсан байдаг. Дээрх судалгаанаас харахад иргэд авлигыг мэдээлэхгүй байхад хүргэж буй “үр дагавраас айдаг” гэх шалтгааныг арилгаснаараа авлигыг ил болгох, шүгэл үлээх боломж бүрдэнэ гэж үзэж болно. Нөгөө талаас, мэдээлэгч этгээдийг хамгаалах талаар төрөөс баримталж буй бодлого тодорхойгүй, эрх зүйн орчин бүрдээгүй зэрэгтэй ч холбоотой. Иргэд мэдээлэх үүргээ айдасгүйгээр биелүүлэх, шүгэл үлээхэд иргэдэд хамгаалалт шаардлагатай байна. Дэлхийн улс орнууд энэ асуудлыг шүгэл үлээгчийг хамгаалах хууль гаргаж шийдвэрлэдэг.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 33 дүгээр зүйлд “... аливаа баримт нотолгоог сайн санааны үүднээс, үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй аливаа этгээдийг аливаа шударга бус хандлагаас хамгаалах ...” арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэх асуудлыг авч үзэхээр тусгасан нь авлигын эсрэг мэдээлэгч этгээдийг хамгаалах үндэслэл болж байна. Мөн албан тушаалтан, иргэний нийгмийн төлөөлөл болон холбогдох байгууллагууд авлигын талаарх мэдээллийг хэрхэн хялбар байдлаар хүргэх, мөн холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааны зарчмыг энэ конвенцод заасан. Конвенцыг хэрэгжилтийг үнэлэх механизмын дагуу манай улсад үнэлгээ хийсэн олон улсын шинжээчид “мэдээлэгчдийг хамгаалах хууль тогтоомж бий болгох зайлшгүй шаардлагатай байна”² гэж дүгнэсэн байдаг.

Судалгаанаас үзэхэд зарим орон шүгэл үлээгчийг хамгаалах харилцааг дотоодын тусгайлсан хуулиар (АНУ-ын болон Япон Улсын Шүгэл үлээгчийг хамгаалах хууль, Их Британийн Нийтийн ашиг сонирхлыг илчлэх хууль г.м.), зарим орон салбарын хууль(Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Авлигын эсрэг хууль, Өрсөлдөөний хууль, Нягтлан бодох бүртгэлийн хууль,

1 Transparency International (2017), People and corruption: Asia Pacific – Global corruption barometer

2 НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (2011). Монгол Улс дахь авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 3 дугаар бүлгийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан


Компанийн тухай хууль, Хөдөлмөрийн хууль)-аар зохицуулсан байна³. 2019 оны байдлаар дэлхийн 27 улсад шүгэл үлээгчийг хамгаалах тусгайлсан хуультай бөгөөд шүгэл үлээгчийг хамгаалж, баталж мөрдүүлэх явдал улам бүр нэмэгдэж 2021 оны байдлаар Австрали, Канад, Япон, Бельги, Энэтхэг, Өмнөд Солонгос, Израйл, Их Британи гэх мэт 32 улс шүгэл үлээгчийг хамгаалах тусгайлсан хуулийг батлан хэрэгжүүлж байна. Аргентин, Австри, Бразил, Чили, Хятад, Кипр, Дани, Орос, Швед, Турк, Нидерланд гэх мэт 27 улс шүгэл үлээгчтэй холбоотой асуудлыг салбарын хууль тогтоомждоо тусгасан байна.

“Шүгэл үлээгч /мэдээлэгч/” гэх нэр томъёог 1972 онд Америкийн иргэний эрхийн төлөө тэмцэгчдийн нэг Ralf Nader “нууц мэдээлэгч”, “матаач” зэрэг сөрөг нэршлээс ялгаатай гэсэн санаагаар тайлбарлаж, шүгэл үлээгч буюу “whistleblow” гэх нэр томъёог эрх мэдэлтэн, өндөр албан тушаалтан, төрийн байгууллагын эсрэг хүчтэй дуугарч, асуудалд нийгмийн анхаарлыг чиглүүлж байгаа хүнийг “шүгэл үлээгч” гэх утгаар хэрэглэж эхэлсэн байна.⁴ Шүгэл үлээгчийн талаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэгдсэн ойлголтод хараахан хүрээгүй байна. Улс орнуудын хууль тогтоомжоос үзэхэд эрх мэдэлтэн, албан тушаалтан, төрийн байгууллагын зүй бус үйлдлийн эсрэг хүчтэй дуугарч асуудалд нийгмийн анхаарлыг чиглүүлж байгаа хүнийг “шүгэл үлээгч” гэдэг утгаар хэрэглэж байна. Шүгэл үлээгч-ийн талаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэгдсэн ойлголтод хараахан хүрээгүй байна. Ихэнх орнуудын хувьд нийтийн албан дахь шүгэл үлээгч, мэдээлэгч, холбогдох мэдээллийг internal witness-дотоод гэрч, эсхүл public interest disclosure-нийтийн эрх ашигт хамаарах мэдээллийг ил болгож буй этгээд, protected disclosure, эсхүл public interest information-нийтийн эрх ашигт хамаарах мэдээлэл зэргээр томъёолсон байна.⁵ Өөрөөр хэлбэл, “Шүгэл үлээгч” гэдэгт байгууллагын дотоодод болж байгаа зүй бус үйлдлээс гадна улс орны хэмжээнд, дэлхий нийтийн түвшинд болж байгаа зүй бус үйлдэл, тухайлбал, нийтийн эрх ашигт шууд харшилсан, хууль, дүрэм зөрчсөн, авлига, луйвар зэргийг баримт нотолгоотойгоор нийтэд дэлгэхийг ойлгож байна. Авлигын асуудал дээр авлигын хэргийг илчлэгч гэж нэрлэх тал байна. Нийтийн ашиг сонирхлыг хохироосон, хохироох бодит нөхцөл бүрдүүлсэн хууль бус үйлдлийг илчилж, энэ тухай өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх, тайлан гаргах, тайлбар өгөх зэрэг нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийн үйлдлийг шүгэл үлээх гэж үзэж болно.

3 OECD, Study on whistleblower protection frameworks, compendium of best practices and guiding principles for legislation, <http://www.oecd.org/g20/topics/anti-corruption/48972967.pdf>

4 Санхүүгийн зохицуулах хороо, Банкнаас бусад санхүүгийн байгууллагын комплейнсын ажилтнуудад зориулсан гарын авлага (суурь ойлголт), (УБ, 2019), 97 дахь тал.

5 Д.Жигваансүрэн, Д.Халиун, “Гадаадын зарим орны шүүмжлэгч (шүгэлдэгч)-ийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын талаарх лавлагаа”, УИХ-ын Тамгын газар Судалгааны эмхэтгэл XXV боть (УБ, 2017), 405 дахь тал.



Жишээ нь Эдвард Сноуденийг шүгэл үлээгч гэж үздэг. Э.Сноуден АНУ-ын тусгай албанд мэдээллийн технологийн техникчийн ажил хийж байхдаа АНУ-ын засаг захиргааны зүгээс олон түмнийг тагнах, мэдээллийг нэгтгэн цуглуулж тусгай мэдээллийн санд хадгалах, чагнах нууц төлөвлөгөөг илчилсэн. Австралийн сэтгүүлч Жулиан Ассанже бол мөн шүгэл үлээгч. Энэ хүн бол WikiLeaks сайтыг үндэслэгч. Энэ сайт нууц, нэрээ нууцалсан эх сурвалжаас, мөн шүгэл үлээгчдээс ирүүлсэн мэдээллийг нийтэлдэг сайт. WikiLeaks сайт нь саяны ярьсан асуудлыг гаргаж тавьснаараа алдартай болсон. Түүний нийтэлсэн материалуудаас АНУ-ын улс төрийн болон цэрэг, тагнуулын байгууллагын бүх түвшний хээл хахууль, улс төрийн наймаа гэх мэт будилаантай бүх зүйл ил болсон. Шүгэл үлээгчид өөр улсад орогнож, эх орондоо очвол хэрэгт татагдах нөхцөл байдалд байх жишээтэй. Испани Улсын Мадрид хотын төрийн байгууллагад ажилладаг А.Г.Рамос шүгэл үлээсний улмаас Испанийн Засгийн газрын нөлөө бүхий гишүүд огцорсон түүхтэй.

Шүгэл үлээгчийг хамгаалах чиглэлээр АНУ тэргүүлэх чиглэлтэй байна. АНУ нь 1778 оны 7 дугаар сарын 30-ны өдөр тэнгисийн цэргийн хүчин дэх хууль бус, авлигын үйлдлийн эсрэг нийтийн ашиг сонирхлыг хамгаалж шүгэл үлээсэн шүгэл үлээгчдийг хамгаалах зорилгоор Америкийг үндэслэгч эцгүүд санал нэгтгэйгээр хууль гаргаж байсан нь дэлхийн хамгийн анхны шүгэл үлээгчийн хууль гэж тооцогддог.⁶ Европын улс орнуудын хуулийг үлгэр жишээ хууль болгож авч үзэж болно. Азид шүгэл үлээгчийг хамгаалах бие даасан хуультай орнууд цөөнгүй байгаагаас БНСУ 2011 онд Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль баталсан. БНСУ-д шүгэл үлээгчийн ил болгож буй мэдээллийг хүлээн авч үүнтэй

⁶ National Whistleblower Center, <https://www.whistleblowers.org/news/the-whistleblowers-of-1777-the-origins-of-national-whistleblower-day/>

холбоотой үйл ажиллагаа явуулах эрхийг Авлигын эсрэг иргэний эрхийн комисс хэрэгжүүлдэг. Тухайлбал, АНУ-д 1986-2020 онд шүгэл үлээгчийн тусламжтайгаар 46.5 тэрбум ам.долларыг улсын орлого болгожээ. Үүнээс 7.8 тэрбум ам.долларыг шүгэл үлээгчид урамшуулал хэлбэрээр олгосон байна. БНСУ шүгэл үлээгчид олгож буй урамшуулал 3 тэрбум вон хүртэлх хэмжээтэй. 2012 оноос хойш шүгэл үлээгчдийн өгсөн мэдээллийн тоо тогтмол нэмэгдэж байгаа бөгөөд 44 сая ам.долларыг шүгэл үлээгчдэд олгожээ. Шүгэл үлээгчдийн тусламжтайгаар 2014-2018 оны хооронд гэмт хэрэгт холбогдсон 1,621 нийтийн албан тушаалтныг албан тушаалаас нь чөлөөлсөн аж.

Судалгаанаас үзэхэд нийтийн ашиг сонирхлыг хөндсөн, хохироосон болон нийтэд хамаатай хөрөнгө, мөнгө завших шамшигдуулах хууль бус үйлдлийг нийтийн дээр гарч суусан эрх мэдэлтнүүд буюу албан тушаалтнууд ихэвчлэн үйлддэг нь нууц биш. Олон нийтэд мэдэгдэхгүй, энэ үйлдлээ нуун дарагдуулахын тулд албан тушаалын байдлаа ашиглах, нийтэд хамаатай хөрөнгө мөнгийг хувааж хүртэх, хээл хахууль өгч, авалцах нөхцөл үүсдэг. Ийм учраас авлигын асуудлыг нийтийн ашиг сонирхлоос ангид авч үзэх боломжгүй. Нөгөө талаас, нийтийн ашиг сонирхлыг хохироосон үйлдлийн талаар нийтийг төлөөлөн дугарах дуу хоолой маш дутмаг байна.

Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 16 дахь хэсэгт “... үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх...” эрх, эрх чөлөөг Монгол Улсын иргэн баталгаатай эдэлнэ гэж заасан. Улмаар Авлигын эсрэг хуулийн 8 дүгээр зүйлийн 8.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т “Ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдэж байгаа бусад этгээд энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлж болно” гэж заасан нь авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар холбогдох байгууллагад мэдээлэх сувгийг нээж өгсөн гэж үзэж болохоор байна. Хэдийгээр мэдээлэх суваг бүрдсэн ч мэдээлэл өгөхөөр зорьж буй шүгэл үлээгчид хууль, хяналтын байгууллагад итгэхгүй байх хандлага түгээмэл байдаг. Өөрөөр хэлбэл, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхийн зэрэгцээ анхаарал хандуулах шаардлагатай асуудал бол хууль сахиулах байгууллагад итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх явдал юм. Хууль сахиулах байгууллагад итгэх итгэл бий болоогүй бол хуультай байгаад ч, шүгэл үлээхгүй байх нөхцөлийг бүрдүүлдэг. Нөгөө талаас хууль бий болсон ч бодит байдалд шүгэл үлээгчийн талаарх мэдээллийг илчилдэг, эсхүл алба хаагчдын ёс зүйн эерэг хандлага төлөвшөөгүй бол уг тогтолцоо нь шүгэл үлээгчдийг “урхидах” хэрэгсэл болох боломжтойг судлаачид онцолсон байдаг.

Шүгэл үлээх нь соёл болж тогтох ёстой.

Иргэн шударга ёсны төлөө өөрийн итгэл үнэмшил, зүй бус үйлдлийг нотолж байгаа гэж үзэж байгаа баримтад тулгуурлаад шүглээ үлээдэг. Үүнийг дагаад нийтийн ашиг сонирхлыг хохироосон зүй бус үйлдэл хийсэн хүмүүсийн эрх ашиг хөндөгдөнө. Нөгөө талаас, шүгэл үлээгчийн өөрийнх нь эрх ашиг хөндөгдөнө, эрсдэл тулгарна. Шүгэл үлээгчийн эсрэг байгууллага нь сөрөг арга хэмжээ авч болзошгүй. Ийм учраас л шүгэл үлээгчийг хамгаалах зохицуулалт хийх шаардлагатай болдог. Нийтийн эрх ашгийн төлөө авлига, албан тушаалын гэмт хэргийн талаар мэдээлж ажлын байр, албан тушаал, нэр хүнд, амь насаа эрсдэлд оруулж буй шүгэл үлээгчдийг аливаа зүй бус үйлдэл, хариу дарамтаас хамгаалах үр дүнтэй, олон улсын стандартад нийцсэн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

УИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.5.6-д “мэдээлэл өгч байгаа иргэн, сэтгүүлчийг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх”-ээр заасан бөгөөд АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Шүгэл үлээгч (мэдээлэгч)-ийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох”-оор тусгасан.

Дээр дурдсан нөхцөл байдлыг харгалзан Авлигатай тэмцэх газраас Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын даргад хүргүүлсэн бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулсан ажлын хэсэг ажиллан төслийг боловсронгуй болгож Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Хуулийн төсөлд нийтийн ашиг сонирхлын асуудлыг тухайлан авч үзэж, түүнд хамаатай зүй бус үйлдлийг таслан зогсоох, үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах, урамшуулах асуудлыг хуулийн хүрээнд авч үзэх нь жишиг юм байна гэдгийг судлан тогтоосны үндсэн дээр зөвхөн авлигын асуудлаар гэж хязгаарлалгүй мөн байгаль орчин, эрүүл мэнд, гэх мэт салбарыг орхигдуулахгүйн үүднээс нийтийн ашиг сонирхлын төлөө гэж тодотгон тусгасан. Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих чиглэлээр байгууллагуудын хүлээх үүрэг, хэрэгжүүлэх ажиллагааг тодорхойлж, нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийн нийгэмд гүйцэтгэх үүргийг нийтэд зөв ойлгуулах, хүлээн зөвшөөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, дэмжих, хамгаалах асуудлыг шийдвэрлэх үндэслэл, журмыг оруулсан. Шүгэл үлээгч нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэнтэй нь холбоотойгоор түүнд болон түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учирсан буюу учирч болзошгүй тохиолдолд холбогдох байгууллагад хандаж, хүсэлт гаргасан тохиолдолд Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээ авах, тухайлбал, хувийн мэдээллийг нууцлах, шүгэл үлээгчийн хувийн

аюулгүй байдлыг хамгаалах зэрэг арга хэмжээ авна гэсэн үг. Нөгөө талаас, хамгаалалтаас гадна шүгэл үлээгч мэдээллээ яаж өгөх, түүнийг нь байгууллага хэрхэн хянан шалгах, шүгэл үлээгчдийн илчилсэн мэдээллийг үндэслэн нөхөн төлүүлсэн, эсхүл оногдуулсан торгуулийн орлогоос сан бүрдүүлэх замаар илчилсэн мэдээллийн үнэн бодит, ач холбогдолтой байдалд үндэслэн тодорхой хувьтай тэнцэх хэмжээгээр урамшуулал олгох тогтолцоог бүрдүүлэх асуудлыг ч мөн авч үзэн төсөлд тусгасан болно.

Шүгэл үлээгчийн үлээсэн мэдээллийг хүлээн авч, шалгах, урамшуулах чиг үүргийг нэг байгууллага хариуцан ажиллах нь зохион байгуулалтын хувьд үр дүнтэй байж болох юм. Уг байгууллага нь холбогдох этгээдүүдэд зөвлөмж хүргүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах, хараат бус, мөрдөн шалгах эрх бүхий байгууллага байх нь үр дүнтэй болохыг олон улсын зарчмуудад тусгасан байгааг харгалзан тусгасан.

Бурууд нүд хурц байж, нэг нь нийтийн төлөө санаа тавьж байж нийгэмд шударга ёс тогтож, авлигын үндэс суурь алга болно. Мэдээлэгчийг хамгаалах хуулийг батлах нь Авлигын индексийн дүнд эерэг өөрчлөлт оруулах нь гарцаагүй. Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль батлагдвал шүгэл үлээх нь нийтийн ашиг сонирхлыг хохироохоос урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үр нөлөөтэй хэрэгсэл болж, хүний үг хэлэх эрх чөлөө, мэдээлэл авах эрхийг хангахад эергээр нөлөөлж, иргэдийн эрх зүйн ухамсар, хариуцлага дээшилнэ. Зөвхөн эрх зүйн орчин бүрдүүлэх, соёлыг тогтоохыг чухалчлахаас гадна хууль сахиулах байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн төлөө ажиллах шаардлагатай. Нөгөө талаас, иргэдэд эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, асуудал хариуцсан албан хаагчийг чадавхжуулах зэрэг ажлыг цогцоор нь хэрэгжүүлж байж үр дүн гарна.

Судалгаанаас үзэхэд зарим орон шүгэл үлээгчийг хамгаалах харилцааг дотоодын тусгайлсан хуулиар (АНУ-ын болон Япон Улсын Шүгэл үлээгчийг хамгаалах хууль, Их Британийн Нийтийн ашиг сонирхлыг илчлэх хууль г.м.), зарим орон салбарын хууль(Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Авлигын эсрэг хууль, Өрсөлдөөний хууль, Нягтлан бодох бүртгэлийн хууль, Компанийн тухай хууль, Хөдөлмөрийн хууль)-аар зохицуулсан байна 3. Австрали, Канад, Япон, Бельги, Энэтхэг, Өмнөд Солонгос, Израйл, Их Британи гэх мэт 32 улс шүгэл үлээгчийг хамгаалах тусгайлсан хуультай бөгөөд шүгэл үлээгчийг хамгаалах хуулийг баталж, мөрдүүлэх явдал улам бүр нэмэгдэж байна.

Таны эрх, таны оролцоо: Авлигад үгүй гэж хэлье.



АВЛИГААС АНГИД БОЛОВСРОЛЫН САЛБАР: ТӨСӨВ, ИЛ ТОД БАЙДАЛ, ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦОО

*“Бүх нийт боловсролын төлөө!”
Иргэний нийгмийн үндэсний эвслийн
ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг*

Боловсролын салбар авлигаас ангид байх, гэхдээ энэ дотроос төсвийн асуудлыг нь онцлон ярих гэж байна. Яагаад боловсролын төсвийн асуудлыг ярихаар болсон бэ гэвэл, боловсролын салбарт улсын төсвийн хамгийн их хувь очдог, магадгүй Сангийн сайдын дараа хамгийн том багц Боловсролын сайдад хуваарилагддаг, саяхан болтол боловсролын салбарт улсын төсвийн 5 төгрөг тутмын нэг нь очдог байсан бол одоо багасаад л байна. Тэгэхдээ энэ бол чамлалтгүй их мөнгө байдаг. Мөнгөний хэмжээ ихсэх тусам авлигын эрсдэл нэмэгдэнэ. Энэ төсвийн зарцуулалт, ил тод нээлтэй байдал ямар байдаг вэ гэдэг тал дээр манай байгууллага хяналт хийсэн жишээн дээрээ үндэслэн ярихаар бэлдсэн байгаа.

Авлигын эсрэг хамгийн амжилттай ажиллах 6 стратегийг ЮНЕСКО-гийн Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилгын хэрэгжилтийн хяналт үнэлгээний дэлхийн тайланд тодорхойлон гаргасан байдаг. Тэдгээр стратегийн нэг нь төрийн бус байгууллагуудыг татан оролцуулах бөгөөд авлигатай төр дангаараа тэмцэж чадахгүй гэдгийг хэлж байгаа юм.

Авлигын эсрэг хэн хэн ажиллах ёстой, яаж ажиллах ёстой гэхлээр дүрэм, журам маш тодорхой байх ёстой, төрийн менежментийн чадавх сайн байх ёстой, хараат бус аудитын байгууллага ажиллах ёстой, мэдээллийн нээлттэй тогтолцоо, хэвлэл мэдээллийн хяналт хийх орчин ээлтэй байж, мөн төрийн бус байгууллагуудыг татан оролцуулж байж авлигын эсрэг үр дүнтэй ажиллана.

Энэ стратегийн дагуу 2017 онд Авлигатай тэмцэх газраас санаачлан БСШУСЯ, “Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг” ТББ, Азийн сан болон манай байгууллага хамтран боловсролын салбар дах авлигын асуудлаар

хэлэлцүүлэг зохион байгуулсан ба энэ хэлэлцүүлгийн үр дүнг ярих нь чухал гэж үзэж байна. Энэ хэлэлцүүлэгт оролцсон 5 Төрийн бус байгууллага зөвлөмж боловсруулснаа Авлигатай тэмцэх газар ба төрийн байгууллагуудад хүргүүлж байсан.



Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу яаманд хандаж гаргасан багц зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэж үзвэл чамлахааргүй дүн харагдана.

Зөвлөмжийн биелэлт (1) БШУЯ

№	Зөвлөмжийн агуулга	Хэрэгжилт
1	БШУЯ-ийн хэлтэст төрийн захиргааны төв байгууллагын ажилтныг хуралдуулах	✓
2	БШУЯ-ийн хэлтэст төрийн захиргааны төв байгууллагын ажилтныг хуралдуулах, зөвлөмжийн агуулгыг орооуулах, авлигын эсрэг арга зүйн үндэсний үзүүлэлт	✓
3	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ажилтныг хуралдуулах	✓
4	БШУЯ-ийн хэлтэст төрийн захиргааны төв байгууллагын ажилтныг хуралдуулах, зөвлөмжийн агуулгыг орооуулах, авлигын эсрэг арга зүйн үндэсний үзүүлэлт	✓
5	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ажилтныг хуралдуулах, зөвлөмжийн агуулгыг орооуулах, авлигын эсрэг арга зүйн үндэсний үзүүлэлт	✓
6	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ажилтныг хуралдуулах, зөвлөмжийн агуулгыг орооуулах, авлигын эсрэг арга зүйн үндэсний үзүүлэлт	✓
7	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ажилтныг хуралдуулах, зөвлөмжийн агуулгыг орооуулах, авлигын эсрэг арга зүйн үндэсний үзүүлэлт	✓
8	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ажилтныг хуралдуулах, зөвлөмжийн агуулгыг орооуулах, авлигын эсрэг арга зүйн үндэсний үзүүлэлт	✓

Багш сурагч, эцэг эх, олон нийтийн авлигын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр яам юу хийсэн бэ гэвэл асуултын тэмдэг, БХАН, Азийн сангийн санхүүжилтээр зарим нэг сургууль дээр үйл ажиллагааг зохион байгуулсан.

Ерөнхий боловсролын сургуулийн санхүүжилтийг тэгш боломжоор хангах, хувьсагчуудаар нэмэгдүүлэх энэ явцад олон нийт, иргэд, иргэний нийгмийн оролцоо хяналтыг бий болгох гэдэг дээр зөвийн тэмдэг, асуултын тэмдэг. Одоо энэ ажил ид хийгдэж байгаа учраас ийм 2 тэмдэг тавьсан байгаа.

Боловсролын үйл ажиллагааны зарим зардлыг хандив, төлбөр хураамж хэлбэрээр авч байгааг төр зохицуулах чиглэлээр ажлууд хийгдсэн гэж үзэж байна. Сая дараа оны төсөв батлагдахад эцэг эхээс хураадаг эдгээр зардлуудыг улсын төсөвт оруулж баталсан байгаа. Тийм учир боловсролын салбар дараа оноос эхлээд эцэг, эхчүүдээс хандив, тусламж авахгүй болно гэж итгэж байна.

Багш ажилтны ёс зүйн дүрмийг шинэчлэх, удирдах ажилтны ёс зүйг тусгах гэсэн чиглэлд багш, удирдах ажилтны ёс зүйн дүрэм 2018 онд шинэчлэгдсэн, удирдах ажилтны ёс зүйн асуудал шинээр нэмж орсон байгаа гэхдээ хэрэгжилт нь туйлын хангалтгүй гэж Иргэний нийгмийн байгууллагууд үздэг.

Боловсролын байгууллага хандив авах журам, тогтолцоотой болох энэ байхгүй байгаа одоогоор. Менежментийн жишиг тогтолцоо өөрийн болон хөндлөнгийн хосолсон гүйцэтгэлийн үнэлгээний систем бий болгох, засаглалаа сайжруулах гэдэг дээр хэд хэдэн журам гаргасан, хэрэгжилт нь хангалттай биш, яагаад гэвэл шинэ тутам гарсан учраас жигд хэрэгжүүлж амжаагүй байна. Удирдах ажилтны ажлын байранд тавигдах шаардлагыг шинэчилж, нээлттэй сонгон шалгаруулах, үнэлгээг нь сайжруулах гэх мэт зохицуулалт хийх одоогийн УИХ-д өргөн бариад байгаа боловсролын багц хуульд туссан байгаа, батлагдах эсэхийг нь сайн мэдэхгүй байна. Тийм учраас анхаарлын тэмдэг тавьсан.

Багшийн ёс зүй, мэргэжлийн стандартыг сайжруулахын тулд мэргэжлийн холбоог байгуулах гэдэг зөвлөмж өгсөн, мэргэжлийн холбооны асуудал хуулийн төсөлд туссан явж байгаа, гэхдээ Боловсролын яам нэг л зориглож өгөхгүй, мэргэжлийн холбооны чиг үүргийг хуульчлахгүй, хэрхэн байгуулагдах, ажиллах талаар тусгаагүй байна.

Иргэний нийгмийн байгууллагууд зөвхөн төрд зөвлөмж өгөөд зогсохгүй өөрсдөдөө зөвлөмж өгсөн байгаа, төрийн байгууллагуудтай нийгмийн эгэх хариуцлагыг чиглэлээр хамтран ажиллаж, үйл ажиллагаагаа уялдуулах, идэвх оролцоогоо нэмэгдүүлэх

Зөвлөмжийн биелэлт (2) ТББ болон ИНБ

№	Зөвлөмжийн үндсэн агуулга	Ажиллагаа
1	Төрийн байгууллагуудтай нийгмийн эгэх хариуцлагын нийтлэлээр санхүүгийн амжилтыг үйл ажиллагаагаа гүйцэтгэх, идэвх сөрөгтэйг нэмэгдүүлэх	✓
2	Байгалийн нөөцтэйг хамгаалах болон байгуулах санаачлагыг төвийн оролцоотойгоор хандивиртгалуудад ажиллуулах	✓
3	Ажлын гүйцэтгэлээр олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, эдгээр зүйн оролцоог нэмэгдүүлэх, хандивиртгалуудад үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлэх	ГЭХЭН
4	Боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг тусгай байгуулал, багш ажилтныг эс зүйн зорилгоос эргэлд байх санаачлагыг сургууль, сурталчлол, үйл ажиллагааг хэрэгжүүлэх	✓
5	Засаглал, мөрдөх ажиллагааг сайжруулах, ажлын гүйцэтгэл, үйл ажиллагааг үндэсний хэмжээнд тусгах	✓
6	Иргэдэд ажлын гүйцэтгэл, сургууль, сурталчлол, үйл ажиллагааг, үйл ажиллагааг хандивиртгалуудад ажиллуулах аргачлал байх болгож, санаачлан ажиллуулах	✓

Үндэсний аудитын газар, Авлигатай тэмцэх газар, сургууль дээрх, эцэг эх багшийн холбоод зэрэг байгууллагуудтай нийгмийн эгэх хариуцлагын чиглэлээр хамтран ажиллаж байна. Ковидын үеийн боловсролын асуудал хариуцсан төрийн байгууллагуудын нийгмийн эгэх хариуцлагын байдлаар мониторинг хийж, зөвлөмжөө яаманд хүргүүлсэн.

Үндэсний аудитын газар 2019 онд “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн” гүйцэтгэлийг аудитыг хийж, төсвийн хөрөнгөний зарцуулалт, үр ашгийг хянахын зэрэгцээгээр ерөнхий боловсролын дэд салбарын чанар, үр дүн нь ямар байсан бэ гэдэгт гүйцэтгэлийн аудит хийсэн. Энэ аудитын дүнг олон нийтэд хүргэх ажлыг бид зохион байгуулсан. Цаашид ч хамтран ажиллахаар тохирсон.

Багшийн мэргэжлийн холбоо байгуулах санаачлагын хуульд тусгуулаад явж байна. Олон нийтийн оролцоо, эцэг эхийн оролцоог сургуулийн эцэг эх, багшийн холбоог 8 аймгийн 28 суманд байгуулаад дэмжээд ажиллаж байна. Эдгээр СЭЭБХ манай байгууллагын боловсруулсан “Сайн сургуулийн аргачлалыг” сургуулиуд дээрээ хэрэгжүүлж, материаллаг болон сэтгэл зүйн орчин таатай, засаглал сайтай сайн сургуультай болохоор ажиллаж байна.

6 дахь зөвлөмжийн хүрээнд сургуулийн төсвийг мөшгих, орон нутагт хуваарилагдаж байгаа боловсролын төсвийг мөшгих 2 төрлийн аргачлалыг боловсруулаад иргэд, иргэний нийгмийн байгууллагуудад арга зүй, төсвийн дэмжлэг үзүүлээд хяналт хийлгүүлсэн. Улсын нэгдсэн төсвийн зардалд боловсролын салбарын эзлэх хувь 2019 онд 15 хувь, 2020 онд цар тахалтай холбоотой, танхимаар хичээллээгүйтэй холбоотой 11 хувь болж багассан. Энэ их төсөв хаашаа, хэнд очдог вэ гэдгийг бид хянах ёстой.



Ингээд харахад боловсролын салбарын ил тод байдал сургуулийн түвшинд харьцангуй гайгүй, нэлээд цааргалж байгаад төсвийн мэдээллээ өгнө. Орон нутгийн түвшинд үнэхээр хангалтгүй байна. Дүүрэг дээр очоод боловсролын салбарын төсвийн мэдээлэл авъя гэхлээр манай дээд түвшний байгууллагаас зөвшөөрөл авиад ир гээд л, та нар биднийг хянадаг хэн бэ, та нарын төсвийн мэдээллийг аваад яах гэж байгаа, ямар зорилгоор ашиглах гэж байгаа гээд, үнэхээр дүүрэг, аймаг, нийслэлийн түвшинд боловсролын төсвийн мэдээлэл хаалттай байна, иргэд, иргэний нийгэмд өгөхгүй байна, хуулиа хэрэгжүүлэхгүй байна гэсэн дүгнэлт гарсан. Зарим нэг мэдээллээ өгсөн газруудын төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг харахад боловсролын төсвийг хайр гамгүй, нааш цааш нь шилжүүлдэг, зориулалтын бусаар зарцуулдаг ийм нөхцөл байдалтай байна. Боловсролын салбарт төсвийн хяналтын асуудлыг хуульчлах хэрэгтэй байна.

Дээрх байдлаас дүгнэхэд:

Мэдээлэл авах эрхийн хэрэгжилтийн байдал хангалтгүй байна. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиас төсвийн мэдээлэл авах эрхийг хасаад шилэн дансны тухай хууль руу шилжүүлсэн гээд дээрх хуулийн дагуу төсвийн мэдээллийг авч чадахгүй байна. Шилэн дансыг жирийн иргэд ойлгож, уншиж, ашиглаж чадахгүй байна. Тийм учраас Төрийн бус байгууллагууд иргэдийг зохион байгуулалтад оруулах, төсвийн мэдээллийг уншиж чаддаг болгож байж, хяналт тавьж, авлигыг хянах нөхцөл байдал үүсээд байгааг эргэн харах шаардлагатай байна.

Цаашид иргэний нийгэм өргөн хүрээнд ажиллахгүй бол болохгүй байна. Татварын шударга ёсны чиглэлээр, тухайлбал, татвараас хэн чөлөөлөгдөөд, хэн татвараа төлөхгүй байгаа, хэн өршөөлд ороод байна вэ гэдэгт хяналт тавих нь боловсролын төсвийн хяналтаас цаашлан гүнзгий хянаж шалгах

шаардлагатай боллоо. Өрийн асуудал бидний анхааралд байх ёстой. Боловсролын санхүүжилтэд Монгол Улсын гадаад өрийн нөхцөл байдалд судалгааг хийлгэж үзэхэд “нөлөөтэй” байна. 2016 онд Ерөнхий боловсролын сургуулиудыг санхүүжүүлдэг нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг Засгийн газрын тогтоолоор жил болгон шинэчлэгдэн батлах ёстой байтал 2016 оноос хойш өөрчилж батлаагүй. Шалтгаан нь Олон улсын валютын сангийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн дагуу төсвийн зарлагыг нэмэгдүүлж болохгүй гэсэн нөхцөл болзол тавьсан байна. Тийм учраас өнөөдөр ерөнхий боловсролын сургуулийн төсөв нэмэгдэхгүй харин ч буурч, эцэг эхийн халааснаас төсвийн цоорхойг нөхөх, боловсролын салбарт авлига нэмэгдэх нөхцөл болсон. Тэгэхлээр бид өрийн менежмент, өр яагаад тавьж байгаа, хэн тавьж байгаа чиглэлээр хяналт тавихгүй бол болохгүй байна.

Дээрээс нь Авлигатай тэмцэх газар, иргэний нийгмийн байгууллагуудыг төртэй ажиллах гүүр болгож өгмөөр байна. Өнгөрсөн хугацаанд боловсролын чиглэлээр ажилладаг Иргэний нийгмийн байгууллагуудыг боловсролын яамтай уулзуулж, хамтарсан уулзалт, хурал зохион байгуулаад, судалгаа хийж байсан сайн туршлага байна. Энэ бол маш үр дүнтэй, үүгээр зогсохгүй бид Үндэсний аудитын газар, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөлтэй хамтарч ажилламаар байна. УИХ-аас томилогддог энэ байгууллагууд хоорондоо хамтарч ажиллахгүйгээр авлига гэдэг энэ мангасыг дарж чадахгүй.

УИХ-д хяналтын функц гэж бий, УИХ энэ үүргээ гүйцэтгэхгүй байна. Ажлаа маш муу хийж байна, энийг иргэд, Иргэний нийгэм, Авлигатай тэмцэх газар УИХ-ыг шахаж болдог юм уу, болдоггүй юм уу. Болох ёстой гэж бодож байна.

Хамгийн сүүлд хэлэх үг бол “Бидний тэмцэл мохоо байна, бидний тэмцэл хурц биш байна, ийм том мангастай, ийм том улс төрийн эрх мэдэл, бизнес мөнгө, шашин, одоо цэрэг арми орж ирж байгаа ийм хоорондоо нягтарсан авлигын сүлжээтэй бид хэд нэг нэгээрээ юм уу, тус тусдаа ч юм уу, ганцхан Авлигатай тэмцэх газар байлдана, амжилт гарна гэдэгт би итгэхгүй байна.

Цаашид

- ★ Төрийн үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хараат бус хяналтын төлөвшилтөд анхаарах;
- ★ Аливаа бодлого шийдвэр гаргахын өмнө олон нийттэй зөвшилцдөг жишиг, ялангуяа орон нутаг ба үндэстний түвшинд тогтоох, олон талын төлөөлөлтэй зөвлөлүүдийг байгуулах, ажиллуулах заалтуудыг хуульчлах, (Үндэсний/орон нутгийн боловсролын бүлэг (LEG));

- ✦ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу байгуулагдсан олон талт төлөөлөл бүхий “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл” зэрэг оролцооны бүтцүүд шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгааг улам батжуулах;
- ✦ Сургалтын байгууллагын шийдвэр гаргах түвшинд суралцагчдын, эцэг эхийн, оюутны байгууллагуудын оролцоог хуульчлах;
- ✦ Санал, гомдол зэрэг мэдээллийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйлдлийн талаарх эргэж мэдэгддэг тогтолцоог хуульчилж өгөх шаардлагатай байна. Иргэдийн, ялангуяа эцэг эхчүүдийн санал, хүсэлт гомдлыг хэрхэн яаж шийдвэрлэсэн үйл явц, хариу үйлдлийг тодорхой ил тод байлгах зэрэг үүнд ордог;
- ✦ Боловсролын салбарт Иргэний нийгмийн байгууллагууд төрийн зарим чиг үүргийг гэрээлэн гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг сайжруулах;
- ✦ Багштай холбоотой аливаа бодлогын асуудлаар тэднийг төлөөлсөн ҮЭ-тэй зөвлөлдөх байдлыг хуульчлах зөвлөмжийг чуулганы зөвлөмжид тусгана гэдэгт найдаж байна.



АВЛИГАТАЙ ЭСРЭГ ЗАЛУУСЫН ОРОЛЦОО, САНААЧИЛГА

*“Цогц хөгжлийн үндэсний төв”
ТББ-ын Тэргүүн М.Энхбадрал*

Та бүхэнд авлигын эсрэг олон улсын өдрийн мэнд хүргэе.

Авлигын эсрэг залуучуудын оролцоо, залуучуудын санаачилгын тухайд санал, туршлагаа хуваалцахад таатай байна.

Авлигын эсрэг тэмцэл нь аль нэг байгууллага, хэн нэгэнд даатгаад орхих талбар биш. Энэ нь зөвхөн залуучуудын бус бүх нийтийн үйл хэрэг, хамтын хүчин зүтгэл байх ёстойг онцольё. Гагцхүү энэ оролцоонд залуучуудыг орхигдуулж болохгүй. Тэдний оролцоог өөрсдийнх нь онцлог давуу талд тулгуурлан дэмжих нь чухал байна.

Олон нийтийн оролцоонд тулгуурлаж авлигыг бууруулах гол шалгуур нь нээлттэй, ил тод байдлыг сайжруулах юм. Нээлттэй байдал нь сайн менежментийн гол зарчим бөгөөд ардчиллыг үнэлэх чухал шалгуур үзүүлэлт болдог. Засаглалын нээлттэй байдал нь иргэдэд мэдээлэлтэй байх боломжийг олгож, тухайн байгууллагын үйл ажиллагаа, ажилд нь хяналт тавих арга хэрэгсэл болж өгдөг. Ийнхүү мэдээллийн ил тод байдал нь шийдвэр гаргах үйл явцад оролцох иргэдийн оролцооны гол дэмжлэг болж байдаг.

Иргэдийн оролцоо бага байгаагийн нэг шалтгаан нь оролцооны тухай уламжлалт хандлага давамгайлсан, товчхондоо оролцооны хэлбэр агуулга хуучирсантай холбоотой. Оролцохын тулд иргэдээс ихээхэн цаг зав, зохион байгуулалт, тусгай мэдлэг, ур чадвар шаардлагатай гэсэн тогтсон хандлага нь иргэний оролцоог хязгаарлаж байна.



Иймд оролцоог ч, мэдээллийг ч инновацжуулах шаардлагатай.

Үүний суурь нь мэдээллийн ил тод байдал юм. Нэгдүгээрт, Мэдээллийг нээлттэй болгох. Хоёрдугаарт, Нээлттэй байгаа мэдээллийг иргэдэд хүргэх, хялбарчлах, цэгцлэх, ойртуулах. Гуравдугаарт, Нээлттэй мэдээллээр дамжуулан засаглалын институтүүдийг хянах соёлыг төлөвшүүлэх.

Засаглалыг хянах гол хяналтыг иргэд хийх ёстой бөгөөд хэрэв мэдээлэл хаалттай байвал түүнийг нээлттэй болгох, мэдээлэл ойлгомжгүй бол түүнийг эмх цэгцтэй, хялбар ойлгомжтой болгож иргэдийн оролцоог дэмжих нь энэ чиглэлд ажиллаж буй иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллага, идэвхтнүүдийн гол зорилго болно.

Мэдээллийг ил тод болгож, иргэдэд илүү хялбар хүртээмжтэй болгох нь мэдээллийн инновац. Оролцоог цахимжуулж хэн ч, хэзээ ч, хаанаас ч оролцох нээлттэй боломж олгох нь оролцооны инновац юм. Энэ хоёр инновацыг хэрэгжүүлэх нь бидний тэргүүлэх чиглэл болно.

Иргэдийн биечилсэн оролцоог шаардах нь иргэний оролцоог хязгаарлахаас хэтрэхгүй бөгөөд буйдан дээрээсээ засаглалыг хянах боломжтой байх нь өнөө цагийн шаардлага болж байна. Монгол Улс интернэт, цахим төхөөрөмжийн хэрэглээгээрээ тэргүүлж буй нь ч бидэнд байгаа давуу тал, нөөц болох юм.

Бид уг чуулганд мэдээллийн ил тод байдал, иргэний оролцоо, хяналтыг дэмжих чиглэлд хэрэгжүүлж буй өөрсдийн туршлагаас танилцуулахаар бэлтгэсэн. “Цогц Хөгжлийн Үндэсний Төв” ТББ-аас хэрэгжүүлж буй дараах 2 төслийг товч танилцуулъя.

1. UH.mn буюу United Info Hub нь төлөөллийн хариуцлагыг дээшлүүлж, иргэний хяналтыг дэмжих төсөл.



Нөгөөтэйгүүр гишүүдийг үндсэн чиг үүрэгтэй нь холбоотой ажлаар үнэлдэг болсноор УИХ-ын гишүүд хийх ёсгүй зүйлээ амлах, түүнийгээ хэрэгжүүлэх гэж ажлаа хийдүүлэх шаардлагагүй болно.

Засаглалын хувьд байнгын хяналтыг иргэд л хийх ёстой. Харин бидний хийх зүйл иргэдийн хяналтад хэрэгтэй мэдээлэл ойлгомжгүй байвал эмх цэгцтэй хялбар байдлаар нэгтгэж харуулах, хаалттай байвал ил тод болгох, олж үзэхэд хэцүү байвал түүнийг хэзээ ч хаанаас ч хянах боломжтой болгон хялбарчлахад оршиж байгаа юм. Товчхондоо мэдээлэл-иргэн хоёрыг холбох зууч, гүүртэй адилтгаж болно.

2. www.Electionmuseum.mn “Сонгуулийн музей нь сонгогчийн санах ойг сайжруулах зорилготой 100 хувь цахимд суурилсан музей юм.”



2020 онд байгуулагдсан “Сонгуулийн музей” буюу www.electionmuseum.mn нь иргэдийн улс төрийн боловсролыг дэмжиж, улс төрчдийн сонгуулийн амлалт мөрийн хөтөлбөрийг мартахагүй байх, дахин худал амлалт, уран үгэнд хууртахгүй байх сонгогчдын дархлааг тогтоохоор ажиллаж байна.

◆ “АВЛИГЫН ЭСРЭГ
ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН-2021”

Салбар хамгаалалтаа 3

**ТӨРИЙН АЛБАНЫ ШУДАРГА, ИЛ ТОД
БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ**



ТӨРИЙН АЛБАНЫ ШУДАРГА, ИЛ ТОД

ТӨРИЙН АЛБАН ДАХЬ АВЛИГЫН ЭРСДЭЛ: СУДАЛГААНЫ ҮР ДҮН

*Авлигатай тэмцэх газрын
Судалгаа шинжилгээний албаны дарга,
ахлах комиссар Ц.Шинэбаяр*



ТӨРИЙН АЛБАНЫ ТОМИЛГОО, ИЛ ТОД БАЙДАЛ: ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨРЧЛӨӨС СЭРГИЙЛЭХ НЬ

*Төрийн албаны зөвлөлийн дарга
Б.Баатарзориг*



АВЛИГА-ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ ТӨРИЙН АУДИТЫН БОДЛОГО ЧИГЛЭЛ

*Монгол Улсын Ерөнхий аудитор
Д.Занданбат*



ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМЖУУЛАХ, АВЛИГА, ХҮНД СУРТЛЫГ БУУРУУЛАХ НЬ: НИЙСЛЭЛИЙН ШИЙДЭЛ, СОРИЛТ, ҮР ДҮН

*Нийслэлийн Инновац, технологийн асуудал
харууцсан төслүүдийн удирдагч Р.Дагва*



БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

ЦАХИМ ШИЛЖИЛТ БА АВЛИГА

*Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга
Б.Болор-Эрдэнэ*

ОЛОН УЛСЫН ХАНДИВ, ТУСЛАМЖИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Дэлхийн банкны Улсын салбарын ахлах зөвлөх Д.Бадамчимэг

ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ: ТӨСӨВ, НИЙТИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГИЙГ ЗАХИРАН ЗАРЦУУЛАХАД ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГААС ТАВИХ ХЯНАЛТ

*“Нээлттэй нийгэм форум” ТББ-ын
Засаглалын менежер Д.Оюунбадам*



ТӨРИЙН АЛБАН ДАХЬ АВЛИГЫН ЭРСДЭЛ: ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ БОЛОН БУСАД СУДАЛГААНЫ ҮР ДҮН

*Авлигатай тэмцэх газрын
Судалгаа шинжилгээний албаны дарга,
ахлах комиссар Ц.Шинэбаяр*

Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Ер нь аливаа асуудлын талаар шүүн хэлэлцэж шийдэл гаргахаас өмнө тухайн асуудалтай холбоотой нөхцөл байдлыг сайтар тодорхойлж, судалж сурвалжилсан байх нь чухал байдаг. Тийм ч учраас энэ илтгэлийг бусад илтгэлийн өмнө эрэмбэлсэн байх. Төрийн албан дахь авлигын эрсдэл гэдэг ерөнхий сэдвийн хүрээнд хуралдаан оролцох бусад илтгэгчид холбогдох олон асуудлуудыг хөндөхөөр байгаа. Миний өнөөдрийн илтгэл үндсэндээ төрийн байгууллагуудын шударга байдлын судалгааны дүнгийн талаар танилцуулна. Энэ хүрээнд тодорхой байгууллагуудын, тухайлбал яамдууд, агентлагууд, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрууд дээр авлигыг бий болгох ямар эрсдэлүүд байна, ямар эрсдэл нь байнга давтагдаж байна, аль байгууллага нь илүү эрсдэлтэй байна гэх мэт тодорхой нөхцөл байдлыг хөндөх юм. Дээр нь мөн бусад судалгааны дүнгийн холбогдох хэсгийг танилцуулга.

Эхлээд Авлигатай тэмцэх газраас хийгддэг давтамжит судалгаануудын талаар товч танилцуулья.

Манай байгууллага 2008 оноос эхлэн авлигын нөхцөл байдал, шалтгаан, авлигыг үүсгэгч хүчин зүйлс, хор хөнөөл, цар хүрээтэй холбоотой судалгаануудыг байнга зохион байгуулж ирсэн. Үүнд Хүүхдийн шударга байдлын судалгаа, Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгаа, Авлигын индекс, Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ, Шударга байдлын үнэлгээ, Авлигын эрсдлийн үнэлгээ зэрэг судалгаа, үнэлгээний ажлуудыг дурдаж болно.



Нэг асуумж аваад, тооцоолол хийдэг нэг хэсэг ч байна. Тодорхой нэг асуудлыг цохож аваад анализ, дүгнэлт хийдэг ч судалгаа байна. Манай судалгаа бол давтамжит буюу дор хаяж 3-с дээш жил тогтмол хийж байгаа судалгаанууд юм.

Хүүхдийн шударга байдлаа судалгаа бол манай өсвөр үеийнхний дундах шударга байдлын хандлага, төлөвшлийг үнэлдэг, 2008 оноос тогтмол хийгдэж байгаа судалгаа юм. Манай нийгэм 15-20 жилийн дараа ямар байх вэ гэдгийг үнэлдэг судалгаа гэж хэлж болно.

Улс төрийн, хууль хяналтын байгууллагуудын хүрээнд төсөөллийн судалгааг 2008 оноос тасралтгүй хийж байна. 2017 он хүртэл улс төрийн хүрээний болон хууль сахиулах хүрээний авлигын нөхцөл байдлыг нэг судалгааны хүрээнд тогтоож байгаад 2018 оноос 2 тусад нь салгаж хийж эхэлсэн.

Өнөөдрийн танилцуулах гол мэдээлэл бол Шударга байдлын үнэлгээний үр дүн юм. Энэ судалгаа нь шударга ёсыг бэхжүүлэх, авлигын шалтгаан нөхцөлийг арилгах, авлигыг таслан зогсоох болон төрийн байгууллагаас авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг суурь мэдээллээр хангах, төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээг нэмэгдүүлэхэд зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлох, үнэлгээний үр дүнг олон нийтэд мэдээлэх замаар төрийн байгууллагын зүгээс үнэлгээний үр дүнг сайжруулах хүсэл зоригийг нэмэгдүүлэх, авлигыг бууруулах санал, санаачилга өрнүүлэх, эрмэлзлийг бий болгох зорилготой.

2016 оноос хойш 5 дахь удаагаа хийж байгаа тул он оноор нь харьцуулах, байгууллагуудыг хооронд нь харьцуулах боломжтой, тоогоор илэрхийлэгддэг судалгаа юм. Үндсэндээ 68 үзүүлэлтээр дүгнэгддэг. Энэ жилийн байдлаа 9950 хүн оролцсон. Дийлэнх нь иргэд. Яам, агентлаг, ЗДТГ-аас үйлчилгээ аваад гарч


ирсэн иргэдээс нүүр тулж уулзасны үндсэн дээр тодорхой асуултанд хариулт авч дүгнэдэг. Дотоод шударга байдлын үнэлгээ гэдэг нь тухайн байгууллагын албан хаагчдаас түүврийн аргаар, урьдчилан бэлтгэсэн асуумжаар хариулт авч гаргадаг. Бодлогод оролцогчдийн судалгаа гэдэг нь тухайн салбар байгууллагын талаар тодорхой мэдлэгтэй, судалгаа хийдэг, бодлого боловсруулахад оролцдог хүмүүсийг бодлогод оролцогч гэж нэрлээд судалгаанд хамруулдаг. Үндсэндээ нэг байгууллагыг гаднаас нь, дотроос нь, дээрээс нь ингэж үнэлүүлээд нэгдсэн дүнг гаргаж тухайн байгууллагыг үнэлдэг. Нэгэнт аливаа асуудлыг үнэлж дүгнэж, эрэмбэлдэг учир тоогоор илэрхийлдэг. Энэ үнэлгээг 1-100 оноогоор үнэлдэг.



Энэ жилийн хувьд төрийн байгууллагуудын шударга байдал 72.9 гэсэн үнэлгээтэй гарсан. Өмнөх нь 2019 онд хийгдсэн. 2020 онд ковидын улмаас хийгдээгүй. Энэ жилийн үнэлгээ 2019 оны үнэлгээнээс бага зэрэг буурсан. Гэхдээ энэ юунаас болов гээд дотор нь задлаад үзвэл дүгнэлт хийж болохоор байгаа. Дээр дурдсан 3 үнэлгээний нэг болох гадаад буюу үйлчилгээ авсан иргэдийн үнэлгээ буурсан. Дотоод болон бодлогод оролцогчдын үнэлгээ өссөн байна. Энэ судалгаанд яамд, агентлаг, 21 аймаг болон нийслэлийн ЗДТГ-ыг хамруулдаг. Нийт 4200-д төрийн байгууллага байдаг. Бүгдийг хамруулах боломжгүй. Энэ судалгааг 8 дугаар сараас эхлүүлж 12 сард дүнг эцэслэн гаргасан.




Хамгийн сайн болон муу үнэлгээтэй байгууллага хоорондоо зөрүү нь 22.4 пункт байна. Товхондоо 100 оноо авахад дутсан тэр хэмжээгээр тухайн байгууллагад авлигын эрсдэл байна гэж ойлгож болно. Улсын дундаж үнэлгээ 72.9 оноо байгаа. Судалгааны дүн ЗГХЭГ-аас тухайн байгууллагуудыг үнэлдэг үнэлгээний нэг үзүүлэлт болдог.



Судалгаанд оролцогчдоос Монгол Улсад авлига хамгийн их тархсан институцийн талаар тодруулахад эрүүл мэндийн байгууллага, шүүх, газрын алба, гаалийн байгууллага, цагдаагийн байгууллага эхний 5-д эрэмбэлэгдсэн байна.

Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад эрүүл мэндийн байгууллага нь 5-д эрэмбэлэгдэж байсан нь 1-д болж, Цагдаагийн байгууллага 7-д эрэмбэлэгдэж байсан нь 5-д болж урагшилсан байна.



Судалгаанд оролцсон иргэдийн зүгээс авлигын шалтгааныг цалин орлого бага, хувь хүний ёс зүйгүй, хэм хэмжээгүй байдал, ядуурал, эдийн засгийн тогтворгүй байдал, хүнд суртал, албан тушаал эрх мэдлээ урвуулан ашигладаг байдалтай холбосон нь хамгийн өндөр хувьтай байна.

Авлигын бууруулахын тулд ил тод байх, цалин хөлс нэмэгдүүлэх, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, албан хаагчийн ёс зүйг сайжруулах, хуулийн хэрэгжилт, зохицуулалтыг сайжруулах гэсэн саналуудыг түгээмэл өгсөн байна.

Д/д	Шалтгаан, нөхцөлийн төрөл	2021 он
1	Цалин, орлого бага	11.7%
2	Хувь хүний ёс зүйгүй, хэм хэмжээгүй байдал	9.8%
3	Ядуурал, Эдийн засгийн тогтворгүй байдал	6.5%
4	Хүнд суртал	6.5%
5	Албан тушаал, Эрх мэдлээ урвуулан ашигладаг байдал	6.3%
6	Хуулийн хэрэгжилт, зохицуулалт сул	5.4%
7	Ажлаа хурдан шуурхай, амжилттай бүтээх	4.4%
8	Танил талын хүрээг ашиглан асуудлаа шийддэг байдал	3.9%

9	Улс төр, намын нөлөө	3.8%
10	Авлига авсан, өгсөн хүнд хариуцлага тооцдоггүй	3.4%
11	Хялбар аргаар ашиг хонжоо олох хүсэл	3.2%
12	Төрийн үйлчилгээ удаан, цаг хугацаа их шаарддаг	3.2%
13	Иргэдийн авилгийн мэдлэг, мэдээлэл дутмаг	2.5%
14	Төрийн буруу тогтолцоо	2.2%
15	Ил тод бус байдал	2.1%
16	Ажилгүйдэл болон ажлын байрны хомсдол	1.9%
17	Хээл хахууль өгч, авч сурсан байдал	1.5%
18	Монголын нийгмийн өнөөгийн байдал	1.3%
19	Төрийн албан хаагчийн боловсрол мэдлэг ур чадвар дутмаг	0.9%
20	Хэлж мэдэхгүй байна	19.7%

Шударга байдлын үнэлгээн дээр доогуур байр эзэлсэн байгууллагад авлигын эрсдлийн үнэлгээ хийдэг. Энэ хүрээнд тухайн байгууллагын бүх бичиг баримт, санхүү, гарсан шүүхийн шийдвэр, албан болон албан бус мэдээ, мэдээлэлд тоон, чанарын, кейс судалгаа, үнэлэлт дүгнэлт хийж аль газар, хэлтэс, ажилтан, албан тушаалтан дээр илүү их эрсдэл байна гэдгийг тогтоодог.

Авлигын эрсдлийн үнэлгээг 2018 оноос тогтмол хийж байна. Аргачлалыг нь 2018 онд боловсруулснаас хойш байнга сайжруулж байгаа. Одоогоор 10 яам, 21 агентлаг, 16 төрийн өмчит үйлдвэрийн газар, ЗДТГ, Засгийн газрын тусгай сан зэрэг нийт 53 байгууллага дээр эрсдлийн үнэлгээ хийгээд байна.

Д/д	Үзүүлэлт	2018	2019	2020	2021	
1	Судалгаанд хамрагдсан нийт байгууллагын тоо	24	15	10	4	
2	Үүнээс	Яам	10	-	-	-
3		Агентлаг	14	-	7	1
4		Төрийн өмчит үйлдвэрийн газар	-	15	1	1
5		Засаг даргын Тамгын Газар	-	-	1	-
6		Засгийн газрын тусгай сан	-	-	1	2

Эрсдлийн үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудад дараах чиглэлийн үйл ажиллагаанд эрсдэлийн түвшин өндөр гэж тогтоогдож байна. Үүнд:

- Байгууллагуудын төсөв, санхүүгийн зарцуулалт, тайлагнал,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ

- худалдан авах ажиллагааны ил тод байдал,
- Хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагаа,
- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт,
- Байгууллагын удирдлагуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл.

Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд дээр хийгдсэн эрсдлийн үнэлгээгээр худалдан авах ажиллагаа, төсөв санхүү, ёс зүйн дүрмийн хэрэгжилт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хүний нөөц, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, удирдлагын манлайлал зэрэг хүрээнд тодорхой эрсдэлүүд тогтоогдсон.

Д/д	Эрсдэл ихтэй үйл ажиллагааны чиглэлүүд	
1	Худалдан авах ажиллагаа	Чанарын үнэлгээ тодорхой бус
		Сонгон шалгаруулалт зарлахгүй байх
2	Төсөв санхүү	Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт дутуу
		Тайлагнал дутуу
3	Ёс зүйн зөрчил	Хариуцлага хүлээлгэхдээ харилцан адилгүй ханддаг
		Ёс зүйн хорооны үйл ажиллагаа дутмаг
4	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	Хуулийн хугацаанд шийдвэрлэдэггүй
		Хэт олон сувгаар гомдол хүлээн авдаг
5	Хүний нөөц	Давхар ажил эрхлэлт
		Ажилчдын шилжих хөдөлгөөн их
		Нээлттэй ажлын байрны ил тод байдал дутмаг
6	Үйлчилгээ	Жишгээс өндөр төлбөртэй үйлчилгээ үзүүлэх
		Үйлчлүүлэгчдэд хүндрэл, чирэгдэл учруулах
		Нэмэлт төлбөртэй үйлчилгээ үзүүлэх
7	Авлигын эсрэг үйл ажиллагаа, Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл	

Газрын асуудал хариуцсан болон газартай холбоотой шийдвэр гаргадаг байгууллагуудад хийсэн авлигын эрсдлийн үнэлгээгээр худалдан авах ажиллагаа, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, үйлчилгээ үзүүлж байгаа байдал, удирдлагын манлайлал зэрэг хүрээнд эрсдэл байгаа нь тогтоогдсон. Цаашид эдгээр байгууллагууд тогтоогдсон эрсдлийг бууруулах, удирдлага нь өөрсдөө

хичээж ажиллах, нийтдээ өргөсөн тангарагтаа үнэнч байж, төрийн албанд яах гэж ажиллаж байгаагаа байнга санаж явмаар байгаа юм.

Д/д	Эрсдэл ихтэй үйл ажиллагаа	
1	Худалдан авах ажиллагаа	Мэдээлэл, баримт хаалттай бус
		Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хуулийн дагуу байгуулдаггүй
		Хуульд заасан бүрэлдэхүүнээр зохион байгуулдаггүй
2	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	Хуулийн хугацаанд шийдвэрлэдэггүй
		Хариуцлага тооцох механизм сул
3	Үйлчилгээ	Дээд шатны байгууллага, удирдлага, улс төрийн шинжтэй зүй бус нөлөө их
		Хууль зөрчсөн шийдвэр, үйл ажиллагаа явуулдаг
		Хууль зөрчин газар олголтын үйл ажиллагаа хийдэг
		Үйлчилгээ авахад шаардлагатай бүрдүүлэх материал их бөгөөд давхардсан шинжтэй
4	Авлигын эсрэг үйл ажиллагаа, Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл	

Ерөнхий дүгнэлт:

- 2021 оны ШБҮ-ээр 72.9 оноо авсан нь өмнөх оноос 1.2 пунктээр буурсан.
- ШБҮ ийнхүү буурахад төрийн байгууллагаас үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж байгууллагын өгсөн үнэлгээ 4.7 пунктээр буурсан нь голлон нөлөөлсөн.
- Төрийн байгууллагууд мэдээллээ илүү ил тод болгох, албан хаагчдын ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх, үйлчлүүлэгчдээс нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж авах зэрэг үйлдлийг таслан зогсоох шаардлагатай;
- ДШБҮ-г тооцоход ашигласан үзүүлэлт болох (төсвийг зориулалтын бусаар ашигладаг шалтгааныг тодруулахад удирдлагын шийдвэрээр гэж хариулсан алба хаагчдын хувь 2019 онтой харьцуулахад 5.8 пунктээр буурсан боловч) төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах явдал нь удирдлагын шийдвэртэй шууд хамааралтай байдаг нь хэвээр хадгалагдсаар байгаа тул бодлого боловсруулагчдын хувьд анхаарал хандуулж хяналтын механизмыг сайжруулах шаардлагатай.

- БОУ-ний судалгаанд оролцогчид төрийн байгууллагуудын авлигыг хянах механизм тааруу байна хэмээн үнэлсэн. Цаашид дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлэх, хариуцлага тооцох, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалах, шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэхэд анхаарах шаардлагатай;
- Монгол Улсад авлига хамгийн их тархсан институцээр “Эрүүл мэндийн байгууллага”-ыг нэрлэсэн байна. Энэхүү үр дүнг өдөр тутамд тулгамдаж буй асуудал, Ковид-19 цар тахлын үеийн нөхцөл байдлаас шалтгаалсан гэж таамаглаж байна. Тухайлбал: иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг авахад эрүүл мэндийн байгууллагын хүртээмжгүй байдал нь иргэдийн үнэлгээнд нөлөөлсөн байж болох юм.
- Шүүх, Газрын алба, Эрүүл мэндийн байгууллага нь сүүлийн 3 судалгаанд дараалан эхний 5-д эрэмбэлэгдсэн тул эдгээр байгууллагуудад тархсан авлигыг бууруулах, таслан зогсооход нэн тэргүүнд анхаарал хандуулж ажиллах.



ТӨРИЙН АЛБАНЫ ТОМИЛГОО, ИЛ ТОД БАЙДАЛ: ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨРЧЛӨӨС СЭРГИЙЛЭХ НЬ

*Төрийн албаны зөвлөлийн дарга
Б.Баатарзориг*

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе!

Шударга, ил тод, авлигагүй төрийн төлөө ажиллах асуудлаар үндэсний энэхүү чуулганыг зохион байгуулж байгаа нь иргэд олон нийт, шударга төрийн албан хаагчдын хүссэн, бас хүлээсэн арга хэмжээ болж байна.

Төрийн албаны тухай хуулийн шинэтгэлийн бодлого авлигыг бууруулах, улмаар авлигад “үгүй” гэж хэлэх нийтийн соёлыг бүтээхэд чиглэгдсэн.

Иргэдээ хүлээн зөвшөөрөгдсөн шударга төрийн албыг төлөвшүүлэх зорилт Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн баримт бичгээр баталгаажсаныг Та бүхэн мэднэ.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газрын нэгдмэл байр суурь, манлайлал, олон талын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан төрийн албаны шинэтгэлийг эрэмбэлэн хэрэгжүүлж байна.

Энэ шинэтгэл яаж хэрэгжих вэ?

Ажил, мэргэжлийн өндөр ур чадвартай, төрд чин үнэнчээр зүтгэх сэтгэлтэй, төр түмний эрх ашгийг хувийнхаасаа өмнө эрэмбэлж чадах, шударга, зарчимч, хариуцлагатай иргэнийг шалгаруулж мэргэжлийнх нь салбарт ажиллуулах, тасралтгүй сургаж хөгжүүлэх, мэргэшиж чадваржсаныг мерит зарчмаар шатлан дэвшүүлэх, тэдний нийгмийн баталгааг нь хангах замаар хэрэгжинэ.

Ажил хийдэггүй, сэтгэлгүй, зорилгоо ойлгож, зарчмаа хэрэгжүүлж чаддаггүй, авлига, ашиг сонирхлын зөрчилтэйг нь төрийн албанаас чөлөөлөх замаар хэрэгжинэ.

Уулзалт хурал, үндэсний чуулган зөвлөгөөнөөр ярьж, хэлэлцсэн зүйлс бодитоор хэрэгждэг жишиг тогтож эхэллээ.

Нийгмийн анхаарлыг тухайлсан асуудалд нэгтгэн төвлөрүүлж, шийдэл

олохыг эрмэлзэж байгаа нь төрийн бүх шатны байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоо, нийгмийн зөвшилцлийн илэрхийлэл.

Төрд ажиллах хүний ёс суртахууны төлөвшил, сахилга бат юу юунаас чухал байгаатай бүгдээрээ санал нийлэх байх.

Зарчмаа ойлгосон, төрийн албыг шударга байлгая гэсэн сэтгэлтэй хүн л төрд ажиллаж байж олон нийтийн шударга ёсны хүсэмжлэл болсон ил тод, ашиг сонирхлоос ангид төрийн албыг цогцлоох зөв эхлэл тавигдах нь зүйн хэрэг.

Нэг. Томилгооны зөрчилгүй төрийн албыг төлөвшүүлцгээе.

“Гараа сайн бол бариа сайн” гэсэн ардын зүйр үг бий.

Төрийн албаны шударга байдал хүний нөөцийн зөв томилгооноос эхэлнэ.

Зөв хүнийг зөв аргаар сонгож, зөв ажил даалгаж, зөв үр дүнд хүргэх нь томилгооны зорилго, үр дүн байх ёстой.

Танил талын дэмжлэг, садан төрлийн нөлөөллөөр төрийн албанд шууд томилогддог засаглалын гажуудал гарч нийгмийн шүүмжлэл дагуулсаар ирсэн нь төрд итгэх иргэдийн итгэл буурах, төрийн албаны нэр хүнд унах нэгэн нөхцөл болсон билээ.

Ийнхүү төрийн албаны үндсэн зарчмыг баримтлахгүй явж ирсэн нь монгол төрийн залгамж чанар, төрийн удирдлагыг сулруулж, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3-т заасан дотоод аюулгүй байдлыг доройтуулж болзошгүй хэмжээнд хүрээд байгааг Төрийн албаны зөвлөлийн 2014 оны тайланд онцлон дурдаж, УИХ-ын анхааралд хүргэсэн байдаг.

Төрийн албаны тухай шинэ хуулийн дагуу хэрэгжүүлж буй Төрийн албаны зөвлөлийн өнөөгийн бодлого, үйл ажиллагаа нь төрийн албанд сайн засаглалыг нутагшуулан, хуулиа дээдэлж, зарчмаа мөрддөг шинэ соёлыг тогтооход бүхэлдээ чиглэгдэж байна.

Үр дүн ч эхнээсээ гарч байгаа.

Төрийн байгууллагуудын өнөөгийн үйл ажиллагааны талаар 10 аймгийн иргэдийн дунд сар гаруйхны өмнө судалгаа явууллаа.

Судалгаанд оролцогчдын 65.4 хувь нь төрийн байгууллагуудаас үйлчилгээ авахад ямар нэгэн хүндрэлгүй болсон, 49.5 хувь нь төрийн байгууллагууд төрийн албаны хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа, 48.4 хувь нь төрийн байгууллагууд шударга ажилладаг гэдэгт итгэдэг гэж тус тус хариулсан байна.

Төрийн захиргааны албан хаагчид хамаарах 21821 албан тушаалын тодорхойлолтыг хянан батлууллаа. Энэ баримт бичгийг томилох эрх бүхий

зарим этгээд тодорхой хүнд тохируулж дураараа засаж өөрчилдөг өмнөх практикыг халж, ажилд тавигдах босго шаардлагыг өндөрсгөсөн. Ашиг сонирхол эхэлдэг эхний гишгүүрийг нь “нураасан” гэж ойлгож болно.

Ингэснээр иргэдийг төрийн алба хаах адил тэгш боломжоор хангах зарчмыг хэрэгжүүлэх суурь нөхцөл бүрдсэн.

Ийнхүү тодорхойлсон шалгуур, шаардлагын дагуу төрийн захиргааны удирдах албан тушаалын 566, гүйцэтгэх албан тушаалын 1299, төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн 214 сул орон тоог тусгай шалгалтын дүнгээр нөхөж, эрдэм оюунаараа ухаалгаар өрсөлдөж төрийн албанд томилогдох эхлэлийг баттай тавьж байна.

Үүний нэг жишээ нь сүүлийн 3 жилд төрийн албаны ерөнхий шалгалт өгч тэнцсэн 10428 хүний 42 хувь буюу 4403 иргэн төрийн албанд “шинэ цус” сэлбэгдсэнээс харж болно.

ЗГХЭГ-тай хамтарсан ажлын хэсгийг энэ оны 10, 11 дүгээр сард 10 аймагт ажиллууллаа. Төрийн 350 гаруй байгууллагын 4606 албан хаагчийг хамруулан төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилт, томилгооны байдалд хяналт шалгалт хийсэн. Томилгоотой холбогдсон 95 шийдвэрийг хүчингүй болголоо. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдож, нийтийн албанд ажиллах эрх хасуулах шийтгэл хүлээсэн 91 иргэнийг төрийн албанаас чөлөөлүүлэв. 2021 оны 9 дүгээр сарын байдлаар, Ковидын хуулийг баримтлан сул орон тоонд хуулийн шаардлага хангаагүй 1037 хүнийг удирдах албан тушаалд сонгон шалгаруултгүйгээр томилон ажиллуулж байгааг тогтоолоо.

Дэлхийн нийтээр цар тахалтай нүүр тулан тэмцэж буй VUCA эриний эгзэгтэй үе дэх Төрийн албаны зөвлөлийн баримталж буй бодлого, чиглэл маш тодорхой. Энэ бол Төрийн албаны тухай хуульд заасан мэргэшсэн, ил тод, ёс зүйтэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх явдал. Энэ бол томилгооны зөрчилгүй төрийн албыг төлөвшүүлэх, нийтийн сайн сайхны төлөө санаачилга, сэтгэл зүтгэл гаргах, иргэдийн итгэлийг хүлээн ажиллах явдал.

Төрийн байгууллагуудад хийх хүний нөөцийн аудитын үйл ажиллагааг улам эрчимжүүлнэ. Төрийн албанд томилгооны зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг яам, агентлаг, төрийн байгууллагуудад өргөн хүрээнд зохион байгуулна.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн ахалсан Цахим засаглалд шилжих, хүнд суртал, авлигагүй төрийн үйлчилгээг бүрдүүлэх үндэсний хороо болон Авлигын индексийг бууруулах Ажлын хэсэгтэй үйл ажиллагаагаа уялдуулна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран хийж байгаа хяналт шалгалтаа үргэлжлүүлнэ. Хуулийн болзол шаардлага хангаагүй, сонгон шалгаруулалтгүйгээр томилогдсон хүмүүсийг төрийн захиргааны албанаас

чөлөөлөх хүртэл арга хэмжээг 2021-2022 онд хэрэгжүүлж дуусгана.

Төрийн байгууллагуудад “Парето зарчим”-ын хүрээнд 20/80-ийн харьцаагаар хүний нөөцийн хөдөлгөөн хийх шаардлага гарч ирэхийг ч үгүйсгэхгүй.

Олон талын оролцоотой, далд нууц сүлжээгээр дамжин хийгддэг авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийг үндсээр нь таслан зогсооход төрийн бүх институтын хамтын ажиллагаа, нэгдмэл хүсэл зорилго, тууштай манлайлал, нийгмийн хяналт нэн чухал.

Хууль бус томилгооны зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хамтын ажиллагааг идэвхжүүлцгээе. Тухайлбал:

- ★ Шударга байдлын үнэлгээ, судалгаанд тулгуурлан авлигын эрсдэл бүхий салбар, байгууллагуудад нэгдмэл, цогц, гол оролцогч талуудтай хамтарсан хяналт шалгалт хийе. Ингэж албан тушаалтны хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, давтагдан гарахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулъя. Энэ хүрээнд хууль зөрчсөн томилгооны ард ашиг сонирхлын нөлөөлөл байгаа эсэхийг холбогдох байгууллагууд нягтлан үздэг байхыг зөвлөө.
- ★ Төрийн албан хаагчийн ёс зүй, зан үйлийн стандартыг шинээр гаргаж, шударга ёсны соёлыг хэвшүүлэе.
- ★ Албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажилд хүчээ нэгтгэе.
- ★ Хуулийн хэрэглээний нэгдмэл байдлыг хангая. Энэ ажлын хүрээнд төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой захиргааны болон иргэний хэргийн шүүхээр 2019 оноос хойш хянан шийдвэрлэсэн хэрэг маргааны байдалд нэгдсэн дүн шинжилгээ хийе.

Хэрэг маргааны шалтгаан нөхцөл, үр дагавар, анхаарах асуудал, авах арга хэмжээний талаар судалгаа хийж, хууль тогтоомж, дүрэм, журмыг боловсронгуй болгоход мэргэжлийн туслалцаа үзүүлэхийг санал болгож байна.

- ★ Шинээр байгуулан ажилд нь оруулж байгаа төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих зөвлөлийн үйл ажиллагааг зөв, тууштай хэрэгжүүлэхэд манлайлал үзүүлж ажиллацгаая.

Хоёр. Төрийн албаны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах талаар

Шинэ технологи, инновацад суурилсан цахим шилжилт төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах үндсэн арга зам болж байна. Иргэн, төр, хувийн хэвшлийн их өгөгдөлд тулгуурлан төрийн үйлчилгээг оновчтой,

хэрэгцээ шаардлагад нь тохирсон байдлаар хүргэх явдал төрийн үйл ажиллагааны ил тод байдлын мөн чанар, улс орны хөгжлийн нэг хэмжүүр болж байна. Төрийн албаны зөвлөл төрийн их өгөгдөлд суурилсан хүний нөөцийн нэгдсэн удирдлагын цахим хөгжүүлэлт хийж Сангийн яамны цалингийн нэгдсэн системтэй холболоо. Ингэснээр цалингийн давхардал, томилгооны зөрчил илрүүлэх, төрийн албан хаагчийн бүртгэл хөдөлгөөний мэдээлэл үнэн зөв, шуурхай хийгдэх, төрийн байгууллагуудын орон тоонд хяналт тавих нөхцөл бүрдсэн. Одоо төрийн бусад байгууллагуудын өгөгдөл мэдээллийн системтэй холбон интеграцжуулах ажил хийгдэж байна. Төрийн албаны сонгон шалгаруулалтын бүртгэх, шалгах, дүгнэх зэрэг шалгалтын бүхий л процессыг бүрэн цахимжууллаа. Хүний оролцоо, хөндлөнгийн нөлөөлөлгүй, олон нийт, мэргэжлийн байгууллагуудын хяналтын дор ил тод, нээлттэй шударга сонгон шалгаруулалтыг эрдэмтэн судлаачидтай хамтран явуулдаг боллоо. Төрийн албаны шалгалтад амжилт үзүүлэх эсэх нь зөвхөн шалгалт өгч байгаа иргэнээс өөрөөс нь шалтгаалдаг болсон. Цаашид хиймэл оюун ухаанд суурилсан шалгалтын арга хэлбэрийг бий болгох асуудлыг судлан шийдвэрлэхээр ажиллаж байна.

“E-Mongolia” үндэсний цахим үйлчилгээний нэгдсэн порталд “Сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын зар” болон “Төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцэж нөөцөд бүртгэгдсэн иргэдийн талаарх лавлагаа”-г оруулан цахим үйлчилгээнд нэгдсэн.

Иргэдийн тавьсан асуудал, өргөдөл, гомдолд хуулийн хүрээнд шуурхай, нэг мөр хариу өгч хэвшүүлж төр, иргэний эрүүл, ил тод харилцааны тогтолцоог бүрдүүлж ажиллах нь чухал юм.

Цахим шилжилтийг төрийн байгууллагуудын ажлыг дүгнэх гол шалгуур болгоё. Ингэх нь улс орны хөгжлийг урагшлуулах, ил тод байдлыг дээшлүүлэх, хүнд суртал, хүлээлгэн чирэгдүүлэх явдлыг арилгахад шийдвэрлэх ач холбогдолтой.

Иргэдийн хүсэл эрмэлзэл, хүлээлт шийдлийг соргоогоор мэдэрч ажиллах нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй байна.

Төрийн байгууллагын үйл ажиллагаа, шийдвэр гаргах үйл явцад иргэд цахимаар оролцох, санал бодлоо илэрхийлэх, өргөдөл, гомдол, тулгамдаж буй асуудлаа шийдвэрлүүлэх нэгдсэн платформыг шинээр байгуулагдах Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран хэрэгжүүлцгээе.

Авлигагүй, ард түмнээ алагчилдаггүй, ил тод төр орших хүчин зүйлийн нэг нь хүнд суртлыг арилгах явдал.

Төрийн байгууллагуудын дүрэм, журам, зөвшөөрөл, лицензийн тоог

зохистой хэмжээнд хүргэж цөөрүүлэх, зохицуулалтыг амьдралд нийцтэй болгож иргэд, бизнес эрхлэгчдэд ээлтэй, ил тод орчныг бүрдүүлэх нь төрийн албанд хүнд суртал, ашиг сонирхлын зөрчил, авлигын эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэхэд үр дүнгээ өгнө гэж үзэж байна.

Европын комисс болон Австрали, Канад зэрэг орнууд хүнд суртлыг бууруулах, шаардлагагүй дүрэм журмыг багасгах замаар иргэддээ ээлтэй төрийн албыг төлөвшүүлж байна.

Олон улсад нэгэнт хэвшиж тогтсон хүнд суртлын “Улаан хүлээс бууруулах”, нэг зохицуулалт шинээр үүсгэхэд нөгөө нэгийг нь заавал хүчингүй болгодог “Нэг нэгийн дүрэм”-ийг Төрийн албаны зөвлөл манлайлан хэрэгжүүлнэ. Санаачилгыг маань төрийн байгууллагууд дэмжин ажиллахыг уриалж байна.

Төрийн албаны шинэтгэлийн бүхий л асуудлаар хоёр талын болон олон талын өргөн оролцоотой хамтын ажиллагааг тогтмолжуулснаар авилгаас ангид төрийн албыг төлөвшүүлэх үйлсэд хамтын үр дүн гаргах болно.

Өнөөдрийн Авлигын эсрэг үндэсний чуулганы зөвлөмжийг хэрэгжүүлэх замаар төрийн албанд хандлага, соёлын өөрчлөлт гаргахад хамтын хүч оюунаар, эрхэлсэн ажил, хүлээсэн чиг үүргийн дагуу идэвхтэй ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Хэлэлцүүлгийн үйл ажиллагаанд амжилт хүсье.



АВЛИГА-ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ ТӨРИЙН АУДИТЫН БОДЛОГО ЧИГЛЭЛ

*Монгол Улсын Ерөнхий аудитор
Д.Занданбат*

Авлигын эсрэг үндэсний чуулганд оролцож байгаа хүндэт зочид, төлөөлөгчид Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгаж, чуулганы үйл ажиллагаанд амжилт хүсье.

Монгол Улсын Төрийн аудитын байгууллага төрөөс авлигын эсрэг хуульчлан баталгаажуулсан хууль тогтоомж болон “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, мөн Засгийн газраас хэрэгжүүлж байгаа арга хэмжээ бүрийг дэмжин ажиллаж ирсний зэрэгцээ дэлхийн нийтийн хөгжлийн чиг хандлагыг онцгойлон анхаарч, олон улсын түвшинд зарласан “Авлигад үгүй гэж хэлье” уриаг талархан дэмжиж байна.

Энэхүү чуулганд хэлэлцэж байгаа асуудал, хүлээгдэж буй үр дүн, үр нөлөөт байдалд анхаарал хандуулахын зэрэгцээ Төрийн аудитын байгууллагын зүгээс авлигын эсрэг хамтдаа дуу хоолойгоо нэгтгэж, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд учруулах хор хөнөөлийн эсрэг үйл ажиллагаагаа чиглүүлж байна.

Төрийн аудитын байгууллага улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд гацаа үүсгэдэг авлига, албан тушаалын нөлөөлөл болон залилангийн шинж чанартай үйлдэл төрийн салбарт оршсоор байгаа талаарх дотоод, гадаадын болон иргэний нийгмийн байгууллагаас гаргасан олон талт судалгааны баримт мэдээ, мэдээлэлд анхаарлаа хандуулж байдаг билээ.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд Үндэсний аудитын газрын хариуцан хэрэгжүүлэх 9, бусад холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх 5, нийт 14 арга хэмжээ туссан бөгөөд хэрэгжилтийн үнэлгээ дунджаар 77.8 хувьтай байна.

“Авлига, авлигын гэмт хэрэг” нь эдийн засаг, нийгмийн хөгжлийг саармагжуулж, иргэд олон нийтийн эрх ашиг, амьдралд хор уршиг үзүүлэн эмзэг байдалд хүргээд зогсохгүй хувь хүний ухамсар, мөн чанарт нөлөөлөх

цаашилбал, нийгмийн эмх цэгцгүй байдалд түлхсэн, эрх зүйн хэм хэмжээг алдагдуулж, саад учруулах харанга болоод байгаа тул бүх түвшний төрийн байгууллага, албан хаагч бүрийн хүчин чармайлт ихээхэн чухал билээ.

Авлига, залилантай холбоотой үйл ажиллагааг таслан зогсоох, бий болох хүчин зүйлс, нөлөөллөөс урьдчилан сэргийлэх тодорхой бөгөөд зохистой горим, тогтолцоог төлөвшүүлэх нь авлигын эсрэг үр өгөөжтэй арга замуудын нэг гэж үзэж байна.

Түүнчлэн, төрийн байгууллагуудын харилцаа хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо, уялдаа холбоо хангалтгүй, авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхээр хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнг нэгтгэн харах боломжгүй байгаа нь улсын хэмжээнд авлига-залилантай холбоотой мэдээллийн чанар, ил тод, үнэн зөв бодитой байдлыг хянах үр нөлөөтэй тогтолцоо бүрдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Мэргэжлийн байгууллагын судалгаанаас үзэхэд бусад салбартайгаа харьцуулахад ёс зүй зөрчигдөж, илүү их боломж, хүсэл эрмэлзлээсээ болж зөрчилд илүү өртөмтгий төрийн салбарын зарим үйл ажиллагааг дурдвал,

- ✦ Төрийн салбарын худалдан авалт, ханган нийлүүлэлт,
- ✦ Хөгжлийн албан ёсны тусламж, татаас, тэтгэмж, хөтөлбөр,
- ✦ Эрх, тусгай зөвшөөрөл, концесс олгох асуудлууд,
- ✦ Гамшгийн үеийн аюулгүй байдлыг бууруулах арга хэмжээ, батлан хамгаалах, татвар, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг салбар үйлчилгээ илүү өртөмтгий байгаа нь ажиглагдаж байна.

Төрийн байгууллагуудын дотоод хяналтын тогтолцоо хэлбэр төдий төлөвшилтэй, тэдгээрийн ажлын хүлээн зөвшөөрөгдөх байдал хангалтгүй, албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиж буй хандлага нь авлига-залилангийн өндөр эрсдэлийг дагуулж байна.

Нөгөө талаас, тусгайлан эргэн харах шаардлагатай анхааралд өртсөн асуудлууд байна:

- ✦ Улс орны хөгжлийн бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн бодит үр дүн тодорхой бус;
- ✦ Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар нь зохистой шаардлагын хэмжээнд хүрэхгүй байх;
- ✦ Төрийн байгууллагуудын соёл, үнэт зүйлс алдагдах зэрэг шалтгаан, нөхцөлүүд тод ажиглагдаж байна.

Төрийн байгууллагуудын аль ч түвшинд үйл ажиллагаа, хөрөнгө санхүү, төсвийн зарцуулалттай холбоотой үүсэж болохуйц авлига, залилангийн шинж чанартай аливаа үйлдлийг хаах зохистой тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод

хяналтын горим, үйл ажиллагаа үгүйлэгдэж байгааг анхаарах цаг болсон бөгөөд энэ чиг үүргийг хэрэгжүүлэх өндөр ухамсар, ёс зүйтэй албан хаагчдыг төрд ажиллуулах, мэргэжлийн бөгөөд бие даасан, хараат бус байдлыг хөхиүлэн дэмжих, нийгмийн баталгааг хангахуйц үр нөлөөтэй арга хэмжээ чухал байна.

Үндэсний хэмжээнд зохион байгуулж буй “Авлигад үгүй гэж хэлье” чуулганд оролцогч Та бүхний анхааралд Монгол Улсын Төрийн аудитын байгууллагаас ойрын болон дунд хугацаанд “төрийн санхүү, төсвийн хяналт”-ыг хэрэгжүүлэхдээ баримтлах аудитын стратеги, бодлого-чиглэлийн талаар товч сонордуулья!

Төрийн аудитад авлига-залилангийн эрсдэлийг тогтоож, үнэлэх ба тогтоосон залилангийн эрсдэлтэй холбоотой хангалттай, зохистой нотолгоог тохиромжтой аудитын горимыг хэрэгжүүлэх замаар олж авах нь төрийн аудитын стандарт, батлагдсан дүрэм, журамд тодорхойлсон элементүүдийн салшгүй нэг хэсэг билээ.

Төрийн аудитын байгууллага төрийн хяналтыг хэрэгжүүлэхдээ мэргэжлийн шийдэлд үндэслэн, Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд тулгарч болохуйц аливаа асуудлаар нөхцөл байдлыг үнэлж, эрсдэлтэй асуудал болон дүн шинжилгээний нотлох зүйлсэд тулгуурлан тухайлсан нөхцөл байдалд бодитой үнэлэлт дүгнэлт өгөхуйц арга хэмжээг аудитын тайлангаар дамжуулан төр, олон нийтэд толилуулсаар байх болно.

Энэ бүхнийг хэрэгжүүлэхэд бүрэн эрхийнхээ хүрээнд аудитын технологи, арга зүй, горимыг сайжруулах, мэдээллийн цахим тогтолцоог бий болгох, нөгөө талаас иргэд, олон нийтийн санаа бодлыг Төрийн хяналтад нээлттэй хүлээн авахад анхаарлаа хандуулж байна.

Төрийн аудитын байгууллага Төрийн байгууллагуудыг манлайлах замаар олон нийтийн анхааралд байгаа үнэн зөв хариу хүссэн, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн бодит цаг хугацааны болон стратегийн аудитыг гүйцэтгэх бөгөөд “Авлига-Сахилга хариуцлага- Ёс зүйн” асуудлыг “Төрийн чигч шударга байдал- ёс зүйн аудит”-ыг байнгын зорилт, шалгах зүйлс болгон сонор соргогоор ажиллахыг эрхэмлэж байгаа болно.

Төрийн санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аудитын үндсэн зорилт, хамрах хүрээний бодлогод дараах чиглэлийг баримталж ажиллах болно.

- ★ Төрийн байгууллагуудын чигч шударга байдлыг үнэлэх,
- ★ Ёс зүйн дүрмийн хэрэгжилт болон биелэлтэд хяналт тавих,
- ★ Гүйцэтгэлийн үр дүн, мэдээллийн үнэн зөв байдлын аудитыг хөгжүүлэх,
- ★ Залилан-Ашиг сонирхлын зөрчлийн аудитын удирдлагыг хэрэгжүүлэх асуудлуудыг тодорхой сэдвийн дагуу гүйцэтгэж, шалгасан зүйлсийн үр нөлөөт байдлыг чухалчлан авч үзэх юм.

Залиланг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх нь Төрийн байгууллагуудын засаглах болон гүйцэтгэх удирдлагын үндсэн үүрэг хариуцлага бөгөөд энэхүү үүрэг хариуцлагад чигч шударга, өндөр ёс суртахуунтай байх соёлыг бий болгох, удирдлагын хариуцлагатай хяналтын дор хэрэгжүүлнэ.

Та бүхний анхааралд толилуулж буй асуудлыг хураангуйлбал, “Төрийн байгууллага, албан хаагчид ёс зүй, ёс суртахуунтай байснаар ард иргэдийн итгэлийг хүлээх бөгөөд АВЛИГА болон ЗАЛИЛАНГИЙН эсрэг чигч шударга байдал төрийн байгууллагад нэн чухал шаардлагатайг ойлгож, ил тод, хариуцлагатай, сайн засаглалыг бэхжүүлэхэд таатай хөрс суурь болох” юм.

Аудитын байгууллага “Ёс зүйн асуудал”-аар аудитыг төлөвшүүлж, төрийн байгууллагууд ёс зүйн зарчимтайгаар үйл ажиллагааны зорилгодоо хүрэхэд нь түлхэц үзүүлж ажиллах болно.

*Авлигын эсрэг-Хамтдаа,
Төрийн чигч шударга байдлыг төлөвшүүлцгээе !*



ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМЖУУЛАХ, АВЛИГА, ХҮНД СУРТЛЫГ БУУРУУЛАХ НЬ: НИЙСЛЭЛИЙН ШИЙДЭЛ, СОРИЛТ, ҮР ДҮН

*Нийслэлийн Инновац, технологийн
асуудал хариуцсан төслүүдийн удирдагч
Р.Дагва*

Энд хүрэлцэн ирсэн та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Бид Монгол хүний сайн сайхан, эрх чөлөөтэй амьдрах боломж, эрх, эрх чөлөөнд хамгийн их саад болж буй авлига, хүнд суртлыг бууруулах, таслан зогсоох аргыг хайж, хамтран хэлэлцэж байна. Авлигыг таслан зогсоож, ил тод, нээлттэй, хариуцлагатай байдлыг бүх түвшинд хангаж ажиллах нь төр, иргэний хамтын ажиллагаанд сайнаар нөлөөлж, хамтран хөгжих гарц юм. Авлигатай тэмцэх газраас санаачлан зохион байгуулж буй энэ удаагийн форум нь Монгол Улсын хөгжил, дэвшилд саад болж буй авлигын шалтгаан, нөхцөлийг бодитоор тодорхойлж, авлигыг таслан зогсоох шинэ санаа, боломж, гарцыг нээсэн үр дүнтэй хэлэлцүүлэг байгаасай гэж хүсэж байна.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хоттой холбоотой харилцааг зохицуулсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай зэрэг суурь хуулиуд шинэчлэгдэж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх гэж байна.

Дээрх хуулиуд хэрэгжиж эхэлснээр нийслэл хотын өмнө тулгамдаад байгаа олон асуудал шийдвэрлэгдэж, хөгжил, дэвшлийн олон боломж, гарц бүрдэж, нийслэл хот илүү нээлттэй, оршин суугчдын эрх, оролцоог хангана гэж үзэж байгаа юм.

Дээрх хуулийн онцлог зохицуулалтын талаар танилцуулбал:

1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа ил тод, нээлттэй болж, чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг илүү тодорхой болгоно;

2. Хуулиар тусгайлан зохицуулаагүй харилцааг нийслэлийн дүрмээр зохицуулснаар албан тушаалтнууд дур зоргоор асуудалд ханддаг явдлыг хална. Нийслэлийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд оролцох иргэдийн оролцоог хангаж, урамшуулах, дэмжих тогтолцоог бүрдүүлнэ;

3. Хотын стандартыг баталж, мөрдүүлснээр иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах боломж нэмэгдэнэ;

4. Нийслэл хотыг бүсчлэн хөгжүүлэх зохицуулалтыг бий болгож, тухайн бүсэд баримтлах дүрэм, журам тодорхой болно;

5. Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнтэй хамтран ажиллах зөвлөлийг байгуулж ажиллуулна;

6. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын засаглалыг сайжруулж, үр ашиггүй, алдагдалтай ажиллаж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг хувьчлах, менежментэд нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдыг татан оролцуулна;

7. Нийслэлийн хөгжлийн хэтийн төлөв, хотжилт, хот байгуулалт, хүн ам, хүрээлэн байгаа орчин, хотын эдийн засгийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд тулгамдаж байгаа асуудлыг судлах чиг үүрэгтэй судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнг байгуулах онцлог зохицуулалтууд орсон болно.

Мөн нийслэлийн зүгээс үзүүлэх төрийн үйлчилгээний цахим шилжилтийн талаар оролцогчдод товч, танилцуулбал:

Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, Засгийн газрын 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх замаар эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэг болгох зорилт тавьж, “Цахим үндэстэн” болох уриалгыг дэвшүүлсэн. Төрийн үйлчилгээ цахимжнаар нийгэм, эдийн засгийн бүх салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологи, инновацыг нэвтрүүлж, хүнд сурталгүй, ил тод цахим засаглал бий болох юм.

Тухайлбал, газрын харилцааг цахимд шилжүүлсэн egazar.gov.mn сайт болон Egazar гар утасны аппликэйшн, нийслэлд худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжүүд болон төрийн байгууллагуудын хариуцлага, хамтын ажиллагаа, хяналтыг сайжруулах нэгдсэн мэдээллийн business.ulaanbaatar.mn систем, нийслэлийн цахим үйлчилгээний eservice.ulaanbaatar.mn тэргүүтэй системүүдийг онцлон танилцуулав.

Хуульд зааснаас бусад нийслэлийн нутаг дэвсгэрт мөрдөгдөж байгаа бүх төрлийн зөвшөөрлийг хүчингүй болгоно;

Төрийн үйлчилгээнд хүнд суртал, шат дамжлага бий болгож буй захиргааны болон захиргааны хэм хэмжээний актыг өөрчилнө;

Хуулиар тусгай зөвшөөрөл авахыг шаардсанаас бусад бүх төрлийн аж

ахуйн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандарт, шаардлагад нийцүүлэн, зөвхөн татварын албанд бүртгүүлсний үндсэн дээр нийслэлийн нутаг дэвсгэрт чөлөөтэй эрхлэх нөхцөл, боломжийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн бүрдүүлнэ;

Хуульд зааснаас бусад тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх, батламж /гэрээ/, гэрчилгээ, тодорхойлолт, дүгнэлт, үнэмлэх, санал, бусад баримт бичиг иргэд, аж ахуйн нэгжээс шаардахыг Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд болон Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба, харьяа байгууллага, дүүргийн Засаг даргын Тамгын газар, бусад нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан хаагчдад хориглоно;

Хуульд заасан тусгай зөвшөөрөл, эрхийг холбогдох хууль, журамд заасан хугацаагаар олгодог болно;

Төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хууль, журамд заасан хугацааг чанд баримтлах, шаардлагагүй тохиолдолд уг хугацааг сунгахгүй байх, сунгах тохиолдолд хууль, журамд заасан хугацааг хэтрүүлэхгүй байх зэрэг зохицуулалтыг хэрэгжүүлэх юм.

“Цаашид нийслэлийн зүгээс авлига, хүнд суртлыг бууруулах үйл ажиллагааны бие даасан төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг иргэд, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах саналтай байгаагаар илэрхийлье”.

Анхаарал хандуулсанд баярлалаа.



ЦАХИМ ШИЛЖИЛТ БА АВЛИГА

*Харилцаа холбоо, мэдээллийн
технологийн газрын дарга
Б.Болор-Эрдэнэ*

*Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ
өдрийн мэндийг хүргэе.*

Цахим засаглал болоод авлигын асуудал нь харилцан уялдаа холбоотой, хамт явдаг том асуудлуудын нэг юм. Олон улсад бүх төрлийн индексийг харахад цахим засаглалын индексээр авлига буурсан уу, авлигын индекс дээр төрийн үйлчилгээ цахимжсан уу гэсэн асуудал яригддаг.

Монгол Улс 2020 оны онлайн үйлчилгээний индексээр дэлхийн 193 орноос 92 дугаарт бичигджээ.

“e-Mongolia” төслийн хувьд бол 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр нээгдэж байлаа. Цахим засаглалын хөгжлийн индекс, цахим оролцооны индекс, хүмүүн капиталын индекс, онлайн үйлчилгээний индекс, харилцаа холбооны дэд бүтцийн индекс зэрэг тоон үзүүлэлтийг жил бүрийн 1 дүгээр сард гаргадаг. Монгол Улсын хувьд онлайн үйлчилгээний индексээр дэлхийд дундаж; харилцаа холбооны дэд бүтцийн индексээр дэлхийд өндөр буюу хангалттай сайн гэсэн үнэлгээтэй байна.

Монгол Улсын 330 сумаас 324 сум шилэн кабелиар холбогдож, интернетэд орсон байна. Барууны эрдэмтдийн судалгаанаас харвал авлигын индекс болоод цахим засаглалын индекс дандаа хамт явдаг. Тухайлбал Европын улсуудад хийсэн судалгаанаас харахад нэг хувийн цахимжуулалт сайжрахад 6.3 хувийн авлига буурдаг гэсэн судалгаа гарсан байна.

Монгол Улсын хувьд энэ индексүүд дараа жилүүдэд нэмэгдээд байр урагшлаад явах болов уу гэсэн итгэл найдвартай байгаа.

Эстони улс цахим засаглалын индексээр хамгийн өндөр, амжилттай явж байгаа улсуудын нэг. Эстони улсын хувьд цахим засаглалын индексээр 2020 онд 3 дугаар байрт, авлигын индексээр 17 дугаар байрт ордог. Дараагийн

хөгжиж байгаа улсуудад Казахстан улс нэлээн сүүлд цахим засаглал хөгжүүлж эхэлсэн гэхэд цахим засаглалын индексээр 29, авлигын индексээр 94-т орж, өмнөх жилүүдээс ахижээ. Гүрж улсын хувьд цахим засаглалын индексээр 65, авлигын индексээр 45-д орсон статистик харагдаж байна.

Монгол Улсын хувьд сүүлийн жилүүдэд цахим засаглалыг нэлээн эрчимтэй хөгжүүлж байна. Төрийн албаны зөвлөл, Үндэсний аудитын газар зэрэг байгууллагуудэнэ ажил дээр төвлөрч, дэмжин ажиллаж байгаа билээ.

Монгол Улсын хувьд Засгийн газрын 2018 оны “Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 259 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх эхлэл тавигдсан. Засгийн газрын 2020 оны “Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн талаар авах арга хэмжээний тухай” 90 дүгээр тогтоолоор “e-Mongolia”-д гол үүрэг өгсөн.

Өнөөдөр “e-Mongolia” нь 1.9 сая хэрэглэгчтэй Монгол Улсын үндэсний том платформ болжээ. 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдөр “e-Mongolia” version төв хувилбар two буюу хоёрдугаар хувилбарыг зарлаад байна. Энэ хувилбар дээр “my profile” буюу цахим үнэмлэх, зээлийн мэдээлэл, хувьцааны мэдээлэл, бүртгэлтэй компанийн мэдээлэл, бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгийн мэдээллийг нэмж, хэрэглээнд нэвтрүүлээ. Иргэдээс өөрсдийнх нь мэдээлэл буруу алдаатай, ташаа орсон гэх мэт гомдол, санал ирсэн байгаа юм. Ардчилсан нийгмийн гол зарчмын нэг болох иргэд төрд өөрийнх нь ямар мэдээлэл байгааг харах, хянах эрхийг “my profile” гэдэг функцээр нээж өгсөн хэрэг юм. Одоогийн байдлаар 57 байгууллагын 571 үйлчилгээг нэвтрүүлээд байна.

Амжилттай болсон үйлчилгээний тоо өнөөдөр 6 сая гаруй болсон. Нийт хэрэглэгчдийн хувьд вэб-ээр аппликейшн хэрэглэж байгаа. Ихэнх хэрэглэгчид, ялангуяа залуучуудын хувьд аппликейшн хэрэглэх хандлага өндөр байдаг. Мэдээж эрэлттэй үйлчилгээний хувьд вакцины гэрчилгээ байна. Нэг шатлалт үйлчилгээ, хоёр шатлалт үйлчилгээ, олон шатлалт үйлчилгээ гэж байдаг. Нэг шатлалт үйлчилгээ нь та бидний мэдэж байгаа лавлагаа тодорхойлолтууд байдаг. Үүнийг олон улсад үйлчилгээ гэж үздэггүй, лавлагаа бичгийг нь л гаргаж өгч байна гэсэн үг олголттой байдаг. Тийм учраас илүү хоёр шатлалтай, олон шатлалтай үйлчилгээнүүд, ялангуяа лиценз олгох ямар нэгэн эрх олгох энэ үйлчилгээнүүдийг цахимжуулхад түлхүү анхаарсаар ирсэн байгаа.

E-Mongolia хоёр дээр компани байгуулах үйлчилгээнүүд орсон. Иргэний үнэмлэх, гадаад паспорт захиалах, жолооны үнэмлэх захиалах үйлчилгээнүүд орсон байгаа. Төрийн албан хаагч таны системрүү нэвтрэх ямар ч боломжгүй. Заавал хувь хүн өөрийнхөө логиноор өөрийнхөө бүртгэлээр орох ийм л боломжтой болсон.

Ямар нэгэн байдлаар төрийн албан хаагч таны мэдээлэл рүү нэвтэрсэн бол нийтийн мэдээллийн хууль, хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, бусад хуулиудаар тухайн иргэнд мэдэгддэг ийм тогтолцоог хийж байгаа. Технологийн хөгжүүлэлтийг хийгээд дууссан.

Мөн эрүүл мэндийн үйлчилгээнүүд орж байгаа. Улсын эмнэлгүүд дээр цаг авах, шинжилгээний хариу авах үйлчилгээнүүдийг орон даяар нэвтрүүлж байна. Эрүүл мэндийн салбарт иргэдээс гомдол, хүсэлт, ялангуяа авлигатай холбоотой гомдлууд их ирдэг газруудын тоонд ордог.

Авлигалын индексийг бууруулах, мөн цахим засаглал, төрийн хүнд суртлыг бууруулах үндэсний хороо гэсэн хоёр ажлын хэсэг болон ажиллаж байна. 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс эхлээд авлигын гомдлыг 1111 дугаар утсаар авдаг болсон. Өнөөдрийн байдлаар авлига, албан тушаалтай холбоотой 21 гомдол ирж, Авлигатай тэмцэх газарт шалгагдаж байна. Хүнд сурталтай холбоотой нийт 1252 гомдол ирсэн. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээ, дүүргийн Газрын алба, алба хаагчдын ур чадвар, ажилдаа хайнга байгаатай холбоотой гомдлууд түлхүү ирснийг тухай бүр шийдвэрлэдэг.

Ажлын хэсгийн хүрээнд 3 дахь өдөр бүр Засгийн газрын хуралдаанд энэ гомдлуудыг танилцуулаад шаардлагатай арга хэмжээнүүдийг авдаг.

Цахим засаглалыг бүртгүүлснээр, үйлчилгээгээ цахим болгосноор хүртээмж өрсөлдөх чадвар маш хурдан нэмэгдэх боломжтой. Ялангуяа Ковид-19 цар тахлын үед e-Mongolia-оор үйлчилгээгээ авч Монгол шуудангаар хүргүүлээд авах боломжтой. Ингэснээр хэрэглэгчид маш их нэмэгдсэн. Нөгөө талаас, төрийн дотоод процесс маш амар болсон. Хяналт хариуцлага ч нэлээд нэмэгдэж байгаа. Олон төрлийн мэдээллийг нээлттэй болгож өгч байгаа. Нийтийн мэдээллийн хуулиар 67 төрлийн мэдээллийг нээлттэй болгохоор зааж оруулсан байгаа. Үүнд төсвийн хяналт байна. Одоогийн байдлаар e-Mongolia нийтдээ 4.8 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 52.8 тэрбум төгрөгийн зардлыг иргэдээс ирүүлсэн, ийм судалгааг хөндлөнгийн судлаачид гаргаж өгсөн. 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр салбарын судалгаануудыг танилцуулахдаа илүү дэлгэрэнгүй аргачлалуудыг та бүхэнд танилцуулах болно. Ил тод байдал, чанар, хүртээмжийг сайжруулж байгаа. Статистик судалгаагаар цахим хэлбэрээр авах боломжтой олон шатлалт үйлчилгээний тоо нийтдээ 32 байгууллагын 463 үйлчилгээ оруулсан.

e-Mongolia үйлчилгээгээр өдөрт 1200-1500 санал хүсэлт, мэссэжүүд ирдэг. Энэ санал хүсэлтэд тулгуурлаж дараагийн ямар үйлчилгээг цахимжуулах вэ гэдгийг шийддэг. e-Mongolia бол зөвхөн Монгол Улсын Засгийн газраас хийж

байгаа платформ биш иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээлэл, иргэд хамтарч бүтээж байгаа платформ юм.

Дараагийн цахим засаглалын гол асуудал бол тоон бичиг үсгийн чадвар буюу цахим ур чадварын асуудал. Ахмадууд, зорилтот зарим бүлгүүд ухаалаг утас хэрэглэхэд хүндрэлтэй байгаа. Тийм учраас e-Mongolia багийн зүгээс Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын хамт олон бүгдээрээ өнгөрсөн зуны 3 сар захын дүүргүүдээр ажилласан. Захын дүүргүүдээр ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрч очиж өөрсдийнх нь гар утсан дээр төрийн үйлчилгээг хэрхэн авах талаар зааж өгсөн. Энэ бол ямар нэгэн видео контент гаргаснаас илүү үр дүнтэй ажил болсон. e-Mongolia-ын баг хөдөө орон нутагт сургалтууд хийж явсан, одоогийн байдлаар нийт 8 аймагт e-Mongolia-ын үйлчилгээг оруулаад байна. Мөн e-Mongolia дээр мэдээллийн аюулгүй байдлын асуудлыг нилээн анхаарч байгаа. Сар бүр e-Mongolia эрсдэлийн үнэлгээ хийдгээс гадна мэдээллийн аюулгүй байдалд дүн шинжилгээ хийлгэдэг. Иргэдээс гомдол ирүүлж байгаа үйлчилгээг цахимжуулна. Хиймэл оюун ухааны туршилтуудыг хийгээд амжилттай болж байна. Хүн, хэн нэгэнд зориулсан үйлчилгээнүүдийг санал болгож байгаа. Шинээр гэр бүл болсон, компани байгуулсан иргэдэд тэр ажилтай нь холбоотой тухайн иргэний амьдралын явцад онцлогтой нь холбоотойгоор үйлчилгээнүүдийг систем өөрөө санал болгоно. Цаашаа гадаад паспорт хугацаа нь дуусаад сунгах уу, жолооны үнэмлэх хугацаа нь дууслаа та сунгах уу гэх мэтчилэн иргэн төрлүү хандах биш, e-Mongolia платформ иргэн рүү ханддаг ийм байдлаар ажиллахаар, ийм үйлчилгээг нэвтрүүлэхээр зорж ажиллаж байна. Мөн авлигын гэмт хэргийн тухай санал гомдлыг илүү амар, хурдтай авч шийддэг функцүүдыг нэмнэ. Цаашдаа Нийтийн мэдээллийн хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах хууль, Цахим гарын үсгийн хууль, Кибер аюулгүй байдлын хуулиудаар төрийн үйлчилгээг сайжруулах заалтууд орсон байгаа учир энэ хуулиуд хэрэгжүүлэх ажлын хүрээнд ажиллаж, үйл ажиллагаа улам сайжирна.



МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ЗАРЦУУЛАЛТАД ИРГЭНИЙ НИЙГМИЙН ЗҮГЭЭС ТАВИХ ХЯНАЛТ, АНХААРАХ АСУУДАЛ

*“Нээлттэй нийгэм форум” ТББ-ын
Засаглалын менежер Д.Оюунбадам*

Авлигын төсөөллийн индексийг гаргахдаа хэд хэдэн судалгааг ашигласан байгаа.

Эдгээрээс төсөв, санхүү, авлигатай холбоотой гурван судалгаанаас харахад нийтийн санхүү, төсвийн ил тод байдал, удирдлага, хариуцлагын чиглэлээр манай улс ахиц гаргах шаардлагатай байна гэж харагдаж байна. Дэлхийн банкны Улс орны бодлого, институцийн үнэлгээ (WB Country Policy & Institutional Assessment 2019), Эдийн засгийн мэдээллийн нэгжийн Улс орнуудын эрсдэлийн үнэлгээ (Economist Intelligence Unit Country Risk Service 2020), Дэлхийн эдийн засгийн форумын Бизнесийн удирдах ажилтнуудын үзэл бодлын судалгааны 2020 оны дүн дэх авлигын холбогдох үзүүлэлтүүдийн үнэлгээгээр Монгол Улс авбал зохих 100 онооноос дөнгөж 28-37 авчээ.

Нийтийн санхүү, төсвийн ил тод байдал, зарцуулалтад иргэний нийгмийн зүгээс хяналт, оролцоог хэд хэдэн чиглэлээр хэрэгжүүлж байна. Тухайлбал:

Судалгаа, шинжилгээ хийх, санал, зөвлөмж боловсруулах

- Төсвийн зарлага, хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлтөд дүн шинжилгээ хийн дүгнэлт, зөвлөмж гаргах;
- Төсвийн холбогдох хууль, тогтоомжийг УИХ-аар хэлэлцэх явцад тэдгээрт анхаарах асуудлуудыг хөндөн, санал боловсруулан хүргүүлэх;
- Олон улсын төсвийн түншлэл (www.internationalbudget.org)-ийн “Төсвийн нээлттэй байдал” олон улсын судалгааны Монгол Улсын үнэлгээг хоёр жил тутамд хийх, дүнг нийтэд хүргэх;
- Төрийн санхүү, төсөвт тавих хяналтыг сайжруулах, олон нийтэд олон талт, бодитой мэдээллийг хүргэх замаар төрийн бодлогын шийдвэрт иргэдийн оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Нээлттэй нийгэм форумын дэргэд “Төсвийн Зөвлөл”-ийг байгуулан ажиллаж байна.

Зөвлөл энэ онд байгуулагдсан ба хараат бус судлаач, шинжээчдээс бүрдэн, төсөв санхүүтэй холбоотой цаг үеийн асуудал, хууль эрх зүйн баримт бичгүүдийн төслүүдийг хэлэлцэн дүн шинжилгээ гаргах, саналаа Улсын Их Хуралд хүргүүлэх зэрэг ажлыг хийж эхлээд байна.

Хяналт, мониторинг хэрэгжүүлэх, иргэдийн оролцоог дэмжих


- Шилэн дансны болон Төсвийн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, зарцуулалтад хяналт тавих (Тухайлбал, Шилэн дансны хуулийг хэрэгжиж эхэлсэн анхны өдрөөс нь иргэний нийгмийн байгууллагууд нэгдсэн зохион байгуулалтын дор орон даяар нэгдсэн мониторинг хийж, дүн мэдээг тогтмол нийтэд хүргэн ажилласан нь энэ хуулийн хэрэгжилтийг хангахад чухал түлхэц болсон юм. Үндэсний аудитын газраас хийсэн 2020 онд хийсэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар Шилэн дансны тухай хуульд заасны дагуу төсвийн удирдлагыг хэрэгжүүлсэн шийдвэр, үйл ажиллагааны ил тод байдлыг улсын төсвийн ТЕЗ-д болон тэдгээрт хамаарах байгууллагууд 91.5 хувь, аймаг, нийслэлийн төсвийн ТЕЗ-д болон тэдгээрт хамаарах байгууллагууд 87.9 хувь хэрэгжүүлж ажилласан байна).
- Шилэн дансанд ил болсон төсвийн мэдээллийг нийтэд хүргэх замаар төсөвт иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх
- Өгөгдлийн шинжилгээ хийх
- Иргэдийн оролцооны шинэ механизм болох “Төсвийн хяналтын сонголт”-ыг орон нутагт тогтмолжуулах (Орон нутгийн ИТХуралтай хамтрах) зэрэг болно.

Төрийн хяналтын болон бусад байгууллагатай хамтын ажиллагаа өрнүүлэх

- Төрийн аудитын байгууллагатай хамтран ажиллах (Төрийн бус байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн аудит оролцсон. Мөн Үндэсний аудитын газраас хийсэн аудитын үр дүнг нийтэд хүргэхэд хамтран ажиллаж байна)
- Нээлттэй засаглалын түншлэлийн үндэсний төлөвлөгөөг боловсруулахад оролцох, Сангийн яамтай хамтран ажиллах гэх мэт.

Монгол Улсын төсвийн ил тод байдал, хариуцлага, иргэд төсвийн үйл явцад оролцох боломжийг өнөөгийн түвшнээс дээшлүүлэх хэрэгтэй байна. Үүнийг харуулах зарим жишээ дурдъя. Олон Улсын төсвийн түншлэл байгууллагатай хамтарч хийгддэг Төсвийн нээлттэй байдлын индексийн олон улсын судалгаанаас харахад манай улсын төсвийн ил тод байдалд ахиц гарч байна. 100 оноо авахаас 2017 онд 46 оноо, 2019 онд 56 оноо авсан. Гэхдээ бас үүнийг


сайжруулах хэрэгтэй байна.



Манай улсад төсвийн үйл явцад иргэдийг оролцуулж байгаа байдал дээр нэн хангалтгүй (100 оноо авахаас 15 авсан) байна. Судалгааны дүн дэлхий даяар танилцуулагддаг ба Монгол Улсын дүнг бид Засгийн газар, Сангийн яаманд хүргүүлж ажилладаг. Сангийн яам энэхүү судалгааны дүгнэлт, зөвлөмжид анхаарал хандуулж иргэдийн төсвийг тогтмол хэвлэдэг болж байна. Мөн хагас жилийн тойм тайланг гаргаж эхэлж буй зэрэг ахиц гарч байна.


Төсвийн хариуцлагын тал дээр нэлээн анхаарах асуудал байгаа нь иргэний нийгмийн зүгээс хийж байгаа судалгаагаар харагдаж байгаа. Жишээлбэл, 2022 оны төсвийн төсөлд маш олон жилээр үргэлжилсэн буюу 2010-2014 онд эхэлсэн нийт 26 барилга байгууламж туссан. Тэдгээрийнх нь төсөвт өртөг нь ихээхэн нэмэгдсэн байна. Эдгээрийг харахад эхнээсээ төлөвлөлтийн шатанд зарим төслийн эхний санхүүжилтийг нь хэт багаар төлөвлөсөн, зарим төслийн санхүүжилт нь хуулийн дагуу батлагдсан ч хэрэгжилт нь удааширсан байна.

Дуусаагүй зарим барилгын үнийн өсөлт (тэрбум төгрөгөөр)



Эх сурвалж: Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн төслийн баримт бичгүүд

2022 оны төсөв: Нийт төсөвт өртөгт эзлэх
эхний санхүүжилт багатай төслүүдийн тоо



Гэтэл 2022 оны төсвийн төсөлд шинэ төслүүдийн эхний санхүүжилтийг хуулийн шаардлагад нийцүүлэхгүйгээр хэт багаар төлөвлөх асуудлууд гарсаар байна. Энэ нь өөрөө он дамжсан удааширсан барилгын бий болгон төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах сөрөг үр дагавар авчирч байна. Төрийн аудитын байгууллагын аудитаар төсвийн нэлээн их зөрчлүүд илэрч байгаа. Иймд төрийн аудитын дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллах хэрэгтэй гэж үзэн иргэний нийгмийн байгууллагын зүгээс аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн мэдээллийг нийтэд хүргэн ажиллаж байна.

Нийтийн төсөв, санхүүгийн ил тод байдал, иргэдийн оролцоо, хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай байгаа тул иргэний нийгмийн зүгээс хийсэн судалгаа, ажиглалтаас гарч байгаа зарим зөвлөмжөөс танилцуулъя.

Бид хамгийн түрүүнд төсвийн хариуцлагыг ярихын тулд төлөвлөлтийн шатнаас эхлэх ёстой. Тэгэхээр төсвийн төлөвлөлтийн баримт бичигт тавигдаж байгаа агуулгын шаардлагыг сайжруулах хэрэгтэй байна. Тухайлбал, хөрөнгө оруулалтын төсвийн төлөвлөлтийн хувьд ЗГ-аас УИХ-д өргөн барьж буй хөрөнгө оруулалтын жагсаалтад шинээр хэрэгжиж эхлэх төслүүдийн эхний санхүүжилтийг нь хуулийн дагуу тусгасан уу, эсвэл олон жил үргэлжилж байгаа төслүүдийн төсөвт өртөг нь хир зэрэг нэмэгдсэн бэ, өөрчлөгдсөн үү гэснийг шууд харуулахгүйгээр ямар ч харьцуулсан агуулгагүй мэдээлэл багтаж байна. Тэгэхээр энэ мэдээллүүдийг жишээлбэл шинээр эхлэх барилгын тухайд гэхэд тухайн барилгын нийт төсөвт өртгийнх нь хэдэн хувийг энэ онд санхүүжүүлж байгаа, шилжих төслүүдийн хувьд анхны төсөвт өртөг нь хэд байсан, энэ санхүүгийн жилд хэд болсон гэдгийг нь төсвийн хөрөнгө оруулалтын одоогийн маягтад нэмж оруулах хэрэгтэй байна. Ингэснээр олон нийт, иргэний нийгэм, хууль тогтоогчдод илүү ач холбогдолтой мэдээлэл өгч, УИХ бүрэн мэдээлэлтэй шийдвэр гаргахад ач холбогдолтой юм.

Мөн төсвийн хөрөнгө оруулалтын бүртгэлийг боловсронгуй болгох хэрэгтэй байна. Төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар хөрөнгө оруулалтын жагсаалт батлагдаж байгаа. Үүнд төслүүд нь хуулийн дугаараар батлагддаг байгаа. Гэтэл батлагдсан төсөл маань хоёр, гурван жил үргэлжлэхэд дараа жилдээ түүний анх батлагдахдаа авсан хуулийн дугаар нь өөрчлөгдөөд явдаг. Тэгэхээр төслүүддээ дахин давтагдахгүй код олгох хэрэгтэй байна. Бид албан бичиг бүртгэхдээ хүртэл дугаар олгодог. Үүн шиг төслүүдийг дахин давтагдахгүй кодтой болгоод төслийн туршдаа тэр код нь өөрчлөгдөхгүй байвал энэ төслийн хэрэгжилтийг хянахад илүү дөхөмтэй болох юм. Энэ кодоо хөрөнгө оруулалтын төслийн маягтад мөн тусгах хэрэгтэй байна. Тэрчлэн төсвийн тодотгол хийгдэх тохиолдолд УИХ-д өргөн баригдах төсөлд туссан хөрөнгө оруулалтын төслүүдийн хувьд худалдан авах ажиллагаа хийгдсэн эсэх, тодотголоор нэмэгдсэн болон хасагдсан төслүүдийн жагсаалт, тухайн онд санхүүжих дүн өөрчлөгдсөн эсэх мэдээллийг маягтад мөн тусгадаг байхаар тусгайлсан маягт боловсруулах нь зүйтэй байна.

Цаашилбал, улсын төсвийн төслийн баримт бичгийн болон батлагдсан төсвийн мэдээллийн иж бүрэн байдлыг сайжруулах шаардлагатай байна. Төсвийн нээлттэй байдлын судалгаагаар авбал зохих 100 онооноос төсвийн төслийн агуулгын иж бүрдэл 59, батлагдсан төсөв 33 авсан байна.

Монгол Улсын төсвийн зарим баримт бичгийн агуулгын иж бүрэн байдал (авбал зохих 100 онооноос)

Төсвийн баримт бичиг	Баримт бичгийн агуулгын оноо
Засгийн газрын төсвийн төсөл	59
Батлагдсан төсөв	33

Эх сурвалж: "Төсвийн нээлттэй байдал-2019" судалгааны дүнгээс

Улсын төсвийн төслийн баримт бичгийн мэдээллийн иж бүрэн байдлыг сайжруулахын тулд дараах мэдээллийг Төсвийн тухай хуулийн 32.2-т нэмж тусгах нь зүйтэй байна:

- Зарлагын тооцооллыг төсвийн жилээс цааш хамгийн багадаа хоёр жилээр, төсвийн аль нэг ангиллаар (эдийн засгийн, төсвийн захирагчаар, зориулалтаар, хөтөлбөрөөр);

- Орлогын тооцооллыг төсвийн жилээс цааш хамгийн багадаа хоёр жилээр, ангиллаар (татварын болон татварын бус гэх зэрэг);
- Төсвийн тооцооллыг хийхдээ суурилсан хүүгийн түвшний мэдээлэл;
- Макро эдийн засгийн янз бүрийн төсөөлөл нь төсөвт үзүүлэх нөлөөлөл(өөрөөр хэлбэл, мэдрэмжийн шинжилгээ)-ийн мэдээлэл;
- Төсвийн жилийн өмнөх жилийн зарлагыг зориулалтаар ангилсан байдлаар;
- Засгийн газрын бодлогуудын санхүүгийн нөлөө хүн амын янз бүрийн бүлэгт ямар байхыг харуулсан зардлын хувилбарууд (хүйсээр, насаар, орлогын түвшнээр эсхүл бүс нутгаар гэх мэтээр);
- Засгийн газрын цаашдын өр төлбөр болон түүний санхүүгийн тогтвортой байдлыг урт хугацаанд үнэлсэн тооцоолол.

Мөн батлагдсан төсвийн мэдээллийн дэлгэрэнгүй байдлыг сайжруулах хэрэгтэй байна. Батлагдсан төсөвт зөвхөн төсөв захирагчаар батлагдсан төсөв нийтэд ил болж байгаа. Харин төсвийн төсөлд бол зарлагыг зориулалтаар, эдийн засгийн ангиллаар гээд олон ангиллаар оруулж байгаа. Тэгэхээр батлагдсан төсвийн орлого, зарлагыг аль нэг ангиллаар нь нэмж гаргадаг болбол илүү хэрэгжилтийг нь хянаад явахад дөхөмтэй гэж үзэж байна. Иймд УИХ-аас баталсан төсвийн баримт бичгийн мэдээллийн иж бүрэн байдлыг сайжруулахын тулд дараах мэдээллийг Төсвийн тухай хуулийн 33.2-т нэмж тусгах нь зүйтэй байна:

- Зарлагыг эдийн засгийн ангиллаар, зориулалтаар болон хөтөлбөрөөр ангилсан байдлаар;
- Орлогыг эх үүсвэрээр ангилсан байдлаар (татварын болон татварын бус гэх мэт).

Цаашилбал, төсвийн ил тод байдал, иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх чиглэлээр Сангийн яам, Үндэсний аудитын газар, УИХ-ын зүгээс тодорхой арга хэмжээнүүд авах хэрэгтэй байна. Тухайлбал, Сангийн яамны зүгээс дараах арга хэмжээг авах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- Шилэн дансны shilendans.gov.mn нэгдсэн системийг нээлттэй өгөгдлийн зарчмаар шинэчлэх (Шилэн дансны цахим платформд төсвийн тоон мэдээллүүд pdf файлаар нийтлэгдсэн байгаа нь олон нийт, судлаачид авч хэрэглэхэд маш хүндрэлтэй байна. Иймд төсвийн тоон мэдээллийг Excel файлаар нийтэлж, Үндэсний статистикийн хорооны 1212.mn шиг мэдээллийг татаж авах, мэдээллийг хайх боломжтой систем болгох хэрэгтэй юм);

- Улсын төсвийн үйл явц, хөрөнгө оруулалт, зарцуулалт тусгай сангууд, гадаадын зээл тусламжийн зарцуулалтын талаар иргэд, олон нийт, татвар төлөгчид жилийн турш саналаа өгч хэлэлцүүлэг өрнүүлж байх цахим талбарыг бий болгох;
- Төсөв боловсруулах үе шатанд олон нийтийн оролцоог хангах аргуудыг туршилтын журмаар нэвтрүүлж эхлэх (Өнөөдрийн байдлаар Монгол Улсад зөвхөн Орон нутгийн хөгжлийн сангийн төслүүдэд иргэдээс санал авч байгаа. Гэхдээ энэ сангийн төсөв нь нэгдсэн төсвийн маш өчүүхэн хэсэг учраас улсын төсвийн гол гол хөрөнгө оруулалт дээр ч гэсэн санал авдаг болох шаардлагатай байна);
- Эмзэг болон төлөөлөл багатай бүлгийг шууд, эсвэл тэдгээрийг төлөөлдөг иргэний нийгмийн байгууллагуудаар дамжуулан төсвийн хэлэлцүүлэгт идэвхтэй татан оролцуулах;
- Жилийн эцсийн тайланд төсвийн тооцоололтой харьцуулахад үр дүнгийн гүйцэтгэл болон өрийн бүтэц ямар байгаа талаарх дэлгэрэнгүй мэдээллийг оруулах;
- Төсвийн хөрөнгө оруулалтын publicinvestment.gov.mn сайт дах хайлтын системийг сайжруулах (Тухайн хайлтын системд жишээлбэл хэдэн онд эхэлсэн гэдгээр нь төслийг хайх боломжгүй, харин төсөв захирагч, эсвэл объектоор нь хайх сонголтууд л одоогоор байна).

Олон улсын судалгаанаас харахад парламент нь төсөв батлахаасаа өмнөх хэлэлцүүлэгт олон нийт, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулж, сонголт хийдэг сайн туршлага байна. Иймд УИХ-ын хувьд төсвийг батлахаасаа өмнөх хэлэлцүүлэгт олон нийт, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулж, сонголт хийж байх хэрэгтэй байна. Мөн төсвийн аудитын тайлангийн хэлэлцүүлгийн сонголт зохион байгуулах нь зүйтэй талаар олон улсын судалгаанаас зөвлөмж гарсныг хэрэгжүүлэх чиглэлээр арга хэмжээ авах хэрэгтэй юм.

Үндэсний аудитын газар(ҮАГ)-ын хувьд холбогдох аудитынхаа шалгалтад иргэд, иргэний нийгмийг оролцуулах албан ёсны механизмыг бий болгох нь зүйтэй байна. Төсөв, санхүүгийн холбогдолтой саналуудыг хүлээн авах албан ёсны механизмыг бүрдүүлэх нь төсвийн хариуцлагыг дээшлүүлэхэд чухал юм. Учир нь Засгийн газрын 11-11.mn сайтад өгсөн иргэдийн санал, гомдол нийтэд ил харагддаг, зарим хүний санал, гомдол регистрийн дугаар гэх мэт хувь хүний мэдээлэлтэйгээ ил байдаг. Үүнээс болж энэ сайт руу төсвийн хариуцлага болон болон авлигын холбогдолтой мэдээллийг иргэд мэдээлэх явдал түгээмэл бус байх магадлалтай юм. Иймд санал, гомдол гаргагч хувь хүний мэдээллийн нууцлалыг сайжруулах хэрэгтэй байгаа юм. Түүнчлэн ҮАГ нь иргэдээс аудитын

төлөвлөгөөнд авсан саналаа хэрхэн ашигласан талаарх тайлан гаргах хэрэгтэй байна. Учир нь ийм тайлан гаргах нь иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд мөн ач холбогдолтой гэж үздэг юм.

Нийтийн төсөв, санхүүгийн ил тод, хариуцлагатай байдал, иргэдийн оролцоог дээшлүүлэх чиглэлээрх эдгээр асуудлыг шийдвэрлэх нь төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, авлигыг бууруулахад хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.





ОЛОН УЛСЫН ХАНДИВ, ТУСЛАМЖИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

*Дэлхийн банкны
Улсын салбарын ахлах зөвлөх
Д.Бадамчимэг*

бүхэнд өдрийн мэнд хүргэе. Миний хувьд өнөөдөр олон улсын хандив тусламжийн үр өгөөжийг сайжруулах талаар цөөн хэдэн зүйлийг та бүхэнтэй ярилцъя.

Хандив тусламжийн хувьд нэг талаас, хөгжлийн түнш байгууллагууд, нөгөө талаас, Засгийн газар хамтарч ажиллаж байгаа ба үр ашгийг нь сайжруулах асуудал дээр түншлэгч байгууллагуудын зүгээс хяналтын болоод зохицуулалтын тодорхой механизмуудыг мөрдөж ажилладаг. Энэ нь тухайн хандив, тусламж зорьсон зорилго, хүрэх эзэн, хүлээсэн үр дүндээ хүрч чадаж байгаа эсэхийг баталгаажуулах механизм юм. Үүнд хамгийн түрүүнд санхүүгийн удирдлагын болон худалдан авах ажиллагааны асуудлууд багтана. Дэлхийн банк болон олон улсын бусад байгууллагууд. Тухайлбал, Азийн хөгжлийн банк зэрэг томоохон байгууллагууд энэ бүх мэдээллийг цахим болгосон байдаг. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнүүд төсөл бүрт нээлттэй, ил тод байх туршлага түгээмэл. Мөн тухайн хэрэгжүүлж буй төслийн явцын болон эцсийн үр дүн ямар байгаад тухайн хандивлагч байгууллагууд өөрсдөө дотоод хяналт шалгалтыг хийж гүйцэтгэдэг. Дотоод хяналт шалгалтаас гадна тухайн төслийн хэрэгжилтийн явцад аливаа авлига, хээл хахуулийн асуудал гарвал шууд төв байгууллага руу гомдол, мэдээлэл хүлээн авдаг механизм олон нийтэд ил тод байдаг. Дээрх хяналт шалгалтуудыг хэрэгжүүлсэн хөгжлийн түншлэгч байгууллагууд төсөл, хөтөлбөрөө үр дүнтэй явуулах чиглэлээр анхаарч ажилладаг.

Нөгөө талаас, Засгийн газар, олон улсын хандив тусламжийг захиран зарцуулан эрх бүхий Сангийн яам тодорхой дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Цахим шилжилтийн реформтой уялдуулаад Сангийн яам

гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн систем (www.odamis.mof.gov.mn)-ийг өнгөрсөн жилийн 12 дугаар сараас эхлэн жил орчмын хугацаанд ашиглаж байна. Засгийн газар гадаад зээл, тусламжийн үйл ажиллагааг нэгдсэн системд бүртгэж авах, хэрэгжилттэй холбоотой явцын хяналт шалгалтыг цахимжуулах, боломжтой бол татварын зарим хөнгөлөлт, чөлөөлөлтийг системээрээ дамжуулан хийх болон төсвийн зарим урсгал зардлыг танах зэрэг зохицуулалтыг системд нэвтрүүлэн ажиллаж байна.

Ийнхүү хандив тусламжийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр нэг талаас, хөгжлийн байгууллагууд, нөгөө талаас, Засгийн газар хамтын ажиллаж байгаагийн зэрэгцээ түншлэгч байгууллагуудын хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаа (donor coordination) чухал ач холбогдолтой. Энэ чиглэлд Засгийн газраас түншлэгч байгууллагуудын хурлуудыг зохион байгуулах, мөн тодорхой салбарын хүрээнд түншлэгч байгууллагуудын үйл ажиллагааг салбарын стратегийн бодлогын хувьд зангидах зэрэг оролдлогуудыг хийж байна. Тухайлбал, миний бие Дэлхийн банкинд төрийн санхүүгийн удирдлагын тогтолцооны шинэчлэлийн чиглэлээр ажилладаг. Энэ хүрээнд Сангийн яаманд Төрийн төсөв, санхүүгийн шинэчлэлийн стратеги гэж стратегийн баримт бичиг дээр нийт хандивлагч, түнш байгууллагууд маань хамтарч, хэрхэн уялдаж ажиллах талаар удирдлага зохион байгуулалтыг хийж байгаа туршлага байна.

Өнөөдрийн төрийн албаны шударга, ил тод байдлыг бэхжүүлэх энэхүү хэлэлцүүлэг дээр зээл, тусламжийн асуудлыг хөндөж оруулсан нь тийм ч санамсаргүй асуудал биш болов уу гэж бодож байна. Учир юу вэ гэвэл донор, хандивлагч байгууллагуудын тогтоосон дүрэм, журмын дагуу л гадны төсөл, хөтөлбөр хэрэгждэг гэх цаг хугацаа магадгүй бидний ард үлдэж байгаа юм. 2008 оноос хойш Дэлхийн дээд хэмжээний уулзалтууд хийгдэж, Парисийн тунхаглал гарснаас хойш ерөнхийдөө зээл, тусламжийн үйл ажиллагааны үр ашгийг бэхжүүлэхийн тулд тухайн орны өөрийн системийн ашиглах (use of country systems) үзэл баримтлал хүчтэй болж эхэлсэн. Энэ агуулгаараа өнөөдөр бид олон улсын хандив, зээл, тусламжийн талаар ярих гэж байгаа бол улс орны өөрийнх нь системийн тухай, тэр системийг оновчтой, үр ашигтай болгох тухай асуудлыг зайлшгүй ярих шаардлага үүссэн.



1. Парисийн тунхаглал болон тухайн улс орны өөрийнх нь системийг ашиглаж зээл, тусламжийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд юун түрүүнд *уялдаа холбоо* буюу тухайн улс орны өөрийн бодлого, стратеги болон бүс нутаг, олон улсын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагад нь илүү уялдсан зээл, тусламжийн үйл ажиллагаа явуулах асуудал багтана.

2. Дараа нь илүү үр дүнд суурилах байдлаар энэхүү төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх концепци сүүлийн жилүүдэд хүчтэй орж ирсэн. Энэ ч утгаараа Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын түнш байгууллагуудын хувьд шинэ арга хэрэгслүүд гарч ирсэн. Өөрөөр хэлбэл, хуучин худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаад, түүний дагуу зөвлөх сонгон шалгаруулаад ч юм уу хэлбэрээр төсөл хэрэгжүүлдэг байсан бол одоо илүүтэй үр дүнд суурилсан, харилцан тохиролцсон үр дүндээ хүрсэн бол холбогдох санхүүжилтийг олгох асуудлууд давамгайлж байна.

Цаашлаад зээл, тусламжийн үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгохын тулд дараах хоёр асуудалд зайлшгүй төвлөрч ярих шаардлагатай. Үүнд:

3. Төсөл, хөтөлбөрийн аливаа үйл ажиллагааны хувьд өмчлөл буюу өөриймсөг хандах (ownership) гэдэг асуудал чухалд тооцогдоно. Зээл тусламжийн хөрөнгө нь төсвийн хөрөнгийн нэг хэсэг учраас төрийн санхүүгийн системээр дамжихын тулд тэнд төрийн албан хаагчид чадавхтай байх ёстой, тогтолцоо болон системийн хувьд үр ашигтай байх ёстой, цаашлаад төрийн санхүүгийн удирдлагын системийн зарим доголдлыг сайжруулах шаардлага байгаа зэргийг харгалзан үзэж, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг байгууллагууд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Тухайлбал, Сангийн яаманд хөрөнгө оруулалтын бүх төслийн саналуудыг цахимаар хүлээн авч, цахим системдээ үнэлгээг нь хийгээд, алиныг нь төсвийн төсөлд тусгах вэ гэдэг ажлыг дэмжээд ажиллаж байна. Мөн өмнөх илтгэгчийн ярьсан төрийн албаны

цалингийн системийг сайжруулах зэрэг системийг оновчтой зөв болгох ажил хийгдэж байна.

4. Олон улсын зээл тусламжийн үйл ажиллагаатай холбоотой байнга яригддаг бас нэг асуудал бол тогтвортой байдал. Тогтвортой байдлыг хангана гэдэг нь хэд хэдэн зүйлээс хамааралтай, Юун түрүүнд, энэ асуудалтай холбоотойгоор төрийн албаны тогтвортой байдал, залгамж чанар юм. Тухайлбал, магадгүй 5 жилийн өмнө тухайн нэг асуудлаар төсөл хэрэгжиж байсан гэх тохиолдол байж болох ч тэрхүү төсөл, хөтөлбөрийн үр дүн гараагүй, холбогдох бодлого өөрчлөгдсөнөөс болоод тухайн төсөл, хөтөлбөр анх төсөөлсөн үр дүндээ хүрч хэрэгжиж чадаагүй гэх мэтчилэн асуудлууд гардаг. Иймд энд яригдаж байгаа оролцоо, төрийн албаны тогтвортой, ил тод, шударга байх гэдэг энэ бүх асуудлууд өөрөө зээл, тусламжийн үр ашгийг сайжруулна гэдэгтэй туйлын цөм холбоотой ойлголт болж хувирч байгаа учраас эдгээр зүйлсийг дурдаж ярилаа.

Олон улсын хөгжлийн байгууллагуудын хувьд нэлээд түгээмэл яригддаг зүйрлэлийг хэлээд илтгэлээ өндөрлөе. Олон улсын хөгжлийн байгууллагуудын зүгээс “Өндгийг дотроосоо хагардаг” гэж үздэг. Өөрөөр хэлбэл, өндөг дотроосоо хагарах юм бол болж боловсроод амьдрал үргэлжилнэ, харин гадны нөлөөтэй хагарах юм бол тэр дороо хэрэглэгдэхүүн болоод дуусна гэсэн санаа. Иймд гадны зээл, тусламж, хандивыг үр ашигтай, үнэхээр улсынхаа хөгжилд нийцтэй, хэрэгтэй зүйлд зарцуулья гэвэл тэр улс орны систем гадны төсөл хөтөлбөрүүдийн үр шимээс хүртэж, боловсроод ‘дотроосоо хагарч’ хөгжлийг бий болгож ажиллах нь зүйтэй бөгөөд энэ чиглэлд олон улсын хөгжлийн байгууллагууд Монгол Улстай хамтрахдаа туйлын таатай байдаг.

Баярлалаа.



◆ ————— “АВЛИГЫН ЭСРЭГ
ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН-2021”

Талбар хэлэлцүүлэг 4

**ХУВИЙН ХЭВШИЛ БА
ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН**



ХУВИЙН ХЭВШИЛ БА ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД, ШУДАРГА БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

*Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын
Худалдан авах ажиллагааны бодлогын
хэлтсийн дарга Ц.Батзул*

АВЛИГААС АНГИД ШУДАРГА ӨРСӨЛДӨӨНИЙГ ДЭМЖИХ НЬ

*Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн
төлөө газрын дарга Б.Бат-Эрдэнэ*

БИЗНЕСИЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ, ӨРСӨЛДӨӨНИЙ ШУДАРГА БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ

*Монголын Үндэсний Худалдаа Аж
Үйлдвэрийн Танхимын ерөнхийлөгч
О.Амартүвшин*





ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАСАГЛАЛ: ИЛ ТОД, ХАРИУЦЛАГА, ШУДАРГА БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

*“Транспарэнси интернэшнл”
байгууллагын Хараат бус зөвлөх,
судлаач Д.Тэгшбаяр*

ХУВИЙН ХЭВШЛИЙН ШУДАРГА БАЙДАЛ

*Монголын бизнесийн зөвлөлийн
Удирдах зөвлөлийн дарга
Ц.Түмэнцогт*

Салбар хэлэлцүүлгээ 4
**ХУВИЙН ХЭВШИЛ
БА ШУДАРГА
ӨРСӨЛДӨӨН**



ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД, ШУДАРГА БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

*Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын
Худалдан авах ажиллагааны бодлогын
хэлтсийн дарга Ц.Батзул*

Монгол Улсын Их Хурлаас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг 2006 онд шинэчлэн баталж одоог хүртэл мөрдөж байна. Энэ хугацаанд улсын худалдан авах ажиллагаа 20 дахин өсч байна, тендер шалгаруулалтын цар хүрээ улам бүр нэмэгдэж байна.

Засгийн газраас худалдан авах ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх ажлыг тасралтгүй хэрэгжүүлж байгаа бөгөөд 2008 онд тендерийн урилгыг нийтлэх цахим хуудсыг ашиглалтад оруулсан. 2011 онд Худалдан авах ажиллагааны төлөвлөх системийг нэвтрүүлсэн ба 2012 онд анхны цахим тендер шалгаруулалтыг зарлаж энэ цагаас хойш цаасан тендер шалгаруулалтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг эхлүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийг хөгжүүлж 2017 онд ашиглалтад нэвтрүүлснээс хойш одоо нийт тендер шалгаруулалтын 99 хувийг цахим системээр жилдээ 22000 тендер зохион байгуулж байна.

Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэл Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Шилэн дансны тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод, нээлттэй мэдээлж байна. Төрийн байгууллагуудын тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, тендер шалгаруулалт зохион байгуулах огноо, Тендерийн урилга, тендерийн баримт бичиг, тендер хүлээн авах эцсийн хугацаа, зохион байгуулах арга, тендер шалгаруулалтын нээлт, шалгарсан оролцогчийн мэдээлэл, бусад өрсөлдсөн

компаниудын мэдээлэл, өгсөн үнийн санал, шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, гэрээний мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлж байна.



2019 онд худалдан авах ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх чухал алхам хийсэн. Улсын Их Хурлаас 2019 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж тендер шалгаруулалтад оролцсон компаниуд захиалагч шийдвэр гаргаснаас хойш ажлын 5 хоногийн хугацаанд шалгарсан тендерийг танилцуулах эрхтэй болсон. Ингэснээр тендер шалгаруулалтын үнэлгээний үе шатанд хяналт тавих боломжтой болсон. 2020 онд 22371, 2021 онд 19815 тендер шалгаруулалтыг зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 2020 онд 54051, 2021 онд 42848 аж ахуйн нэгж оролцсон байна. Шалгарсан тендер оролцогчийн материалтай 2021 онд 1872 удаа танилцсан байна.

Худалдан авах ажиллагааны мэдээллийг 2006 онтой харьцуулахын аргагүйгээр нэмэгдээд байна. Цаашид худалдан авах ажиллагаанд харах боломжгүй зүйл үлдээхгүй байхаар хуульчилж байгаа.

Дээрх журмыг баталснаар Сангийн яаманд гардаг байсан үндэслэлгүй гомдлын тоо 19 хувиар буурсан бөгөөд тендер оролцогчид шалгарсан оролцогчийн материалтай танилцсанаараа хөндлөнгийн хяналт бодитоор тавих боломжтой болсон гэж үзэж байна.

Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан үзэл баримтлалын хүрээнд Сангийн яамнаас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын

төслийг боловсруулж байгаа бөгөөд мэдээллийг ил тод болгох хүрээнд дараах зохицуулалтыг тусгаад байна:

- ✦ худалдан авах ажиллагааны бүх үе шат;
- ✦ сонирхлын зөрчлийг илрүүлэх зорилгоор албан тушаалтны мэдээлэл;
- ✦ авлигын болон мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүний харилцан хамааралтай компани тендерт оролцох эрхийг хязгаарлах;
- ✦ тендерийн системийг бусад мэдээллийн сантай холбож гэрээ авсан компаниудын мэдээллийг ил болгоно;
- ✦ шалгарсан оролцогчийн тендерийг бусад оролцогчдод ил болгож хяналт тавих боломжийг олгох;
- ✦ тендерийг ил болгохоос татгалзсан тохиолдолд бий болох хууль зүйн үр дагаврыг тодорхойлох;
- ✦ хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлж, төсвийн зарцуулалтын ил тод байдлыг нэмэгдүүлэх.

Цаашид худалдан авах ажиллагааны ил тод нээлттэй байдлыг тасралтгүй нэмэгдүүлэн ажиллах бөгөөд хүний оролцоог бууруулах, хариуцлага тооцох, шуурхай, хялбар тендер шалгаруулалт зохион байгуулах эрх зүйн орчныг бий болгохоор ажиллаж байна.



АВЛИГААС АНГИД ШУДАРГА ӨРСӨЛДӨӨНИЙГ ДЭМЖИХ НЬ

*Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн
төлөө газрын дарга Б.Бат-Эрдэнэ*

Бизнесийн байгууллагуудын хувьд нэг л үндсэн зарчим бий. Ашгийн байх, ашиг олох ёстой гэсэн зарчим дээр тулгуурладаг. Тиймээс тогтвортой, удаан хугацаанд үйл ажиллагаагаа явуулах хэрэгтэй. Зах зээлд тухайн салбартаа тэргүүлэх байр суурийг эзлэхийн төлөө бизнесийн байгууллагууд хичээж байгаа. Зах зээлд эзэлсэн байр сууриа бататгах, хадгалах, ахиулах түвшин дээр бизнесийн зорилго агуулга нь оршдог. Өрсөлдөөний тухай хуулийн үзэл баримтлалд аж ахуйн нэгж, хуулийн этгээд хоорондын өрсөлдөөнийг шударга байлгах гэсэн үндсэн зарчим үйлчилж байна. Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтныг өрсөлдөөний шударга байдалд нөлөөлсөн эсэхийг шалгаж тогтоох, нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг бид авч хэрэгжүүлдэг гэсэн үг. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газрын зүгээс Өрсөлдөөний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьдаг бөгөөд авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбогдохоос урьдчилан сэргийлэх хүрээнд Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийг анхааруулдаг. Энэ нь төрийн захиргааны байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудаас өрсөлдөөнийг хязгаарлахыг хориглосон заалт юм.

Өөр нэг хяналт нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” буюу манайхны хэлдгээр тендерийн тухай хууль. Энэ хуульд манай байгууллага хяналт тавьж ажилладаг. Өрсөлдөөнийг хязгаарлахгүй байхаас гадна авлига, албан тушаалтай холбоо бүхий асуудлууд ихээр яригддаг 10 орчим зүйл байна.

Нэгдүгээрт: Давхардсан чиг үүрэгтэй холбоотой асуудал. Тухайлбал хяналтын чиг үүргийн 44 байгууллага өнөөдөр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байна. Энэ байгууллага бүр дээр хүнд суртал, авлига, албан тушаалын

асуудал үүсдэг гэж нэг талдаа аж ахуйн нэгж, иргэд мэдээлдэг.

Хоёрдугаарт: Төрийн бүтэцтэй холбоотой асуудлууд байна. Жишээлбэл, тодорхой хэмжээнд давхардсан чиг үүргээсээ гадна төрийн бүтцийг давхардуулсан хэлбэрээр байгуулсан нь өөрөө тодорхой хэмжээнд энэ авлига албан тушаалын хэрэгтэй зайлшгүй холбогдох нөхцөлийг үүсгэж байгаа. Өөрөөр хэлбэл, гар хүндрүүлэх гэдэг ч юм уу, тухайн хүмүүстэй харилцах харилцаан дээр зайлшгүй асуудлууд үүсдэг гэж тодорхойлдог. Өнөөдөр Улаанбаатар хотын 51 хувь нь гэр хороололд амьдарч байна. Гэр хороололд 10341 орчим жижиг дэлгүүр бий. Энэ дэлгүүрүүдээр мэргэжлийн хяналтын байцаагч, цагдаа, дүүргийн худалдаа, үйлчилгээний хэлтсийн албан хаагчид хяналт шалгалтаар очдог. Хяналт шалгалт нэрээр ороод гарахдаа өөрийнхөө гар утасны дугаарыг өгөх, ийшээ тийшээ явахдаа манайх найр цуглаан хийх гэж байна. Арга хэмжээний асуудлыг шийд гэдэг ч юм уу, иймэрхүү үүрэг даалгавруудыг өгдөг гэж дэлгүүрийн худалдагч, эзэд хэлж байна. Энэ бол авлига.

Гуравдугаарт: Зөвшөөрөл бус зөвшөөрөлтэй холбоотой асуудал. Тусгай зөвшөөрлөө авсаар байтал стандартын дагуу эсэх дээр заавал мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт шаарддаг. Сүүлийн үед нэмэгдээд “Цахим мэдээллийн сан”-д заавал бүртгүүлж байж үйл ажиллагаа чинь явагдах эрх нээгдэнэ гэдэг болсныг хэлж байна. Зөвшөөрөл бус зөвшөөрөлтэй холбоотой ийм асуудлууд бас хөндөгддөг.

Өрсөлдөөний байгууллагын хувьд, ялангуяа төрийн байгууллагаас хуульд заагаагүй зөвшөөрөл авахыг шаардаж байгаа эсэх, хуульд заагаагүй бүртгэл явуулж байгаа эсэх, хуульд заагаагүй төлбөр, хураамж авч байгаа эсэхийг хянах дээр ажиллаж байна. Аль нэг аж ахуй эрхлэгчид бусдаас давуу байдал олгосон эсэхтэй холбоотой асуудал гээд энэ 4 үндсэн зүйлийн хүрээнд манай байгууллага хяналт шалгалтын үйл ажиллагааг хийсэн. Олон асуудлууд гарсан. Ялангуяа хуульд зааснаас бусад зөвшөөрөл, лиценз төлбөр, хураамж авдаг асуудал. Үүнийг бид эхнээс нь зогсоож эхэлсэн бөгөөд, тухайлбал хүнс үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний хэлтэс гэх энэ байгууллага нийслэл, аймаг болон дүүргүүдийн дэргэд байгуулагдаж “батламж” нэрээр зөвшөөрөл олгох, батламжийн төлбөр гэх хураамжийг авч байсан. Энэ байдлыг зогсоосон. Иймд хуульд заагаагүй төлбөр хураамж, бүртгэл хураамжтай холбоотой асуудлыг зайлшгүй нэг талдаа хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэх ёстой. УИХ-д өргөн баригдсан Зөвшөөрлийн тухай хуулиар эцэслэгдэн шийдвэрлэгдэнэ гэж харж байгаа.

“Төрийн болон нутгийн өмчөөр хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-тай холбоотой олон зүйл бий. Бид аж ахуйн нэгжүүдтэй энэ

хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Захиалагчтай холбоотой маш олон асуудал гардаг. Хэн нэгэн этгээдэд зориулан бэлтгэсэн эсэх, хэн нэгэн этгээдийг тендер сонгон шалгаруулалтад оруулахгүй, эсхүл шалгаруулахгүй байхаар бэлтгэсэн эсэх, цөөн тооны аж ахуй эрхлэгчдийг дэмжсэн байдлаар бэлтгэсэн эсэх ч гэдэг юм уу, зайлшгүй шалгах ёстой зүйлс. Хэлэлцүүлэг дээр гарч байгаа зүйлийг сая Сангийн яамны албан тушаалтан ч хэлж байна. 523 гомдол ирснээс 407 гомдол нь хууль зөрчиж зарласан нь үндэслэлтэй гэж. Энэ нь нийт гомдлын 77 хувийг эзэлж байна.



Тендерийн хууль дээр аж ахуйн нэгжүүддээ төр арга хэмжээ аваад байгаа болохоос биш яг нөгөө талдаа захиалагч болон үнэлгээний хорооны албан тушаалтнуудад хариуцлага тооцох асуудлууд хөндөгдөхгүй байна. Үүнийг бид хөндөх ёстой. Үүнийг хөндөөгүйгээс улбаалаад энэ авлига, албан тушаалын хэргүүд үргэлжилсээр байна. Тухайлбал, гэрээ контракт байгуулахаасаа өмнө буюу сонгон шалгаруулалт хийгдэх явцад нэг талдаа авлига авч байна. Бас гэрээний явцад авч байна. Гэрээний төгсгөл хэсэг буюу, магадгүй тухайн гэрээ аливаа нөхцөл байдлаас шалтгаалж сунгагдах тохиолдол үүсэх, магадгүй тухайн гэрээний дүгнэлт дээр авлига, албан тушаалын асуудал яригддаг. Үүнийг зайлшгүй шийдэх ёстой гэж аж ахуй, бизнес эрхлэгчид саналаа хэлж байна. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газраас тендерийн тухай хуультай холбогдуулаад судалгаа шинжилгээ хийсэн. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар дээр ирсэн ирсэн нийт гомдлын дагуу шалгахад 85 хувь нь захиалагчийн зөрчилтэй байна. Тухайлбал, хуулийн цоорхой дээр тухайн тендер, сонгон шалгаруулалт зохион байгуулж байгаа тендер үнэлгээний хороонууд ажиллаж байгаа гэж дүгнэж байгаа. Ковид-цар тахалтай

холбогдуулан 5 дахь өдөр тендер зарлаад шууд ирэх 1 дэх өдөр нь нээж байсан тохиолдлууд бий. Энэхүү хуулийн зөрчсөнтэй холбоотой асуудлуудыг хөндөхөөр та нар саатуулсан шүү. Хариуцлагаа хүлээнэ биз гэх жишээтэй. Бид тодорхой хэмжээнд засаж залруулахын төлөө ажиллаж байгаа боловч нөгөө талдаа сууриар нь шийдвэрлэхгүй бол болохгүй байна гэдэг талаас хуулийн шинэчилсэн найруулга дээр саналаа өгч байгаа.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газрын хувьд та бүхэндээ кейсүүд хэлэхийг хүсэж байна.

Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороо Хайластын 1-1 тоотод байрлах Далайхүү худалдааны төвтэй холбоотой, нийт 170 гаруй өрх, орон сууцны халаалтын үйл ажиллагааг хариуцаж ажилладаг “Ванхүү” гэх компанитай холбоотой асуудал. Энэ компанитай холбоотой асуудлыг шийдвэрлүүлэх гэж маш олон удаа бид хандаж байгаа. Огт шийдвэрлэхгүй байна. Үүний ард авлига байгаа гэж үзэж байна. Яагаад олон мянган иргэний эрүүл амьдрах орчныг сүйтгэж байгаа утаатай холбоотой, тоосонцортой холбоотой асуудлыг мэргэжлийн хяналтын байгууллагад өгөөд, мэргэжлийн хяналтын байгууллага нь хийдэггүй юм бэ. Өнгөрсөн 5 дугаар сард шалгалт хийгээд стандартын шаардлага хангахгүй байгаа учраас хаах хэрэгтэй гэдгийг газар дээр нь ярилцсан. Яг үнэндээ стандартаа ойлгоогүйгээс үүдээд тэр зуух нь тэсрэх, дэлбэрэх аюултай. Цаашлаад тухайн газрын хоёр ч байр дэлбэрэх аюулд өртөх магадлалтай, аюултай нөхцөл байдалтай байгаа. Мэргэжлийн шинжээчид ирж дүгнэсэн. Энэ дээр шинжилгээний дүгнэлтүүд гараад 5 сард хаагаад, 9 сард эхлэхэд нь шинэ технологиор эхлүүлэе гэдэг үүрэг өгсөн боловч өнөөдрийг хүртэл энэ байгууллага ажилласаар л байна. Бид ганцхан байгууллагын асуудлыг шийдэж чадахгүй байж нөгөө мянган авлигын асуудлыг яриад ямар ч нэмэргүй болж байгаа юм.

Дараагийн асуудал: Хил гаалиар орж ирж байгаа импортын автомашины мэдээллийг шууд ил тод гаргадаг болгосон. Ингээд эхэлсэн чинь осол аваарт орсон машиныг гаалийн мэдээллийн санд оруулахдаа засварлаж оруулаад эхэлсэн. Ямар ч осол аваар, эвдрэл байхгүй мэтээр. Жишээлбэл 7 дугаар сарын 02-ны өдөр орж ирсэн цагаан бенз. Долдугаар сар гэдэг бол зуны улирал. Зун орж ирсэн бенз автомашины зураг орохдоо, эвдрэлгүй бас цастай өвлийн зурагтай машины зураг гаалийн мэдээллийн санд орж байх жишээтэй. Үүнтэй холбогдуулан 5-6 алба хаагчийн асуудлыг Авлигатай тэмцэх газар шилжүүлсэн. Гаалийн байгууллагаас зөрчлийн даргаас нь тодорхой хэмжээний цалин бууруулах арга хэмжээ авсан гэж мэдүүлсэн. Бид ийм асуудлуудыг шийдвэрлэхгүйгээр авлигатай тэмцэх тухай яриад хэрэггүй.

Энэ бол нэгдүгээрт тухайн аж ахуйн нэгж, байгууллагуудын өрсөлдөөнд шууд нөлөөлж байгаа хэлбэр. Хоёрдугаарт хэрэглэгчийн амь насанд шууд заналхийлж байгаа хэлбэр. Өнгөрсөн хугацаанд манай байгууллагын хувьд тодорхой хэмжээнд асуудлуудыг шийдэхийг зорьж ирлээ. Шийдлүүд дээр саналууд ч санал болгож ирсэн. Ялангуяа хуулийн шинэчилсэн найруулга дээр маш сайн өөрчлөлтүүд ороосой гэж хүсэж байна.

Төгсгөлд нь хэлэхэд Авлигатай тэмцэх газрын салбар харьяа нэгж, байгууллагуудыг Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий газруудад зайлшгүй байгуулах хэрэгтэй юм билээ. Энэ тухайд Монгол Улсын Шадар сайдад албан ёсны хүсэлтийг манайхаас хүргүүлсэн. Эрдэнэт, Өмнөговь, Алтанбулаг гээд хилийн боомт бүхий аймгууд дээр бүгдэд нь байгуулах шаардлагатай. Үнэндээ тэнд ямар ч хараа хяналт алга. Ингэж хяналтын тогтолцоог бий болгож байж авлигатай тэмцэх тухай асуудлыг хөндөхөөс биш яг өнөөдрийн байгаа бүтэц бүрэлдэхүүнээр авлигатай тэмцэх газрын хувьд хүч дутаж байна. Авлига таслан зогсоогдохгүй, өнөөдрийг хүртэл үргэлжилсээр л байна. Сүүлдээ авлигачид нь хуулийн хамгаалалтад орохын тулд Улсын Их Хурлын гишүүн хүртэл болдог болсон. Энэ тогтолцоог таслан зогсоох хэрэгтэй.

ХУВИЙН ХЭВШЛИЙН ШУДАРГА БАЙДАЛ

*Монголын бизнесийн зөвлөлийн
Удирдах зөвлөлийн дарга
Ц.Түмэнцогт*



Монголын бизнесийн зөвлөл нь 2007 онд байгуулагдсан эдийн засгийн эрх чөлөө, өмчийн эрхийг дээдэлсэн нийгэм, гишүүддээ үйлчлэх эрхэм зорилготой төрийн бус байгууллага юм. Өнөөдөр манай байгууллага нь 260 орчим идэвхтэй гишүүдтэй, мөн Монгол Улсад байгаа санхүүгийн байгууллагууд, Элчин сайдын яамдууд мөн гадаадад бүртгэлтэй, хөрөнгийн биржид бүртгэлтэй Монголд үйл ажиллагаа явуулдаг компаниуд бүгд манай гишүүд. Уул уурхай, эрчим хүч, дэд бүтэц, цаг уурын өөрчлөлт, тогтвортой санхүүжилт, татвар, эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадвар цахим шилжилт гээд 5 дэд ажлын хэсэгт хуваагдан ажилладаг.

Хувийн хэвшлийн өнөөдрийн байдал авлигатай тэмцэх уриан доор ямархуу сорилт тулгарч байна гэхээсээ илүүтэйгээр Монголын бизнесийн орчин, дэлхий нийтийн бизнесийн орчинд тулгарч байгаа чиг хандлага сорилтуудыг эхлээд товчхон дурдъя. Дэлхий нийтэд тархсан цар тахал бол дэлхий нийтийн эдийн засаг, бизнест хүчтэй сөрөг нөлөө үзүүлж байна.

Үйлдвэрлэгч орон БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2020 онд Ковидтой байсан ч гэсэн 6,7 хувиар өссөн гэж зарим шинжээч нар ярьж байна. Энэ нь юуг харуулж байна вэ? гэхээр өөрсдөө нэмүү өртөг бүтээдэг, ажлын байраар хангадаг улс л ковидтой хязгаарлагдмал үед ялагч байх нь. Хамгийн наад захын жишээ амны хаалтыг БНХАУ л үйлдвэрлэж байна. Ковидын орчин нөхцөлөөс шалтгаалж аялал, бизнес зэрэг зүйлсийн нөхцөл байдал өөрчлөгдөж сургалт, семинар бүгд онлайн хэлбэр лүү шилжиж байна. Энэ нь цаашдаа бизнесийн орчинд маш олон арван жилийн үр дагавар болохнээ гэж харж байгаа. Үүнтэй холбоотой тээвэр ложистик, инфляци үнийн өсөлт байна. Энэ бол зөвхөн Монгол Улсад биш бүх л томоохон худалдаа эрхэлж байгаа орнуудад шууд нөлөөлж байгаа. Үйлдвэрлэгч орнуудаас хэрэглэгч орнууд руу явах тээвэр ложистикийн зардал, чирэгдэл, хадгалалт зэрэг энэ бүх зүйлд маш их зардал чирэгдэл гарч,

тээвэр, ложистикийн үнийн өсөлт, инфляци бол байнга үргэлжлэхээр байна. Цаашид Монгол Улсын хэмжээнд бараа, бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний бараагаа импортлодог орны хувьд, мөн гадагшаа мах, түүхий эдээ гаргадаг улсын хувьд тээвэр, ложистикийн асуудлыг шийдэхгүйгээр эдийн засгийн болон бизнесийн хувьд хүнд сорилтууд хэвээрээ байх болно.

Бас нэг том сорилт бол цаг уурын өөрчлөлт. Саяхан 10 сард НҮБ-ын конвенцийн дэлхийн цаг уурын өөрчлөлт талаар Коп-26 гэж уулзалт боллоо. Тэр уулзалтаар дэлхийн цаг уурын өөрчлөлт 2 хэмээр өөрчлөгдөх юм бол дэлхий нийтэд нөлөө үзүүлнэ. Ялангуяа ядуу буурай орнуудад ган гачиг болох эсхүл хэт их усархаг бороо орж үер болох ч гэдэг юм уу энэ цаг уурын өөрчлөлт 2050 он гэхэд тогтвортой хэмжээнд буюу 1,5 хэмд барих зорилтдоо хүрэхгүй гэсэн дүгнэлт гарч байгаа. Тэгэхээр энэ цаг уурын өөрчлөлт нь Монголын талд хэд хэдэн нааштай боловч сөрөг мэдээллүүд орж ирж байна.

Манай өмнөд хөрш БНХАУ 2060 он гэхэд нүүрс хүчлийн давхар исэлгүй карбан? улс гэж зарласан байгаа. Мөн Австрали улс мөн энэ амлалтыг авч байна. Хятад Улсаас нүүрсний чиглэлийн хөрөнгө оруулалтыг дэмжихгүй хөрөнгө оруулалт хийхгүй гэсэн. Энэ манай нүүрсний зах зээлд шууд нөлөөлөхөөр, манай нүүрсэн дээр ажиллах шинээр баригдах гэж байгаа станцуудад шууд нөлөөлөхөөр сөрөг мэдээлэл. Нөгөө талаар цэвэр эрчим хүч, ногоон эдийн засаг руу шилжинэ гэдэг өөрөө сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний дэд бүтцэд хөрөнгө оруулалт шаардлагатай гэсэн мессэж өгч байна. Энэ нь зэс экспортлогч манай орны хувьд сайн мэдээ юм. Зэсийн үнэ нэмэгдэнэ зэсийн хэрэгцээ нэмэгдэнэ. Монгол Улсын эдийн засаг бизнесийнхэнд шууд нөлөөлнэ. Монгол Улсын ерөнхийлөгч У.Хүрэлсүх нь НҮБ-ын индэр дээрээс Монгол Улс цаг уурын өөрчлөлттэй тэмцэх аянд нэг тэрбум мод тарина хэмээн мэдэгдэж бид хувь нэмрээ оруулж байгаа.

Дараагийн асуулдал бол дижитал шилжилт буюу аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал. Крипто, блок чэйн гэх шал өөр асар хурдтай дижитал шилжилтийн үр нөлөө нөлөөлж байна. Янз бүрийн койн, крипто, виртуал хөрөнгийн зохицуулалт гээд яригдаж байна. Энэ нь Монгол Улсад бас шууд нөлөөлж, бизнес, санхүү их хэмжээгээр урсаж сүүлийн үеийн тоогоор 5,6 их наядын хөрөнгө койн, крипто валют токейн руу орж байна гэсэн мэдээллүүд байгаа. Хэдийгээр блок чейнд тулгуурласан зохицуулалт байхгүй байгаа ч гэсэн зарим улсууд үүнд маш их шүүмжлэлтэй хандаж байгаа. Эдийн засгийн үйл ажиллагаа мөн үү. Татвар ногдуулж болох уу? ямар нэгэн зохицуулалтгүй их мөнгө ороод байгаа нь тухайн хөрөнгө оруулагч аж ахуй нэгжүүдийн ажил мөн юм шиг боловч нөгөөтэйгүүр Монголын хувьд, хязгаарлагдмал эх үүсвэртэй

улсын хувьд улс орноо хөгжүүлэх, бүтээн байгуулалтын төслүүд биш дижитал аст руу мөнгө орж байгаа нь бидний зайлшгүй анхаарах зүйл гэж үзэж байгаа юм.

Монголынхоо дотоод шударга өрсөлдөөн хувийн хэвшлийн бизнесийн орчны хувьд Дэлхийн банкны “Doing Business” тайланд Монгол Улсын хөрөнгө оруулалтын өрсөлдөх чадварын бизнесийн орчинд хамгийн сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг дурдсан байгаа. Эрчим хүчний хангамж их сул, барилга байгууламж, бүтээн байгуулалт хийхэд олон зөвшөөрөл шаардагддаг, их цаг хугацаа ордог, эрх зүйн орчин тогтвортой биш, тухайн салбарын бодлогууд нь байнга өөрчлөгдөж байдаг зэрэг нь бодитой оршин байна. Монгол Улсын Ерөнхий Сайдын шинэ сэргэлтийн хөтөлбөрт хамгийн том ажлуудын нэг бол Эрчим хүчний асуудал. Сүүлийн 5 жилд 1 их наяд долларын хөрөнгийг хөрш орнууддаа эрчим хүчний төлбөрт өгсөн байна. Энэ маш том мөнгөн урсгал гадагшаа урсаж байна. Нөгөөтэйгүүр Монголдоо нэмүү өртөг бий болгох ажлын байр бий болгох боломж алдагдаж, суурь салбарт нэлээн анхаарал шаардаж байгаа юм.

Сүүлийн жилүүдэд 1.8, 1.9 тэрбум долларын гадаадын хөрөнгө оруулалт орж ирж байгаа гэх боловч дийлэх нь буюу 1 тэрбум гаруй доллар нь Оюу толгойн хөрөнгө оруулалт, уул уурхай давамгайлсан хөрөнгө оруулалт байна. Уул уурхайд оруулж байгаа хөрөнгө оруулалтыг хасчих юм бол хөрөнгө оруулалт хасах бусад салбарт нөлөөлөхүйц хэмжээний хөрөнгө оруулалт орохгүй, харин ч бүр гарч байгаа гэсэн тоонууд гарч байгаа юм. Энэ бол гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн өөрчлөлт 50 мянган доллар, 100 мянган доллар босгохын асуудал биш, урт хугацаанд тогтвортой байх асуудал. Төрийн үйлчилгээ, хувийн үйлчилгээ гэж яг юуг хэлэх юм бэ? төр ямар үйлчилгээнүүдийг үзүүлэх, хувийн бизнесийнхэн ямар үйлчилгээг хийх юм бэ гээд яригдлаа. Саяхан автомашины албан журмын даатгалыг төрд авах уу, үгүй юу гээд асуудал яригдаж байна. Төр мөнгөтэй ашигтай салбар луу орох шаардлагагүй гэж үзэж байгаа юм. Ялангуяа сонгодог зохицуулалтын төрийн үйлчилгээ гэж ямар үйлчилгээг хэлэх вэ гэхээр цэвэр хэрэглээг нь хязгаарлах боломжгүй батлан хамгаалах ч юм уу? агаарын чанар ч юм уу? тэр чиглэлүүдийг л тэр хариуцах ёстой, бусад бүх чиглэлийг хувийн хэвшлийнхэн хийх бололцоотой гэж үзэж байна. Энэ чиглэлийг бизнесийн орчин гаднын хөрөнгө оруулалт, дотоодын хөрөнгө оруулалт татахдаа анхаарах ёстой юм уу гэж бодож байгаа. Нөгөөтэйгүүр Солонгос, Япон зэрэг орнуудын туршлагыг харахад ихэнхдээ үндэсний компаниуддаа тулгуурлаж, тэднийгээ манлайлуулж, тэд нь эдийн засгийн зүтгүүр хүч болсон ийм эдийн засаг байгаа юм. Жишээ нь

Солонгосын Хьондай, Самсунг, Японы Сони, Тоёота. Гэтэл манайд үндэсний компаниудаа дэмждэггүй, нэр хүнд имиджийг дэмждэггүй байдлыг засах ёстой. Хөдөлгөгч хүч нь үндэсний компаниуд ажил олгогч, татвар төлдөг байж байж улс хөгжих ёстой гэсэн үзэл баримтлалыг тэргүүн чиглэл болгох ёстой. Засгийн газрын бүтцийн хувьд гаднын хөрөнгө оруулалтыг татах, гаднын хөрөнгө оруулалтыг дэмжих investment promotion гэж нэрлээд байгаа тийм агентлаг, байгууллага байхгүй байна. Хуучин Гадаадын хөрөнгө оруулалтын газар гэж байлаа, одоо тийм дагнасан байгууллага байхгүй. Бас нэг асуудал нь худалдааны асуудал хариуцсан агентлаг Засгийн газрын бүтцэд заавал байх ёстой гэж үзэж байгаа, ялангуяа далайд гарцгүй экспорт, импортоос шалтгаалдаг хил дээр Гашуун сухайт, Ганц мод дээр байнгын экспорт, импортын худалдааны асуудал үүсдэг. Дагнасан агентлаг Засгийн газрын бүтцэд зайлшгүй байх ёстой гэж бизнес эрхлэгчид үзэж байгаа юм.

Баярлалаа.



БИЗНЕСИЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ, ӨРСӨЛДӨӨНИЙ ШУДАРГА БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ

*Монголын Үндэсний Худалдаа Аж
Үйлдвэрийн Танхимын ерөнхийлөгч
О.Амартүвшин*

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсын эдийн засгийн чадвар өнөөдөр ямар түвшинд байгаа, өрсөлдөөний гол чанар, үзүүлэлт, үүний дотор өрсөлдөх чадварын индекс, хүнд суртлын индексийн талаар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим ер нь авлигатай яаж, хэрхэн тэмцэж байгаа вэ, бизнес эрхлэгчдийг ёс зүйтэй байлгахын тулд ямар ажил хийж байгаа болон ер нь бид өөрсдөө хариуцлагатай байх ямар алхмыг санаачилж байгаа талаар та бүхэнтэй хуваалцана.

Дэлхийн өрсөлдөх чадварын тайланд манай улс судалгаанд хамрагдсан улсуудаас 60 дугаарт эрэмбэлэгдэж байна. Энэ нэлээд олон үзүүлэлтээр сул байгаагийн илрэл. Ерөнхий сайд Шинэ зууны хөтөлбөр-Шинэ сэргэлтийн бодлого гэж танилцуулсан. Үүн дотор, ялангуяа эдийн засгийн сэргэлттэй холбоотой асуудлыг бид бүх талаар дэмжиж ажиллана. Бид сул үзүүлэлтүүдээ сайжруулж байж өрсөлдөх чадвараа дээшлүүлнэ. Эдийн засгийн чадлын хувьд бид 58-д, засаглалын үр ашиг 60, бизнесийн үр ашиг 54, дэд бүтэц 62, үүн дотор олон асуудлыг хэмжиж гаргасан байгаа.

Монголын бизнесийн орчны үнэлгээ ямар байна вэ? 2017 оныг 2020 онтой харьцуулж үзвэл үзүүлэлтүүд судалгаанд оролцогчдын үнэлгээгээр бага зэрэг сайжирч байгаа. Тухайлбал, Ерөнхий үнэлгээ 2,45 байсан бол 2,91 болж өссөн байна. Дээд оноо нь 5 учраас 60 хүрэхгүй хувьтай үнэлэгдэж байна гэсэн үг. Бизнесийн орчны засаглал болон хууль, эрх зүйн орчинтой холбоотой асуудлууд 2017-2020 оны хооронд хэрхэн өөрчлөгдсөн бэ. Үүнд: Засаглалын үйл ажиллагаа 2,2-2,63 болж, Бизнес, хууль эрх зүйн орчин 2,48-2,75, Засгийн

газрын институцын тогтолцоо, уялдаа холбоо 2,8-2,6 байна.

Хамгийн өндөр үнэлгээ, бага үнэлгээг танилцуулахад хамгийн бага үнэлгээтэй нь Төрийн худалдан авах ажиллагаа, тендерт оролцох процесс нэлээн сул үнэлгээ авсан бол одоо энэ хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаа. Сангийн яам, Худалдан авах ажиллагааны газартай хамтраад хоёр ч удаа хэлэлцүүлэг зохион байгуулсан. Нэлээд олон компаниудаас тендертэй холбоотой ирдэг санал болох хуульд тусгагдсанаар тендер шалгаруулалтад цахим, ил тод, шилэн зэргээр ахиц гарна гэсэн хүлээлттэй байна. Төрийн байгууллагуудын хүнд суртал 2,38, Төрийн байгууллагын авлига, хээл хахууль нь нэлээд сул оноотой байгаа. Өнөө өглөөний гол илтгэлүүдээс сонсоход, Ерөнхий сайдын үгэнд энэ асуудлыг засаж залруулах санаачилга нэлээд идэвхтэй өрнөж байгаа юм байна гэж ойлголоо.

Бизнесийн хууль, эрх зүйтэй холбоотой Шударга өрсөлдөөний үзүүлэлт 2,65, тендерийн хуулийн нийцэл 2,62 байна. Ер нь Зөрчлийн тухай хууль болон Зөвшөөрлийн тухай хууль гол маргааныг дагуулж байгаа. Ерөнхий сайдын үгэнд 2022 оны туршид ээлжит хяналт, шалгалт, аливаа хугацаатай болон хугацаагүй шалгалтыг царцаах тухай ярьж байгаа нь маш чухал. Шинэ сэргэлтийн хуульд энэ асуудал агуулгаараа тусаж өгсөн. Ялангуяа бид Ковидын үед энэ асуудлыг зайлшгүй хийх ёстой, цаашдаа хуулиа засаж залруулах ч шаардлагатай.

МҮХАҮТ-ын хийсэн хүнд суртлын судалгаанд дурдсанаар бизнес эрхлэгч, хувь хүмүүс 940 төрлийн зөвшөөрлийг аливаа нэг төрийн холбогдох байгууллагаас авч байна. Энэний цаана хугацаа, ашиг сонирхол, авлигын асуудал байнга хөндөгддөг. Дээрх зөвшөөрлийн дийлэнх хэсгийг Улаанбаатар хот олгож ирсэн. Тиймээс Нийслэлийн Засаг дарга Сумьяабазар зөвшөөрлийг эрс цөөлөхөө амласан. Энэ асуудлаар томоохон хэлэлцүүлгийг хамтарч зохион байгуулахаар тохирсон. 2018 оны Хүнд суртлын индексээр тухайн үед Ус сувгийн удирдах газар хамгийн муу оноо авч байсан. Гэтэл нөгөө байгууллага нь бидний нэр төрд халдлаа гэж шүүхэд хандсан байх жишээтэй. Бид асуудалтай тэмцэх, асуудлаа ажил хэрэг болгож засаж залруулах биш хандлага нь буруу байгаа учраас судалгаа хийсэн байгууллагыг шүүхэд өгөөд явж байна.

МҮХАҮТ дэргэдээ гурван том зөвлөлийг ажиллуулж байгаа. Компаенсын зөвлөл, Бизнесийн ёс зүйн төв, Нийгмийн хариуцлагын зөвлөл маш идэвхтэй үйл ажиллагаагаа явуулж байгаа. Ялангуяа Компаенсын зөвлөл МҮХАҮТ-ын дэргэд 2019 онд байгуулагдсан, компанийн засаглалыг бэхжүүлэх, аж ахуйн нэгж байгууллага хууль тогтоомж, дүрэм, журам зааварт нийцүүлж үйл ажиллагаа явуулах чадамжийг нэмэгдүүлэх, дэмжих зорилготой. Бид компаенсын төлөв байдал 2020 судалгааг саяхан явуулж үр дүнг нь олон нийтэд танилцуулсан.

Бизнесийн ёс зүйн төвийг МҮХАҮТ, Транспаренси интернейшнл Монгол, “Рио Тинто”-той хамтраад энэ оны 4 дүгээр сард байгууллаа. Бизнесийн ёс зүй, шударга байдал гэдгийг шинээр таниулах, шударга байдал хаанаас эхлэх ёстой юм гээд аль болох олон компанийг хамруулан сургалт, ойлголт мэдээлэл өгөх зорилготой.

Ер нь авлига хоёр талтай гэж үзэж болохоор. Нэг талд нь худалдан авалттай холбоотой, эсхүл зөвшөөрөл үйл ажиллагаа явуулахтай холбоотой, нөгөө талдаа эс үйлдэлтэй холбоотой. Аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид талаасаа бол ажлаа бүтээх гээд түрүүлж санал болгодог. Төрийн талаас эс үйлдэхүйг яаж засах вэ гэвэл бид өөрсдөө шударга ёсыг тогтоож эхлэх ёстой. Комплаенсын бизнесийн ёс зүйн анхдугаар чуулганыг бид саяхан зохион байгуулсан. Үүнд илтгэлийн уралдаан, авлигаас яаж ангид байх, бизнес өөрөө ямар ёс зүйтэй байх, ер нь бизнес эрхлэгч өөрөө ямар ёс зүйтэй байх, социал маш хүчтэй хөгжсөн байгаа энэ үед эдгээрийг илүү эрхэмлэх юм бол цаашдаа бизнесийн нэр хүнд, үнэт зүйл илүү сайжирна.

Судалгаанаас харахад авлига, залилангаас эхлэлтэй үүсэж байгаа асуудлыг ерөөсөө тооцдоггүй юм байна. Тухайн үедээ асуудал болдог, дараа нь асуудал хөндөгдөнгүүт намайг хохироочихлоо, ингэлээ тэглээ гээд бөөн асуудал үүсгэдэг. Гэтэл өөрсдөө шүгэл үлээх, эсхүл эрх ашгаа хамгаалж мэддэггүй, зөв газартаа хандаж чаддаггүй тохиолдол байна. Хэн нэгэн хүн тухайн асуудлаа шийдэж чадахгүй бол хий бухимдаад яваад байдаг. Нэг бол өөрөө шийдчих гээд оролдоод яваад байдаг. Энэ нь өөрөө Монголд нэг талаасаа мэргэжлийн төрийн бус байгууллагууд үүсээгүйтэй, төрийн бус байгууллагуудын чиг үүрэг яг дундын эрх ашгийг хамгаалах гэдэг рүү чиглээгүйтэй холбоотой. Тэр утгаараа Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын шинэ хуулийг мэргэжлийн дагнасан танхимд суурилсан үндэсний танхим байгаар ярьж байгаа юм. Нэгдэн нийлж, эрх ашгаа системээр нь шийдэхгүй бол бид асуудлаас ангижирч чадахгүй юм байна.

Ашиг сонирхлын зөрчил илэрсэн тохиолдолд компаниуд яахаа мэддэггүй. Хэнд хандахаа ч мэддэггүй. Уг нь Авлигатай тэмцэх газар их ажил хийгээд байдаг, гомдлоо бидэнд өгөөч ээ бид шалгая гэхээр бид 3 саяулаа бие биеэ таньдаг мэддэг, нэг алхаад нөгөө хүнээ таньдаг мэддэг энэ зовлонгоосоо болоод асуудлаа өөрсдөө зөв шийдүүлж чаддаггүй. Шүгэл үлээх гэж тодорхой нэр томьёо бий болчихоод байхад өөрсдөө үүсгэдэггүй, өөрийнхөө асуудлыг түрүүлж шийдсэнийгээ зөв гэж ойлгоод байдаг уламжлалт хандлагаас бид салахгүйгээр энэ чөтгөрийн тойрог арилахгүй. Тэгэхээр шинэ үеийн бизнес эрхлэгчид асуудалд цоо шинээр ханддаг болох хэрэгтэй байна.

Авлигыг үл тэвчих дотоод зохицуулалтгүй. Ер нь ихэнх захирал өөрсдөө эсхүл ажил хариуцсан хүнээ ямар нэгэн замаар наад ажлаа зохицуул гэдэг. Тухайн үүрэг хүлээсэн ажилтан нь бусдыг хоол унданд оруулж, бэлэг сэлт өгөх ёстой юм уу, эсхүл нөгөө танил тал гээд явчихдаг. Тэгэхээр өөрсдөөсөө өөрчлөлтийг эхэлье гэдгийг ялангуяа бизнес эрхлэгчдэд хандан уриалмаар байна. Үнэхээр эс үйлдлээрээ асуудлыг нь шийдэж өгөхгүй бол ханддаг тэр механизмыг бий болгоё. Танхим “Трэйд Монголиа” сайт нээсэн. Нэмээд Дэлхийн банк, Үндэсний хөгжлийн газартай хамтран санал гомдлыг хүлээж авдаг платформ хөгжүүлсэн. Олон хүний санал гомдол тухайн асуудалд төвлөрсөн тохиолдолд асуудлыг нь бодлогын хувьд шийддэг механизмыг зөв бүрдүүлэх ёстой гэж харж байна.

Ихэнх аж ахуйн нэгж ёс зүйн дүрэмгүй байна. Юу нь болно, болохгүйг заагласан, дотоодын хэм хэмжээг заасан бизнесийн кодыг нэвтрүүлэе. Бизнес эрхлэгчид эхлээд өөрсдөө энэ асуудлын хэм хэмжээгээ тогтоодог, ойлгодог байх нь чухал. Дараа нь төрдөө шаардлагаа зөв тавьдаг, өөрсдөө авлигыг санаачилдаггүй байя гэдгийг энд хөндмөөр байна.

Танай байгууллага хууль, дүрэм, журам стандартыг дагаж мөрдүүлэх чиглэлээр хэнээс туслалцаа авдаг вэ. Ер нь мэргэжлийн байгууллагад ханддаг уу? гэсэн судалгаанд оролцогчдын 11 хувь нь орон тооны хуульчтай, хуульчдаас зөвлөгөө авдаг нь 23 хувь, төрийн байгууллага албан тушаалтнаас асуудаг нь 30 хувь байгаа нь маш өндөр хувь байна. Шаардлага гарсан үедээ таньдаг мэддэг хүнээсээ асуудаг, захирлууд нь өөрсдөө хөөцөлддөг, ажил хариуцсан хүндээ даалгадаг ийм харилцаа л яваад байна.

“Транспарэнси интернэйшнл” ТББ-аас гаргасан Шударга байдлын үнэлгээний талаар сонирхолтой судалгааны дүн байгаа. Үүнд бидний буюу бизнес эрхлэгчдийн гол алдаа харагдаж байгаа нь Ёс зүйт байдлын менежмент гэдэг ойлголт хамгийн бага. Талуудын оролцоо бол байдаг юм байна. ТУЗ буюу засаглал их муутай, ил тод байдал муутай зэрэг гажуудал байна. Тэгэхээр бид ёс зүйт байдал, ил тод байдал, засаглалаа өөрсдөө сайжруулахгүйгээр цаашдаа авлигаас ангид байх, авлигатай тэмцэх нь хойрго байх болно.

Бизнесийн орчныг сайжруулахтай холбоотой яг юу хийх ёстой юм бэ гээд бизнес эрхлэгчдээс асуухад хууль эрх зүйн орчныг сайжруулах асуудлыг хөнддөг. Үүнд ихэвчлэн Зөрчлийн тухай хууль, хяналт шалгалт, Зөвшөөрлийн хууль багтдаг. Авлига, хүнд суртлыг бууруулах нь бид бүгдээс мөн хамаарна. Хэрэв хүн асуудал үүсгээд байгаа бол тэрийг нь харьяалах байгууллагад нь мэдэгддэг болж сурахаас энэ байдал засарна. Тэгэхгүй гурвуулаа байж байгаад өөрийнхийгөө шийдчихээд, нөгөө хоёрынхыгөө өөрсдөө мэд гээд орхидог нь

түрүүлж авлига өгөх социалист уралдаан болчихоод байна. Шулуухан хэлэхэд өгөхөө ч байчихъя, үнэхээр тухайн хүн гарын үсэг, тэр зөвшөөрлөө өгөхгүй удаагаад байгаа бол хандах институц нь хуулиараа байгааг ойлгомоор байна.

Тендерийн ил тод, шударга байдал гэдэг бол үнэхээр засагдаж байгаа юм байна, өөрчилж байгаа юм байна гэдгийг хоёр удаагийн хэлэлцүүлгээр тодорхой ойлголт авсан. Ер нь байнга гомдоллодог асуудлууд хуульд тусгалаа олоод байгаа нь ихээхэн дэвшилттэй юм.

Эцэст нь бизнес эрхлэгчид өөрчлөлтийг өөрсдөөсөө эхлүүлэх нь зүйтэй гэдгийг дахин хэлэхийг хүсэж байна.

Баярлалаа.





ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАСАГЛАЛ: ИЛ ТОД, ХАРИУЦЛАГА, ШУДАРГА БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

*“Транспарэнси интернэшнл”
байгууллагын Хараат бус зөвлөх,
судлаач Д.Тэгшбаяр*

Миний өнөөдөр хэлэлцүүлэх илтгэл өмнөх илтгэгч нарын бүх сэдэвтэй холбогдож байна. Юуны өмнө “Бизнесийн ёс зүй, шударга байдлын үнэлгээ”-ээс гаргасан нэг дүнг нэмж дурдъя. “Бизнесийн байгууллагуудад юу хамгийн их хүндрэл учруулж байна вэ?” гэдэг асуултын хариултад нийт 23 орчим хүндрэлүүдийг хувийн хэвшлийн компаниуд өөрсдөө тодорхойлсон. Санхүүгийн бага хүүтэй зээл, санхүүжилтийн асуудлыг хөндсөн ч үүний дараагийн гурван хүндрэлийг:

1. Шударга өрсөлдөх боломж алга,
2. Төрийн худалдан авалтад оролцох сонирхол байгаа ч үйл ажиллагаанд нь авлига дагадаг,
3. Өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт шалгалт өндөр байна гэсэн бэрхшээлийг бизнесийн байгууллагууд хэлсэн байдаг.

Энэ нь төрийн өмчийн компаниудтай яаж холбогдож байгаа юм бэ? Төрийн өмчийн хуулийн этгээд 6000 гаруй байгаа ба үүнд зарим төрийн байгууллагууд, агентлаг хуулийн тодорхойлолтоороо багтдаг. Зөвхөн төрийн болон орон нутгийн өмчит компани 339 байгаа юм байна. Эдгээрийн төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж 170, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 232, 170 төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжээс 15 нь эрсдэлтэй гэсэн судалгааны дүн гарсан байна.

Ихэнх охин болон хамтарсан төрийн өмчит компаниуд ашиггүй ажиллаж байна. 2019 оны байдлаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас бусад нь 230-аад тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Алдагдалтай ажиллаж байгаа нь засаглалын ямар асуудлуудаас болоод байдаг юм бэ гэдгийг харахаар 2015-2020 оны хооронд хийсэн Нээлттэй нийгэм

форум, Компанийн засаглалын хөгжлийн төв, Санхүүгийн зохицуулах хороо, Трансперэнси интернешнл зэрэг байгууллагуудын хэдэн жилийн судалгааны дүнг ангилаад үзэхээр олон улсын байгууллагаас өгч байгаа зөвлөмж, ил тод байдалд нэлээн их шаардлагуудыг тавиад байна. Үүнээс 2 асуудлуудыг нь онцолъё.

Нэгд, засаглалын асуудал нь удирдлага, бүтэц, хяналт хэрэгжүүлж байгаа этгээдийн асуудалтай холбогдож байна. Ер нь Монголын төрийн өмчийн компаниуд 100 оноо авахаас 54 оноотой буюу тал хувьд нь л засаглалын зарчимд нийцэж байна гэсэн үнэлгээ гарсан байна. Удирдлагын томилгоо ил тод биш, ур чадвар сул, мэргэжлийн хүн төрийн өмчийн компанид томилогдохгүй байна, ихэвчлэн энэ нь санхүүгийн болоод хөрөнгийн менежмент хийх шийдвэр гаргадаг эрх бүхий этгээд учраас ний нуугүй хэлэхэд тайлангийн дүнгээс харахад улс төрийн томилгоо, ялангуяа сонгуулийн үед өгсөн хандивын буцаан дэмжлэг болгох байдлаар томилгоо хийгддэг гэсэн дүр зураг харагдсан. Төлөөлөн удирдах зөвлөл өөрийгөө үнэлэх аргачлал одоогоор алга байна. Маш цөөхөн компани аргачлалтай. Мөн ТУЗ-ийн хараат бус байдал хангагдахгүй байна гэсэн дүр зураг гарсан. Хувийн хэвшлийн компанид хараат бус ТУЗ-ийн гишүүдийг томилох нь харьцангуй давуу. Гэхдээ төрийн өмчийн компанид хараат бус ТУЗ-ийн гишүүд томилогдохгүй байна гэсэн дүн гарсан.

Хоёрт, төрийн өмчийн компанийн чиг үүрэгт санхүүгийн удирдлага, засаглалын хүрээг хуульд бүрэн тодорхойлж өгөөгүй. Ялангуяа “Эрдэнэс Монгол” ХХК Компанийн тухай хуулийн хүрээнд ажилладаг ч тодорхойгүй үлдсэн маш олон асуудлууд байна. Охин болон хараат компани байгуулах, эсхүл хөрөнгө удирдах, менежмент хийхдээ энэ асуудалд тодорхой зохицуулалт хийх дотоод дүрэм, журам байхгүй, ноогдол ашгийн бодлоготой төрийн өмчийн компани байхгүй гэж хэлж болохоор байна. “Эрдэнэс Монгол” ХХК түрүү жилээс ноогдол ашгийн бодлого, хувьцаа эзэмшигчтэй харьцах бодлого боловсруулаад төсөл нь хийгдсэн. Гэхдээ одоог хүртэл батлагдаагүй. Үүнээс гадна гүйцэтгэх удирдлагын үнэлгээний шалгуур гэж хийгддэг ч олон улсын стандартад нийцэхгүй байна гэсэн дүн гарсан. Ил тод байдал сул бөгөөд Шилэн дансны хөтлөлт харилцан адилгүй, ялангуяа орон нутгийн өмчийн компаниудад Шилэн дансны хөтлөлт огт хэрэгжихгүй байна.

Үүнтэй холбогдуулж “Дата мэдээллийн үзэсгэлэн” дээр тавигдсан Монголын дата клуб гэдэг байгууллагын боловсруулсан мэдээллийг жишээ болгоё. “Монголын дата клуб” гэдэг байгууллага зөвхөн 2019, 2020 оны “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Монголросцветмет” ХХК гэсэн гурван компанийн 2 жилийн хугацааны худалдан авалтын мэдээллийг

их сургуулийн багш нартай хамтраад 4 нээлттэй мэдээллийн сангаас шүүж, мэдээллийг түүж боловсруулсан байдаг. Энэ 3 компани 2 жилийн хугацаанд 4000 орчим худалдан авалтыг зохион байгуулан, нийтдээ 5,8 их наяд төгрөгийн худалдан авалт хийжээ.

Гэхдээ худалдан авалтыг ангилаад үзэхэд зөвхөн Эрдэнэт үйлдвэр 2 их наяд төгрөгийн худалдан авалтыг 2865 удаагийн тендерээр хийсэн байна. Уг худалдан авалтын 92 хувийг нь 4 компани ханган нийлүүлсэн байна. Цааш яаж үргэлжлэх вэ гэдгийг харахад мэдээлэл ил тод байхын давуу тал, ач холбогдол үүнээс харагдана. Хэрвээ мэдээлэл ил тод байгаагүй бол бид энийг мэдэх ямар ч арга байхгүй.

“Эрдэнэс Тавантолгой” ХК 3,7 их наяд төгрөгийн худалдан авалтыг 425 удаагийн тендерээр гүйцэтгэсэн ба үүний тал хувийг нь топ 10 компани худалдан авалтаар нийлүүлсэн байна.

“Монголросцветмет” ХХК үлдсэн 110 орчим тэрбум төгрөгийн худалдан авалт хийж, үүний тал хувийг мөн 10 компани нийлүүлсэн байна. Хэрэв 3 компанийг нийлүүлээд, худалдан авалтын тендерийг нэгтгэж авч үзвэл нийт худалдан авалтын 92 хувийг 11 компани л гүйцэтгэсэн байна. 4000 тендерийн 92 хувийг нь 11 компани гүйцэтгэнэ гэдэг нь Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас явуулсан судалгаагаар хувийн хэвшилд шударгаар өрсөлдөх боломж алга гэж хэлээд байгаагийн үндэслэл нь ч байж болох юм гэж харж байна.

Үүнээс гадна хөрөнгө, орлогын мэдүүлэг Авлигатай тэмцэх газарт төрийн албан хаагчид гаргадаг. Эдгээр хөрөнгө, орлогын мэдүүлэгт дурдагдсан 132 аж ахуйн нэгж 400 тэрбум төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна. Энэ бол зөвхөн сүүлийн 2 жилийн хугацааны, 4 датаны мэдээлэл. Өмнөх илтгэгчдийн хэлсэн хувийн хэвшил, хөрөнгө оруулалт, гадны хөрөнгө оруулалтыг дэмжих асуудалд ямар чөдөр тушаа байдаг вэ гэдгийг олон улсын байгууллагууд судлаад, шударга өрсөлдөх боломж байхгүй, хязгаарлагдмал гэж хэлэх нь давамгайлж байгаагийн үндсэн шалтгаан энд байдаг болов уу. Энэ ямар асуудлуудыг дагуулж байна вэ гэдгийг харах хэрэгтэй. Бид яагаад удирдлагын томилгоо, санхүүгийн асуудлыг онцлоод байгаа юм бэ гэдгийг бас харж үзэх шаардлагатай.

Төрийн өмчийн хуулийн этгээдийн эцсийн эзэмшигч нь нийт ард иргэд, өөрсдийн хөрөнгийг хэн захиран зарцуулж, ямар шийдвэрийг хэзээ, яаж гаргаж байна, хэдэн төгрөний гэрээг, хэнтэй яаж хийж байна гэдгийг мэдэх эрх нь иргэдэд олгогдсон байдаг. Энэ мэдэх эрхийн дагуу бидэнд нээлттэй мэдээлэл шаардлагатай. Олон улсын сайн жишгээр өмнө нь хэлсэнчлэн 2015-2020 оны

хооронд хийгдсэн судалгааны дүнгээс харагдсан удирдлагын томилгоо яг мэргэжлийн түвшинд байх шаардлага бий. Түүнээс гадна эдгээр хүмүүс нь яаж томилогдож байгаа нь олон нийтэд ил тод байх ёстой. Яагаад гэвэл энэ томилогдсон хүмүүс нь иргэд, олон нийтийн өмнөөс шийдвэр гаргаад байгаа учраас ил тод байх шаардлагатай гэж үздэг байна.

Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл нь санхүүгийн давуу байдлыг үүсгэж байна гэж үздэг. Тэдгээр хүмүүсийн шийдвэрээр 4 компани 90 хувийг, эсхүл 11 компани 92 хувийн худалдан авалтыг ханган нийлүүлж байна. Эдгээр нь бүгд шударга бус гэж хэлж байгаа юм биш. Гэвч бусад компани яагаад чадахгүй байгаа юм гэхээр жишээлбэл, “Эрдэнэс Тавантолгой” ХК-д хийгдсэн тендерт оролцон, 2-г орсон компаниас тандалт хийхэд тухайн компани нь тендерийн эхэнд орсон компаниа судалжээ. Шалгараагүй компани нь 100 орчим ажилтантай, 15 жил ажилласан туршлагатай, шалгарсан компани нь 3 ажилтантай, 3 өөр байгууллагад ажилладаг, нийгмийн даатгалаа зөвхөн нэг сар тухайн шалгарсан байгууллагад төлсөн компани шалгарсан байх жишээтэй байна.

Ийм данхар бүтцийг багасгах, илүү ил тод байлгахад юу шаардлагатай гэхээр нэгдүгээрт, эдийн засгийн холимог тогтолцоотой байгаа энэ нөхцөлд төрийн өмчит компанийн үйл ажиллагааг зохицуулсан дагнасан хууль тогтоомжтой байх шаардлагатай гэж үзэж байгаа.

Авлигатай гэмцэх ажлын хэсгийн хүрээнд Төрийн өмчит хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг боловсруулж засаглалын асуудлуудыг ил тод болгох, олон улсын зарчимд нийцүүлэх хүрээнд ажиллана гэдгийг нэмж хэлмээр байна.

Та бүхэнд баярлалаа.

АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

Нэг. Авлигатай тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн болон холбогдох бусад байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр:

- 1.1. Авлигын гэмт хэрэгт хариуцлага тооцох боломжгүй байдал үүсгэж буй шалтгаан, нөхцөлийг судлан тогтоож, арилгах, ялангуяа хэргийн нотлох ажиллагааны онцлогийг хуульд тусгах, хөөн хэлэлцэх хугацааг бодитой, үндэслэлтэй тогтоон мөрдүүлэх замаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд шинэтгэл хийх;
- 1.2. Эрүүгийн хуулийн Авлигын гэмт хэрэг бүлэгт тусгасан гэмт хэрэг тус бүрийн бүрэлдэхүүн, ногдуулах ял, хариуцлагыг тухайн хэргийн онцлогтой уялдуулан тодорхой болгож ялгамжтай хуульчлах, ял хариуцлагыг чангатгах, энэ төрлийн гэмт хэрэгт эд хөрөнгө хураах ялыг оногдуулдаг болох, торгох ял хэрэглэхгүй байх өөрчлөлтийг хуульд тусгах;
- 1.3. Мэдүүлэг авах, тогтоол, шийдвэр танилцуулах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулахаар гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээчийг дуудан ирүүлэх болон албадан ирүүлэх эрхийг мөрдөгчид олгох асуудлыг шийдвэрлүүлэх;
- 1.4. Яллагдагчид зорчих эрхийг хязгаарлах таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг мөрдөн байцаалтын шатанд мөрдөгчийн саналыг үндэслэн прокурор, шүүхийн шатанд прокурорын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэдэг байхаар өөрчлөх;
- 1.5. Эрх бүхий байгууллагын цахим мэдээллийн сангаас цахим гарын үсгээр баталгаажуулж авсан лавлагаа, тодорхойлолтыг нотлох баримтад тооцож үнэлэх эрх зүйн зохицуулалт, аргачлалыг бий болгох;
- 1.6. Мөрдөн шалгах ажиллагаанд дүрс харж ярилцах, дуу хоолойноос бичигт хөрвүүлэх зэрэг технологийн дэвшлийг ашиглах боломж, нөхцөлийг бүрдүүлж, нотлох баримтаар үнэлэх эрх зүйн орчин бий болгох;
- 1.7. Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, хохирол нөхөн төлүүлэх, хөрөнгө буцаах чиглэлээр Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн гишүүн орнууд болон бусад улс оронтой хамтын ажиллагааг хөгжүүлэх, дээрх чиглэлд Конвенцийн зохицуулалтыг өргөнөөр ашиглаж хэвших, эрх зүйн харилцан туслалцааны гэрээг байгуулах талаар идэвх санаачилгатай ажиллах;

- 1.8. Авлигатай тэмцэх газар, тагнуул, цагдаа зэрэг хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдыг авлига, эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр мэргэшүүлэх, хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах чиглэлээр чадавхжуулах, мэдээлэл, харилцан туршлага солилцох боломжийг бүрдүүлэх;
- 1.9. Мөрдөгчдийн хэрэг хянан шийдвэрлэх уламжлалт арга барилыг шинэчлэх, нотлох баримт шинжлэн судлах ажиллагаанд санхүүгийн программ болон бусад техник технологид суурилсан дэвшилтэт арга барилыг нэвтрүүлэх, энэ чиглэлээр албан хаагчдыг чадавхжуулах;
- 1.10. Авлигын хэргийг хянан шалгадаг мөрдөгч, прокурор, шүүгчийг мэргэшүүлэх, давтан сургах сургалтын хөтөлбөрийг боловсруулж нэвтрүүлэх, кэйс анализ, дүн шинжилгээнд тулгуурласан сургалтыг тогтмол явуулж, сургалтын үр дүнд үнэлэлт өгөх ажлыг хэвшүүлэх;
- 1.11. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх аливаа оролдлогын талаар нөлөөллийн мэдүүлгийг гаргаж хэвшүүлэх, энэ талаарх хууль тогтоомжийг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авах;
- 1.12. Авлигын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлыг хангах, тухайлбал, шалгаж байгаа хэрэг бүрийн талаар нэг стандартын дагуу олон нийтэд тогтмол мэдээлдэг болох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах, авлигыг хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг цахим санд бүрэн оруулдаггүй, удаадаг, сангаас устгадаг явдлыг таслан зогсоож, шийдвэр бүртэй танилцах боломжийг бүрдүүлэх;
- 1.13. Авлигын хэргийг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны явц, үр дүнгээс гадна шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагааны талаар мэдээ, мэдээллийг нээлттэй болгох. Тухайлбал, авлигын хэрэгт шийтгүүлсэн ял шийтгэлийг биечлэн эдэлсэн хугацаа, хугацаанаас өмнө суллагдсан, учруулсан хохирлоо нөхөн төлсөн эсэх мэдээллийг олон нийтэд хүргэх;
- 1.14. Авлигын хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлсэн хөрөнгө төсвийн аль ангилал, зардалд орсон, үүгээр ямар хөрөнгө оруулалт хийсэн талаар олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлэх;
- 1.15. Оффшор бүсээс оруулж ирсэн хууль бус хөрөнгийг ямар дансанд байршуулж, аль байгууллагад шилжүүлсэн зэрэг мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэх;
- 1.16. Нийтийн албан тушаалтнуудын татвар төлөлтийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.

Хоёр. Төрийн албаны шударга, ил тод байдлыг бэхжүүлэх чиглэлээр:

- 2.1. Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ, авлигын эрсдэлийн үнэлгээ зэрэг судалгааны үр дүнд тулгуурлан авлигын эрсдэл бүхий салбар, байгууллагад чиглэсэн арга хэмжээг тусгайлан авч хэрэгжүүлэх, авлигын гэмт хэрэг, авлига, ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах;
- 2.2. Төрийн албаны их өгөгдөлд суурилсан хүний нөөцийн нэгдсэн удирдлагын цахим системийг хөгжүүлэх, ашиглалтыг нэмэгдүүлэх, ялангуяа уг их өгөгдөлд суурилан төрийн албан хаагчийн томилгоог хийх. Энэхүү системийг төрийн байгууллагуудын цахим системтэй интеграцжуулахад холбогдох байгууллагууд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах;
- 2.3. Төрийн албаны хүний нөөцийн аудитыг Үндэсний аудитын газар, Төрийн албаны зөвлөл хамтран хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн хандлага, соёлыг сайжруулах, ёс зүй, сахилга хариуцлагад тавих хяналтыг чангатгах, төрийн албаны шалгалт, төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэхэд хиймэл оюун ухааныг ашиглах боломжийг судлах, ёс зүй, зан үйлийг үнэлэх сэтгэл зүйн туршилтыг өргөжүүлэх;
- 2.4. Төрийн албаны хууль тогтоомжоор албан тушаалд тавьсан шаардлагыг хангаагүй, сонгон шалгаруулалтгүйгээр томилсон хүмүүсийг төрийн албанаас чөлөөлөх, томилсон этгээдэд хариуцлага тооцох, албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхэд онцгойлон анхаарах;
- 2.5. Төрийн албан дахь статистик, тоон мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, гүйцэтгэлийн үр дүн, мэдээллийн үнэн зөв байдлын аудитыг хөгжүүлэх, төрийн байгууллагуудын харилцаа, мэдээлэл солилцоо, уялдаа холбоог сайжруулах, хэлбэрийн төдий дотоод хяналтын тогтолцоог өөрчлөх;
- 2.6. Төрийн худалдан авалт, ханган нийлүүлэлт, хөгжлийн албан ёсны тусламж, татаас, тэтгэмж, хөтөлбөр болон эрх, тусгай зөвшөөрөл, концесс олгох зэрэг үйл ажиллагаатай холбоотойгоор авлига, залилангийн гэмт хэрэг гарахад нөлөөлөхүйц хүчин зүйлсийг арилгах, аудит хийхдээ хөндлөнгийн болон дотоод хяналтын зохистой горимыг сонгон хэрэглэх;
- 2.7. Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулахаас бусад тохиолдолд иргэн, аж ахуйн нэгжээс эрхэлж буй аливаа үйлчилгээ, үйл ажиллагаанд хуульд заагаагүй зөвшөөрөл олгодог явдлыг таслан зогсоох, төр өөрт байгаа мэдээллээ иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг тогтолцоог халах;

- 2.8. Цахим засаглалыг хөгжүүлэх, E-Mongolia цахим системээр үзүүлэх төрийн үйлчилгээний төрөл, тоо, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээ авахад нэн шаардлагатай тоон бичиг үсгийн чадвартай иргэнийг бэлтгэхэд онцгойлон анхаарах, сургалт сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах, иргэд төрөөс үйлчилгээ авдаг жишгээс төр иргэддээ үйлчилгээ санал болгодог хэлбэрт шилжих;
- 2.9. Гадаадын зээл, тусламжийн төслүүдийн удирдлагын мэдээллийн системийн ашиглалтыг сайжруулах, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг олгох, зээл тусламжийн үр ашгийг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах;
- 2.10. Төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн иж бүрэн байдлын түвшинг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний бүртгэлийг боловсронгуй болгох, кодлох, шилэн дансны нэгдсэн системийг нээлттэй өгөгдлийн зарчмаар шинэчлэх, аудитын явцад олон нийтийн зүгээс дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлсэн албан ёсны механизмыг бүрдүүлэх.

Гурав. Авлигатай тэмцэхэд хэвлэл мэдээллийн болон иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр:


- 3.1. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үйл хэрэгт хувь нэмрээ оруулж буй сэтгүүлчид болон бусад оролцогчдын аюулгүй байдлыг хангах, урамшуулах тогтолцоог бүрдүүлэн Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн төслийг батлан мөрдүүлэх;
- 3.2. Төрийн бус байгууллагын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, энэ чиглэлээр иргэний нийгмийн байгууллагууд хамтарч ажиллах;
- 3.3. Авлигатай амжилттай тэмцэж буй гадаад орны болон өөрийн улсын сайн туршлагыг судлах, түгээн дэлгэрүүлэх, энэ ажилд эрдэмтэн, судлаач, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг татан оролцуулж, хамтран ажиллах;
- 3.4. Төрийн бус байгууллагууд төрийн албаны томилгоо, санхүү, төсвийн хяналтын чиглэлээр өөр хоорондоо болон Үндэсний аудитын газар, Хүний эрхийн үндэсний комисс, Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим зэрэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах, үүнд цахим мэдээллийн сан, их өгөгдлийн шинжилгээг ашиглах боломжийг бүрдүүлэх, мэдээлэл олж авахаас гадна мэдээллийг ашиглах мэдлэг, чадварыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;
- 3.5. Авлигатай тэмцэх ажилд судлаачдыг татан оролцуулах, мэргэшүүлэх

- зорилгоор их, дээд сургууль, Шинжлэх ухааны академи, хүрээлэнгүүдтэй хамтран ажиллах;
- 3.6. Авлигын эсрэг үйл ажиллагаан дахь иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэхэд ашиглах цахим платформуудыг бүтээх, хөгжүүлэх, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах;
 - 3.7. Төрийн бус байгууллагуудыг чадавхжуулах, ажилтнуудыг сургах, мэргэшүүлэхэд дэмжлэг үзүүлэх, иргэдийн мэдээлэл авах, харилцаа холбооны технологийг хэрэглэх, мэдээллийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр төр, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах;
 - 3.8. Бүх шатны боловсролын байгууллагад суралцаж буй хүүхэд, залууст авлигыг үл тэвчих соёл, хүмүүжил төлөвшүүлэхэд онцгой анхаарах, энэ чиглэлээр Боловсрол, шинжлэх ухааны яам санаачилгатай ажиллах;
 - 3.9. Үндэстэн дамнасан сэтгүүлчдийн болон иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээ, олон улсын үр дүнтэй хамтын ажиллагаа, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үр нөлөөг нэмэгдүүлэх замаар үндэстэн дамнасан авлига, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэхэд анхаарал хандуулах;
 - 3.10. Хэвлэл мэдээллийн байгууллагууд эцсийн өмчлөгч болон санхүүгийн мэдээллээ, ялангуяа орлогын эх үүсвэрийнхээ талаарх мэдээллийг ил болгох зохицуулалтыг сайжруулах;
 - 3.11. Хэвлэл мэдээллийн компаниудын эзэмшигч болон ашиг хүртэгч өмчлөгчтэй холбоотой ашиг сонирхлын зөрчлийг судлах, ил тод байдлыг дэмжих эрх зүйн орчныг сайжруулах,
 - 3.12. Зөвхөн авлигатай тэмцэх төдийгүй нийтийн эрх ашгийг хөндсөн аливаа бодлого боловсруулах үйл явцад иргэдийн анхаарлыг хандуулах, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, иргэний нийгмийн байгууллагын оролцоог бодитоор хангахад хэвлэл мэдээллийн байгууллага дэмжлэг үзүүлэх;
 - 3.13. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны бүртгэл, мэдээллийг нэгдсэн стандартад оруулах, түгээх замаар иргэдийн мэдэх эрхийг хангах, төрийн үйл хэрэгт оролцож, хяналт тавих боломжийг нэмэгдүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллага дэмжлэг үзүүлэх;
 - 3.14. Авлигын хэргийг эрэн сурвалжлах болон худалдан авах ажиллагаа, төрийн хөрөнгийн зарцуулалтыг мөшгих чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагууд хараат бусаар хамтран ажиллах, энэ үйл ажиллагаанд цахим мэдээллийн сан, их өгөгдлийн шинжилгээг ашиглах;

- 3.15. Хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм, хууль сахиулах байгууллагуудын хоорондын бүтээлч харилцаа, хамтын ажиллагааны шударга, хараат бус байдлыг ханган бэхжүүлэх;
- 3.16. Хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч, ажилтнуудыг шударга ёс, ёс зүйн сургалтад хамруулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодлого, ёс зүйн тодорхой дүрэм бүхий дотоод шударга байдлын тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- 3.17. Эрх зүй ба ёс зүйн хүрээнд хараат бус, эрэн сурвалжилсан бүтээлийг хөхиүлэн дэмжих, түгээн сурталчлах;
- 3.18. Авлига, хээл хахуулийн гэмт хэргийн талаар олон улсын хэвлэлд гарч буй мэдээ, мэдээлэлд тогтмол дүн шинжилгээ хийж, сайн туршлагыг түгээхэд чиглэсэн арга хэмжээ авах;
- 3.19. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн редакцийн хараат бус байдлыг хангах, санхүүгийн бусад эх үүсвэрийг хөгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авах.

Дөрөв. Хувийн хэвшил ба шударга өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр:

- 4.1. Үндэсний компаниудын нэр хүнд, манлайлалд тулгуурласан эдийн засгийг хөгжүүлэх;
- 4.2. Комплаенс болон бизнесийн ёс зүйн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлсэн хувийн хэвшлийг хөхиүлэн дэмжих, урамшуулах чиглэлээр эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлыг судлах;
- 4.3. Аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоодод шударга байдлын эрсдэлийн үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр заавар, зөвлөгөө өгөх;
- 4.4. Компанийн эцсийн өмчлөгч, ашиг хүртэгчийн болон төрийн худалдан авах ажиллагаанд оролцогч аж ахуйн нэгжийн мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох;
- 4.5. Гадаадын хөрөнгө оруулалт, худалдааны асуудал хариуцсан дагнасан төрийн байгууллага, агентлагтай болох асуудлыг судлах;
- 4.6. Төрийн хяналт шалгалтын давхардлыг арилгах;
- 4.7. Бизнесийн үйл ажиллагааны төрөл, онцлогийг харгалзан стандартыг сайжруулах, шинээр болон шинэчлэх ажлыг зохион байгуулж бизнесийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, дэмжлэг үзүүлэх;
- 4.8. Тусгай зөвшөөрлийн тоог бууруулах, тэдгээрийг хугацаатай олгодог тогтолцоог өөрчлөх, цахимжуулах чиглэлээр Зөвшөөрлийн тухай хуулийг шинэчлэн батлах;

- 
- 4.9. Төрийн өмчит аж ахуйн нэгжийн чиг үүрэг, санхүүгийн удирдлага, засаглалын хүрээ зэрэг тодорхойгүй асуудал/охин компани байгуулах, ногдол ашгийн бодлого зэрэг/-ыг зохицуулах зорилгоор Төрийн өмчит хуулийн этгээдийн тухай хууль тогтоомжийг батлах, төрийн өмчит аж ахуйн нэгжийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурыг олон улсын стандартад нийцүүлэх, тэдгээрийн төсөв хөрөнгийн зарцуулалтад олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг бүрдүүлэх;
- 4.10. Төрийн өмчит компаниудын удирдлагын томилгоог ил тод болгох, эрүүгийн ял шийтгэгдсэн этгээдийг томилохыг хориглох, төрийн өмчит аж ахуйн нэгжийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус байдлыг хангаж, өөрийн үнэлгээний аргачлалыг бий болгох.

